МОНГОЛ УЛС
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН

ДОМИЙН ТӨМӨРТОГОО

МОНГОЛ ХЭЛНИЙ ҮГИЙН ГАРАЛЫН ТАЙЛБАР ТОЛЬ

МОНГОЛ УЛС
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН

Номын сан

ДОМИЙН ТӨМӨРТОГОО

2018.10.05

МОНГОЛ ХЭЛНИЙ ҮГИЙН ГАРАЛЫН ТАЙЛБАР ТОЛЬ

(Эрдэм шинжилгээний хэрэглэгдэхүүн)

Улаанбаатар
2018

ННА 81.2-8
ДАА 411
Т-587

МОНГОЛ ХЭЛНИЙ ҮГИЙН ГАРАЛЫН ТАЙЛБАР ТОЛЬ
Эрдэм шинжилгээний хэрэглэгдэхүүн

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Д.Оюун
Цаасны хэмжээ: 172х245 1/10
Хэвлэлийн хуудас: 44,6

«Адмон Принт» ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв. 2018

ISBN 978-99978-892-9-4

MONGOLIAN ACADEMY OF SCIENCES
INSTITUTE OF LANGUAGE AND LITERATURE

AN ETYMOLOGICAL DICTIONARY OF MONGOLIAN LANGUAGE

BY TUMURTOGOO DOMII

ULAANBAATAR. 2018

ӨМӨНӨХ ҮГ

Монгол хэлний судалгаа үүсэн хөгжиж ирсэн хоёр зуу шахам жилийн хугацаанд монгол хэл аялгууны толь, орчуулгын толь, тайлбар толь, бичигийн дурсхал, сурвалж бичгийн үгсийн хэлхээ, үгийн бүтэцийн толь, харь үгийн толь, нэр томъёоны толь зэрэг үгсийн сангийн олон талын зорилалттай толь бичгүүд олоноор гарч сургалт, судалгааны ажилд өргөн хэрэглэгдсээр байгаа билээ. Харин монгол хэлний сургалт, судалгааны ажил болон бүх нийтийн бичгийн хэрэглээнд нэн шаардлагатай үгийн гаралын толь бичиг гаралгүй хүлээгдсээр эдүгээ хүрчээ.

Монгол хэлний үгсийн сангийн судалгааны олон жилийн судалгааны үр дүнд үгийн гаралын толь боловсруулан гаргах таатай нөхцөл бүрдсэн гэж үзсэн тул миний бие энэхүү толийг эмхэдхэн боловсруулах ажилыг 2012 онд эхлүүлж, уламаар 2014 оноос уг ажилыг эрдэм шинжилгээний суурь судалгааны төсөлт ажил болгон батлуулсан билээ. Тус толийг хийхийн тул нэг талаас, XIII-XIV зууны үеэс уйгуржин бичигийн дурасхал болон XVII-XIX зууны үеийн түүхэн сурвалж бичигүүд, бүддийн гүн ухааны зохиол бүтээлүүдийн үгийн сангийн материал, нөгөө талаас, монгол хэл аялгуу, ардын аман зохиолын үгсийн сангийн материал цуглуулж, хөмөрөг бүрдүүлэх шаардлагатай болсон билээ. Тийнхүү хөмөрөг бүрдүүлэх ажилд академич Д. Цэрэнсодном, профессор Ш. Чоймаа, Ц. Шагдарсүрэн, Ц. Өнөрбаян, Г. Гантогтох, доктор О. Самбуудорж, Б. Катуу, М. Баярсайхан, Ю. Цэндээ, эрдэм шинжилгээний ажилтан Г. Сүлд-Эрдэнэ, Б. Энхсувд нар оролцож баялаг материал цуглуулсан билээ. Мөн акад. Д. Цэрэнсодном, проф. Ц. Шагдарсүрэн, Ш. Чоймаа нар зарим үгийн гаралд холбогдох тусхай материал бэлдхэж өгсөнийг онцлон дурдвал зохино. Түүнчилэн монгол хэлэнд орсон хитад, төвөд, энэдхэг-европ хэлний үгсийн хөмөрөг бүрдүүлэхэд доктор Ш. Эгшиг, С. Мөнхсайхан, С. Батхишиг, Б. Отгонсүрэн, П. Ням-Очир, Н. Балжинням нар оролцсоны дотор С. Мөнхсайхан, С. Батхишиг, Н. Балжинням нар нэн их идэвхи зүдхэлтэй ажиллаж, хитад, энэдхэг-европ гаралтай үгсийн баялаг хөмөрөг бүрдүүлсэнийг тусхайлан дурдмаар байна. Мөн төвөдөч эрдэмтэн, профессор Д. Бүрэнээ төвөд хэлнээс монгол хэлэнд орсон гурван зуу гаруй үгсийн бичлэгийг жигдлэн засаж өгсөн болно.

Миний бие олон эрдэмтэн нөхөдийн бүрдүүлсэн баялаг материалыг эмхэлэн цэгцлэсэний дээр монгол, дөрвөлжин, хитад, араб үсэгийн дурасхалууд болон хожуу үеийн түүхэн сурвалж бичиг, бүддийн гүн ухааны зохиол бүтээлүүдээс жишээ сэлт түүвэрлэн авах, мөн монгол хэлэнд орсон түрэг, уйгур, манж-түнгүс санскрит, перс хэлний үгсийг тухай тухайн хэлний толь бичигүүдээс шүүрдэн авч боловсруулах, түүнчилэн монгол хэлэнд орсон энэдхэг-европ хэлний үгс хаагуур дамжин хэрхэн хувисч ирсэн байдалыг тогтоох зэрэг ажилыг сүүлийн дөрвөн жилийн хугацаанд хийж гүйцэдхэсэн болно.

Монгол хэлний үгийн гаралын толийн бүтэц, арга зүйг анх боловсоруулж эхлэх үед үлгэр загвар болохуйц толь бичиг гараагүй, алтайн төрөл хэлнүүдийн үгийн гаралын талаар хэд хэдэн томоохон толь бичиг[1] гарсан боловч тэдгээрт тухайн хэлнийхээ үгсийн гарал үүсэл, дотоод бүтэц, хувьсан өөрчлөгдөж ирсэн байдалыг тусхасан нь нэн цөөн, их толөв хэл аялгуунуудын үгсийн сангийн харьцуулсан судалгааны шинжтэй болсон байлаа. Тийм учираас миний бие өөрийнхөө төсөөлөн бодсоны дагуу, цуглуулж буй өргөн хүрээтэй материалаа аль болохоор шингээн багтаасан бүтэц, арга зүйг боловсоруулан мөрдөж ирлээ. Тухайлвал, сонгож авсан толгой үг тус бүрийн ард монгол бичигийн тогтсон бичлэг, тухайн үгийн дотоод бүтэц, үндэсэн утга, агуулгын тайлбар, нийтлэг шинжтэй хоршоо үг, тогтвортой хэлц, тус үгийн язгуураас салбарлан гарсан нийлмэл бүтэцтэй үгс, бичигийн дурасхал болон түүхэн сурвалж, утга зохиолоос эшилж авсан бодит жишээ, зонхилох аялгуунуудын дуудлага зэрэгийг дагалдуулсан болно. Монгол хэлэнд орсон гадаад үгсийн хувьд, үг тус бүрийн хамаарал, эртний хэлбэр, дамжиж ирсэн байдал, илэрхийлэх үндэсэн ба шилжсэн утга, бичигийн дурасхал болон түүхэн сурвалж бичиг, ном бичигийн жишээ зэрэгийг багтаалаа. Харин өрөнө, доронын олон хэлний үгсийг тухай тухайнх нь үсэгээр бүрэн жигд тэмдэглэх боломж хизгаарлагдмал байгаа учир нийтэд нь латин галигаар тэмдэглэсэн болно. Мөн зарим үгийн гаралын талаар гарсан эрдэмтэдийн саналыг харьцуулан дурдсанаас гадана тодорхой нэгэн үгийн бүтэц ба утгын талаар гарсан тусхай судалгааны нэрийг дагалдууллаа. Шаардлагатай зарим тохиолд тухайн үгийн дотоод бүтэцэд гарсан авианы түүхэн хувьсалыг цуваа цагийн үүднээс авч үзсэн бий.

Монгол хэлний үгийн гаралын толийг бүрэн гүйцэд хийнэ гэвэл олон хүний хүч оролцоо, бичигийн хэл, аман аялгууны баялаг материал, хүрэлцээтэй цаг хугацаа шаардлагатай тул эхний ээлжинд энэ хүртэл хийж гүйцэдхэсэн ажилаа цэгцлэн нийтлүүлэхээр шийдлээ. Энэ удаагийн бэлдхэсэн толь бичигт нийт 3700 орчим толгой үг багтсаны дотор 2200 орчим монгол үг, 1500 орчим гадаад хэлний үгийг багтаалаа. Мөн монгол хэлний үгийн гаралын талаар гарсан судалгааны ном зүй, товчилсон нэрсийн жагсаалт зэрэгийг хавсаргасан болно. Цаашид монгол хэл судалалын залгамж үеийн залуу судлаачид энэхүү толийг үргэлжилүүлэн улам боловсронгуй, илүү өргөн хүрээтэй болгоно гэдэгт итгэж байна.

---

[1] M. Räsänen, Versuch eines etymologischen Wörterbuchs der Türksprachen, Helsinki, 1969, XVI + 1-533 // G. Clauson, An Etymological Dictionary of Pre-Thirteenth-Century Turkish, Oxford, 1972, 48 + 989 pp. // Э. В. Севортян, Этимологический словарь тюркских языков, М., 1974 (768 стр. // pdf, 44Mb), 1978 (349 стр. // pdf, 29Mb), 1980 (395 стр. // pdf, 22Mb), 1989 (pdf, 19Mb), 1997 (pdf, 19Mb), 2000 (pdf, 4Mb), 2003 (pdf, 4Mb) // Б. И. Татаринцев, Этимологический словарь тувинского языка, Новосибирск, т. I (2000) 344 стр. т. II (2002) 388 стр. т. III (2004) 440 стр. т .IV (2008) 442 стр. // М. Р. Федотов, Этимологический словарь чувашского языка, в двух томах, Чебоксары, 1996 // S. A. Starostin, A. V. Dybo, O. A. Mudrak, An Etymological of the Altaic Languages, Leiden / Boston: Brill, 2003, vol. I-III (2003), 2096 pp.

Бидний энэхүү толь бичгийн ажил эхэлсэнээс хойш Оросын Холбооны Улсад монгол хэлний үгийн гаралын тухай судалгааны зарим бүтээл гарлаа. Түүний нэг нь профессор Г. Д. Санжеевын удирдлагаар дөч гаруй жилийн өмнө эхлэн хийсэн томоохон бүтээлийн эхний хоёр дэвтэр саяхан нийтлэгдлээ.[2] Тэрхүү бүтээлд толь бичгийн толгой үгийг бүрдүүлэн, зарим үгийн харьцуулсан жишээг хавсаргаж, харь гаралтай цөөн үгийн гаралыг тодорхойлсон байна. Тус толь бичгийн толгой үгийн бүрдүүлэлтээс ажиглавал, монгол хэлний үгийн сангийн үлэмж өргөн хүрээг хамарсан доривтой томоохон бүтээл болох байсан нь тодорхой харагдаж байна. Харамсалтай нь 1982 онд проф. Санжеев таалал төгссөний дараа тэрхүү ажил цааш нь үргэлжилж чадсангүй. Мөн саяхан профессор Ангархаевын удирдлагаар буриад хэлний үгийн гаралын толийн эхний боть хэвлэгдэн гарчээ.[3] Дээрхээс гадана өрөнө дахины зарим эрдэмтэд ч бас ийм толь бичиг бэлдэж байгаа тухай мэдээлэл бий. Тийм учираас эх хэлнийхээ үгийн гаралын тухай асуудалыг орхигдуулалгүй судалах шаардлагатай байгааг залгамж үеийн залуу судлаачиддаа сануулмаар байна.

Эцэст нь, энэхүү толь бичгийн сан хөмөрөг бүрдүүлэхэд идэвхи зүдхэлтэй оролцсон эрдэмтэн нөхөд, залуу судлаач нартаа чин сэдхэлийн талархалаа илэрхийлэе.

Академич Д. Төмөртогоо

---

[2] Г. Д. Санжеев, М. Н. Орловская, З. В. Шевернина, Этимологический словарь монгольских языков, Том I (А-Е) Москва, 2015, 3-222, Том II (G-P) Мосвка, 2016, 3-230

[3] А. Л. Ангархаев, Этимологический словарь бурятского языка, том I. (А-М) Улан-Удэ, 2016, 342 стр.

ТОЛЬ БИЧИГ АШИГЛАГЧИДЫН АНХААРАЛД


1. Эрдэм шинжилгээний хэрэглэгдэхүүн болгон нийтлэж буй энэхүү толь бичигт орсон зарим толгой үгийн эртний бүтэцийг одоогийн мөрдөж байгаа зөв бичих дүрэмээр бүрэн зөв тусхах боломжгүй тул өөрөөр тэмдэглэсэн болно. Тийм учираас толгой үг болон түүний тайлбарын бичлэг өөр хоорондоо зөрөөтэй болсон газар цөөнгүй бий.

Таширамд дурдахад, миний бие монгол хэлнийхээ авианы тогтолцоо, үгийн бүтэцийг түүхэн хэл шинжилэлийн үүднээс судалан тогтоосон бүтээлүүддээ кирил бичигийн зөв бичих зүйн талаар ахмад үеийн эрдэмтэн багш нарынхаа боловсоруулсан онолын үндэслэлтэй зарчимын саналыг баримтласаар ирсэн бөгөөд энэ удаа ч мөн тэрхүү зарчимаа баримталсан болно. Хойшид ч...

2. Монгол хэлэнд шинэ тутам орсон европ гаралтай толгой үгсийг эдүгээ нийтээр хэрэглэж байгаа бичлэгийг баримтлан бичсэн бөгөөд харин тэдгээрийн тайлбарын хэсэгт тухайн үгийг монгол хэлний бодит дуудлагаар нь тэмдэглэсэн болно. Жишээлэхэд, орос хэлээр дамжиж монгол хэлэнд орж ирсэн *'трактор'* гэдэг үгийг монгол хүн *'тараахтар'* гэж дууддаг бөгөөд энэ нь гадаад хэлний үгийг зөв дуудаж чаддаггүй, хэлний боловсорол доройн шинж огтхон ч бус, харин монгол хэлнийхээ эгшигийн зохьцол, гийгүүлэгчийн байр, үеийн бүтэцэд захирагдаж байгаа хэрэг юм. Цаашдаа япон, солонгос зэрэг Азийн бусад үндэстэнүүдийн нэгэн адил эх хэлэндээ орсон харь гаралтай үгсийн бичлэгийг хэлнийхээ бодит дуудлагад тохируулан, зөв бичих дүрэмийн толиор жигдлэн тогтоож, нийтээр дагаж мөрдөх нь зөв буй заа. Харин тухайн гадаад хэлээр ярьж, бичихдээ угийн бичлэг, дуудлагыг дагаж мөрдөх нь зүйн хэрэг. Саяхан дахин боловсоруулсан кирил бичигийн зөв бичих дүрэмийн тольд *гараж* {< Fr. garage} гэх мэт европ гаралтай зарим үгийг монгол хэлний бодит дуудлагад нийцүүлэн *гарааш* гэж бичсэн нь сайшаалтай.

3. Эртний бичигийн дурасхал, түүхэн сурвалж бичигүүдээс эшлэн авсан жишээнүүдийг галиг үсэгээр буулгаад, уламаар түүний хөрвүүлэгийг одоогийн монгол хэлэнд дөхүүлэн утгачилж буулгасан болно.

4. Тус толийн толгой үгсийн дотор биеэ даасан үгийн сангийн утгагүй, аль ч үгийн аймагт хамааруулах боломжгүй анхдагч язгуур цөөнгүй байгаа билээ. Тийм учираас нийт толгой үгийн ард үгсийн аймагийн ялган заасан товчилол бичээгүй болно. Харин үйл үгийн ард зураас (-) тавьсанаас гадана дангаараа үгийн сангийн утга илэрхийлэхгүй байгаа анхдагч язгуурын дээр од (*) тэмдэг тавьсан болно.



А

Абури |aburi|{< *ayuri / egüri*} х у у ч : *'үүрд мөнх'* (Монгол бичигийн хэлний *egüri* 'үүрд' гэсэн үгийн хувилбар: *aburi/egüri.* Энэ үг бичигийн хэлэнд гагцхүү өгөх-оршихын тийн ялгалын хэлбэрээр тохиолддог) || Ж= *'nayarbai gür ulus nayadun čenggen-iyer nasu **aburi-da** nasulan jiryatuyai'* [нармай гүрэн улас наадам цэнгэлээр насан үүрд наслан жаргатугай](ВТ 167a) // *'naran **aburi-du** gerel-i yaryayu'* [наран үүрд гэрэл гаргаюу](Sub.VI) // *'sayin ner-e tanu **egüri-de** aldaršiyuldamui'* [сайн нэр чинь үүрд алдаршмуй](Hin. 10)

Ав |aba| *'хоморголон горөөлох', 'ан ав'* (олуулаа хамтарч ан ав хийх) || Cf. Turk. ***aw*** 'Jagd' (Gabain 297), ***aw*** 'дичь, охота' (Радлов I:636), *aba* 'охота', 'ловля' (Щербак, 2005, 19) || Ж= *'Čiŋgis qahān **aba** bawu'ād'* [Чингис хаан ан аваас буугаад](MNT 191) // ***aba*** 'охота' (Mu. 93) || Энэ үгээс *abačin* [= aba-čin] 'авчин' гэсэн үг үүссэн нь зарим дурасхалд тэмдэглэгджээ. (Ayiladqal 16). Мөн түүнээс *abala-* [= aba-la] 'авла' гэсэн үйл үг үүсч, улам түүнээс *abalayčin* [= aba-la-yčin] 'авлагчин' гэсэн үг үүсчээ. || Ж= ***'abalayčin** aran-a ayula-dur keger-tür üldegüljü alaydan qarbuydan jobamui'* [авлагчин хүнээ ууланд, хээрт үлдээж алагдан харвагдан зовмуй] (Turf. IX:7) || х о р ш : *'ан ав', 'ав хоморго'* || Kha. *aw,* Ord. *awa,* Bur. *aba,* Oir. *ab*

Авааль |abali|[= aba-li] *'анхны эхнэр'* (амьдаралаа холбохоор сонгож авсан анхны гэргий) || Ж= *'Bodončar-un abalin eme-deče töregsen Barim-ši'iratu Qabiči neretü büle'ē'* [Бодончарын анхны гэргийгээс төрсөн Барим шийрт нэртэй билээ](MNT 43) || Kha. *awaal'*, Ord. *awaal,* Bur. *abāli,* Oir. *awāl'ı*

Т у с х а й с у д а л г а а: П. О. Рыкин, О семантики и этимологии термина свойство *abulin ete* в *'Тайной истории монголов'*, *'Радловский сборник'*, СПб., 2008, 362-368

Авид I |abida|{< Skr. *amitābha*} *'цаглашгүй гэрэлт'* (Бүддийн сургаалын ном зохиолд Сугавадын орон дахь язгуурын таван бурханы нэгийг *'авид'* гэдэг) || Ж= *'čindamani-yin yurban tarni **abida** burqan-u tarni'* [чандманы гурван тарни авид бурханы тарни](Bud. col.1a) || Kha. *awid,* Ord. *awid*

Авид II |abid| х у у ч : *'хос'* (мал амьтаны хошного) || Ж= *'uriyāŋqadai kü'ün čö'ē buğu alaju, qabirğas inu, **abid** inu širaju'* [урианхай хүн цаа буга алж, хавирга, хосыг нь шарж](MNT 12) || Oir. *abid*

Авидарма |abidarma|{< Uig. *abidarim* < Skr. *abhidharma*} *'илт ном'* (сав ертөнц, шим ертөнц тогтсоноос эхлээд дээд үнэнийг ухаарах хүртэлхи гүн ухааны цогц ойлголтыг багтаасан бурханы зарлиг номын гурван аймаг савын нэг, дотоод хөлгөний ном) || Ж= *'nirvan-daqi jiryalang-ud-i törügülüči vinai sudur **abidarim** kiged jrly nom-ud'* [нирваан дахь жаргаланг төрүүлэгч винай судар авидарим хийгээд зарлиг номууд](ВТ 165a)

Авидла |abidla|[= abid-la] *'майвшируул-', 'майдхаруул-', 'аргад-'* || Ж= *'irgen orğa altan, möŋgün, adu'ūsun ide'ēn joli'ā öggüye ke'ēn **abidla'āsu** ülü talbiran, düled türgün-e adalamui* [иргэн оргон, алт мөнгө, адуусан идээгээр золио өгөө хэмээн аргадваас эс тайдхаран улам илүү адгав](MNT 272)

Авлига |abliγ-a|[= ab-liγa] *'авлага'* (анхандаа *'авлага'* гэсэн утга илэрхийлж байгаад хожим хувийн ажил үйлээ бүтээхийн тул бусадад өгдөг хээл хахуулийг нэрлэх болжээ) || Ж= *'uridu qoidu qaučin šin-e* ***abliγ-a*** *buyu'* [урид хойд, хуучин шинэ авлига буюу](Turf. XXII:10) // *'Quyildar-un urug-un urug-a kürtele Quyildar-un tusa-yin tula önečid-ün* ***abliga*** *abun atuγai'* [Хуйлдарын урагийн урагт хүртэл Хуйлдарын тусын тул өнчидийн авлага авч байтугай] (MNT 185) || Kha. *awilaγ*, Bur. *abalga*, Ord. *awɮyn*, Bur. *abalga*

Автобус |autobus|{< Rus. *автобус* < Ger. *autobus*} *'автобууc'* (эргэн тойрон цонхтой, олон суудалтай хүн тээвэрийн машин) || Kha. *awtɒbūs*, Bur. *avtóbus*

Автомат |automat|[= auto-mat]{< Rus. *автомат* < Gr. *αυτο'ματος*} *'автомаат'* (хүний оролцоогүйгээр нарийн үйл ажиллагаа гүйцэдхэдэг машин).

Авч |abači|[= aba- či] *'анчин'* || Ж= *abačin* (Ail.16) // *abači* 'chasseur' (HY M33) || Oir. *awašin*, Oir. *awᵉšⁱ*

Авшиг |abišig|{< Skr. *abhiṣeka*} *'аршаанаар ариудхасан', 'эрх соёрхсон'* (эртний энздхэгт хаан ор суух хүний толгой дээр нь дөрвөн мөрөний уснаас дусааж, магнайд нь энгэсэг түрхэж, төр барих эрх олгож байсан ёслолын нэр) Хожимоо бүддийн сургаалын нууц үндэсийг соносох, номлох, бисалгах эрх олохыг *'авшиг хүртэх'* гэх болжээ || Ж= *'üdter* ***abišig-i*** *ögkü'* [үтэр авшиг өгөх] (Tara 23) // *Gowa dan noyan yekede bayarlaju tabiγ kündülel üyiledüged kew včir-un abičü abču'* [Годан ноён ихэд баярлаж тавиг хүндлэл үйлдээд хий очирын ашиг авч](JT 4a) || х э л ц : *'авшиг авах'* || Kha. *awšig*, Oir. *äwšig*

Авъяас |abiyas|{< Skr. *abhyāsa*} *'мөрөлхи билиг', 'дадал зуршил'* (бусадаас онцгой төрөлхийн билиг чадвар) || Ж= *'buyan-u* ***abiyas*** *qola abču odumui'* [буяны авъяас хол авч одмуй](Sub. IX) || х о р ш : *'авъяас билиг', 'авъяас сонирхол', 'авъяас чадвар'* || Kha. *awyās*, Ord. *awijas*, Bur. *abʲyas*, Ord. *äwäs*

Аг |aγ|{< Tib. *sngags*} *'сэдхэлийг аварах'* (Бурханы шашины хурал номын уншилга залбирал) || х э л ц : *'аг тарнийн ёс'* (бүддийн шашины уншилга, залбиралын ёс жаяг)

Агай |aγai|[= *a-γai] *'байгаа'* (**a* язгуурт дутмаг үйл үгийн одоо цагийн хэлбэр) || Ж= *'imada barilju* ***aγai*** *altan gerege'* [түүнд өргөн барьж байгаа алтан гэрэгэ](Teh. B6-7) // *'te'über barilju* ***a'ai*** *jarliq ökbe'* [тэрвээр барьж байгаа зарлиг өгөв](KMQB. A12a)

Агам |agam|{< Skr. *āgama*} *'бурханы сургаалыг уранаар үгүүлэхүй'* || Ж= *agam yugti nom-ud-tur sayitur daduγsan bi Čosgi-odsir'* [агам юүгти номыг сайтар сурсан Чойжи-Одсэр би](BT 166a)

Агар |agaru|{< Tib. *a ga ru* < Skr. *akaru*} *'анхилуун үнэрт мөнх ногоон мод'* (том бөөрөнхий боргоцойтой, анхилам сайхан үнэртэй халуун мөнх ногоон мод) || Ж= *agaru čindan terigüten čay čay-tur tülekü küjïs-i bariγsan'* [агар зандан тэргүүтэн цаг цагт түлэх хүжисийг барьсан](Burq. 46) || х о р ш : *'агар зандан'* || Kha, Bur. *agar*, Ord. *agur*, Oir. *agʊr*

Агент |agent|{< Lat. *agēns*} *'аагент', 'төлөөлөгч'* (албан даалгавар биелүүлдэг этгээд)

Агентлаг |agentlig|[= agent-lig]{< Eng. *agency* < L. *agentia*} *'аагентлаг', 'үүрэг хүлээсэн байгууллага'* (төр засаг, мэдээлэл зэрэг аль нэгэн байгууллагын өмнөөс үүрэг хүлээсэн гүйцэдхэх байгууллага)

Аги |agi|{< Man. *age*} *'хаан ховүүн'* (Чин уласын үед хаад ноёдын ховүүдийг *'аги'* хэмээн хүндэдхэн нэрлэж байгаад хожим нь *хошой чин ван* цол өргөмжилдөг болжээ.) || Ж= *'Цэрэнгийн хүүхэнийг Чин сүжигт вангийн агид өгөе'* (Д. Нацагдорж, Их авхай) || Kha, Ord, Bur. *agi*, Oir. *äg*[a]

Аглаг |aγlaγ| *'зэлүүд орон', 'буйд газар'* (ном бисалгах аглаг орон) || Cf. AT. *aylaq* 'lonely, uninhabited place' (Starostin, 276), *aylay* 'безлюдный' (Щербак 1997, 94), *aglag* 'уединенный' (Щербак, 2005, 19) || Ж= *'ayay-qa tegimlig-üd joqistu aylay oron sayurin-i olqu boltuγai'* [*аяга-ха тэгимлэгүүд зохист аглаг орон сууриныг олох болтугай*] (BT160a) // *'aylaq kibe tere kü'ünlē'* [я уединился с таким-то человеком](Mu. 96) || х о р ш : *'аглаг зэлүүд'* || х э л ц : *'аглагт суух'* (буйд газар удаан сууж, ном уншиж, бисалгал үйлдэх) || Kha, Bur. *aglag*, Oir. *aglig*

Агниста |aginasda|{< Skr. *akaniśtha*} *'эрхэм дээд'* (дээд таван ариун ороны нэг) || Ж= *'tere dayun ... **aganisda**-dur kürtele sonosdabai'* [тэр дуу ... аганистад хүртэл соносдов](Burq. 26)

Аграмба |aγramba|{< Tib. *sngags ram pa*} *'агарамба', 'тарни дэмнэгч'* (Буддийн шашины жүдийн дацанд 10-15 жил суралцан дамжаа барьж, тарнийн аймагийн номлолд мэргэжсэн хүнд олгодог эрдэмийн дээд зэрэг)

Агроном |agronom|{< Rus. *агроном* < Ger. *αγρονόμος*} *'агарноом'* (газар тариалангийн мэргэжилтэн) || Kha. *agarnōm*, Bur. *agronom*

Агсам |aγsum| *'агсагнан дайрах байдал', 'довтлон тэмүүлэх зан'* || Cf. AT *aχsum* 'drunk', 'stubborn', 'bad-tempered' (Clauson 95), *agsam* 'горячий', 'буйный' (Щербак, 2005, 20) || х о р ш : *'агсам согтуу'* || Kha, Bur. *agsam*, Ord. *agsum*, Oir. *aksʊm*

Агт |aγta| *'хүлэг морь', 'агталсан адуу'* (угтаа агталсан адууг ийн нэрлэж байгаад хожим хүлэг морийн ерөнхий утгыг илдхэх болжээ.) || Cf. Turk. *akta* 'оскопленный' (Радлов I:116), *agta* 'скакун', 'холощенный конь' (Щербак 2005, 20); Man. *akta* 'gelding' (Norman 12) || Ж= *'Činggis qaγan er-e-yi ülü jobaγan aγta-yi ülü kölürgen'* [Чингис хаан эрийг үл зовоон, агтыг үл хөлөргөн] (Hin.16) // *'qarγam sayin **ağta** qatara'ūljʊ'* [хондлой сайт агтыг хатируулж] (MNT 123) // *aqta* 'cheval hongre' (HY M36) // *ahta* 'gelding' (Ras. 204 A-21) || х о р ш : *'агт морь'* || Kha, Bur. *agta*, Ord. *ata*, Oir. *akt*[a]

Агтач |aγtači(n)|[= aγta-či(n)] *'морь маллагч', 'адуучин'* || Ж= *'aγtači Unuγučar'* [агтач Унугучар](ND 28) // *'mori-iān Kököčü **ağtači** da-'ān bari'ū-ljʊ'ūi* [морио Хөхөчү агтачдаа бариулжээ](MNT 188) // *'ağta baritugai, **ağtačin** boltugai'* [агт барьтугай, агтчин болтугай](MNT 124) // *aqtači* 'palefrenier' (Ist. 16)

Агуураг |aγuriγ| х у у ч : *'орд өргөө', 'хүрээ'* || Ж= *'Činggis qahan-u **a'uruγ** Hariltu na'ur-a büle'ei'* [Чингис хааны хүрээ Арилт нуурын эрэгт байв](MNT 136). Энэ үгийг проф. Igor de Rachewiltz *'camp'* хэмээн орчуулсан (*The Secret*

History of the Mongols, 2004, 58) бол академич Д. Цэрэнсодном *'суурин'* (*Монголын нууц товчоо*, 263-264), Ш. Чоймаа *'гэр хүрээн'* (*Монголын нууц товчоо*, 82) гэж буулгасан нь үгтаа адил юм. Мөн профессор F. W. Cleaves 1362 онд Индү вангийн дурасхалд зориулан босхосон хөшөөний бичээст буй *'ayruγ'* гэсэн үгийг дээр дурдсан *'ayurïy'* гэдэг үгийн хувилбар гэж үзжээ. (*The Sino-Mongolian Inscription of 1362 in Memory of Hindu*, HJAS 12, 1949, 87, 112-113)

Агшин |gšan|{< Uig. *kšan* < Skr. *kṣaṇa*} *'агшин'*, *'хором'* (юмс үзэгдэлийн бүтэх, эвдэрэх цаг хугацааны хамагийн бага нэгж. Энэ хугацааг улас үндэстэн өөр өөрөөр тайлбарладаг байна. Энэдхэгүүд нүд нэг ирмэх хугацааг, төвөдүүд хуруугаа инчидэхийн тавны нэг хувьтай дүйцэх хугацааг, монголчууд хуруу инчдэхийн аравны нэг хувьтай тэнцэх хугацааг *'агшин'* гэж үздэг байжээ. Мөн *'Сандуйн жүд'* (Нууц хураангуйн үндэс) хэмээх төвөд сударт хуруугаа нэг удаа инчдэхийн жаран дөрөвний нэг хувьтай тэнцэх хугацааг *'агшин'* гэж тэмдэглэсэн байдаг байна. Орчин үеийн монгол хэлэнд түр зуурын богино хугацааг ийн нэрлэнэ) || Ж= *'Bodistv ger-teče yaruysan tere* ***gšan****-dur tngri-eče čečeg-üd oruǰu'* [Бодисадва гэрээсээ гарсан тэр агшинд тэнгэрээс цэцэгс орж](Burq. 17) // *'inčidqui dayun nigen bolbasu* ***gšan*** *kemeyü'* [нэг инчидхүйн дууг агшин хэмээнэ](Chimeg 42a) || х о р ш : *'агшин зуур'* || Kha. *agšin*, Bur. *agšan*, Oir. *akšṃ*

Ад |ada|{< Uig. *ada* < Skr. *ata*} *'гай тодхор'* (үйлийн үрээр ирэх гай зовлон) || Cf. Turk. ***ada*** 'чорт, злой дух' (Радлов I:477), ***ada*** 'Gefahr' (Gabain 292) || Ж= *'Oločin küregen-i ene* ***ada*** *tülegen-eče aburan tonilyayulun čidaquyu'* [Олочин хүргэнийг энэ ад түлгэнээс аваран тонилгон чадах уу](Chang. 21) // *'ilčin-dür qour* ***ada*** *kürgekügü kemen sedkiǰü'* [элчинд хор ад хүргэх хэмээн сэдхэж](Chang. 32) // *amurliysan sedkil-tü bögetele* ***ada*** *todqod-i ayuyulur-un'* [Махагал амирласан сэдхэлт бөгөөс ад тодхорыг айлгаруун](Maha. B) // *ada* 'malheur envoyé par un espirit' (HY M34) || Проф. F. W. Cleaves *'ada tülegen'* гэсэн хэллэгийн эхний үгийг *'хэцүү бэрх, аюул зовлон'*, дараагийн үгийг *'гай гамшиг'*, *'хор аюул'* гэсэн утгатай гэж үзжээ. (*The Sino-Mongolian Inscription of 1335 in Memory of Chang Ying Jui*, HJAS 13, 1950, 117). Мөн *'qour ada'* гэсэн хэллэгийг F. W. Cleaves *'harm and disaster'* (*The Sixth Chapter of an Early Mongolian Version of the Hsiao Ching, Mongolian Studies*, 17. 1994, 11), W. Fuchs, A. Mostaert нар *'malheur, calamité'* (*Ein Ming-Druck einer chinesisch-mongolischen Ausgabe des Hsiao-ching*, Mon. Ser. 4, 1939/1940, 328) хэмээн орчуулсан нь өөр хоорондоо адил утгатай байна. || х о р ш : *ada tülegen* 'ад түлигэн', *qour ada* 'хор ад', *ada todqur* 'ад тодхор', 'ад зздхэр' // х э л ц : *'ад нөхцөх / ад шүглэх'* (муу үйлд татагдах), *'ад үзэх'* (шооводорлох, гадуурхах) || Kha. *ad*, Ord, Bur. *ada*, Oir. *ad*[e]

Адаг |adaγ| 1. *'хөл'* 2. *'эцэс'*, *'сүүл'*, *'төгөсхөл'* **1.** Эртний монгол, түрэг хэлэнд *'хөл'*-ийг *adaγ* 'адаг' гэсэн утгаар хэрэглэдэг байжээ. || Cf. *adaq* 'нога' (ДТС 8), AT *adak* 'leg', 'foot' (Clauson 45), *adag* 'нога', 'конец' (Щербак, 2005, 19) || Монгол хэлний эртний бичигийн дурасхалуудад *'хөл'* гэсэн утгаар орсон жишээ ганцхан удаа тохиолдож байна. Ж= *'kölgen-ečegen bayuǰu* ***adaγ****-tur inu mörgübei'* [мориноосоо бууж, хөлд нь мөргөв](Burq. 32). Таширамд

дурдахад, эртний монгол хэлэнд *'толгой'*-г *ekin* 'эхин' гэдэг үгээр илэрхийлж байжээ. Монгол хэлэнд *'эх адаггүй'* гэсэн хэлц байдаг нь угтаа *'хөл толгой нь ялгагдахгүй'* гэсэн утгыг илэрхийлж байжээ. **2.** Монгол, түрэг хэлэнд тус үг нь бас *'эцэс', 'сүүл', 'төгөсхөл'* гэсэн утгаар өргөн хэрэглэгдэж байжээ. || Cf. Turk *адак* 'послед ный, самый плохой' (Радлов, I:436) Эдүгээ бидний үед үлдсэн эртний болон дундад үеийн монгол хэлний бичигийн дурасхалд ийм жишээ тохиолдохгүй байгаа боловч XVII зууны зарим сурвалж бичигт *'эцэс, сүүл'* гэсэн утгатай тохиолдож байна. || Ж= *'qabur-un **aday** sara-yin arban qoyar'* [хаварын сүүл сарын арван хоёр] (Asaraγči, 32) || х о р ш : *'адаг сүүл', 'эх адаг'* || х э л ц : *'адагийн наад зах нь'* (at least, in the last resort), *'адагийн амьтан'* (хамагийн муу хүн) || Kha, Bur. *adag,* Ord. *adak,* Oir. *adᵊg*

Адаптер |adapter|{< Rus. *адаптер* < Eng. *adapter* < Lat. *adaptare*} *'адаптар'* (тохируулагч цахилгаан хэрэгсэлийн хүчдэлийг тохируулагч)

Адарт- |adarta| *'хадарах', 'шударах'* || Ж= *'ara'ātu moğai-a **adarta'āsu** adar-qan-i inu bü abulčaya'* [араат могойд хадаруулваас хадараанд нь бүү ороё] (MNT 164)

Адис |adis|{< Skr. *ādisa*} *'аварал', 'ерөөл'* (Бурханы шашины ёсонд богд, дээд ламтан сүсэгтэн хүний зулайд ном судар болон мутараа хүргэж, ерөөл, өршөөл соёрхох үйлийг хэлнэ) || х э л ц : *'адис авах'* (адис хүртэх), *'адис хүртээх'* (адислах || Kha, Ord, Bur. *adis,* Oir. *ädɒs*

Адистид |adistid|{< Skr. *adhiṣṭhita*} *'аварал', 'хишиг', 'соёрхол'* (Бурханы шашины ёсонд бисалгалын хүчээр хамаг амьтаныг ивээн нигүүлсэх оюуны хүч чадал олох үйлийн нэр). Tib. *byin rlabs* 'жинлав' || Ж= *'arban jüg-ün burqan-nuγud-un **adistid'*** [арван зүгийн бурхадуудын адистид](Burq. 2b)

Адмирал |admiral|{< Rus. *адмирал* < Swed. *amiral* < Fr. *amiral*} *'адмираал', 'далай тэнгисийн эзэн'* (усан цэрэгийн дээд командлагч)

Адуус / адгуус |aduγusun|[= aduγu-sun] *'адгуус', 'мал'* (араатан амьтадаас бусад хөхтөн амьтадын ерөнхий нэр) || Ж= *'ödür-tür γurban qošiγun **aduγusun**-u miqabar tabiγlabasu'* [өдөрт гурван хошуу адуусаны махаар тавиглаваас] (Taq.23) // *'aqa-nar de'ü-ner tabu'ūla **adūsun** ide'ē-bēn qubiyaldurun'* [ах дүү тавуулаа мах, сүүн хүнэсээ хуваалцан](MNT 23) // *'ebesün usun-u ǰoqimǰi-bar **adūsun** teǰē'ülü'ēd'* [өвөс усны зохисоор адуу малаа тэжээгээд](KMQB A 27) // *adūsun* 'скотина' (Mu. 96) // *adūsun* 'animals' (Ras.199 B5) || х о р ш : *'adusun ide'ē'* (мах шөл, цагаан идээ), *'адуусан амьтан', 'мал адгуус'* || Kha. adūs, Ord. *adaġūs,* Bur. *adūhan,* Oir. *adūsᵊn*

Адхаг |adqaγ| *'далд муу* санаа' (уридын өш хонзонгоо санаж, хариугаа авах сэдхэлгээ) || Ж= *'**adqaγ** ügei linqu-a bariγsan-a mörgümü'* [адхаггүй линхуа барьсанд мөргүмү](Arj. I) // *'Amaramaγ tngri tabun sumun qarbuγsan dur ... **adqaγ**-un tedüi ber ese bolba'* [Амармаг тэнгэр таван сум харвасанд ... адхагийн төдий эс болов](Chimeg 22b) || Kha. Bur. Oir. *adxag,* Oir. *atxɒg*

Адъяа |adiya|{< Skr. *āditya*} *'наран гараг'* буюу *ням* гараг (гал махбодтой, их хүмүүсийн сүлд гараг. Энэ өдөр шүтээнийг амилуулах, хурим найр хийх, хөрөнгө тавих, эм найруулах үйлд сайн гэж зурхайн сударт заасан байдаг

байна) || Ж= *'Aditiya gergei yügen erijü odıyad'* [Адъяа гэргийгээ эрж олоод] (Chimeg 41b) || Эдүгээ энэ үг зөвхөн хүний нэрд хэрэглэгдэнэ. || Kha. *adiyā*, Oir. *aḍā*

Ажи* |aji| *'ажир-'* гэдэг үгийн уттыг хадгалсан анхдагч язгуур. Энэхүү язгуураас *ajïy* [ajïy] 'ажиг', *ajïra-* [ajïra] 'ажир-' зэрэг үгс үүсчээ.

Ажиг |ajïγ|[= aji-γ] *'ажигла'* гэсэн уттыг хадгалсан үүсмэл үг. Энэ үгээс *ajïγči* [aji-γ-či] 'ажигч', *ajïyla-* [aji-γ-la] 'ажигла-' гэх зэрэг шинэ үг үүссэн байна. || х о р ш : *'сураг ажиг', 'ажиг сэжиг'* || х э л ц : *'ажиг ав'* (сэжиг олж мэдэх) || Kha. *aǰig*, Ord. *aǰik*, Bur. *ažag*, Oir. *aǰ'g*

Ажир- |ajïra|[= aji-ra] *'орших', 'тавтай бай-'* || Ж= *'tede ... Burqan-qaldunnača bawuju geyid-tür iyen ajïraba'* [тэд ... Бурхан халдунаас бууж гэр орондоо саатан суув](MNT 102) // *'Maqamayi qatun ... öber-ün oron-dur-iyan ajïrabai'* [Махамай хатан ... өөрийн орондоо тухлан суув](Burq. 37b) || Орчин цагийн монгол хэлэнд гагцүү үгүйсхэх *-гүй* дагавар авч, *'айлтгүй', 'зоволтгүй'* гэсэн утга илэрхийлдэг. || Ж= *зүгаан дээлтэй хүн өвөлийн хүйтэнд ажирахгүй.* || Kha. *aǰir*, Ord. *aǰira-*, Oir. *aǰ'r*

Ажинай |ajïnai|{< Skr. *ājaneya*} *'өндөр язгуурт', 'сэцэн билигт'* (эртний энэдхэг үлгэр домогт гардаг хүний хэл мэддэг төгөс дээд тэнгэрийн хүлэг) Монгол хэлэнд *'хурдан хөлөг'* гэсэн утгаар хэрэглэгддэг байна. || Ж= *'ajïnai morin-ača anggida sayin morin'* [хурдан хөлөг мориноос өөр сайн морь](Sub. III) || х о р ш : *'ажнай хөлөг'* || Kha. *adžnai*, Ord. *adžinān*

Азар |ajar|{< Skr. *ācārya*} *'номын багш', 'номлогч', 'айлдагч'* (Эртний энэдхэгт ведийн сургаалыг айлдагчийг тийн нэрлэдэг байжээ)

Азарга |ajïrγa| *агтлагдаагүй эр адуу* || Cf. AT *adyïr* 'жеребец' (ДТС 10), *adğir* 'stallion' (Clauson 47), *adyïr* 'жеребец' (Щербак 1997, 94); Man. *ajïrga* 'жеребец' (Цинциус I:17), *ajïrgan* 'a male horse' (Norman, 11) || Ж= *'gegüd qoyar unuyad qoyar nigen ajïrγa'* [гүүнүүд, хоёр унага, хоёр нэгэн азарга](Turf. 54) // *'ajïrğa ge ün čabčilalduju'* [азарга гүү цавчилдаж](MNT 141) // *ajïrqa* 'ėtalon' (HY M34) // *ajïrγa* 'жеребец' (Mu. 97) // *ajïrya* 'ėtalon' (Ist. 15) // *ajïrya* 'жеребец' (IM M119) // *ajirya* 'Testikel habend' (LH 1255) // *ajirğa* 'stallion' (Ras.199 B6) || ш и л ж : *'том', 'бүдүүн', 'хүчтэй'* || Ж= *'азарган чоно'* (бүдүүн чоно), *'азарган бороо'* (ширүүн бороо) || Kha. *adzarʊğʊ*, Ord. *adžarğa*, Bur. *azarğa*, Oir. *aǰirğʊ*

Ази |azi|{< Rus. Азия < Gr. *Ασία*} *'Аз'* (дэлхийн хамагийн том тив)

Азот |azot|{< Rus. *азот* < Gr. *άζωτο*} *'азоот'* (өнгө, амтгүй хий) || Kha. *adzōt*, Bur. *azōt*

Ай- |ayu- /ayi-| *'эмээх', 'түгших'* (эртний монгол хэлэнд энэ утгыг хадгалсан *ayi-*, *ayu-* гэсэн хоёр өөр язгуур байжээ.) || Ж= **1**. *'nigeken ber amitan ülü jobon* ***ayuqui*** *dorumjilaqui ügei boluyad'* [нэгээхэн бээр амьтан үл зовон айх, доромжилох үгүй болоод](BT 158a) // *'amaray sayin eǰen-ečegen anggijiraqui jobalang bolqu bolbau kemen* ***ayuǰu****'* [дотоно сайн эзэнээсээ ангижирахын зовлон болох болов уу хэмээн айж](Burq.12) // *'anda bü* ***ayū****! qata'üǰi'* [анд минь бүү ай! хатууж!](MNT 170) // ***ayuba*** 'ängstigte sich' (LH 1264) || Ж= **2**. *'yayud*

kedi anu buliju tataju abubasu yeke jrly-un yosuyar ülügü ***aiqun'*** [юм хүмийг нь булааж татаж авсан ч их зарлигийн ёсоор үл айх] (Abaga II:14) // *'bi kemen gemšikü-eče ülü* ***aiqu*** *bögesü'* [би хэмээн гэмшихээс үл айх бөгөөс](Sul. 12a) // *tengriyēse* ***ai*** 'побойся тенгри!'(Mu. 347) // *ayiqsan* 'испуганный' (Mu.109) // *aiba* 'бояться' (IM M126) // *ai* 'fear, be afraid' (Zir. 88) || Дундад үеийн монгол хэлний онцлогийг тусхасан араб бичигийн монгол дурасхалд *ayi-* болон түүний хувьсалын үр дүнд үүссэн *aï-*гийн аль аль нь тохиолдож байна. Харин МНТ болон дөрвөлжин бичигийн дурасхалуудад зөвхөн *ayu-* гэсэн язгууртай тохиолдож буй. Дундад үеийн монгол хэлний сүүлч үеэс *ayu-* нь бичигийн хэлэнд, *ai-* {< *a'i-* < *ayi-*} гэсэн нь амид хэл аялгуунуудад хэрэглэгдэх болсон байна. Энэхүү язгуураас *ayidas* [ayi-das] 'айдас', *ayilya-* [ayi-lya] 'айлга-', *ayumsiy* [ayu-msiy] 'аймшиг', *ayumaqai* [ayu-ma-qai] 'аймхай', *ayul* [ayu-l] 'аюул' гэх мэт нилээд олон шинэ үг үүсчээ. || х о р ш : *'айж ичих', 'айж сандарах', 'айж цочих', 'айж эмээх'* || Kha. *aī-*, Bur. *aj-*, Ord, Oir. *ā-*

Ай II |ayi|{< **ayï*} *гарал, угсаа нэгтэй 'ayil', 'ayimay'* гэсэн үгсийн утгыг хадгалсан анхдагч язгуур.

Ай-кю [ai kiyu]{< Eng. IQ (*Intelligence Quotient*)} *'айкүү', 'оюуны чадамжийн хэр хэмжээ'* (хүний ой тогтоолт, сэтгэхүйн хурд, гүйлгээ ухааны түвшинг тусгай үзүүлэлтээр тогтоох арга)

Айл |ayil|[= ayil-]{< *ayïl*} *'гэр', 'хөрш оршин суугчид', 'өрөх', 'орон байр'* || Cf. *ayïl* (ДТС 18), *ail* 'юрта', 'деревня' (Радлов, I:33), *ajl* 'семья' (Щербак 2005, 20) || Ж= *'ailun tedüi* [гэрийн төдий](Alt.24a) // *'Temüjin-i ...* ***ayīl****-dur nigen qono'ūlun, bitü'ūlün yabu-qui-dur* [Тэмүжинийг ... айлд нэг хонуулан нууж явахауйд](MNT 81) // *'****ayil****-un tedüi kegeli-tü'* [гэрийн чинээ гэдэстэй] (Turf. 6) Энэхүү үгээс *ayilčila-* [ayi-l-čila] 'айлчил-', *ayilčin* [ayi-l-čin] 'айлчин', *ayilla-* [ayi-l-la] 'айллах' гэх зэрэг үгс үүсчээ. || х о р ш : *'айл амьтан', 'айл гэр', 'айл хөрш', 'айл саахалт', 'айл аймаг', 'айл хунар'* || Kha, Bur. *ail*, Ord, Oir. *āl*

Айлд- |ayilad| *'үгүүлэх'* (ихэс дээдэс, лам ноёд сургаал үгээ хайрлах) Энэ үгээс *ayiladburi* [ayilad-buri] 'айлдвар', *ayiladqa-* [ayilad-qa] 'айлдха-', *ayilad-qal* [ayilad-qa-l] 'айлдхал' гэх зэрэг үгс үүсчээ. || Kha. *aildɒ-*, Ord. *ālldχa-*, Bur. *ailada-*

Айлдха- |ayiladqa|[= ayilad-qa] *'өргөн мэдээлэх'* (хаад ихэст санал хүсэлээ илэрхийлэн мэдүүлэх)

АйИЛТС [ailtes]{< Eng. IELTS (International English Language Testing System) *'айлтэс', 'англи хэлний олон улсын хэмжээний сорил'* (англи хэлний мэдлэгийн түвшин тогтоох тусхай сорил)

Аймаг |ayimay|[= ayi-may]{< **ayï-may*} *'угсаатаны холбоо', 'гарал нэгтэн', 'засаг захиргааны нэгж', 'хэсэг бөлөг'* || Cf. Turk *aimak* 'народ', 'род' (Радлов, I:25), Uig. *aymaq* 'tribe' (Schwarz 38), Man. *ajmak* 'племя' (Цинциус I:22), *aiman* 'tribe' (Norman, 9) || Ж= *'qayaly-a sakiysan dörben* ***ayimay*** *čerig-üd'* [хаалга сахьсан дөрвөн хэсэг цэрэг](Burq.21b) // *'dayisun-u arban qoyar* ***ayimay*** *čerig-i Bandu terigüten-e daruydajuyui'* [дайсаны арван хоёр аймаг цэргийг Банду тэргүүтэнээ дарагджээ](Sub.VI:15a) // *'ta ede ele či'ūlugsad haran bügüde'ēr*

ayïmaḳ ayïmaḳ *bayïd-qun'* [энд цугларсан та бүгэд аймаг аймагаараа байгтун] *(MNT 154) // aimaq* 'tribu' *(HY M34)* || х о р ш : *'овог аймаг', 'айл аймаг'* || Kha, Bur. *aimag,* Ord. *ǎmak,* Oir. *ǎmvǧ*

Аймас- |ayimas|[= ayimas] *'зэвүүцэх', 'хилигнэх'* || Ж= *'ulus-un eǰen* ***ayimasbasu*** *ber bayasqu-lang-iyar imadur šitüǰü'* [уласын эзэн хилигнэвээс баясхалантайгаар түүнд шүтэж](Sub. VIII:5a) *// 'yeke köbegün-diir* ***ayimasqu*** *ary-a-yi eriye kemen eyeteldüǰü'* [их хүвүүнд аймасах аргыг эрэе хэмээн эетэл-дээд] *(Chimeg 6/7b)*

Айраг |ayiraγ| *'исхэж боловсоруулсан сүү'* || Cf. Turk. *airan* 'питье, приготовляемое из кислого коровья молока' (Радлов, I:25), *airān* 'butter milk' (Clauson 276), *ayran* 'fermented milk' (Schwarz 36), *ajran* 'kumys' (Starostin 280), *ajran* 'напиток из кислого молока' (Щербак 1997, 95), *ajrag* 'кислое молоко' (Щербак 2005, 20) || Ж= *ayiraq* 'lait de chamelle' *(HY M38) // airan* 'mare's milk' *(Ras. 187 C26)* || х о р ш : *'айраг арих', 'айраг сархад', 'айраг цагаа'* || Kha, Bur. *ajrag,* Ord. *ǎrəg,* Oir. *ǎrvǧ*

Ай-Ти [ai ti]{< Eng. IT (*Information Technology*)} *'айти'* (мэдээлэлийн технологи)

Ай-Эс-Би-Эн [ai-es-bi-en]{< Eng. ISBN (*International Standard Book Number*)} *'олон улсын стандарт номын дугаар'* (хэвлэгдэн гарч буй номыг нэгдмэл тогтолцоогоор бүрдхэх стандартчилал)

Ай-Эс-О [ai-es-o]{< Eng. ISO (*International Organization for Standardization*)} *'Олон улсын Стандартын Байгууллага'*

Академи |akademi|{< Rus. *академия* < Pol. *akademia* < Gr. *ακαδεμία*} *'академий'* (эрдэм шинжилгээний үйл ажиллагааг удирдах дээд байгууллага) || Kha, Bur. *aimag,* Ord. *ǎmăg*

Акварium |akvariüm|{< Rus. *аквариум* < Lat. *aquārium*} *'аквариуум'* (усны амьтан үзүүлэх шилэн сав) || Kha. *akvāŕūm,* Bur. *akvarium*

Аккредитив |akreditiv|{< Fr. *accresditiff* < Lat. *accreditivus*} *'акардитийв', 'итгэмж'* (банк хоорондын мөнгөн гүйлгээ тооцооны батламж бичиг)

Акробат |akrobat|{< Rus. *акробат* < Fr. *acrobate* < Gr. *ἀκροβάτης*} *'акарбаат', 'утасан дээгүүр явагч'* (циркийн хүнд хэлбэрийн үзүүлбэр)

Акт [akt]{< Rus. *акт* < Lat. *actus*} *'аахт'* (албан ёсны баримт бичиг)

Акци |akci|{< Fr. *action*} *'аахц', 'үнэт цаас'* (хувь нийлүүлсэн компанийн үйл ажиллагаанд оролцох эрх олгодог үнэт цаас)

Ал I |al|{< Uig. *al* < Pers. *āl*} *'хурц улаан'* || Cf. Turk. *al* 'алый' (Радлов, I:25), *al* 'ярко-красный' (ДТС 31) || Ж= *'altan büse-yin ǧorki-dača,* ***al*** *de'ël-ün hürtesün-eče'* [алтан бүсийн аралаас, улаан дээлийн тасархайгаас](MNT 238) *// al* 'vermeil' *(HY M34) // 'imada bariju ayai altan gerige* ***al*** *tamyatai'* [түүнд барьж буй алтан гэрээ улаан тамгатай](Teh. b7) || Kha, Bur, Oir. *al*

Ал II |al / ala| *'салтаа', 'алцаа'* || Cf. Turk. *ala* 'внутреняя часть штанов' (Радлов, I:351), **āl* 'lower side' (ЭСТЯ 1, 214-215) || Ж= *'****Ala****-dur ši'ēgte-eče altan bosoǧa-dur činu aǰu'* [салтаандаа шээгтэй байхаасаа аваад алтан босгонд чинь байж](MNT 203) || Энэхүү язгууpаас *alča* [al-ča] 'алц' гэсэн үүсмэл

язгуур үүсч, уламаар түүнээс *alčaγ-a* [al-ča-γ-a] ‘алцаа’, *alčaγana-* [al-ča-γana] ‘алцгана-’, *alčaγar* [al-ča-γar] ‘алцгар’, *alčayi* [al-ča-yi] ‘алцай’, *alčan* [al-ča-n] ‘алцан’ гэх мэт үгс үүссэн байна. Энэ үг нь орчин цагийн аман ярианы хэлэнд эр, эм бэлгийн ерөнхий нэр болжээ. || Kha. *al,* Bur. *ala,* Oir. *alᵇ*

Алаг |alaγ|{< ala-γ} *‘өөр өөр өнгө хослосон’* || Cf. Turk. *ala* ‘полосатый’, ‘пестрый’ (Радлов I:25), *ala* ‘пегий’ (ДТС 31), PA **āla* ‘variegated’ (Starostin 291); *ala* ‘пестрый’ (Цинциус I:27) || Ж= *‘mingyan **alaγ** aduyun tüberege inü yaǰar ködegelekü’* [минган алаг адууны төвөргөөн нь газар хөдөлгөхүй](Bod. 20b) // *‘**alaγ** bulaγ önggeten’* [алаг булаг өнгөтөн](Burq. 55) // *‘bö’ēre **alaǧ** hüker köllejü’* [бөөр алаг үхэр хөллөж](MNT 100) // *alaq* ‘ta’un corbeau à cou blanc’ (HY M34) // *ala* ‘пегий’ (Mu. 97) // *ala* ‘пестрый’ (IM M122) // *ala* ‘grappled’ (Ras. 187 C6) / *alaq* ‘leprous’ (Ras. 204 A15) || х о р ш : *‘алаг эрээн’, ‘алаг булаг’* || Kha, Bur. *alag,* Ord. alak, Oir. *alᵇg*

Алангир |alangir| х у у ч : *‘харгай модон нум’* || Ж= *‘te’ün-ü qoyīna qabur **alaŋgir** numutan qarbiyāldun bükü-dür’* [Түүнээс хожим хавар нь алангир нумтан харвалдан байхуйд](MNT 116)

Алархай үз **Налархай**

Алачуг |alačuγ|{< Pers. *alāchiq* ‘felt tents’ (Steingass, 91)} х у у ч : *‘урц’, ’овоохой’* (модны холтосоор барьсан овоохой) || Cf. Turk. *alačyk* ‘юрта из коры’, ‘шалаш из ветвей’ (Радлов, I:362) Мөн умард Кавказад оршин суугч татарчуудын хэрэглэдэг байсан эсгий бүрээстэй мухлаг тэрэгийг *alačuq* гэдэг байжээ. || Ж= *‘adu’učin bidan-u **alačuq-a** kürtügei’* [адуучин бидний урц гэрт очтугай](MNT 118)

Алба(н) |alba(n)| х у у ч : *‘матвар’* (Юань гүрэний үед жирийн албатууд албан журамаар төлдөг байсан мал сүрэг, аму тариа. Чин уласын үед тогтмол авдаг татварыг ийн нэрлэх болжээ. Орчин үед төрийн өмөнөөс хариуцлага хүлээдэг аливаа ажил үүрэгийн нэр болжээ) || Cf. Man. *alban* ‘tax’, ‘duty’ (Norman, 12); Turk. *alba* ‘принуждение’, ‘насилие’ (Радлов, I:432) || Ж= *‘toyid erkegüd šingšingüd dašmad aliba **alba** γubčiri ülü üǰen’* [тойд, эрхүүд, шиншингүүд, дашмад аливаа алба гувчуур үл үзэн](Khub. I) // *‘**alba** ǰasaγ ulaγ-a šigüsü’* [алба засаг, улаа шүүс](Turf. 21) // *‘ulus-un **alban**-i qabčisuγai’* [уласын албыг хаасугай](ET 48a) || Энэ үгээс *albada-* [alba-da] ‘албад-’, *albaǰi-* [alba-ǰi] ‘албаж’, *alban* [alba-n] ‘албан’, *albarqa-* [alba-rqa] ‘албарх-’, *albatu* [alba-tu] ‘албат’ гэх мэт шинэ үгс үүсчээ. Академич Б. Я. Владимирцов энэ үгийг якут хэлний *al-* ‘авах’ гэсэн язгуураас үүссэн гэжээ. (Б. Я. Владимирцов, *Общественный строй монголов. Монгольский кочевой феодализм,* ‘Работы по истории и этнографии монгольских народов’, М., 2002, 452) || х о р ш : *‘ажил алба’, ‘алба матвар’* || х э л ц : *‘алба хаа- / алба хаш-’* (албан ажил үүрэг гүйцэдхэх) || Kha, Oir. *albă,* Bur. Oir. *alwᵽ*

Албат |albatu| *‘харъяат иргэн’* || Ж= *‘**albatu** ulus činu elbeg boltuγai’* [албат улас чинь элбэг болтугай](ET 35b) // *‘noyad anu **albatu** köbegüd-iyen ... dayu-daǰu’* [ноёд нь албат хүвүүдээ ... дуудаж](QJ 16a)

Албин |albin| *'чөдхөр', 'хорон санаа'* || Ж= ***'ablin-a eliy-e-de kürtegsen kümün'*** [ал чөдхөр шүтлэсэн хүмүүн](Sub. II:2) || х о р ш : *'албин чөдхөр'* || Kha. *alʹbin*, Ord. *albiŋ*, Bur. *alʹiban*, Oir. *ălwin*

Алгебра |algebra|{< Rus. *алгебра* < Pol. *algiebra* < Ger. *Algebra* Lat. *algebra*} *'айлгэбер', 'томьёоны ухаан'* || Kha. *ālgebār*, Bur. *álgebra*

Алгинч |alginči|[= algin + či]{< * alïn} х у у ч : *'толгойн харуул'* || Cf. Turk. ***alïn*** 'лоб' (ДТС 35) || Ж= *'Bodončar* ***alginčin*** *ha'ulqaba'* [Бодончар толгойн харуул болон дайрав](MNT37) Монгол хэлний бичигийн дурасхалд нэн ховор тохиолддог энэ үгийн утгыг N. Poppe *'vanguard'* (*On Some Military Terms in the Yüan ch'ao pi-shih*, Mon. Ser. 26, 1967, 509), Igor de Rachewiltz *'scout'* (*The Secret History of the Mongols*, I. 2004, 7) хэмээн орчуулжээ. Энэ үгээс *alginčila-* [algin-či-la] 'алгинчил-' гэсэн нийлмэл бүтэцтэй шинэ үг үүсчээ.

Алгинчил- |alginčila|[= algin-či-la] *'манлайлах', 'тэргүүлэх'* || Ж= *'Jebe, Qubilai qoyar-i* ***alginčilaǰu****, yabu'ad Sa'āri-ke'ēr-i kürü'ēsü'* [Зэв, Хубилай хоёр тэргүүлэн явж, Саарь-хээрт хүрвээс](MNT 193)

Алгоритм [algoritm]{< Rus. *алгоритм* < Lat. *algorismus*} *'алгарийтем'* (тодорхой тогтоосон нарийн дараалал бүхий үйлдэлийн дагуу хариу шийдэл гаргаж авах багц үйлдэл)

Алд |alda| *'дэлгэсэн хоёр гарын уртын хэмжээ'* (нэг алд нь таван тохойтой тэнцэнэ. 360 алд нь нэг *'газар'* болно.) || Cf. Man. *andan*, Ul. *alda*, Nan. *alda* || Ж= *'ǧurban* ***alda*** *beyetü, ǧunaǰin bodo idešitü'* [гурван алд биетэй, гунажин бодын идэштэй](MNT 195) // *alda* 'сажень' (Mu. 98) // *niken alda* 'une brasse' (Ist. 16) // *niken alda* 'one fathom' (Ras.201 C23) || х о р ш : *'алд дэлэм'* || Kha. *aldʊ*, Ord, Bur. *alda*, Oir. *aldᵒr*

Алдар |aldar| *'суу билиг', 'өндөр нэр хүнд'*. Энэ үгээс *aldarsi-* [aldar-si] 'алдарш-', *aldarsiyul-* [aldar-si-] 'алдарш-', *aldartu* [aldar-tu] 'алдарт' зэрэг үг үүсчээ. || Ж= *'uridus-uγan nere* ***aldar****-i yutuγdaqui-ača emiyekü-yin tula'* [уридасынхаа нэр алдарыг гутаагдахаас эмээхийн тул](Taq. 33a) // *'aldar nere yeketei, Alan-ǧo'ā neretei'* [алдар нэр ихтэй, Алан гоа нэртэй](MNT 7) || х о р ш : *'алдар гавъяа', 'алдар нэр', 'алдар хүнд', 'алдар суу'* || Kha, Ord, Bur. *aldar*, Oir. *aldᵒr*

Т у с х а й с у д а л г а а : F. W. Cleaves, *'Aldar čab ~ čab aldar'*, HJAS18, 1955, 221-233

Алдарт |aldartu|[= aldar-tu] *'суут', 'өндөр хүндэт'* || Ж= ***'aldartu*** *Činggis qaγan-u jirγudaγar üy-e'* [алдарт Чингис хааны зургаадугаар үе](BT 166b)

Алдарш- |aldarsi|[= aldar-si] *'нэр нь олоноо түгэн мандах'* || Ж= *'ečige eke-yin sedkil-i amuγulqui sayin ner-e-yi* ***aldaršiγulqui'*** [эцэг эхийн сэдхэлийг амараах сайн нэрийг алдаршуулахуй](Taq.28b) // *'merged sayin-u aldar inu bükü arban jüg-tür* ***aldaršituγai'*** [мэргэн сайны алдар нь бүх арван зүгтээ алдарштугай](BT 161a)

Алжаа- |alǰiya|[= alǰi-ya] *'зүдэрэх', 'зовох', 'ядарах'* || Ж= *'degedüs-ün sedkil ber* ***[a]lǰaγaǰu*** *čerigüd-iyer dayin aran-i bariγuluγad'* [дээдэсийн сэдхэл алжааж, дайсан этгээдийг цэрэгээр бариулаад](Chang. 53) // *'čima-dača* ***alǰiyā-qui****-ača*

ayūjū' [чамайг зүдэрэхээс айж](MNT 145) || Энэ үгээс *aljiyal* [alji-yal] 'алжаал', *aljiyangyui* [alji-ya-ŋyui] 'алжаангуй', *aljiyas* [alji-ya-s] 'алжаас' гэх мэт үгс салбарлан гарчээ. || Kha. *aldžā-*, Bur. *alžā*

Алжаангуй |aljiyangyui|[= alji-ya-ŋyui] *'ядарангуй', 'зүдэрэнгүй'* || Ж= *'elinčüg inü qar-a yiuǰing ebedčin kürteǰü* ***alǰangyu*** *boluɣsan-dur'* [элэнц нь хар йиүжин өвчин хүртэж зүдэрэнгүй болсонд](Hin. 18) || Kha. *aldžāŋ̄gui*

Алжаас |aljiyas|[= alji-ya-s] *'бууруу', 'осол гэм'* || Ж= *'erdem-i* ***alǰiyas*** *suruɣsan aran jöb suruɣsan-i dorumǰilayu'* [эрдэмийг бууруу сурсан хүн зөвийг сурсан хүнийг доромжилно](Sub. III:6) // *'ulus-un ejen qahān bö'ētele yosu ügei* ***alǰi'ās*** *üyile-dür dölesgekü minü nigen buru'ū ene bolba je'* [уласын эзэн хаан бөгөөтөл ёсгүй бууруу үйлд татагдах минь миний нэг бууруу болой](MNT 281) // ***alǰāstu*** *adalitqaba tūni* [приписал его ошибке](Mu. 99) || Kha. *aldžāl*

Алжи* |alji/alja| *'алжаах', 'алзах'* гэсэн утгыг хадгалсан язгуур. Энэхүү язгуураас *alǰiya* [alji-ya] 'алжаа-' гэсэн үг үүсчээ.

Алз |alja| *'алдах', 'эндэх'* || Ж= *'tendeče uɣubasu yayu* ***alǰaqu*** *ta kem/e/be'* [та тэндээс уувал юу алзах хэмээв](Sul.11b) || Энэ үг орчин цагийн монгол хэлэнд биеэ даан идэвхитэй хэрэглэгддэггүй, гагцхүү *-гүй* дагавар авч *'айлтгүй', 'ажирахгүй'* гэсэн утгыг илэрхийлдэг

Алигали |aligali|{< Skr. *aligali*} *'галиг'* (эртний энэдхэг хэл зүйн бичиг дэх *'а тэргүүтэн эгшиг,* ***ga*** *тэргүүтэн гийгүүлэгч'* гэсэн үгийн товчилол. Энэ нь уггаа бүх үсэгийг галиглан буулгасан *'цагаан толгой'* гэсэн утгыг илэрхийлж байжээ)

Алим |alim-a|{< Turk. *alma*} *'алим'* (их төлөв улаан, шар өнгөтэй, амтлаг, шүүслэг жимэс) || Cf. Turk. *alma* 'яблоко' (Радлов I:436), AT *alma* 'яблоко' (ДТС 36), *alma* 'apple' (Clauson 146), Uig. *alma* 'apple' (Schwarz 47) || Ж= *alima* 'poire' (HY Most 35) // *alma* 'яблока' (IM 432, IM M123) // *alima* 'apple' (Ras.202 B3) || х о р ш : *'алим жимэс'* || Kha. *alim*, Ord. *alima*, Oir. *al'mᵘn*

Алмаас |almas|{< Uig. *almas* < Pers. *almaz* < Gr. *ἀδάμας*} *'алмааз', 'эвдэршгүй'* (хамагийн хатуулаг эрдэнийн чулуу) || х о р ш : *'очир алмас', 'алмас эрдэнэ'* || Kha. *almās*, Bur. *almáz*, Oir. *almɒs*

Алмарад |almurad|{< *al* 'улаан) + Arab. *murād*} *'алмараад'* (ороонгын төрөлд багтах уданборын жимэс)

Алмас |almas|{< Arab. *almās*} *'алмас' (цасны хүн)'* || Kha, Ord. *almas*, Oir. *almɒs*

Алмуур |almaɣur|[= alma-ɣur] *'маяг'* (дээд талдаа хөндөлөвчтэй урт суга таяг)

Алоэ |aloe|{< Rus. *алоэ* < Ger. *Aloe* < Gr. *ἀλόη*} *'алой', 'зүүн настын шүүс'* (хурц өргөст навчтай кактусын төрөлийн модлог ургамалын шүүс)

Алт(н) |alta(n)| 'шар өнгөтэй үнэт метал' || Cf. Turk. *altyn* 'золота' (Радлов I:405) || Ж= *'bars terigütü* ***altan*** *gerege ögči'* [барын толгойтой алтан гэрэгэ өгч](Chang 35) // *'nigen* ***altan*** *süke tabun menggü süke basa qorin qibutan törges ögügsen ajuɣu'* [нэгэн алтан сүх, таван мөнгөн сүх, бас хорин хив торго өгсөн ажээ](Jig. 29) // *'* ***altan*** *büse jamuqa anda-da büsele'ūlbei'* [алтан бүс Жамухад

бүслүүлэв](MNT 117) // *altan* 'золота' (Mu. 99) || х о р ш : *'алт монгө', 'алт эрдэнэ'* || Kha. *altā*, Ord, Bur. *alta*, Oir. *altɔn*

А.ш |alča|[= al-ča] *'алчайх'* гэсэн утгыг хадгалсан үүсмэл язгуур. Энэхүү язгуураас *alčaya* [al-ča-ya] 'алцаа', *alčayar* [al-ča-yar] 'алцгар', *alčan* [al-ča-n] 'алцан', *алчай-* [al-ča-yi] 'алцай' гэх мэт үгс үүсчээ.

Алчай- |alčayi|[= al-ča-i] *'хөлөө хоёр тийш тэлэх'* || Ж= *'jarim-ud anu gedergü unaju alčayiqun terigüten eldeb jigergemšig-i üjejü'* [зарим нь гэдэргээ унаж алцайх зэрэг элдэв гайхамаарыг үзэж](Burq. 17b) || Kha. *altsai-*, Ord. *altš'ā-*, Bur. *alsai-*, Oir. *altšā-*

Алчуур үз **Арчуур**

Альбом |alibom|{< Rum. *альбом* < Fr. *album* < Lat. *album*} *'альбоом'* (зурагийн цомог) || Kha. *ál'bōm*, Bur. *alībōm*

Ам(ан) |am(an)| 1. 'идэж, уух эрхтэн' 2. *'амсар', 'завсар', 'сүв'*. 3. *'үг хэл'* || Ж= **1.** *'aman-ača šilüsün čuburiqun'* [амнаас шүлэс цуварах](Burq. 1b) // *'barsun aman-ača tonilju yaruyad'* [барын амнаас сугарч гараад](Chang 43) // *'aman čaγān qula'* [ам цагаан хул](MNT 147) // *aman* 'рот' (Mu. 99) // *aman* 'рот' (IM 432) *aman* 'bouche' (Ist. 16) // *aman* 'bouche' (HY M35) // *aman* 'Mund' (LH 1257) // *aman* 'mouth' (Ras.198 C27) // *aman* 'mouth' (Zir. 85) || Ж= **2.** *'qourtu mayui jayayan-u aman-dur oruysan amitan'* [хорт муу заяаны аманд орсон амьтан](Bod. 12a) // *'qamuγ-iyar γaγča ükül-ün aman-dur orumui'* [бүгэдээрээ гагц үхэлийн аманд ормуй](Burq. 5b) || Ж= **3.** Ж= *'aman aldan ögülegsen-i Sudadani qayan sonosču'* [үг алдан үгүүлсэнийг Сударани хаан соносч](Burq. 13a) // *'jrlγ nom-ud-i sonosqui kiged amaγar uriqui sayitur delge-retügei'* [зарлиг номуудыг соносхуй хийгээд амаар уншихуй сайтар дэлгэртүгэй](BT 158b) || Энэ үгээс *amada-* [ama-da] 'амд-', *amayai* [ama-γai] 'амгай', *amala-* [ama-la] 'амла-', *amančir* [ama-nčir] 'аманцар', *amsa-* [am-sa] 'амс-', *amasar* [ama-sar] 'амсар', *amta* [am-ta] 'амт' зэрэг мэт үгс үүсч, уламаар тэдгээрээс цааш нийлмэл бүтэцтэй олон үг үүссэн байна. || х о р ш : *'ам бул', ам өрх', 'ам өчиг', 'ам хамар'* // *'нүүр ам', 'хэл ам'* // *'аман зохиол', 'аман хуур', 'аман хүзүү'* || х э л ц : *'ам авах'* (амлалт хийлгэх), *'ам алдах'* (далд санаагаа санамсаргүй хэлэх), *'ам ангайх'* (үг хэлэх), *'ам асуух'* (тавлах), *'ам булаалдах'* (өрсөлдөн ярих), *'ам бузарлах'* (бүтэхгүй зүйлийг хүсэх), *'ам гарах'* (амлалт өгөх), *'ам дагах'* (хэлсэн үгийг биелүүлэх), *'ам зөрөх'* (хэрэлдэх), *'ам муруйх'* (маргалдах), *'ам нийлэх'* (санаа нийлэх), *ам нээх* (үг хэлэх), *'ам өгөх'* (амлах), *'ам таглах'* (хариу хэлэх аргагүй болгох), *'ам уралдах'* (өрсөлдөн ярих), *'ам хаах'* (амласан ажилаа ор нэрийн төдий хийх), *'ам халах'* (халуун яриа өрнүүлэх), *'ам хатах'* (цангах), *'ам хүрэх'* (амсах) // *'амаа алгадуулах'* (өнгөрсөн хойно нь харамсах), *'амаа ангайх'* (гайхах) *'амаа барих'* (харамсах), *'амаа билүүдэх'* (хов жив ярих), *'амаа татах'* (ярихаа зогсоох), *'амаа удэх'* (ярихгүй байх), *'амаа хамхих'* (үгээ хэлэхгүй чимээгүй суух), *'амаа хөдөлгөх'* (юм идэх) || н и й л : *'амны бэлгэ'* (сайхан зөгнөл), *'амны гарз'* (биелэхгүй зүйлийн тухай гуйх), *'амны уншилга'* (нэг зүйлийг дахин дахин ярих) *'амны хишиг'* (өндөр хувь заяа), || Kha. *amā*, Ord, Bur. *ama*, Oir. *amᵘn*

Амагалан |amuγulang|[= amu-qu-lan] *'амар тайван'* || Ж= *'nasuda* ***amuγulang-a*** *amiduraju ükübei dayun büü sonostuγai'* [насандаа амагалан амьдарч үхэлийн дуу бүү соностугай](ВТ 156b) // ***'amuγulang*** *Jögelen degedü kümün-i mayui aran düledte maši könügemüi'* [амагалан зөөлөн дээд хүнийг муу хүн маш халбараар хөнөөмүй](Sub. V) // *amuqulang* 'tranquillité, paix' (HY M35) // *ene amūlan* 'это отдых' (Mu. 155) Энэ үг авианы түүхэн хувьсалынхаа дагуу эдүгээ *amūlaŋ* 'амуулан' гэж дуудагдах ёстой боловч бичигийн хэлний тогтсон уламжилалаар *amagalaŋ* 'амагалан' хэмээн хэлэгдэж буй. || х о р ш : *'амагалан тайван', 'амар амагалан', 'тувшин амагалан', 'энх амагалан'* || Kha, *amağalaŋ,* Ord. *amugulaŋ,* Bur. *amğalaŋ,* Oir. *amğülŋ*

Амар |amur|[= amu-r] *'амарах'* гэсэн утгыг хадгалсан үүсмэл язгуур || Cf. *amul* 'смирный' (ДТС 42), *amul* 'quiet', 'peaceable', 'even-tempered' (Clauson 160), *amul* 'спокойный', 'тихий' (Щербак 1997, 98) || Ж= *'yirtinčü dekin ber* ***amur*** *sayid boltuγai'* [ертөнц дахин амар сайн болтугай](ВТ 158a) // *'baγsi ridi qubilγan-iyar qur-a oruγulju bey-e-dür dusuγsan-iyar yali* ***amuraba****'* [багш риди хувилгаанаар хур оруулж, биед дуссанаар яли амарав](Chimeg 5a) // *amuraba* 'спокойствие' (IM 432) // *amuraba* 'покоится', 'отдыхать' (IM M123) || Энэхүү язгуураас *amurji-* [amu-r-ji] 'амарж-', *amurli-* [amu-r-li] 'амарли-' зэрэг үйл үгс салаалан гарч, бие даасан үг болжээ. || х о р ш : *'амар амагалан', 'амар жимэр', 'амар мэнд', 'амар сайн', 'амар тувшин', 'амар хилбар'*

Барагшин |baruγšun|{< Tib. *brag zhun*} *'хадны хайлмаг давирхай'* (хаднаас ургадаг олон төрөлийн органик нэгдэл бүхий өдхөн давирхай) || Kha. *barag-šiŋ,* Ord. *baraǧšān*

Барам |baram|{< Tib. *par ma*} *'чөдхөр'* (гүрэм хийхэд зориулан гурилаар хийсэн ад чөдхөрийн бэлгэдэл дүрс) || Ж= ***barama*** *'wretched'* (Ras. 203 C15)

Баранзад |baranǰad|{< Tib. *bar mdzod*] *'баранзад хадаг'* (Өлзий хутагийн найман тэмдэгтэй, хамар угалз хээтэй, шашины зан үйлд хэрэглэдэг хоёр алд урт хүндэдхэлийн хадаг)

Барел |barrel{< Rus. *баррель* < Sp. *barril*} *'барээл', 'морх'* (159 литертэй тэнцэх шатахууны хэмжүүр)

Баргиад үз **Бригад**

Баринтаг |barintaγ| 1. ихэс дээдэсийн хувцасны хүндэдхэл 2. *ном судар боодог даавуун ваадан* || Ж= *'бараан авдараа уудалж* ***баринтагт*** *номуудыг*

гаргав' (Ц. Дамдинсүрэн, Балбар дархан) || Kha. *bariŋtag,* Ord. *barintak,* Oir. *bär'mtag*

Бармен |barmen|{< Eng. *bar + men*} *'бармэн'* (баар, рестораны танхимд түгээх арих, дарасны хэмжээ, жорыг тохируулагч)

Бармид |baramid|{< Uig. *baramid* < Skr. *pāramitā*} *'чинад хизгаарт хүрэхүй', 'тогөс тогөлдөр'* (бурханы мөрт хүрэх сайн үйлийн нэр. Буддийн номлолд *'өглөг бармид', 'шагшаабад бармид', 'хүлцэнгүй бармид', 'хичээнгүй бармид', 'дияан бармид', 'билиг бармид', 'аргын бармид', 'ерөөлийн бармид', 'хүчний бармид', 'бэлгэ билигийн бармид'* гэсэн арван бармид байдаг ажээ. || Ж= *'Asangki galab-ud-tur jirγuγan* ***baramid****-i bütügen'* [зургаан бармидыг бүтээн] (Burq. 19) || Kha. *barmid,* Oir. *bärāmәd*

Барс |bars|{< Uig. *bars* < Pers. *pārs*} *'бар'* (муурын бүлэгийн эрээн зүстэй хүчирхэг том араатан) || Ж= ***'bars*** *terigütü altan gerege ögčü'* [барсын толгойтой алтан гэрэгэ өгч](Chang. 35) // *'ölösügsen* ***bars****-un kürkiregüi dayun-iyar bečin modun-u oqi-ača unaǰuγui'* [өлөссөн барын хүрхэрэх чимээгээр сармагчин модны оройгоос унах](Sub.IV:1b) // *'bariǰu ülü sa'āraqu* ***bars*** *metü'* [барьж үл саарах барс мэт](MNT 78) // *bars* 'tigre' (HY M39) // *bars* 'тигр' (IM 433) // *bars* 'тигр' (Qaz, Po 201) // *bars* 'Panther' (LH 1265) // *bars* 'tiger' (Ras.199 C10) // *pars* 'tigre' (Ist. 61) || х о р ш : *'бар арслан'* || Kha, Ord, Bur. *bar,* Oir. *bars*

Бартер |barter|{< Eng. *barter*} *'баартер'* (бүтээгдэхүүн солилцоо)

Баруг |*baruγ*| х у у ч : *'нохой'* (сахалаг үстэй, анч нохой) || Cf. AT *baraq* 'собака с лохматой и длинной шерстью, отличается необычайной стремительностью и ловкостью, считается лучшей среди охотничьих собак' (ДТС 83) || Ж= *'balamud dobtulqu* ***baruğ*** *metü'* [балмад довтлох нохой мэт] (MNT 78)

Барүр |barur-a|{< Tib. *ba ru ra*} мөхлөг үртэй самар (эхүүн амттай, хар халистай, тослог идээтэй эмийн ургамал)

Бархан |barqan|{< Tib. *par khang*} *'хэвийн байшин'* (тусхайлан бэлдхэсэн бараар бичиг ном, зураг дүрс дармаллан хэвлэх газар)

Бархасвади |barqasbadi|{< Skr. *bṛhaspati*} Пүрэв гараг (хий махбодтой, санваартан хүний сүлд гараг. Энэ өдөр хүү төрвөл ухаантай, охин төрвөл урт насална гэж зурхайн сударт заасан байдаг байна)

Барцад |barčad|{< Tib. *bar chad*} *'завсарын гай'* (гай тодхор, саад) || Ж= *'Хүүд минь сүрхий* ***барцадтай*** *байсанаас сум дийлжээ'* (Ч. Лодойдамба, Тунгалаг тамир) || х о р ш : *'гай барцад'* || Kha. *bartsad,* Ord. *bartšat,* Bur. *baršad,* Oir. *bartšɨd*

Басаал- |basaγala| х у у ч : *'бэлтгэ-', 'базаа-'* || Ж= *'yeke tüsürge-yin bara'ūn, jewūn ete'ēd ide'ē* ***basa'ālaju'*** [их сөнгийн баруун зүүн талд хоол ундаа базааж] (MNT 213) Энэ үгийг проф. I de Rachewiltz *'look after'* гэж орчуулжээ. (*The Secret History of the Mongols,* I. 2004, 145)

Басейн |basseyin|{< Rus. *бассейн* < Fr. *bassin* < Lat. *baccinum*} *'басэйн'* (хиймэл цөөрөм) || Kha. *basein,* Bur. *bassein*

Батальон |batalyon|{< Rus. *батальон* < Fr. *bataillon*} *'батилоон', 'суман цэрэг'* || Kha. *batelōn*, Bur. *batalyon*

Бацаан |bačaγan|{< Rus. *пацан*} *'жуулдаркай'*

Бая-* |baya| *баян* гэдэг үгийн анхдагч язгуур. || Cf. Turk. ***baj*** 'богатый' (ДТС 79), ***bāy*** 'rich' (Clauson 384), Uig. *bay* 'rich, wealthy' (Schwarz 62) Энэхүү язгуураас *bayad* [baya-d] 'баял', *bayaji-* [baya-ji] 'баяж', *bayaliγ* [baya-liγ] 'баялаг', *bayan* [baya-n] 'баян', *bayar* [baya-r] 'баяр', *bayas-* [baya-s] 'баяс-' гэсэн үгс үүсч, тэдгээрээс тухайн үгтэг хадгалсан нэр үг, тэмдэг үг, үйл үг дам үүсчээ.

Баяж- |bayaJi|[= baya-Ji] *'баян болох'* || Ж= *'ed-iyer **bayajibasu** kičün ber nemeγü'* [эдээр баяжвал хүч нэмэгдэнэ](Sub. IV:8) // ***bayajiqu** noyalaqu qoyar-ḥur beyes-ečegen es-e ele anggijirayulbasu'* [баяжих ноёлох хоёроор бие биеэс эс ангижирвал](Taq. 5b) // *bayajiba* 'разбогател' (Mu. 114) || Kha. *bayᵉdž-*, Ord. *bajadži-*, Bur. *bayaza-*, Oir. *bajdži*

Баялаг |bayalig| *'баян', 'унэт зүйлс'* || Cf. AT *bajlïq* 'богатство' (ДТС 79), Uig. *bayliq* 'richness' (Schwarz 63), Kaz. *baïlyk* (Базылхан 73) || Ж= *'ed-i jaruγči **bayaliγud**...busud-i jiryayuluγad'* [эдийг зарагч баялагууд... бусадыг жаргаагаад] (Sub. VI:12a) || х о р ш : *'эд баялаг'* || Kha. *bayᵉlag*, Ord. *bayalak*, Bur. *bayalig*, Oir. *bajᵉlig*

Баян |bayan|[= baya-n] *'элбэг', 'дүүрэн'* || Cf. *bajan* 'богатый' (Щербак 2005, 25); Man. *bayan* 'богатый' (Цинциус I:65) || Ж= *'dorudu kümün **bayan** ber bolbasu ujuyur-tu ügegün aran-a daruγdayu'* [доорд хүн баян болвол язгуултан нь ядуу ардаа дарагдана](Sub. IV:1b) // *bayan* 'riche' (HY M39) // ***bayan** bolba ere'* [мужчина стал богат](Mu.114) // *bayan* 'богатый' (IM 433, IM M129) // *bayan* 'rich, wealthy' (Ras. 203 B14) || Энэ үг элбэг баяны бэлгэдэл болж, хүний нэр цолонд өргөн хэрэглэгдэж байсаныг МНТ-оос харж болно. || Ж= *Toroγoljin-bayan* (MNT 3), *Šinčï-bayan* (§ 9), *Naqu-bayan* (MNT 90), *Telegetü-bayan* (MNT 137) || х о р ш : *'баян тарган', 'баян чинээлэг'* // *'элбэг баян'* || Kha, Ord, Bur. *bayan*, Oir. *bajᵊn*

Баяс- |bayas|[= baya-s] *'санаа сэдхэлээрээ баян болох', 'баярлаж хөөрөх'*. Энэ үгээс *bayasqa-* [baya-s-qa] 'баясха-', *bayasqulang* [baya-s-qu-lang] 'баясхалан' гэх зэрэг үгс үүсчээ. || Ж= *'yirtinčü daqin bügüdeger **bayasun**'* [ертөнц дахин бүгэд ээр баясан](Sub. VI:12b) // *'Dei-sečen Temüjin-i üjeji, maši yeke **bayasču**'* [Дэй сэцэн Тэмүжинийг хараад маш их баярлаж](MNT 94-5) // *'ingri-ner biširen **bayasču**'* [тэнгэр нар биширэн баясч](Burq.12b) // *bayasba* 'радовался' (Mu.114); *bayasba* 'радовать' (IM 433) // *bayas* 'веселый' (IM M127) || Kha, Ord. *bayas-*, Bur. *bayasa-*, Oir. *bajɪs-*

Баясхалан |bayasqulang|[= baya-s-qu-lan] *'сэдхэлийн баяр хөөр'* || Ж= *'tengsel ügei **bayasqulang**-i törügülügči degedü boyda'* [тэнсэлгүй баясхалан төрүүлэгч дээд богд](Burq. 33a) // ***bayasqulan*** 'радость' (Mu.114) || х о р ш : *'баяр баясхалан'* || Kha, Bur. *bayasxalaŋ*, Ord. *bayasxulaŋ*, Oir. *bajᵊsgʊlʊŋ*

Бейсбол |beyisbol|{< Rus. *бейсбол* < Eng. *baseball*} *'бэйсбоол', 'цохиурт бөмбөг'* (тусхай талбайд дөрвөн үүр дамжин гүйж, цохиураар бөмбөгийг

цохиж, оноо цуглуулдаг тоглоом)

Бензин |benzin|{< Rus. *бензин* < Fr. *benzine*} *'бэнзийн', 'шатахуун'* || Kha. *beŋdzīn*, Bur. *beŋzin*

Бестселлер |bestseller|{< Eng. *best + seller*} *'гүйлгээ ихтэй'* (уншигчидын сонирхолын ихэд татаж, олон хувиар борлуулагдсан дуулиантай ном)

Бетон |beton|{< Rus. *бетон* < Lat. *bitumen*} *'бетоон'* (цемент, элэс, хайргын зуурмагаар цудхаж бэлдсэн барилгын материал)

Би |bi|{< *bin < *min} *'би'* (нэгдүгээр биеийн ганц тоот төлөөний нэр) || Ж= *'**bi** mayuqan idegen-iyer ber küčün oruju aqu boltuγai'* [би муухан хоолоор хүч орох болтугай](BT 162b 13-14) // *'**bi** ene kö'ün-be'ën čimada öksü'* [би энэ хүүгээ чамд өгөө](MNT 15) Тус төлөөний нэрийн тийн ялгалаар ялгалагдах үндэс нь *min-* 'мин', *nad-* 'над', *nam-* 'нам' болно.

Би-Би-Си |bi-bi-si|{< BBC *'British Broadcasting Corporation'*} *'би-би-си'* 'Британы нэвтэрүүлэгийн корпораци' (Английн мэдээ, мэдээлэлийн агентлаг)

Библи |bibli|{< Rus. *библия* < Lat. *biblia* < Gr. *βίβλία*} *'бийбел судар'* (загалмайн шашины ариун судар)

Бивлин |bibiling|{< Tib. *pi pi ling* < Skr. *pipali*} *'бивлин'* (халуун чанартай, эхүүн амттай хоол хүнэсэнд хэрэглэдэг ургамал) || Kha. *biwliŋ*, Ord. *beweleŋ*

Бигүди |bigudi|{< Rus. *бигуди* < Fr. *bigoudi*} *'бигүүж'* (үс ороож, хэвэнд оруулах хэрэгсэл)

Бигшү |bhigšu|{< Skr. *bhikṣu*} *'хувараг'* (өөрийн гэсэн өмч хөрөнгөгүй бадар барин амьдарч бурханы шашины ёс жаягийг дагагч лам) || Ж= *'Sita, Sindü, **Bigšu** kiged Gangga'* [Сита, Синду, Бигшү хийгээд Ганга](Chimeg 28a)

Бид |bide|{< bi-den} *бид* (нэгдүгээр биеийн олон тоот төлөөний үүсмэл нэр) || Ж= *'**bida** Činggis qayan-u uruγ-ud'* [Бид Чингис хааны удамнахан] (Ölj.24) // *'qatun Börte-yi činu qari'ūlǰu abčiraya **bida**'* [бид хатан Бөртийг чинь буцааж авчирая](MNT 104) || Kha. *bidə*, Ord. *bide*, Bur. *beden*, Oir. *bid*

Биду |bidu| *'хэсэх', 'тэнэх'* || Cf. Turk. *bidun 'хэсүүлч', 'нүүдэлч'* (арабын эртний нүүдэлчидийг түрэгүүд тийн нэрлэдэг байжээ) || Cf. Man. *badú* 'ехать' (Цинциус I:63) || Ж= *'Oŋ qan gurban balaγad **bidun** yorčiǰu'* [Он хан гурван хотоор хэсэн явж](MNT 151) // *'Magada ulus-i **bidun** yabuγad'* [Магад уласаар хэсүүчилэн яваад](Burq. 34b)

Бидон |biton|{< Rus. *бидон* < Fr. *bidon*} *'битаан'* (шингэн зүйл хийдэг тагтай метал хувин) || Kha. *bitān*

Бидуу |bidaγu / budaγu| *'ядуу', 'дорой'* || Ж= *'angqan-u degüü Bodončar-i mungqay **bidaγu** buyu kemen uruγ-a ülü toγan'* [анхны дүү Бодончарыг мунхаг бидуу буюу хэмээн урагтаа үл тоон](AT 6b) || Kha, Ord. *bidū*

Бидэр |bider| *'молбо', 'мирализаа'* || Cf. Kaz. *beder* 'бидэр' (Базылхан 73) || Kha. *bider*, Ord. *beder*, Bur. *bedir*, Oir. *bedər*

Биенхэд- |beyengkedü-|[beye-ŋke-dü] *'биечилэн', 'биеэрээ оролцох'* || Ж= *'Atai-buq-a ... yeke törü-yi sedkiǰü **beyenggedün** šitügeleldün qadquldu γad'* [Атайбуха ... их төрөө бодож, биеэрээ эсэргүүцэн байлдаад](Hin. 22)

Бизнес |biznes|{< Eng. *business*} *'бийзнес', 'ажил үйлс', 'худалдаа наймаа'* || Kha. *bidznes*, Bur. *biznes*

Бизъяа |bi̯jaya|{< Skr. *vijaya*} *'сайтар ялгуусан'* (эдүгээ их төлөв хүний нэрд хэрэглэдэг)

Бий тэс |bii tas|{< Turk. *bei* 'хөшөө' + *tas* 'чулуу'} *'чулуун хөшөө'* || Ж= *'Yeke Mongγol ulus-tur jrlγ-iyar Ši ning ong Indū-de bayiγuldaǰsan* ***bii tas*** *buyu'* [Их Монгол улсад зарлигаар Шинин ван Индүүд босхосон чулуун хөшөө] (Hin. 1)

Бийваа |biba|{< Uig. *biba* < Chin. *pi-pa*} Эгшигт охин тэнгэрийн чавхдаст хөгжим (дүгэрэг цартай, дөрвөн чавхдастай хөгжимийн зэвсэг) || Ж= ***'biba,*** *bilir, kenggerge, činggil, čamquy terigūten'* [бийваа, билар, хэнгэрэг, цамхаг тэргүүтэн](Burq. 11) || Kha. *bīwā*, Ord. *biwa*, Oir. *bīw*

Бийр |bir|{< Chin. *bĭer*} *'үсэн үзэг'* (урт ишинд бэхэлсэн үсэн үзэг) || Ж= *'зүрхний дотор нь басхүү зул ноцож, сэтгэл нь хөгжөөд даруй* ***бийрийг*** *авч шүлэг зохион эхлэв'* (Д. Нацагдорж, Зул) || х о р ш : *'бийр янтай'* || Kha, Bur, Oir. *bīr*, Ord. *bēr*

Бил- |bili-| *'илбэх'* || Ж= *'baraγun γar-iyar öber-ün üsün-i* ***bilibesü'*** [баруун гараараа өөрийн үсээ илвээс](Burq. 58b) // *'ke'ēli minü* ***bilǰü****, gege'ēn inü ke'ēli-dür minü šiŋgekū büle'ē'* [хэвэлийг минь илж, гэгээ нь хэвэлийд минь шингэх бөлгөө](MNT 21)

Билар |bilar| *'цартай бишхүүр'* || Cf. Turk. ***bylar*** || Ж= *'biba,* ***bilir,*** *kenggerge, činggil, čamquy terigūten'* [бийваа, билар, хэнгэрэг, цамхаг тэргүүтэн] (Burq. 11) || Kha. *bilar*

Билдар |bilder| *'бие'* || Ж= *bey-e* ***belder*** *üsün mariyan bolǰu'* [бие хаа нь ус, мах болж](Taq.2a5) // *'qaγan-u ökin bey-e* ***bildar*** *sayitai'* [хааны охин бие билдар сайтай](Chimeg 6/7a) || Орчин цагийн монгол хэлэнд биеийн хүч чадалыг илэрхийлэх болжээ. || х о р ш : *'бие билдар'* || Kha. *bʻaldar*, Oir. *bildʾr*

Билет |bilet|{< Rus. *билет* < Fr. billet} *'билээд', 'масалбар'* (үзвэр, үйлчилгээнд орох эрхийн тасалбар)

Билжүүр |bilǰigür| *'билзуухай'* || Ж= *'****bilǰigür****-i kedüi be teǰigebesü nuta iǰilidqui qamiγ-a bui'* [билзуухайг хэдий тэжээвч яг ижилших нь хаа буй] (Burq. 10a) // *'öčigen nigen-te* ***bilǰi'ūr*** *odolidugsan-i teyīn kü bulǰu abula'ā'* [өчигдөр нэг удаа билзуухай харвасаныг бас булааж авсан](MNT 77) // *bilǰiqur* 'passereau / sparrow' (*Zhi Yuan.*, Kara 285)

Билиг |bilig| *'ойун ухаан'* || Cf. AT *bilig* 'знание' (ДТС 99), *belig* 'разум', 'мудрость', 'знание' (Щербак 2004, 27) || Ж= *'arčimal toli metü gegegen* ***bilig-tü'*** [арчмал толь мэт гэгээн билигт](BT 166b) // *'****bilig-ün*** *nidün-iyer mungqaγ-un qarangγui-yi geyigül-sügei'* [билигийн нүдээр мунхагийн харанхуйг гийгүүлсүгэй](Burq.16b) // *'****bilik*** *yabuba tūnēse'* [от него шла мудрость](Mu. 119) || х о р ш : *'авъяас билиг', 'арга билиг', 'ойун билиг', 'эрдэм билиг'* || Kha, Bur. *bilig*, Ord. *belik*, Oir. *bilʾg*

Бильярд |bilyard|{< Rus. *бильярд* < Eng. *billiards* < Fr. *billard*} *'бильярд'* (тусхай зориулалтын ширээн дээр жижиг модон бөмбөгийг урт саваагаар түлхэж, эсрэг талын булангийн торонд түлхэж оруулдаг тоглоом) || Kha, Bur. *bilyārd*

Бимба |bimba|{< Tib. *spen pa*} *долоон хоногийн зургаа дахь өдөрийн нэр.* (нарны аймагийн есөн гарагийн нэг.) || Skr. *śanaiścara* 'санчир' || Kha. *bʹamba*, Oir. *bembə*

Бин |bing|{< Chin. *bíng*} *'зуурч, жигнэсэн гурил'* || Ж= *'өөрийн авч гарсан гурван* ***бингийн*** *нэгийг өгч тэнхэрүүлэн аваад'* (Д. Нацагдорж, Тулга, тогоо, шанага гурав) || Kha. *biŋ*

Бинвад |binvad|{< Tokh. *pinwāt* < Skr. *piṇḍapāta*} *'өглөг'* || Ж= *'уаγča* ***binvad****-tur dulduyiduγči toyin kemēgdekü ene büi'* [гагц өглөгт дулдуйдагч тойн хэмээх энэ буй] // *'bišilγan nom-i inu tegüs toγtaγad* ***binvadčin*** *toyid-un manglai boltuγai'* [номыг нь бисалган төгөс тогтоогоод өглөгч тойдын манлай болтугай](BT 167b)

Биндэръяа |binduriy-a|{< Skr. *vaidūrya*}*'хатуу, тунгалаг эрдэнийн чулуу'* (шар, ногоон, хөх, цэнхэр туяатай энэхүү эрдэнийн чулуу нь долоон зүйлийн эрдэнийн чулууны нэгэнд багтдаг) || Ж= *'alaγan metü* ***vayiduri*** *erdini gićki-gürtü-yin dotur-a eldeb öngge daγun sayitan šibaγuqad-iyar dügürügsen'* [алаган мэт биндэръяа эрдэнийн гишгүүрт дотор элдэв өнгө дуу сайт шувуудаар дүүрсэн] (Burq. 46a) || Kha. *biŋderyā*, Bur. *beŋderyā*, Ord. *wiiduriya*

Бинт I |bintü|{< Skr. *bintu*} *'дусал'* (манж бичигийн нэмэлт тэмдэг)

Бинт II |bingtü| *'үнэн шударга', 'чамбай'* 'ноёд түшмэдийн цол) || х о р ш : *'бинт ван'*

Биологи |biologi|{< Rus. *биология* < Fr. *biologie* < Gr. *βίολογία*} *'биолоог'* (амид байгаль судалах ухаан) || Kha. *biōlōg*, Bur. *biológ*

Биратикабуд |biratikabud|{< Uig. *pratikabud* < Skr. *bratyekabuddha*} *'нирвааны хизгаарт хүрсэн, өөрийгөө ялсан бурхан'* || Ж= *'****biratikabud*** *kīgēd širavag-ud ber jiryalangtan boltuγai'* [биратикавуд хийгээд ширвагууд жаргалантан болтугай](BT 162a)

Бирвааз |birvaza|{< Rus. *перевоз*} *'бирвааз', 'гаталгагч'* (гол мөрөнийг гаталуулах тавцант зөөвөрийн хэрэгсэл) || Kha. *birvādz*

Бирга |birγ-a|{< Tib. *ber ka*} *'нар, сар, цэцэг гуравын бэлгэдэл'* (ном сударын хуудасны эхэнд тавьдаг бэлгэдэлийн тэмдэг) || Kha. *bʹarğa*, Oir, Bur. *birğo*

Бирд |birid|{< Uig. *birid* < Skr. *preta*} *'өлөн чөдхөр'* (Бурханы шашины номлолд орчилонгийн бүх амьтаныг *'зургаан зүйлийн хамаг амьтан'* гэж хураангуйлан нэрлэдэг. Тэдгээрийн дотороос *тэнгэр нар, асури, хүн* гурав нь дээд заяаны оронд багтах бөгөөд *адгуус, там, бирд* гурав нь муу заяаны оронд багтана. Бирд хэмээгч муу заяат амьтаны талаар *'ам нь агуй мэт агуу, гэдэс нь гэрийн чинээ, хоолой нь хилгас мэт нарийн тул мөнхийн зовлонт'* хэмээн тодорхойлсон байдаг.) || Ж= *'ker be tamu-dača tonilbasu* ***birid****-tür törüyü'* [хэрэв тамаас зайлвал бирдэд төрөү](Turf. VI) // *'nasuda nigül-i kü üyiledügčin narin köl-ten* ***birid****-ün nidün-dür nayur dalai-yin usun ber širgijü* [насандаа нүгэл үйлдэгч нарийн хөлт бирдийн нүдэнд нуур далайн ус ширгэж](Turf. VI) || Орчин цагийн монгол хэлэнд энэ үг *'харамч'* гэсэн утгыг илдхэдэг. || Kha. *birdə*, Ord. *berit*, Oir. *birʲd*

Бирж |birǰi|{< Rus. *биржа* < Fr. *bourse* < Ger. *Börse*} *'бийрж', 'хэтэвч'* (үнэт цаас арилжих газар)

Бирман |biraman|{< Uig. *biraman* < Skr. *brāhmana*} *'номлон явагч', 'эрдэмтэн, гарсан' ('Веда'-ийн сургаалыг номлогч дээд кастынхан. Харин монгол ном зохиолд 'лам', 'банди' гэсэн утгаар хэрэглэх болжээ)* || Ж= *'üjemerčin mergen **biraman** bayši-nar'* [үзмэрчин мэргэн бирман багш нар](Burq.19b) // *'naiman ǰayun **biraman**-nuγud-ta čai bariǰu'* [найман зуун бирманд цай барьж](Burq.43a) || Kha, Ord, Bur. *birman*, Oir. *birmɤn*

Бисаа |bis|{< Chin. *bi shi*} *'гэрийн хачиг'* (гэр оронд үрждэг цус сорогч шавьж) || Kha, Bur. *bisā*, Ord. *bisa*

Бисал- |bisil| *'үн бодох', 'боловсоруулах'* || Cf. Turk *biš*. Энэ үгээс *bisilγa-* [= bisil-γa] 'бисалга-', *bisilγal* [bisil-γa-l] 'бисалгал' гэх мэт үгс үүсчээ. || Ж= *uraloqu üγile-dür **bišiluysan** metü'* [урлах үйлд бисалгасан мэт](Sub.IX:2)

Бисалга- |bisilγa|[= bisal-γa] *'үнэгий бодож боловсоруулах'* || Ж= *'medegsen-iyen aylaγ-a **bišilyabasu**'* [сурсанаа аглагт бисалгаваас](ВТ 159b) // *'γauča-γar aylaγ-tur odču **bišilyabasu** kilbarγan-a tuγulǰu'* [ганцаар аглагт очиж бисалгавал хилбархан туулж](Burq. 31b) || Kha, Ord, Bur. *bisalga-*, Oir. *bisᵊlgɤ-*

Бисалгал |bisilγal|[= bisal-γa-l] гүнээ бодож боловсоруулах үйл || Ж= *'Ловон нүд анин **бисалгал** үйлдэн хонх жингэнүүлнэ'* (Д. Намдаг, Нүгэл, буян хоёр) || Kha, Ord. *bisalgal*, Oir. *bisilgɤl*

Бисгар |bisqara| х у у ч : *'халих', 'мархах'* || Ж= *'tökem-e dügüreng bolǰu ese **bisqariγulbasu** tegünčilen bayan-iyar kü ayu'* [төхөм дүүрэн болж эс халиваас тийнхүү үргэлж баяжих буюу](Taq. 5a) // *'a'ūr-i'ān darun yadan ǰabilan sa'ūǰu, qoyar kökōd-iyēn gargaǰu, qoyar ebüdüg dege ūn **bisari'ūlǰu**'* [уураа даран ядаж завилан суугаад хоёр хөхөө өвдөг дээрээ давуулан тавиад](MNT 244)

Бифштекс |bifsteks|{< Rus. *бифштекс* < Eng. *beef* 'үхэр'+ *steaks* 'хэрчсэн мах'} *'бифштээкс'* (хавтагайлан давтаж шарсан мах)

Бицхан |bičiqan| *'жижигхэн', 'өчүүхэн'* || *'ene keüken-i **bičiken**-ečeni ügei bolyaltai'* [энэ хүүхэнийг бицханаас нь үгүй болголтой](Asaraγči 27b)|| Kha. *bitsxan*, Ord. *bičaxan*, Bur. *bišyxan*, Oir. *bičkən*, Oir. *bitšχɤn*

Бич |bečin| *'сармагчин'* || Cf. Turk. *bäčin* 'обезьяна' (Радлов, IV:1625), AT. *bičin* 'обезьяна' (ДТС 98), *bečin* 'monkey', 'ape' (Clauson 295), *bišen* 'обезьяна' (Щербак 2005, 28) || Ж= *'görügeči-yin tour-tur toruysan **bičin** metü'* [анчины торонд орсон сармагчин мэт](Burq. 5a) // *bečin* 'singe' (HY M40) // *bečin* 'обезьяна' (Mu. 115) // *bičin* 'ape' (Ras. 199 C15) // *pičin* 'singe' (Ist. 61) // *bejin* 'обезьяна' (Qaz. Po. 200) || Kha. *bitš*/ *mitš*, Ord. *metši(n)* Bur. *bišen*, Oir. *betšɪn*

Тусхай судалгаа: Han Woo Choi, On the Origin of Old Turkic *bičin / bečin*, CAJ 33:3-4, 1989, 218-222

Бич- |bičі|{< *biti} *'үсэгээр тэмдэглэх'* || Cf. Man. *biči* 'писать' (Цинциус I:86) || Ж= *'üker ǰil ǰunu terigün sara-yin ǰirγuγan qaučid-ta Köndelen-e bükü-dür **bičibei***' [үхэр жил зуны тэргүүн сарын зургаан хуучидаар Хөндөлөнд байхуйд бичив](Ar. 1289) // *'bičin ǰil namur-un dumdadu sara-yin naiman qaγučid-ta Sultaniya-ǧ bükü-dür **bičibei**'* [бичин жил намарын дунд сарын найман

хуучидаар Султаниад байхад бичив](Abu.1320) // ***bičibe*** *bičēči* 'писец писал' (Mu 118) // ***bičibe*** 'писал' (IM 433) // ***bitibü*** 'писать' (IM M127) || х о р ш : *'зурж бичих'* || Kha. *bitš'-*, Ord. *bitši-*, Bur. *beše-*, Oir. *bitš'-*

Бичиг |biçig|[= biçi-g]{< *bitig} *'гэ мэдэглэх үсэг'* || Cf. AT *bitig* 'книга' (ДТС 99), *bitig* 'book, letter, document' (Clauson 303), *bitig* 'грамота', 'документ' (Щербак 1997, 131); Man. *bitxe* 'письменность' (Цинциус I:86), *bithe* 'letter' (Norman, 31) || Ж= *'jarğu jarğulağsan-i kökö debter* ***bičig*** *bičijü, debterlejü'* [зарга заргалдсаныг хөх дэвтэрт бичиг бичиж дэвтэрлэж](MNT 203-38) // *'bii tas-un* ***bičig****-i joqiyayulun'* [чулуун хөшөөний бичигийг зохиолгон](Chang 8) // *bičik* 'lettre officielle' (HY M40) // *bičik* 'письмо' (Mu. 118) // *bičik* 'писание', 'письмо' (IM 434) // *bičik* 'écrit' (Ist. 20) // *bičik* 'book' (Ras.205 D6) || х о р ш : *'бичиг үсэг'*, *'бичиг сачиг'* || Kha. Oir. *bitšig*, Ord. *bitšik*, Bur. *bešeg*

Т у с х а й с у д а л г а а : D. Sinor, Two Altaic Verbs for *'writing'* and their Uralic Connections, *Studies in Finno-Ugric Linguistics* {UAS 131}, Indiana University, 1977, 319-332

Бичээч |bičigeči|[= bičі-ge-či] *'бичигч, 'бичигийн хүн'* || Ж= *'Qoruqai-yin idegsen mör jiruqai bičig taqi bögesü* ***bičigeči*** *busu'* [хорхойн идсэн мөр нь бичиг зураг мөн ч гэсэн бичээчийнх биш](Sub.III:8a) // *'d[aruyas-t]a* ***bičige-čin****-e manu sayin ečige-de'* [дарга нар, бичээчид, бидний сайн эцэгт](Abaga I) // *bičibe* ***bičēči*** 'писец писал' (Mu.118) // ***bičēči*** 'пишущий' (IM 433) // ***bičigäči*** 'пишущий' (IM M129) // ***bičixči*** 'scribe' 'Kund.147)

Бишир- |büsire /bisire| *'хүндэдхэ-', 'итгэ', 'үнэмш'.* || Ж= *'Činggis qahān Badai, Kišilig qoyar-un üges* ***büširejü'*** [Чингис хаан Бадай, Хишилиг хоёрын үгэнд итгэж](MNT 170) // *'Bodistv-un köl-dür kündülen mörgüjü bayasqui* ***bišireküi*** *sedkil-iyer takiyad'* [Бодисадвагийн хөлд хүндэлэн мөргөж, баясах бишрэх сэдхэлээр тахиад](Burq. 49a) || х о р ш : *'бишрэн шүтэх'* || Kha. *bišir*, Ord. *bišire-*, Bur. *bešer-*, Oir. *biš'r-*

Биширэл |büsirel /bisirel| *'бишрэхүй', 'үгнээ хүндэдхэхүй'* || Ж= *'erte* ***büširel*** *ügei čaysabad ebdegsen nigen qulayai toyin'* [эрт шигшаабад эвдсэн биширэлгүй нэгэн хуурамаг тойн](Turf. 10) || х о р ш : *'итгэл биширэл', 'сүсэг биширэл'* || Kha, Ord. *biširel*, Bur. *bešerel*, Oir. *biš'rəl*

Блог |blog|{< Eng. *web log*} *'болоог', 'сүлжээний тэмдэглэл'* (их төлөв хувь хүн өөрийнхөө үйл ажиллагааг танилцуулах, бусадтай харилцах үүрэгтэй цахим хуудас)

Блютүүт |bliyu tüüt|{< Eng. *bluetooth*} *'блютүүт'* (ямар нэгэн холбох хэрэгсэлгүйгээр тодорхой зайнаас зураг, мэдээлэл, дуу бичлэг татах утасгүй төхөөрөмж)

Богд |boγda| *'дээд лам тан', 'их багштан'* || Ж= *'****boγda*** *sayid-un ayali aburi taqimdayu'* [богд сайдын ааль авир тахимдуу](Taq. 17b) // *'erdem-tei* ***boγda*** *Maqa-a-gali'* [эрдэмтэй богд Махагал](Maha. B) || Kha. *bogdŏ*, Ord, Bur. *bogdo*, Oir. *bogd*ᵒ

Богтло- |boγtala|[= boγta-la] *'хүчээр гэрлүүлэх'* (эцэг эх нь охиныхоо хайр сэдхэлийг эс харгалзан хүүгийн талаас бэлэг сэлт авч, сэм тохиролцон нөхөрт

таргах) || Ж= *'Эд болоод монго нь байдагүйсэн бол эзэг болоод ана нь юундаа богтлах вэ'* (Д. Намлаг, Шинэ байшинд)

Богтог |boytay|[boyta-y]{< Turk. *boqta*} *'титэм малгай'* (эзгууртан хатан хүний өмсөлөг тогосын од, үнэт чулуу, сувал тэргүүтэнээр чимсэн өндөр оройтой малгай) || Ж= *boḫtaq* 'woman's headgear' (Ras. 205 C40) // *'boqtatu xoros'* [петух с гребешком](Mu. 121) Энэ үгээс *boytala-* [boyta-la] *'богтло-'* гэсэн үйл үг үүсчээ. || Ж= *'Hö'ölün-üjin eme mergen töreji, üčüked kö'ud-iyen teji'ěrün okitala bogtalaju, hojitala büselejü'* [мэргэн төрсөн Өлүн үжин очүүхэн хүвүүдээ тэжээн өхийтэл богтолж, одойтол бүсэлж](MNT 74) || Kha. *bogtog*

Т у с х а й с у д а л г а а : Б. Түвшинтөгс, Малгай ташбал манайх ... буюу *'богтог'* хэмээх үгийн тухай, *Монголын Алтай Судлал*, Уб., 2011, 238-245

Бодгаль |bodayali|{< Uig. *budgali* < Skr. *pudgala*} *'тусхай зүйл', 'амид төрөлтөн', 'хүмүүн'* -ийг заасан нэр. Энэ үгийн гаралаар акад. Б. Я. Владимирцов тодорхой дурдсан бий. (*Mongolica* I. Об отношении монгольского языка к индо-европейским языкам Средней Азии, *'Работы по монгольскому языкознанию'* «Восточная литература» РАН, М., 2005, 112)

Бодь |bodi|{< Skr. *boddhi*} *'төгөс ухамсаргүй', 'нигүүлсэнгүй', 'ариун'* (хир бүгэдийг ариглаж, эрдэм бүхэнийг багтаасан хорон санаагүй, ариун сэдхэл) || Tib. *byang chub* 'жанчив' || Ж= *'amitan-a tusayin tula bodi qutuy-i erikü'* [амьтаны тусын тул гэгээрсэн хутагийг эрэхүй](Burq. 3a) // *'edüge bodi modun-u dergede odsuyai'* [эдүгээ бодь модны дэргэд очсугай](Burq. 45a) || х о р ш : *'бодь хутаг', 'бодь явдал', 'бодь сэдхэл'* || Kha, Ord, Bur. *bodi*, Oir. *bodī*

Бодибилдинг |bodibilding|{< Eng. *body* 'бие' + *building* 'бүтэц'} *'бодибилдинг'* (биений булчинг хөгжүүлэн зангируулж, тусхайлан үзүүлдэг нэгэн төрлийн спорт)

Бодисадва |bodisadu-a|{< Skr. *bodhisattva*} *'бодь сэтгэлт'* (хамаг амьтаныг орчилонгийн зовлонгоос гэтэлгэхийн тул өөрийн жаргалыг огоорон, бодь сэдхэлийг олсон гэгээн хутагтуудын дээд Бурхан багш, түүний найман их шавь нь бодисадва юм. Бурхан багшийн найман шавь нь *Манзушири, Очирваань, Жанрайсэг, Газарын зүрэхэн, Түйдхэрийг тийн арилгагч, Огторгуйн зүрэхэн, Майдар, Хотол* сайн эдгээр болой) || Ж= ***Bodistv quvray-ud-un küčün-iyer amitan jiryalang-iyar yabuqun boltuyai'*** [Бодисадва хуварагуудын хүчээр амьтаны жаргалангаар явах болтугай](BT 164a) || Kha. *bodisad*, Ord. *bodisodi*, Bur. *bodisada*, Oir. *bodīsadī*

Бодичид |bodičid|{< Uig *bodičit* < Skr. *boddhicitta*} *'гэгээн'* || Ж= ***'bodičid sedkil-eče ülü qayačan bodi yabudal-iyar yabuyad'*** [гэгээн сэдхэлээсээ үл хагацан боди явдалаар яваад](BT 156a12)

Бой |boi| *'хаг'* (нялх хүүхэдийн хаг) || Ж= ***'boi-yi tanu arilğaju, borbi tanu ergü ülǰü'*** [бойг чинь арилгаж борвийг чинь эргүүлж](MNT 254) Орчин цагийн монгол хэлэнд *'бой нь арилаагүй, борви нь тэнийгээгүй'* гэсэн хэллэг байдаг нь дээрхи жишээний хувилбар даруй мөн. Монгол хэлний *boyiǰi* [boyi-ji] 'бойжих' гэдэг үг үгтаа энэ үгээс гарсан бололтой.

Бойпор |boyipur|{< Tib. *spos phor*} *'хүжсийн аяга'* (анхилам үнэртэй ариун сан уутнуулах тахилын сав) || *'**bойпор** барьсан лам нар гарч, цэцэд мангшир бурханы өмнө сан тавина'* (Б. Ринчен, Цогт тайж) || Kha. *boipor*, Ord. *bŏwor*, Bur. *boipŭr*

Бокс |boks|{< Rus. *бокс* < Eng. *box*) *'боокс', 'нударган зодоон'*

Болд |bolud|{< Uig. *bolud* < Pers. *pulād*} || Kaz. *bolat* (Базылхан 79) // *bolud* 'сталь' (Радлов, 1262:120) || Kha. *boldō*, Ord. *bolot*, Bur. *boldo*, Oir. *bolᵘd*

Болор |bolur|{< Pers. *bulūr*} тунгалаг онгөтэй хагас эрдэнийн чулуу || Ж= *'**bolur** saba-dur dabtamal altan tüsürügsen metü buyan-u küčün'* [болор саванд давтмал алт дүүргэсэн мэт буяны хүч](Burq. 45a) // *bolor* 'cristal de roche' (НУ М40) || х о р ш : *'болор эрдэнэ'* || Kha, Ord. *bolor*, Bur. *molor*, Oir. *bolᵘr*

Бомбо |bombu|{< Tib. *bon po*} *'хохийн шашин'* (Доронод Хан уласын үед хитадад дэлгэрсэн даосын шашин)

Бомбоо |bombu|{< Tib. *sbom po*} *'бүдүүн'* (Буддийн шашины ёсонд нууц авшиг хүртээх үед багш ламтан өөрийн чандманын үзүүр буюу эр бэлгэ эрхтэнийхээ үзүүрээс шингэн дусал гаргаж, шавийн хэлэн дээр тавихад шавь нь түүнийг эм бэлгийн шингэн хэмээн сэдхэж хүртэх ёс байжээ. Түүнээс улбаалан эр хүний бэлгэ эрхтэнийг заасан нэр болжээ.)

Бонд |bond|{< Eng. *bond*} *'боонд', 'орийн баталгаа', 'зээлийн үнэт цаас'* (уласын монгон тэмдэгтийг орлох цаасан мөнгө)

Бонус |bonus|{< Rus. *бонус* < Lat. *bonus*} *'боонуус', 'монгон урамшуулал'*

Боо- |boγo|{< boγa} *'баглах', 'ороох'* || Cf. AT. *boy* 'душить' (ДТС 109) || Cf. Man. *boyo* 'развязать' (Цинциус I:87) || Ж= *'ke'ēr-e **boğūğsan** nambuqa sa'ūluğa-bān ačiraba'* [хээр боож тавьсан намбага суулгаа авчирав](MNT 93) // *bōba* 'был задушен' (Mu. 122) || Энэ язгуураас *boγoγda-* {boγo-γda] 'боогд-', *boyodal* [boγo-dal] 'боодол', *boyolya-* [boγo-lγa] 'боолго-', *boyolta* [boγo-lta] 'боолт', *boyom-a* [boγo-ma] 'боом' зэрэг үгс үүсчээ. || х о р ш : *'booж баглах', 'booж хаах'* || Kha, Ord, Bur, Oir. bō-

Боов |boobu|{< Chin. *bō bo*} тосонд хайрсан гурилан идээ || Kha. *bōv*, Bur. *bōbo*

Боодуу |booduu|{< Chin. *bāo dāo*} *'хутага'* (мах ногоо хэрчих) Орчин үед *'заазуур'* гэсэн үгээр хэрэглэгддэг

Боол |boγol|{< *boγāl* > *bo'āl* > *bo'ōl* > *bōl*} *'зарц'* || Cf. Man. *bōl* 'раб' (Цинциус I:91) || Ж= *'Bi öčügüken **boyol** tüšimel Ui suu ülü čidaqu budayu oyitu kümün bögetele'* [өчүүхэн боол түшмэл Уй суу би юу ч үл чадах мунхаг оюут хүн атал](Hin. 46); *'bosoğa-yin činu **boğōl** boltuğai'* [босогын чинь боол болтугай](MNT 137); *bidani bōl 'наш раб'* (Mu. 118), *bōl* 'slave' (Ras. 203B)

Бооцоо |boγučaγ-a|{< Chin. *bāoqián*} *'мөрийнд төлөх мөнгө'* || Kha. *bōtsō*, Bur. *bōsō*, Oir. *bōtsān*

Бор |bor| *'дарс'* || Cf. Turk. *bor* 'вино' (Радлов, 1661); AT *bor* 'вино' (ДТС 112), *bor* 'Wein' (Gabain 304), *bor* 'Wein' Räsänen 80), *bor* 'wine' (Clauson 354) || Ж= *'**bor** darasun-a ilağdaqu minu buru'ū bolba'* [бор дарасанд дийлдэх минь буруу болов](MNT 281) // *'Industan ekiten ilčin-e abču odqu **bor** araki-yi qada-*

yalaju' [энэдхэг тэргүүтэн элчинд авч очих бор арихийг хадгалж](Turf 18:9) // *boro* 'cendre' (HY M42) // *bor* 'вино' (Mu. 121) // *bor* 'wine' (Ras.205 B16)

Бордиюр |bordiyur|{< Rus. *бордюр* < Fr. *bordure*} *'боржуур'* (замын хажуугийн хашилга)

Боржигон |borjigin| *'Эзэн Чингисийн овог'* (Боржигинчууд Хэрлэн, Онон, Туул гурван голын сав газар, Бурхан халдуны өвөр. Сэнгүр горхины Хар зүрэхний Хөх нуур хавиар нүүдэллэн нутаглаж байжээ) || Ж= *'Bodančar borjigin omuytan bolbai'* [Бодончар боржигин омогтон болов](ET 26a) || Kha, Ord. *bordžigin*

Борз |ara]a|[= boru-ja] *'нэрмэл арих'* (шаргыг дахин нэрж гаргасан шимийн арих)

Борлог |borluy| *'усан үзэмийн талбай'* || Ж= *'yajar usun bay* ***borluy****-i taqi es-e ögbe'* [газар ус, цэцэрлэг усан үзэмийн талбайг ч эс өгөв](Qqot. VIII:10)

Борной |borunai|{< Rus. *борона*} *'тарианы самнуур'*

Боронз үз **Бронз**

Босс |boss|{< Rus. *босс* < Eng. *boss*} *'бооос', 'эзэн', 'ноён', 'дарга'*

Ботаник |botanik|{< Rus. *ботаника* < Ger. *Botanik* < Gr. *βοτανική*} *'ботаааник'* (ургамал судалалын ухаан)

Ботого |botuyan|[= bota-yan] *'нэг настай тэмээ'* || Cf. AT. *botuq* 'верблюжонок' (ДТС 115), *botū* 'camel colt, usually under a year old' (Clauson, 299), Kaz. *bota* (Базылхан 84) || Ж= *'Onan müren-nü teri'ün-e* ***Botoğan****-bo'ōŋi-da boljalduya'* [Онон мөрөний эхэн Ботогон бооржид болзолдоё](MNT 106-15) // *botuyan-u qoryal-un tedüi nüke ügei subud-i talbin'* [ботогоны хорголын чинээ нүхгүй сувадыг тавьж](ET 44b) // ***botayan*** 'верблюжонок' (Mu.122) // *namur töreksen botaya* [верблюженок, родившийся осенью](Mu. 245) // *botagan* 'young camel' (Ras.199 B15) || Kha, Ord, Bur. *botogo*, Oir. *bot°gv*

Боть |boti|{< Tib. *po ti*} *'дэвтэр'* (олон хуудасаар боож дэвтэрлэсэн ном бичиг) || Kha. *bot'*, Ord, Bur. *boti*

Боулин |bowuling|{< Rus. *боулинг* < Eng. *bowling*} *'бооулин'* (босоо модон байнуудыг өнхөрүүлсэн бөмбөгөөр унагаах тоглоом)

Бошог |bošuy|{< Uig. *bošuy*} *'зарлиг', 'соёрхол', 'ивээл', 'өршөөл'* || Ж= *'bošuytu jinung qayan buyu'* [бошогт жинон хаан буюу](AT 174b) // *'sa-sky-a pandida rje bcun bsod nams rče mova-yin* ***bošuy*** *üjegülügsen čay ene mön bölüge'* [Сажа бандида Жебзунсоднамзэмогийн бошог үзүүлсэн цаг энэ мөн бөлгөө] (ЛТ 3b) || х э л ц : *'хааны бошог'* (хааны зарлиг); 'бошог үзүүлэх' (ирээдүйг зөгнөн хэлэх); *'бошог халах'* (хаан төрийг солих); *'бошог соёрхох'* (зөвшөөрөл хүсэх) || Kha. *bošigo*, Ord. *bošok*, Bur. *bošog*, Oir. *bos°gv*

Бошинз |bosinja|{< Chin. *bu shān zi*} *'даавуун цамц'* (ханцуйгүй дан цамц) || Ж= *'уранхай нооронхой* ***бошинз****, пиндгэр эсгий шаахай мэтийг өмөссөн хитад тариачин'* (Д. Намдаг, Цаг төрийн үймээн)

Бөгтөр |böktür|[= bökü-tür] *'бөхгөр', 'бөхийсөн'* || Ж= *'****bögötür*** *qoŋgor-i unu'ad'* [бөгтөр хонгорыг унаад](MNT 95-3) // *'****böketür*** *bolba ötegü'* [старик стал горбатым](Mu. 123) || Ж= *'нуруу* ***бөгтөр*** *туранхай авгай сандран гүйн*

гарч ирлээ' (Д. Намдаг, Цаг төрийн үймээн) || Kha. *bögtör*, Ord. *bögötör*, Bur. *bügder*, Oir. *bökt^{s}r*

Бөгтөргө |böktürge| *'тэгнээ'* || Ж= *'arslan omuγ sedkil-ün šiltaγ-a-bar üne-gen-ü* ***bögtürge*** *ergüjügüi kemen sonosdamu'* [арслан омогт сэдхэлийн хүчээр үнэний бөгтөргө өргөжээ хэмээн соносдмуй](Sub. V:8a)

Болдийд- |böldeyid|[= böldе-yi-d] х у у ч : *'өөр тийш зайл-', 'хөндийр-'* || Ж= *'tere üge-dür Jamuqa ōre* ***böldeyidčü*** *ǧarču, nökөd-te'ēn ügülerün'* [тэр үгэнд Жамуха хажуу тийш зайлан гарч, нөхөддөө үгүүлэрүүн](MNT 170) Профессор I. de Rachewiltz энэ үгийг *'set apart'* (хажуу тийш болоод) гэж орчуулжээ.

Болдог |böldegen|{< *büli-deg*} *'төмсөг'* || Ж= ***böldegeni*** *arasun* 'scrotum' (Mu. 123) // *böldegen* 'testiculi' (Mu.123) // *böldöge* 'testicule' (Ist. 21) // *bülde-gen* 'Testikel' (LH 1265) // *böldöge* 'the testicles' (Ras. 199 A12) // *büldäg* 'tes-ticle' (Zir. 94)

Болзог |böleJeg| *'бөгөж'* || Cf. AT *bilēzük* 'bracelet' (Clauson 345), Turk. *biläzük* 'браслет' (ДТС 99), *biläzük* 'браслет', 'кольцо' (Щербак 1997, 106) || Ж= *'qaγan ber nigen bös kiged* ***bölüjüg****-iyen öggüged'* [хаан бээр нэгэн бөс хийгээд бөгөжөө өгөөд](Chimeg 47a) // *bilezüg* 'кольцо' (Mu. 119) // *biläzük* 'браслет' (IM M129) || Kha. *böldzög*, Ord. *beledžik*, Bur. *bügeže*, Oir. *biltsəg*

Болог |bölög|{< *böl* + *g*} *'хэсэг', 'бөөн'* || Cf. Turk. *böl-* 'делить, разделить, отделять' (Радлов IV:1699), AT *bölüg* 'часть, доля' (ДТС 117), AT *bölük* 'section, part' (Clauson 339), *büleg* 'отдел', 'глава' (Щербак 2005, 31) || Ж= *'Tüŋgelig ǧoroqan huru'ū nigen* ***bölög*** *irgen newüjü'* [Түнгэлиг горхи руу нэг хэсэг хүн нүүж](MNT 5) // *'Jorin irügekü arbadaγar* ***bölög****-ün tayilbur Joqiyaju daγusbai* [зорин ерөөх аравдугаар бөлөгийн тайлбарыг зохиож дуусав](BT 166a 2) // ***bölük*** *irgen* 'толпа людей' (Mu. 123) || х о р ш : *'анги бөлөг', 'хэсэг бөлөг'* || Kha, Bur. *büleg*, Ord. *bölög*, Oir. *böl^{s}g*

Бөөр |böger-e| *шээс боловсоруулах хос эрхтэн* || Cf. Turk. *böräk* 'die Niere' (Радлов, IV:1698); AT. *bögür* 'почка' (ДТС 116), *bögör* 'kidney' (Clauson 328), Uig. *böräk* 'kidney' (Schwarz 82) || Ж= *'Jarim-ud* ***bōger-e*** *elige idekün'* [зарим нь бөөр, элэг идэх](Burq.55b) // *bö'ēre* 'rein' (HY M43) // *bö'ēre* 'почка' (IM 434) // *börek* 'les reins' (Ist. 21) // *bōre* 'die Taillengegend' (LH 1266) // *böire* 'kidney' (Ras.199 A1) || Kha. *bōr*, Ord. *bōrö*, Bur. *bōre*, Oir. *bōr^{s}*

Бөөс |bögesün|[= böge-sün] *'амьтаны цус сорогч жижиг шавж'* || Ж= *bö'esün* 'pou' (HY M43) // *alaba* ***böwēsüni*** 'убил вошь' (Mu. 97) // *büsün* 'вошь' (IM M128) // *bösün* 'Laus' (LH 1266) // *bösün* 'louse' (Ras.200 A7) // *bōsün* 'вошь' (Qaz. Po 202) // *bösün* 'louse' (Zir. 92) || х о р ш : *'бөөс хуурс'* || Kha, Ord. *bös*, Bur. *bōhen*, Oir. *bōs^{s}n*

Бөрт |böritü|{< böri + tü} *'чоно'* || Cf. Turk. *böri* 'волк' (ДТС 118), Uig. *börä* 'wolf' (Schwarz 82) || Ж= *'de'ēre teŋgeri-eče Jaya'ātu töregsen* ***Börte****-činō aju'ū'* [дээд тэнгэрээс заяатай төрсөн Бөртэ чино ажгуу](MNT 1-2)

Т у с х а й с у д а л г а а : I. de. Rachewiltz, A Note on the Word *Bōrte* in the *Secret History of the Mongols*, EAH 13/14, 1997, 153-155

Бөс |bɔ̈s|{< Uig. *bɔ̈z* < Chin. *bù zi* 'хөвөн даавуу' || Cf. Turk. *boz* 'Baumwollstoff' (304), *bɔ̈z* 'бумажная материя' (Радлов, IV:1706) || Ж= ***bɔ̈s ba yonggod soyurqaju ilemü*** [бөс болон утас соёрхон илгээмүү](KMQB B16) // *bɔ̈z* 'ткань' (Mu. 124) // *bɔ̈z* 'Leinwand' (LH 1266) // *bɔ̈z* 'cotton' (Ras.205 B25) // *büz* 'fine white linen', 'cotton' (Zir. 94) || х о р ш : *'бөс даавуу'*, *'бөс бараа'* || Kha, Ord, Oir. *bɔ̈s*, Bur. *büše*

Бөх I |bɔ̈ke /bɔ̈kɔ̈| *'хүчтэн'* // Pl. *bɔ̈kɔ̈s* (Sul. 13 || Cf. Turk. *bökä* 'силач, борец' (Радлов, IV:1693); *bɔ̈kä* 'герой' (ДТС 116-117); Man. *bükü* 'сильный' (Цинциус I:105) || Ж= *'Büri-bɔ̈kɔ̈ ulus-un bɔ̈kɔ̈ Belgüdei-ye niru'ü-bān quguldaju ükübe* [Бүри бөх уласын бөх Бэлгүүдэйд нуруугаа хугалуулж үхэв](MNT 140) // *'maši kücütü jayan bɔ̈ke-yi öcügüken jayačin boyolčilan jarumui'* [маш хүчит заан бөхийг өчүүхэн заанчин боолчилон зармуй](Sub. IV:4b) // *böke* 'сильный' (Mu. 123) // Эртний монгол хэлэнд хүч чадалын бэлгэдэл болсон энэ үг хүний нэрд олонтаа хэрэглэгддэг байсаны жишээг МНТ-оос мэдэж болно. || Ж= *Čiduqul-bɔ̈kɔ̈* (MNT 41), *Büri-bɔ̈kɔ̈* (MNT 50), *Čilger-bɔ̈kɔ̈* (MNT 111) || Kha. *bɔ̈x*, Ord. *bɔ̈ᵗxɔ̈*, Bur. *büxe*, Oir. *bɔ̈kᵃ*

Бөх II |bɔ̈kū| *'тэмээний бөх'* || Cf. PT **bök* 'hump' (Starostin 350) || Ж= *temēnü* ***bɔ̈kün*** 'верблюжий горб' (Mu. 345) // *bökkän* 'hump of a camel' (Zir. 92) // *bɔ̈ketü* 'hunch-backed' (Ras. 204 A18) || Kha. *bɔ̈x*, Ord. *bɔ̈ᵗxɔ̈*, Bur. *büxe*, Oir. *bɔ̈kᵃ*

Бөх* III |bɔ̈kū| *'бөхий-'* гэсэн утгыг хадгалсан язгуур || Cf. Turk. *bök* 'сгибать, прогибать' (Радлов, IV:1716), AT *bük-* 'to bend, bow' (Clauson 324) || Энэ язгуураас *bɔ̈kūčü* [bɔ̈kü-čü] 'бөхц-', *bɔ̈kügene* [bɔ̈kü-gene] 'бөхгөнө-', *bɔ̈küger* [bɔ̈kü-ger] 'бөхгөр', *bɔ̈külje-* [bɔ̈kü-lje] 'бөхөлз-', *bɔ̈küski* [bɔ̈kü-ski] 'бөхөсхий-', *bɔ̈kütü* [bɔ̈kü-tü] 'бөхт', *bɔ̈kütür* [bɔ̈kü-tür] 'бөхтөр', *bɔ̈küyi* [bɔ̈kü-yi] 'бөхий-' гэх мэт нийлмэл бүтэцтэй үгс үүсчээ.

Бөхгөр |bɔ̈kūger|[= bɔ̈kü-ger] *'бөгтөр'* || Kha. *bɔ̈xəgör*, Ord. *bɔ̈ᵗxɔ̈gɔ̈r*, Oir. *bɔ̈kᵇgör*

Бөхий- |bɔ̈kūyi|[= bɔ̈kü-yi] *'тонгойх'* || Ж= *'sečen biligten kücüten köbegüd činü tegün-e* ***bɔ̈keyimüi'*** [сэцэн билигтэн хүчтэн хөвгүүд чинь түүнээ бөхиймүй] (Burq. 42a) // *'üsün-iyen saqal-iyan čayiju ülemji maši* ***bɔ̈keyigsen*** [үс сахал нь цайж, үлэмж ихээр бөхийсөн](Burq. 8a) // ***bɔ̈keihe*** *öbügen* [старик стал согбенным](Mu. 123) || Kha. *bɔ̈xī-*, Ord. *bɔ̈ᵗxī-*, Bur. *büxī-*, Oir. *bɔ̈kī-*

Бөхийлгө- |bɔ̈keyilge|[= bɔ̈kü-yi-lge] *'тэргүүнээ тонгойлгох'*, *дорогш буулгах* || Ж= *'modun-u gešigün-i doruyši bolyaju ög kemebesü tegünčilen* ***bɔ̈keyilgejü'*** [модны гишүүг дорогш болгож өг хэмээвээс хэлсэнчилэн бөхийлгөж] (Burq. 42b) || Kha. *bɔ̈xīlgɔ̈-*, Ord. *bɔ̈ᵗχīlgɔ̈-*, Bur. *büχīlge-*, Oir. *bɔ̈kīlgə-*

Бөхөлз- |bɔ̈külje|[< bɔ̈kü-lje] *'олонтаа бөхийх'* || *'Данзан хариу хэлэлгүй* ***бөхөлзөв'*** (Д. Намдаг, Цаг төрийн үймээн) || Kha. *bɔ̈xɔ̈ldzə-*, Ord. *bɔ̈ᵗxɔ̈ldzi-*, Bur. *büxelze-*, Oir. *bɔ̈kᵇlzə-*

Бөхс |bɔ̈gse| *бэлхүүснээс дээшхи биеийн хэсэг* || Cf. Turk. *böksä 'часть туловища выше поясницы'* (Радлов, IV:1695), *böksäk* 'верхняя часть груди' (Щербак, 1997, 109) || Ж= *'kücütü-yin küjü'ün, bökö-yin* ***bökse*** *daruju ögbe je či'*

[хүчитийн хүзүү бөхийн бөхсийг ларж огов чи](MNT 209) // ***bökse*** *yeke boluqsan et* || х э л ц : *'бөхс долоох'* (хуурамчаар билдуучилах), *'бохс ухах'* (мууг нь үзэх) || Kha. *böχsə*, Ord. *bögsö*, Bur. *bügse;* Oir. *böks*[0]

Бөхто |bökütü|[= bökü-tü] *'бохтий'* Энэ язгууraас *bökütügene-* [bökü-tügene] 'бөхтөгөнө-', *bökütüger* [bökü-tü-ger] 'бөхтөгөр', *bökütülje-* [bökü-tü-lje] бөхтөлэ-', *bökütüyi-* [bökü-tü-yi] 'бөхтий-' зэрэг олон үг үүссэн байна.

Бохцо |bökücü|[= bökü-cü] *'бөгций'* гэсэн утгыг хадгалсан язгуур. Эл язгууraас *bökücügene-* [bökü-cü-gene] 'бөхцөгөнө', *bökücüger* [bökü-cü-ger] 'бөхцөгөр' гэх зэрэг үгс үүсчээ.

Брайль |brail|{< Rus. *брайль* < Fr. *braille*] *'барайль'* (хараагүй хүнд зориулсан товгор цэгэн үсэг. Энэ үсэгийг харааны бэрхшээлтэй хүү Louis Braille 1821 онд 15 настайдаа зохиожээ.)

Брезент |berjent|{< Rus. брезент} *'бэрзээнт'* (ус нэвтэрдэггүй нягт зузаан өрмөг)

Бригад |brigad|{< Rus. *бригада* < Fr. *brigade*} *цэрэгийн анги нэгэдхэл* (Энэ үг зөвхөн цэрэгийн анги төдийгүй, үйлдвэр худалдаа, үйлчилгээний газар зэрэг зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулж байгаа хэсэг бүлэгийг нэрлэдэг) || Ж= *'Норов нь нэгдэлийн ногоо* ***бригадад*** *төмөс ногооны мастераар ажиллаж байгаа гэнэ'* (Ц. Дамдинсүрэн, Шарав, Норов хоёр) || Kha. *bargiād*, Bur. *birgād*

Бронз |boronz|{< Rus. *бронза* < Fr. *bronze*} *'боронз'* (зэс, цагаан тугалга хоёрыг нийлүүлсэн мөнгөлөг өнгөтэй нунтаг.)

Брэнд |brend|{< Eng. *brand*} *'бэрээнд'* (нэрд гарсан, сайн чанарын шилдэг бүтээгдэхүүн болон түүний ялгах тэмдэг)

Буг |buγ| *'ад чөдхөр'* || *'Ямар* ***буг*** *шулам чамд ийм арга зааж өгсөн юм бол!'* (Б. Ринчен, Шүхэрч Буниа) || х о р ш : *'буг чөдхөр'* || Kha, Ord, Bur, Oir. *bug*

Буга |buγu| *олон салаа эвэртэй үзэсхэлэнт гөрөөс* || Cf. Uig. *buğa* 'deer' (Schwarz 88) || Ж= *'hoi dotora uriyāqadai kü'ün čö'ē* ***buğu*** *alaǰu'* [ой дотор урианхадай хүн чөө буга алж](MNT 12) // *buqu* 'cerf' (HY M43) // ***buγuyin*** *tuγul* 'теленок оленя' (Mu. 124) // *buqu* 'deer' (Ras.199 C26) || Kha, Bur, Oir. *buğa*, Ord. *buğu*

Бугау |baγuu| х у у ч : *'дөнгө'* (хэрэгтэний толгойд углаж түгждэг хүнд хавтагай мод) || Cf. Turk. *buqaγu* 'chain', 'string' || Ж= ***'buğa'ū*** *inu čučalǰu, galdur tülejü'* [гавыг минь салгаж галд түлж](MNT 85) || Ж= *köldēn* ***buqa'ū*** okiba [наложил на свои ноги кольца](Mu. 222) // *baγu* 'браслет' (IM M128) // *buğân* 'bracelet' (Ras.205 C15) || Эрт цагт гэмтэний хоёр гарыг холбодог модон дөнгийг нэрлэж байгаад хожимоо хэрэгтэний хүзүү, хөлөнд угладаг нүхтэй том хавтагай модыг нэрлэх болжээ

Т у с х а й с у д а л г а а : Ш. Чоймаа, *«Mongyol-un niγuča tobčiyan»*-u *'buqaγu'* kemekü üge-yin toγurin-du sinjilekü ni, ÖMNŠU 3, 2001, 56-62 // *'Монгол сурвалж судлал'*, Уб., 2017, 141-149

Бугуй | buγuu| *'гарын шууны яс'* || Cf. Turk. *bukağı* || Ж= *'gelbüre kö'ün-eče buga'ū tataǰu abču'* [тэр гэнэн хүүгийн шуунаас нь татаж](MNT 81) // *'köldēn* ***buqa'ū*** *okiba'* [наложил на свои ноги кольца](Mu. P 222) // *baγū* 'браслет' (IM

433) || Энэ үгээс *buγubči* [buγu-bči] 'бугуйч', *buγuγili* [buγu-γi-li] 'бугуйл' гэх мэт үгс үүсчээ. || Kha. *buǧui*, Ord, Bur, Oir. *buǧū*.

Бул I |bud|{< Skr. *budha*} *'үлэмж гараг'* буюу *лхагва гараг* (усан махбодтой, ягчисын сүлд гараг. Эдийг бүтээх, худалдаа арилжаа хийх, хишиг даллага авах, үсэг зурхайд суралцахал сайн өдөр гэж зурхайн сударт заасан байдаг байна.)

Буд* II |budu/ buda| *'будангуй', 'бүрхэг'* гэсэн утгыг хадгалсан язгуур. || Cf. Man. *budu* 'краситъ' (Цинциус I:102) || Энэхүү язгуураас *buduγ* [budu-γ] 'будаг', *buduγači* [budu-γači] 'будаач', *buduγda-* [budu-γda] 'будагд-', *budaγu* [budu-γu] 'будагуу', *budung* [budu-ŋ] 'будан', *budungγui* [budu-ŋγui] 'будангуй', *budura-* [budu-ra] 'будар-', *budumal* [budu-mal] 'будмал' гэх зэрэг олон шинэ үгс үүсчээ.

Будагуу |budaγu|[= buda-γu] *'тэнэгдүү', 'мунхаг'* (Энэ үг нь *'будангуй'* гэсэн үгийн *budung* гэсэн язгуураас үүсэлтэй. I de Rachewiltz тус үгийн утгыг англи хэлний *'stupid', 'foolish', 'half-wit'* гэсэн үгээр дүйлгэн буулгажээ) || Ж= ***budaγu*** *kümün sadun-iyan qoqirayulǰu ǰad kümün-i teǰigegčin-i ber üǰebe'* [мунхаг хүн саданаа хохироож, харийн хүнийг тэжээсэнийг үзэв](Sub.12b)// *'Bodončar-a muŋqaǧ* ***budawī*** *buγu ke'ēn uruǧ-a ülü to'ān, qubi ese ögbe'* [Бодончар мунхагийг тэнэгдүү хэмээн урагт үл тооцон хувь өгсөнгүй](MNT 23) || Oir. *budū*

Тусхай судалгаа: Ц. Шагдарсүрэн, *'Үлгэрийн далай'*-н нэгэн монгол орчуулга дахи *budaγun* гэдэг үгийн тухай, *Quæstiones Mongolorum Disputatæ*, Association for International Studies of Mongolian Culture, Tokyo, 2, 2006, 171-181

Будан |budung|[= budu-ŋ| *'манан'* || Ж= *'öŋgür* ***budan****-dur ese tö'ōribe'* [өнгүр мананд төөрсөнгүй](MNT 213) // *budan* 'туман' (Mu. 124) || Ж= *'буурал Кремлийн дээр нал эрдэнийн улаан одон* ***будантай*** *шөнө тодхон гийдэг'* (Б. Ринчен, Москвад баяр хүргэе) || х о р ш : *'манан будан', 'униар будан'* || Ord, Bur, Oir. *budaŋ*

Будангуй |budungγui|[= budu-ŋγui] *'бүрхэг', 'мунхаг'* || Ж= *'üǰügür qiǰaγar ügei* ***budungγui*** *irgen-dür törüǰü'* [хэмжээ хизгааргүй мунхаг хүмүүн болон төрж](BTO IV:1) || Kha. *budaŋgui*, Bur. *budaŋgy*, Ord. *budaŋg"ī*, Oir. *budɒŋgū*

Будлан |budalan|{< Tib. *po ta la* < Skr. *poṭala*} *'онгоц баригч'* (Лhас хот дахь уулын орой дээрхи Далай ламын ордон)

Буйдан |buyidang|{< Chin. *pūdiàn*} *'олбогт дэвсэхэр'* (түшлэгтэй зөөлөн суудал).

Бул |bulu| *'тэрэгний бул'* (тэрэгний голын эргэлдэх булцуу) || Cf. Uig. *bul* 'vehicle', 'hub' (Schwarz 88); *bul* 'втулка у колеса' (Радлов, 1834) || Kha. *bul*, Ord. *bulu*, Bur. *bula*, Oir. *bul*"

Бул- I |bula| *'газар дор дарагдах'* || Ж= *'Төмөр босож дээл хувцасаа тайлан, заримыг нь газар булж, заримыг нь гүвж сэгсэрэн өмсөв'* (Ч. Лодойдамба, Тунгалаг тамир) || Энэ үгээс *bulaγ* [bula-γ] 'булаг', *bulayda-* [bula-γda] 'булагд-', *bulasi* [bula-si] 'булш' зэрэг үг салаалан гарчээ.

Бул- II |buli| *'булаа'* гэдэг үгийн анхдагч язгуур || Ж= *'yau ke anu* ***buliǰu*** *tataǰu büü abturγai'* [юу ч булааж татаж бүү автугай](Khub. II:28) // *'ebečin*

jobalang ber amitan-u öngge čirai-yi ***buliǰu'*** [өвчин зовлон амьтаны өнгө зүсийг булааж](Burq. 5b) // *'Temüǰin, Qasar qoyar-ača Begter, Belgüdei qoyar* ***buliǰu abuba'*** [Тэмүжин, Хасар хоёроос Бэгтэр, Бэлгүүдэй хоёр булааж авав](MNT 76)

Булаа- |buliy-a|{< buli-ya} *'хүчээр булааж авах'* || Cf. Turk. *bul-* 'to find' || Ж= *'darasun miqa kiged ed bügüde* ***buliyan'*** [дарас, мах хийгээд эд бүгдийг булаан](Ail.6) // *'****buliyaǰu*** *abuɣsan morin'* [булааж авсан морь](Qqot. IV) || Kha, Ord, Oir. *bulā-*, Bur. *bulyā-*

Булаг |bulaγ|{< *bul-γ} *'газар дороос ундаран гарах ус'* || Cf. AT *bulaq* 'Quelle' (Gabain 305), *bulaq* 'источник' (ДТС 121), *bulak* 'a spring /of water/ (Clauson 336), Turk. *bulak* 'Quelle' (Räsänen, 87); *bolak* 'родник' (Цинциус I:91) || Ж= *'****bulaɣ*** *öbesün es-e ele širgibesü širuɣai-bar darun qamiɣa čidaqu'* [өөрөө ширгээгүй булагийг шороогоор дарсан ч яаж булах](Sub.VII:8b) // *'mɑɣui* ***bulaɣ*** *jun debülün urusuyu'* [муу булаг зун дэвэрэн урсана](Sub. V:5b) // *bulaq* 'source' (HY M43) // *qala'ūn* ***bulaq*** 'горячий источник' (Mu. 289) // *bulaq* 'sources' (Ist. 22) // *bulaq* 'spring', 'source' (Ras.201 C1) || х о р ш : *'булаг шанд', 'булаг ус'* || Kha, Bur. *bulag*, Ord. *bulak*, Oir. *bul"ğ*

Булга I |bulγa| *'хүү mamax', 'mac mamax', 'тулалдах'* гэсэн утгыг илдхэсэн язгуур. || Ж= *Gür qan abaǧa-lu'ā-bān* ***bulǧa*** *bolulčaǰu'* [Гүр хан авгатайгаа тулалдаж](MNT 150) // *bulγa* 'сражение' (IM. 434) // *bulγaγ* 'сражение' (IM M128) || Энэхүү язгууралс *bulγala-* [bulγa-la] 'булгал-', *bulγara-* [bulγa-ra] 'булгар-' гэсэн үндэс үүсчээ. || Kha. *bulŋğo*, Oir. *bulğ"*

Булга II |bulγa| х у у ч : *'харийнхан', 'дайсан'.* || Cf. Turk. *bulγa* 'aufruhr' (Räsänen, 88) || Ж= *'yeke törü-yin emün-e küčü öggün yabuɣad* ***bulγ-a-yi*** *burčiysan-u qoyin-a'* [их төрийн өмөнө хүчээ зориулан яваад самууныг дарсаны дараа](Hin.20) // *'Il* ***bulγa*** *irgen-dür kürbesü büsiretügei, ayutuɣai'* [харийн дайсагнагч иргэнд хүрвээс биширтүгэй, айтугай](Gü.4-6) Энэ үгүүлбэрийг P. Pelliot *'S'il arrive à des peuples soumis et [à des peuples] révoltés, qu'ils le respectent et qu'ils craigment'* гэж орчуулсан байна. (*Mongols et Papauté*, 22) || Орчин цагийн монгол хэлэнд уг үгийн *'мулт'* гэсэн хувилбар нь элбэг тохиолддог.

Булгалд- |bulqaldu|{< *bulqa-ldu*} *'тулалд-', 'тэмцэлд-'* || Ж= *'ǧurban sönid, ǧurban üdüd* ***bulǧaldurun'*** [гурван шөнө, гурван өдөр тулалдарун](MNT 185) // *'öber ǰaɣuraban* ***bulγalduǰu*** *ugilaldun ebčegüben deledbei'* [өөр зууралс тэмцэлдэж уйлалдан чээжээ дэлдэнэ](Burq. 64b)

Бульдозер |bulidozer|{< Rus. *бульдозер* < Eng. *bulldozer*} *'бүлдоозор'* (түрж, өргөдөг трактор)

Булигаар |buliγar|{< Pers. *bulγārī*}] *'боловсоруулсан шир'* (Перс гаралтай энэ үг болгар хэлнээс орос хэлээр дамжин монгол хэлэнд орж иржээ.) || Kha. *bulğār*, Bur. *bulğair*

Булт |bulta| *'мултарах'* гэсэн үгийн язгуур. Энэхүү язгууралс *bultayi-* [bulta-yi] 'булгай-', *bultari-* [bulta-ri] 'мултар-' гэх зэрэг үг үүсчээ.

Бултар- |bultari|[= bulta-ri] *'мултарах', 'зайлах'* || Ж= *'erke-yi üǰebesü ary-a-bar* ***bultariyu'*** [бэрх үйлтэй тулгарвал аргаар мултарна](Sub. III:11b) // *berke-yi*

üjebēsü ary-a-bar ***bultariyu*** *'* [бэрхийг үзвээс аргаар мултарюу](Sub.3) // *'bidandur kešig oro'üldaqun haran* ***bultariju*** *'* [бидэнд хэшиг оруулах хүн зайлж](MNT 224) || Kha, Bur. *multar-*, Ord. *multur-*, Oir. *bultor*

Бум |bum|{< Tib. *'bum*} *'арван тум'* (зургаан оронтой тоо) || Kha, Ord, Oir. *bum*

Бумба |bumba|{< Tib. *bum pa*} *'хулх'* (нарийн амсар, бүдүүн биетэй алт, мөнгө, зэс, гуулиар хийсэн аршаатай сав) || Ж= *'найман тахил, есөн эрдэнэ, хүжний онгоц, бойпор, хулис, бумба'* (Б. Ринчен, Гүнж) || Kha, Ord, Bur. *bumba*, Oir. *bumb*ᵉ

Бундан |bungdan|{< Tib. *dpung ldan*} *'өмөг төгөлдөр'* (хөзөрийн зүрэх хэлбэртэй дүрс)

Бундариг |bundarig|{< Skr. *puṇḍarīka*} *'цагаан линхуа'* || Ж= *'Bodistv nar .. bariju irekü* ***bundarig*** *linqu-a'* [Бодисадва нар ... барьж ирсэн цагаан линхуа] (Burq. 53)

Бундхорол |bonduqurlu|{< Tib. *bon gto 'khor lo*} *'бомбын дарлагын хүрд'* (ад зэтгэрийн хорлолоос хамгаалах сахиус. Тэр нь хааш хаашаа нэмэхэд 15 болдог босоо, хөндөлөн, ташуу зураас бүхий яст мэлхийн дүрсийг тойруулан есөн мэнгэ, долоон гариг хорин найман од тэргүүтнийг байрлуулж, завсарт нь хас тэмдэг зурсан дүрс. Хожим түүнийг муу ад зэдхэрийг дарахыг бэлгэдэн гэрийн тодхон дээр залдаг болжээ. Бас холын аян замд явагсадыг аливаа муу зүтгийн хорлол зэдхэрээс хамгаалахын сахиус гэж үздэг байжээ.)

Бунхан |bungqan|{< Tib. *spungs khang*} *'цогцсын байшин'* (хаад ихэсийн шарилыг хадгалах газар) || Kha, Ord. *buŋxan*

Бурам |burma|{< Tib. *bu ram*} *'чихэрлэг жимэс'* (чихэрийн нишингээс гаргаж авсан чихэрлэг амттан) || Ж= *'sayaysan sün-dür* ***buram*** *šikir kiged-i qoliju'* [саасан сүүнд бурам, чихэр зэрэгийг холиж](Burq. 43b) || Kha, Ord. *buram*, Bur. *burma*, Oir. *burom*

Бурантаг |burantay|{< Turk. *burun* 'хамар' + *tay*} *'тэмээ хөтөлөх оосор'* || Cf. Turk. *burun* 'нос', 'клюв' (ДТС 1821), *burun* 'Nase' (Gabain 306), 'нос' (ДТС 126), AT *burun* 'nose' (Clauson 366), *burunduq* 'повод, прикрепляемый к продетому в нос верблюда стерженьку' (ДТС 126), AT. *burunduk* 'nosering for controlling animals, esp. camels' (Clauson 368), *burunduk* 'верблюжий намордник' (Радлов, 1824) || Ж= *unqasun buruntuq* 'шерстяной повод для верблюда' (Mu. 266) // *'buyur-a[yi] temegen bolyan yabubasu* ***buruntuy****-iyan setereyü'* [буурыг тэмээ болгон явуулвал бурантагаа сэтэлюү](AT 109b) // *burun* 'ridge of the nose' (Zir. 93) || Kha, Bur. *burantag*, Ord. *buruntuk*, Oir. *burontᵘg*

Бурга- |burya/ burgi| *'цацарах', 'бударах'* Энэ үгээс *buryaliy* [burya-liy] 'бургалиг' гэсэн үс үүсчээ.

Бургалиг |burqalig|{< burya-liy} *'бударан орох'* || Ж= *'nugud, galawud-un ödün hüsün anu* ***burqaliğ*** *časun metü butaraju'* [нугас, галууны өд үс бударах цас мэт бутарч](MNT 31)

Бургер |burger|{< Rus. *бургер* < Ger. *Hamburg + er*] *'бүүргэр'* (анх Германы Хамбүрг хотод гарсан хачиртай талх. Бургер нь мах, ногоо, бяслаг хавчуулсан

байдаг бөгөөд үндэсэн хавчуургаар нь *cheeseburger* 'бислагтай бургер', *chickenburger* 'тахианы махтай бургер' гэх мэтээр нэрлэдэг.)

Бурги- |burgi|{< bur-gi} *'оргил-', 'бужигна-'* || Kha, Ord. *burgi-*, Bur. *burja*

Дал II |dal|{< Skr. dala} *мөчиргүй, цэх шулуун шилбэтэй дэвүүр мэт том навчтай халуун ороны мод.* || Ж= *'****dal-a*** *modud-un emün-e niǰiged erdini kib-iyer čimegtü ǰedküger talbiǰu'* [дал мододын өмөнө тус бүр эрдэнийн хив торгоор чимсэн зэдхэр тавиж](Burq. 46b) // *'****dala*** *modun kiged nüdügür modun'* [дал мод хийгээд нүдүүр мод](Chimeg 21b) || Kha. *dal*

Дала(н) |dala(n)|[= *dal-n] *'70'* (Уттаа долоо /7/, *'дал'* /70/ гэсэн тооны үгийн анхдагч язгуур. || Ж= *'arban naimaduyar on ǰirγuγan sara-yin arban dörben-e ǰöb* ***dalan*** *doluγan nasun-dur-iyan ebedčin-iyer ügei bolǰuγu'* [арван наймдугаар оны зургаан сарын арван дөрвөнд яг далан долоон насандаа өвчинөөр үгүй болжээ](Hin. 36) // ***dalan*** *minqan* 'семьдесят тысяч' (Mu. 138) // ***dalan*** 'siebzig' (LH 56)

Дам |dam| *'дамжих'* гэсэн утгыг хадгалсан язгуур. Энэхүү язгууруас *damǰi-* [dam-ǰi] 'дамжих', *damla-* [dam-la] 'дамла-', *damna-* [dam-na] 'дамна-' гэх мэт үгс үүсчээ.

Дамар |damaru|{< Skr. *damaru*} *'жижиг хэнгэрэг'* (шашины зан үйлд хэрэглэдэг товчин цохиуртай, дундууpаа хотгор, хоёр талдаа арисан цартай жижиг дэрэвгэр хэнгэрэг) || Kha. *damar,* Ord. *ramuri*, Bur. *damāri,* Oir. *dam^{v}r*

Дамж- |damǰi|[= dam-ǰi] *'шилжих'* Энэхүү язгууpаас *damǰiya* [dam-ǰi-ya] 'дамжаа', *damǰilγa* [dam-ǰi-lγa] 'дамжилга', *damǰiγul-* [dam-ǰi-γul] 'дамжуул', *damǰiγur* [dam-ǰi-γur] 'дамжуур' гэх зэрэг нийлмэл бүтэцтэй үгс үүссэн байна. || х э л ц : *'ам дамжих'* (цуу яриа тархах), *'гар дамжих'* (олон хүн дамжин шилжих)

Дамжаа |damǰiy-a|{< Tib. *dam bca'*} *'гэрчилсэн бичиг'* (Бүддийн гүн ухааны судар тарнийн олон шатны сургалтыг дамжин суралцаж, ном хаялцан мэдхэлцэх шат. Бурханы шашины шаталсан сургалтад гавжийн дамжаа, агримбын дамжаа, маарамбын дамжаа, зээрэмбийн дамжаа зэрэг шатлалууд байдаг. Орчин үед аливаа түр сургалтыг ийн нэрлэх болжээ.) || х э л ц : *'дамжаа барих'* (бүддийн гүн ухааны олон шатны сургалтыг дүүргэж, эрдэмийн зэрэг хамгаалсан хүнд барих хүндэдхэлийн зоог) Kha. *damdžā,* Bur. *damžā*

Дамжиг |damǰiγ|{< Tib. *dam tshig*} *'тангараг'*. Монгол хэлэнд *'эргэлзээ'* гэсэн утгаар хэрэглэгддэг || Ж= *'дамын үг* ***дамжигтай****, холын үг хуудуутай'* (Д. Намдаг, Цаг төрийн үймээн)

Дампуу |dampuu|{< Chin. *dàng pu*} хугацаатай барьцаалан зээлдүүлэх газар (зээлдэн барьцаалсан эд юмсаа эргүүлэн авч чадахгүй болохыг *'дампуурах'* гэдэг байжээ) || Kha. *dampū,* Ord. *daŋpū*

Дамшваа |damiseyiba|{< Tib. *bkra mi shis pa*} *'өлзий бус'*

Дамшиг |damsiγ|{< Tib. *dam bshig*} *'тангарагаа эвдэх'* (мөрдвөл зохих сахилаа алдсан хувараг. Хожим утга нь шилжиж, *'бүтэлгүй амьтан', 'томоогүй золиг'* гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ.) || Kha. *damšig*

Дан |dang|{< Tib. *gdangs*} *'ая'* (ая дан)

Дандар |dandar|{< Uig. *dantira* < Skr. *tantra*} *'нууц сургаал'* (Бүддийн шашины номлол дахь их хөлгөний аймагийн тарнийн ёсны сургаал) || Kha. *dandar*

Данжаад |dangǰiyada|{< Chin. *dāng jia de*} *'гэрийн эзэн', 'өрхийн тэргүүн'* (хитад пүүсийн эзэн)

Данжуур |danǰuur|{< Tib. *bstan 'gyur*} *'шастирын орчуулга'* (эртний энэдхэг, төвөд эрдэмтэдийн их, бага арван ухаанаар туурвисан 4300 гаруй

зохиолын цоморлиг. Монголчууд XVIII зууны үеэс анхдугаар жанжаа хутагт Агваанчойндон, Ролбидорж нарын удирдлагаар *'Данжуур'*-ын бүрэн орчуулгыг хийж дуусхаад 225 ботиор хэвлүүлжээ.) || Kha, Ord, Oir. *dandžūr*

Данласун || х у у ч : *'дов толгой'*. Ж= *'Dayir-etügen-i **daŋlasun**-u tedüi bükü-eče'* [Дайр-этүгэнийг дов толгой төдий бүхийгээс](MNT 245)

Данх |dangqu|{< Chin. *tóng hú*} шингэн зүйл хийх сэнжтэй метал сав. || Kha. *daŋʰxл*

Данхараад ||{< Rus. *домкрат*} *'данхараад'*, *'өргүүр'* (машины дороос тулж, хөндийрүүлэх авсаархан өргүүр) || Kha. *daŋʰxarāt*

Даншиг |danšuy|{< Tib. *bstan bzhugs*} *'бат оршил'* (1696 онд анхдугаар Богд Занабазарын насан хутаг өнө удаан бат оршихын бэлгэдэл болгон зохион байгуулсан наадам. Анхандаа гурван жил тутам хийж байсан бол наймдугаар Богдын үед жил тутам хийх болжээ) || х о р ш : *даншиг наадам* || Kha. *daŋšig*

Дар- |daru| *'хучил-'*, *'хавч-'*, *'шах-'* Ж= *'šimnus-un ayimay-i **daruju**'* [шулмасын аймагийг дарж](Burq. 49b) // *'küčütü-yin küjü'ün, bökö-yin bögse **daruju** ögbe je či* [хүчитийн хүзүү, бөхийн бөгс дарж өгөв чи](MNT 209) // *'**daruba** dušmani'* [подавил врага](Mu. 138) || Энэхүү язгууртаас *daruya* [daru-ya] 'дарга', *daruyda-* [daru-yda] 'дарагд-', *daruyul-* [daru-yul] 'даруул-', *darula-* [daru-la] 'дарла-', *darumal* [daru-mal] 'дармал' гэх мэт үг үүсч, уламаар тэдгээрээс өөр олон шинэ үг салбарлан гарчээ. || х э л ц: *'өр дарах'* (өгцөөгөө өгч дуусгах), *'нас дарах'* (өндөр настай болох), *'хөл дарах'* (олон хүн цугларах) *'хар дарах'* (аймшигтай зүүд зүүдлэх), *'шил дарах'* 'ар араасаа давхцах' || Kha, Oir. *dar-*, Ord. *daru*, Bur. *dara-*

Дар |dara|{< Skr. *tāra*} *'гэтэлгэн үйлдэгч'* || Ж= *'Sujati neretei ökin-ü šibegčin **Dari** neretei ükiju'* [Сужати нэртэй охины Дари нэртэй шивэгчин үхэж](Burq. 41b) // *'**Dar-a** eke-dür soyurqa'* [Дар эхэд соёрх](Arj. II:3)

Дар эх |dari eke|{< Skr. *tāra* + eke} *'гэтэлгэн үйлдэгч эх'* (Буддийн ёсонд найман аюулаас гэтэлгэгч *дар эх*-ийг *'ногоон дар эх'*, *'цагаан дар эх'* гэсэн хоёр янзын *дар эх* байдаг байна.) || Ж= ***Tar-a** eke-dür mörgümü bi* [Дарь эхэд мөргүмү би](Arj. II:2)

Дарга |daruya|{< *daru* + *ya*} *'удирдагч'*, *'тэргүүлэгч'* // Pl. *daruyas* || Cf. Turk. ***daruγa*** 'chef eines Bezirks od. einer Stadt' (Räsänen 133); Man. *darugā* 'староста' (Цинциус I:200) || Ж= ***'daruyas** noyad-tača ečinegün aduyusun qonin qudalduqu'* [дарга, ноёдоос далдуур адуус, хони худалдах](Turf. 27) // ***daruγa*** 'начальник' (Mu. Suppl.403) // ***daruγa*** 'правитель' (IM M134) // ***darugā*** 'major' (Ras.198 A29) || Түрэг хэлэнд адил утгатай *daruya* гэсэн үг байгаа болович *daru-* гэсэн үйл үг байхгүй байгаагаас үзвэл энэ нь монгол хэлнээс зээлдэн авсан үг бололтой. || х о р ш : 'дарга сайд' || Kha. *darʊğʊ*, Ord. *darğu*, Bur. *darğa*, Oir. *darğʊ*

Т у с х а й с у д а л г а а : V. Minorski *'Darugha, in Mongolian 'chief', is a common administrative term. Judging by the Ahsan al-tavārīkh*, 489 (v, i., p. 185) *it was applied to governors in general, but in later times was more particularly used as the title of the governer of the capital. On the other hand, in large government*

departments the head clerks controlling the staff were also called darugha. (A Manual of Safavid Administration, Persian Text in Facsimile, London, 1943, 141) // F. W. Cleaves *'The most literal meaning of daruγa, a nomen imperfecti in form, but a nomen actoris in function, would appear to be «the presser» in the sense of «that which presses» or «the one who presses»'* (Daruγa and Gerege, HJAS 16, 1953, 250)

Даргач |daruγači|[= daru-γa-či] *'ахлагч', 'захирагч'* || Ж= *'**daruγači** anda-yin erdini-tü bey-e-yi engke amuγulang-i ögčü ilegsen bičig'* [ахлагч андын эрдэнэт биед энх амагаланг хүсэж илгээсэн бичиг](Qqot.IX) // *'balaġad balaġad-tur **daruğačin** talbiǰu'* [хот хотын дарга](MNT 263) // *daruγači* 'правитель' (IM 435)

Даржин |darǰin| *'багц хив'* (Бурханы шашины сүнэс дуудах зан үйлд хэрэглэдэг 5 өнгийн маш нимгэн хив. Хожим чанар муутай нимгэн даавууг ийн нэрлэж байсанаа нь утга нь шилжиж *'ядуу марчиг'* гэсэн утгатай болжээ)

Дарма |darma|{< Uig. *darm* < Skr. *dharma*} *'ном'* Tib. *chos* 'чой' (Буддийн сургаал дахь *бурхан, ном, лам* гэсэн гурван их эрдэнийн нэг) || Ж= *'Darm-a-čari neretü tngri-yin köbegün* [Дарма-чари нэрт тэнгэрийн хүвүүн](Burq. 17a)

Дархан |darqan| *'чөлөөт иргэн'* (гавъяа байгуулж, алба татвараас чөлөөлөгдсөн хүнд хөхиүлэн олгодог цол байжээ) // Pl. *darqad* || Ж= *'imayi itegeltü tuγ-tu čerigüd-ün noyan bolγan tüšiged **darqan** ner-e ber öggügsen aǰuγu'* [түүнийг итгэлт тугт цэрэгийн ноён болгон түшээд, дархан нэр өгсөн ажээ](Hin. 22) || Kha, Ord, Bur. *darxan,* Oir. *darxɒn*

Дарцаг |darčoγ|{< Tib. *dar lčog*} *'унжсан хив'* (хүрээ хийдийн үүдэн дээр хадхадаг гурван залаа бүчтэй тарнийн үсэг бүхий жижиг далбаа. Хожим бөс даавуугаар хийсэн иш бүхий жижиг далбааг хэлдэг болжээ.) || х о р ш : *муг дарцаг* || Kha. *dartsag,* Ord. *dartšuk,* Bur. *dardsag,* Oir. *dartsʊg*

Дарь |dari|{< Pers. *dārū*} *'тэсэрэх нунтаг'.* || х о р ш : *'дарь хүхэр'* || Kha. *darʲ,* Ord, Bur. *dari,* Oir. *där*

Датабааз |databaγaǰa|{< Eng. *data* 'мэдээ, баримт' + *base* 'суурь'} *'даата бааз'* (компьютерийн мэдээлэлийн сан)

Дах |daqu| *гадагшаа харсан сахалаг үстэй нэхий нөмөрөг.* || Cf. AT *yakū / daġgū* 'raincoat' (Clauson 898), Turk. *jaqu* || Ж= *Čotan eke-yin šidkül ke'ēn qara buluġan **daqu** abčiraǰu büle'ē'* [Цотон эхийн бэлэг хэмээн хар булаган дах авчирч](MNT 96) || х о р ш : *'дах дэгтий'* || Kha. *dax,* Ord. *daxu,* Bur. *daxa,* Oir. *daxᵘ*

Дацан |*dačang*|{< Tib. *grwa tshaṅg*} *'хүрээ', 'хуварагийн аймаг'* (Бурханы шашины лам хуварагуудын ном хурж, ёслол үйлдэх орон сүм) || Ж= *гэлэн Лувсанд шавь болгон өгч **дацанд** суулгасан юм.* (Ц. Дамдинсүрэн, Гологдсон хүүхэн) || х о р ш : *'сүм дацан'* || Kha. *datsan,* Bur. *dasan,* Oir. *datsᵊn*

Дашлхүмбэ |dasi lhungbu|{< Tib. *bkra shis lhun po*} *'өлзий хутагт Сумбэр уул'* (1447 онд анхдугаар Далай лам Гэндэндүв (1391-1475)-ийн Төвөдөд байгуулсан хийдийн нэр.)

Дашман |dašman|{< Pers. *dānišmand*} *'санваартан'* (Исламын шашины) || Cf. Turk. *dānišmän* 'gelehrter' (Räsänen 131) || Ж= *'toyid erkegūd šingšingūd **dašmad** aliba alba γubčiri ülü üǰen'* [тойд, эрхүүд, шиншинүүд, дашмад аливаа

алба гувчуур үл үзэн](Khub.1261:8-9) // *dašman* 'христианский ученый' (Mu. 164). *fetwa eribe dantšmanāsa* [просил мудрого о решении](Mu. 168)

Дашням |dasinim-a|{< Tib. *bkra shis nyi ma} 'өлзий хутагт өдөр'* (зурхайн ёсоор сард нэг удаа тохиолдох хутагт сайн өдөр)

Даяг |dayig|{< Tib. *brda yig} 'дохионы бичиг'* (Бурханы сургаал номлолын утга учирыг зүйлчилэн бичсэн толь бичиг)

Дезодрант |dezodrant|{< Rus. *дезодрант* < Fr. *desodorisant* 'анхилуун үнэрт'} *'дездараант'* (шүршиж хэрэглэдэг анхилуун үнэрт)

Декан |декан|{< Rus. *декан* < Ger. *Dekan*} *'дикаан'* (их сургуулийн салбарын захирал)

Диаметр |diameter|{< Rus. *диаметр* < Gr. *διαμετρος*} *'диамээтер', 'голч'*

Диваажин |divajan|{< Tib. *bde ba can} 'тэнгэрийн орон', 'амагалант орон'* (Бурхан сахиус орших ариун амагалан Авидийн орон) || Kha. *divādzin*, Bur. *divāzan*, Oir. *dewādzin*

Диван |divan|{< Rus. *диван* < Pers. *divan*} *'буйдан'* (түшлэгтэй зөөлөн суудал)

Дивангар |divangyar|{< Skr. *dīpamkara*} *'зул зохиогч', 'гэрэлтүүлэгч'* (Гаутама багшийн өмнөх үеийн хорин дөрвөн бурхадын тэргүүн) || Ж= *'oytaryu-yin činar-tu bükü-yi dibangkar-a burqan üjegülüged'* [огторгуйн чанарт бүхийг дивангар бурханд үзүүлээд](Burq.6a) || Энэ үг хожимоо *'нэн эртний'* гэсэн утга илэрхийлэх болж, бүр монголчилогдон сунжирч *'диван галба'* гэсэн хэлбэрээр хэрэглэгдэх болжээ. || Kha. *diwangar*

Дивидент |divident|{< Rus. *дивидент* < Lat. *dividendum*} *'дивидээнт', 'ноогдол ашиг'* (хувь нийлүүлэгчидэд оруулсан хөрөнгийнх нь хэрээр ашиг хүртээх ноогдол)

Ди-Ви-Ди |dividi|{< Eng. DVD (digital video disk) *'дивиди'* (дуу хөгжимийн шингээлт бүхий зээрэнц)

Дивиз |diviz|{< Rus. *дивизия*} *'дийвийз'* (хэд хэдэн хороо цэрэгээс бүрдэх цэрэг, армийн нэгж)

Дигваранз |diγbaranja|{< Tib. *sdig pa rwa can} 'дигваранз', 'хилэнцэт хорхой', 'ямааны уруу'* || Kha. *digwaranzv*,

Дижитал |dijital|{< Eng. *digital* < Lat. *digitus*} *'дижитал'* (мэдээлэлийг тоон хэлбэрт шилжүүлэн дамжуулах үйлдэл)

Дизайн |dizayin|{< Eng. *design*} *'дизайн', 'загвар', 'ур хийц'* (хувцас загвар, дотоод засал чимэглэл зэрэгийн ур хийц, хэв загвар)

Дизель |dizel|{< Rus. *дизель* < Ger. *diesel*} *'дийзел түлэш'* (дотоод шаталтын хөдөлгүүрийг үндэслэгч Германы зохион бүтээгч Rudolf Diesel /1858-1913/)

Дийз |deyije}{< Chin. *die zi*} *'жижиг таваг'* || Kha. *dīdz*

Дилер |diler|{< Rus. *дилер* < Eng. *dealer*} *'дийлер'* (валютын ханшийн хэлбэлзлийг ашиглан наймаалдаг банкны ажилтан)

Диплом |diolom|{< Rus. *диплом* < Fr. *diplôme* < Lat. *dipoloma* < Gr. *δίπλωμα*} 'диплоом' (мэргэжил, чадварын үнэлгээний үнэмлэх)

Дипломат |dilomat|{< Rus. *дипломат* < Fr. *diolomate*} *'дипломаат'* (олон уласын харилцааны чиглэлээр мэргэжсэн ажилтан)

Дисерт |desert|{< Rus. *десерт* < Fr. *desseret*} *'дисээрт', 'амтат зууш'*

Диск |disk|{< Rus. *диск* < Gr. *δίσκος*} *'дийск'* (дуу хөгжимийн шингээлттэй ялтас)

Дисплей |dispelei|{< Eng. *display*} *'дисплей'* (цахим бичвэрийн дэлгэц)

Диссертаци |dessertaci|{< Rus. *диссертация* < Lat. *dissertatio*} *'дисертаац'* (эрдэмийн зэрэг горилж бичсэн зохиол)

Дияан |diyan|{< Uig. *dyan* < Skr. *dhyāna*} *'амагалан сэтгэхүй', 'бисалгал'* (нэгэн үзүүрт сэтгэлээр номлол бисалгал хийж суух аглаг газар) || Ж= *'sedkil-iyen **diyan**-dur jarubasu... **diyan** bišilγaqui boltuγai'* [сэдхэлээ дияанд зориулваас ... дияан бисалгах болтугай](ВТ 160a) || Kha, Ord. *dijān*

До* |do| *'доод', 'доош', 'дор'* гэсэн утгыг хадгалсан анхдагч язгуур. Энэхүү анхдагч язгуураас *doγo* [*do-γo] 'догоо', *doro* [*do-ra] 'дор' гэсэн үүсмэл язгуур салбарлан гарч, улам тэдгээрээс *doγodu* [do-γo-du] 'доод', *doγoγši* [do-γo-(γ)ši] 'доош', *doγoγur* [do-γo-γur] 'доогуур', *doradu* [do-ra-du] 'дорд', *doraγši* [do-ra-(γ)ši] 'дорогш', *dorayi* [do-ra-yi] 'дорой' гэх мэт тухайн язгуур уттыг хадгалсан олон тооны шинэ үг үүссэн байна.

Дог |doγ|{< Tib. *tog*} *'үзүүр', 'орой'* (тугны үзүүрт тогтоосон чимэглэл. Хожим утга нь шилжиж данх савны тагны дээрхи бариул зэрэгийг нэрлэх болжээ.)

Догшин |doγsin| *'эмнэг', 'зэрлэг'* || Cf. Turk. *tokšyn* 'дикий', 'лютый', 'необузданный' (Радлов, III:1155) || Ж= *'arslan kiged **doγšin** ariyatan-iyar dügürügsen aylay oron'* [арслан хийгээд догшин араатанаар дүүрсэн аглаг орон] (Burq.24b) || Эртний монголчууд хүчирхэгийн бэлгэдэл болгож энэ үтийг хүний нэрд хэрэглэдэг байжээ. || Ж= *Bai-šiŋqor-dogšin* (MNT 47), *Dörbei-dogšin* (MNT 240) || х о р ш : *'зэрлэг догшин', 'ширүүн догшин', 'эмнэг догшин'* || Kha. *doχšin*, Ord, Bur. *dogšin*, Oir. *dokš'n*

Додиг |dodiγ|{< Tib. *stod gyogs*} *'чээжний өмөсхөл'* (ханцуйгүй хантааз)

Доктор |doktor|{< Rus. *доктор* < Lat. *doctor*} *'дооктор'* (эрдэмийн дээд зэрэг)

Докторант |doktorant|{< Rus. *докторант*} *'дооторант'* (докторын зэрэг горилогч)

Докторантур |dokmorantur|{< Rus. *докторантур*} *'дооторантуур'* (докторын сургалт)

Доллар |dollar|{< Rus. *доллар* < Eng. *dollar*} *'доолар'* (Америк, Канад, Австрали зэрэг уласын мөнгөн тэмдэгт)

Долоон |doluγan|[< *dal-(u)-γan] *'1 x 7 = 7'* || Ж= *'jöb dalan **doluγan** nasun-dur-iyan ebedčin-iyer ügei boljuγu'* [яг далан долоон насандаа өвчинөөр үгүй болжээ](Hin. 36) // *'Qabul qahān-nu **dolo'ān** kö'ūd-ün dumdadu Qotula'* [Хабул хааны долоон хүүгийн дундах Хотул](MNT 53) // ***dolān** nasutu üker* [семилетняя рогатая скотина](Mu. 142) // *dolān* 'sieben' (LH 56) // *dolān* 'sept' (Ist. 27) // *dolān* 'sieben' (LH 56) // *dolân* 'seven' (Ras. 201 B1) || Kha, Ord, Bur. *dolō*, Oir. *dolā*

Дом |dom|{< Tib. *sdom*} *эмчилэн засах арга* (далдын хүчинд итгэж, аливаа муу зүйлийг ид шидийн хүчээр засч зайлуулах сүсэг бишрэлийн зан үйл) || х о р ш : *'эм дом'* || Kha, Ord, Bur, Oir. *dom*

Домбо |dombu|{< Tib. *ldong bo*} *'хувин'* (цай хийх зорилалттай цоргогүй босоо метал хувин) || Kha, Bur. *dombo*, Ord. *domo*, Oir. *dombᵘ*

Домог |domuγ| *'үлгэр'* || х о р ш : *'үлгэр домог'* || Kha, Bur. *domog*, Ord. *domok*, Oir. *domᵘg*

Домэйн ||{< Fr. *domaine* < Lat. *dominium*} *'домэйн'* (вэб сайтын бүрдхэлд ашигладаг давтагдашгүй хаяг)

Дон |dong|{< Tib. *gdon*} *'ад', 'чөдхөр'* (ад шүгэлсэн мэт аливаа юманд хэт шохоорхон дурлах) || х э л ц : *'дон шүглэх'* (ад нөхцөх)

Донго* |dongγu| *'dongyud'* гэсэн үгийн язгуур.

Донгод- |dongγod|[= dongγo-d]{< *doŋgad*} 1. *'уянгалан дугарах'* 2. *бурууштаах', 'зэмлэх'* 3. *'үгүүлэх'* || Cf. *donγu* 'sound', 'voice' (Zir. 98) || Ж= **1.** *'qun yalayun terigüten ... sonosqu metü sayiqan dayūn-iyar* ***dongyudun'*** [хун галуу тэргүүтэн ... соносох мэт сайхан дуугаар донгодон](Burq. 2a) // ***donqatba*** *ötkün* 'кричал пронзительно' (Mu. 143) Ж= **2.** *'Čiŋgis qahān tende Öŋgür, Arqai qoyar-i maši* ***doŋğodba'*** [Чингис хаан тэнд Өнгүр, Архай хоёрыг их зэмлэв](MNT 118) Ж= **3.** *'aqa inu qari'u ese* ***doŋğodba'*** [ах нь хариу эс үгүүлэв](MNT 34) // *doŋutba* 'мешал' (IM 436) || Kha. *doŋgod-*, Ord, Bur. *doŋgodo-*, Oir. *doŋğᵘdᵃ-*

Донид |donid|{< Tib. *stong nyid*} *'хоосон чанар'* (Бүддийн гүн ухаан дахь *бодьтой, хийсвэр* хоёрын тухай харьцангуйн онол) || Skr. *śūnyatā*

Донир |donir|{< Tib. *mgron gnyer*} *'шамдан хичээх'* (миндаг тушаалтаны бараа болж, даанс даяг хөтөлөгч түшмэл. XX зууны эхээр Богд Жебзундамбын алтан тамгыг сахиж, ордоны хэрэгийг эрхэлсэн түшмэлийг ийн нэрлэж байв) || Kha. *donir*, Ord. *gonir*, Oir. *donᵘr*

Донор |donor|{< Fr. *donneur*} *'өглөг', 'хандив'* (Монгол хэлэнд анх эрүүл цусаа хандивлах сайн үйлийг ийнхүү нэрлэж байгаад хожим эдийн засагийн хандивын утгаар ч бас хэрэглэгдэх болжээ)

Доо* |doγo|[= *do-γo] *'доор', 'доош'*. (Энэхүү үүсмэл язгуураас *doγodu* [*do-γo-du] 'доод', *doγoγši* [*do-γo-(γ)ši] 'доош', *doγoγur* [*do-γo-γur] 'доогуур' гэх мэт үгс үүсч, бас тэдгээрээс өөр шинэ үгс үүссэн бий.

Доод |doγodu|[= doγo-du]{< **do-γa-du*} *'доогуурхи', 'доорхи'* || Ж= *'энэдхэг газарын эрдэнийн хормогчоор* ***доод*** *биеийг чимсэн'* (Д. Нацагдорж, Энэдхэгийн бүсгүй)

Дооромбо |doramba|{< Tib. *mdo rams pa*} *'чулуун дээр маш хэтэрхий'* (цогчин дуганы чулуун дэвсэхэр дээр хатуужин сууж, цанидын дамжаа барьсан гэвш)

Дор |doro|[< *do-ra] *'дээр'* гэсэн үгийн эсрэг утгатай үүсмэл язгуур. Энэхүү үүсмэл язгуураас *doroda-* [doroda] 'дорд', *dorodu* [dorodu] 'дорд', *doroγši* [doroγši] 'дорогш', *doromǰi* [doromǰi] 'доромж', *doroi* [doroi] 'дорой' гэх мэт олон үг үүсчээ. || Ж= *'tabun aran-i Bagisba bayši-yin* ***dora*** *ǰauqudun'* [таван хүнийг Пагба багшийн дор суулган](Khub. 1:13) // *'modun-u* ***dour-a*** *sayuǰu*

degel-iyen oyubai' [модны дор сууж дээлээ оёв](Burq. 42b) // *'Sorqan-šira-yin ger-tür, tergen-dür, iseri-yīn* ***doro*** *kürtele neŋǰiǰü'* [Сорхан шарын гэрт, тэргэнд, суудалын дор хүртэл нэгжиж](MNT 86) // ***dora*** 'внизу' (Mu. 143) // *dora* 'под' (IM M135) // *dōra* 'unten' (LH 56) // *dora* 'under', 'below' (Ras.205 D44) // *dōra* 'under', 'below' (Zir. 99)

Дорд |dorodu|[< *do-ra-du] *'дорой', 'буурай'* // Pl. *dorodus* || Ж= ***'dorodu*** *kümün bayan ber bolbasu uǰuγur-tu ügegün aran-a daruγdayu'* [дорд хүн баян боловч дээд язгуурт ядуу хүнд дарагдах](Sub.IV:1b) // *'öber-eče* ***dorudus*** *öčüked-i büü basumǰilan'* [өөрөөс дордос өчүүхэнийг бүү басамжилан](Hin. 28) || Kha. *dord*

Дорждан |*dorǰidan*|{< Tib. *rdo rje gdan*} *'очирт суурин'* (манай эриний өмнөх VI зууны сүүлчээр Гаутама багш заларан ирж, бурхан багшийн дүрд хувилсан газарын нэр. Эдүгээ доронод энэдхэг дэх бурхан шашины эргэл мөргөлийн ариун орон болох Бодгаяа гэдэг газар)

Доржпалам |dorǰi palam|{< Tib. *rdo rje* 'очир эрдэнэ' + *pha lam* 'алмаас'} *'очир алмаас'* (хамагийн хатуулаг энэхүү эрдэнийн чулуу нь долоон зүйлийн эрдэнийн чулууны нэгэнд багтдаг.)

Дориун |doriγun|[= *do-ra-γun] *'дорой', 'доорд'* (уттаа *'дор'* гэсэн утга бүхий язгуураас гаралтай учир *'дорой муу'* гэсэн утга илэрхийлж байжээ) || Ж= *'noqai terigütü irgen* ***doriγun*** *čirai-tan-i emes kemen basuγu'* [нохой толгойтой дорой царайтан иргэдийг эмс хэмээн басна](Sub.III:6b) Гэвч яваандаа энэ үгийн утга нь эсрэг эргэж, *'овоо сайн', 'зэгсэн', 'бузгай'* гэх мэт утгаар хэрэглэгдэх болсон байна. || Ж= *'ǰalaγu ider elegür* ***doriγun*** *bükü-dür-iyen ǰad-ta busud-ta tayalaγulun aγsan ber öteljü nasun-dur kürügsen-dür öber-ün uruγ-a ber tebčigden büi'* [идэр залуу, эрүүл саруул байхдаа гаданын хүнд, бусадад таалагдаж байсан ч өтлөх насанд хүрэхээрээ өөрийн урагтаа ч гологдоно] (Burq.5a) // *'ičireg üges-i* ***doriγun*** *keleleyü'* [нууц үгсийг олноор хэлнэ](Sub. III:11a) Орчин үеийн монгол хэлэнд энэ үг *'бузгай', 'зэгсэн', 'овоо'* гэсэн утгаар хэрэглэгддэг. || х о р ш : *'бузгай', 'дориун'* || Kha, Ord. *doṙūn,* Bur. *doryūn*

Дорой |doroi|[< *do-ra-i] *'доорд', 'ядуу'*. Энэхүү үүсмэл үгээс *doroyita-* [do-ro-yi-ta] 'доройт-', *doroyitaγul-* [do-ro-yi-ta-γul] 'доройтуул-' зэрэг үг дам дам үүсчээ. || Ж= *'ečige minü odbasu ber* ***doroyitaqu****-yin belge büi'* [эцэг минь одвоос доройтохын тэмдэг буй](Burq. 55a) // ***dorai*** *kibe tūni* [ослабил его](Mu. 143) || х о р ш : *'ядуу дорой', 'дорой буурай'* || Kha, Bur. *doroi,* Ord, Oir. *dorā*

Доройтуул- |doroyitaγul|[= *do-ra-yi-ta-γul] 'дордуулах', *'мууруулах'* || Ж= *'ene toyin-i yambar-iyar* ***doroyitaγulun*** *üyiledkü bida kemen ögülegsen-dur'* [бид энэ тойныг яаж доройтуулах вэ хэмээн үгүүлсэнд](Burq. 56b) // *'öčin meljen ağsad Sarta'ūl irgen-ü Soltan-i* ***dorayīta'ūlǰu'*** [өчиж мэлзэн байсан сартуул иргэний хааныг буулган авч](MNT 260)

Доромж |doromǰi|[< *do-ra-mǰi] *'дорд үзэх'* Энэ үгээс *doromǰila-* [do-ro-mǰi-la] 'доромжил-', *doromǰilaγul-* [do-ro-mǰi-la-γul] 'доромжилуул-', *dorom-ǰilaγda-* [do-ro-mǰi-la-γda] 'доромжилогд-' гэх мэт нийлмэл бүтэцтэй үгс дам дам үүсчээ.

Доромжил- |doromjila|[< *do-ra-mji-la] *'дорд үзэх'* || Ж= *'erdem-i alfiyas suruysan aran jöb suruysan-i* ***dorumfilayu*** [эрдэмийг буруу сурсан хүн зөв сурсаныг доромжилох](Sub. III:6a) // *'maytaysan-iyar ber ülü bayasun* ***dorumfilaydabasu*** *ber ülü kü mayulan'* [магтсан ч үл баясан, доромжилогдсон ч үл муудах](Sub.II:7b) // *'dörben kö'üd inü Dobun-mergen abaġa-yu'ān uruġ-a ülü bolġan* ***doromfilaju****, qaġačaju, gējü newübe'* [дөрвөн хүвүүд нь Добун мэргэн аваагаа урагт эс тооцон доромжилж, салж орхиж нүүв](MNT 11) // *dorumfilaba tüni* [оскорбил его](Mu. 143)

Дороно |doruna|[= doru-na] *'наран ургах зүг'* || Ж= ***dorun-a-ača*** *naran uryuqu'* [дорноос наран ургах](OM 132b) || Kha, Ord, Bur. *dorono*

Дот* |dotu| *'домор'* гэдэг үгийн анхдагч язгуур. Энэхүү язгуураас *dotuya* [*dotu-ya] 'дотоо', *dotuysi* [*dotu-(y)si] 'дотогш', *dotuyūn* [*dotu-yūn] 'дотуун', *dotuyūr* [*dotu-yūr] 'дотуур', *dotuna* [*dotu-na] 'дотоно', *dotura* [*dotu-ra] 'дотор' гэх мэт үндэсүүд үүсч, уламаар тэдгээрээс *dotuyadu* [dotu-ya-du] 'дотоод', *dotuyaji* [*dotu-ya-ji] 'дотоож' гэх мэт өдий төдий шинэ үг үүссэн байна. || Ж= *'nidün* ***dotuyši*** *širgijü gün qudduy-un iruyar-a üjegdekü odun metü'* [нүд нь дотогш ширгэж, гүн худагийн ёроолд харагдах од мэт](Qqot III:12)

Дотоно |dotuna|[= *dotu-na] *'гадана'* гэсэн үгийн эсрэг утгатай үг. (*'ойрын'*, *'шадар'* гэсэн утга илэрхийлнэ) || Ж= ***'dotona*** *bidan-u dergede yabuju'* [бидний хажууд ойр шадар явж](MNT 224) // *dotana* 'inner' (Zir. 98) || Энэ үгээс *dotunačila-* [*dotu-na-čila] 'дотоночил-', *dotunala-* [*dotu-na-la] 'дотонол-', *dotunadu* [*dotu-na-du] 'дотонод' гэх мэт үгс үүсчээ. || *toṭuna* 'inner' (Ras. 206 A1) // *dotana* 'in', 'inner', 'interior' (Zir. 98) || х о р ш : *'дотоно гадана'* // *'ойр дотоно'* || Kha. *dotőnő*, Bur. *dotono*

Дотонол- |dotunala|[= dotu-na-la] *'дотоночилох'* || Ж= *'Divubal-a ong imayi maši* ***dotunalun*** *asaraqui* [Дивубал ван түүнийг маш дотоночилон асарахуй] (Jig. 2) Ж= *'ülemji tayalan* ***dotunalabasu****...mayulalduqui-yin šiltayan bolai'* [үлэмж таалан дотоночилвол муудалцахын шалтгаан болно](Sub.VI:9a)

Дотоо |dotuγ-a|[= *dotu-ya] *'гадаа'* гэсэн үгийн эсрэг утгатай үүсмэл язгуур. Эл язгуураас *dotuyadu* [dotu-ya-du] 'дотоод', *dotuyaji* [dotu-ya-ji] 'дотоож' гэсэн үгс үүсчээ || Ж= *'yaday-a* ***dotuy-a*** *bolbasu'* [гадана, дотоно болвол](Qqot.VII)

Дотоод |dotuγadu|[= *dotu-ya-du] *'гадаад'* гэдэгийн эсрэг утгатай үг || Ж= ***dotuyadu*** *ba yadayadu tarni not'* [дотоод ба гадаад ном](Tara. I:1) || х о р ш : *'дотоод гадаад'* || Kha. *dotōd*, Bur. *dotōdo*, Oir. *dotād*

Дотоож |dotuγaji|[= *do-tu-ya-ji] *'дотуур өмөд'* || Ж= *'Jelme ... ġağča* ***doto'ājitu*** *čurama ničügün ... güyijü'* [Зэлмэ ... ганц дотуур өмөдтэй чармаа нүцгэнээр ... гүйж](MNT 145-10) || Kha. *dotōdz*, Ord. *dotoğōdu*, Oir. *dotādz*

Дотор |dotur-a|[*do-tu-ra] *'гадана'* гэдэгийн эсрэг утгатай үг || Ж= *'ingri yajar-un jayur-a qamuy amitan-u* ***dotur-a*** *kümün-eče degedü ügei'* [тэнгэр газарын зуур хамаг амьтаны дотор хүнээс дээд нь үгүй](Taq.16b) // *'Odčigin mana-ġarši erte Čiŋgis qa'ān-i bosu'āi üdü'üi-e oron* ***dotora*** *büküi-dür oroju'* [Отчигин өглөө эрт Чингис хааныг босоогүй, орон дотороо байхад нь орж](MNT 245) // *biliktü*

bolba din ***dotura*** [стал мудрым в религии](Mu. 119) // *dotora* 'drinnen' (LH 55) || Kha, Bur. *dotor*, Ord. *dotur*, Oir. *doťr*

Дохи- |doki|[< doqi] *'толгойгоо бөхөлзүүлэх'* (бодол санаагаа хөдөлгөөнөөр илэрхийлэх) || Ж= *'tere čaǧa'ān moritu kū'ün u'ürǧa-bār-iān* ***dokiju*** *bayība'* [тэр цагаан морьтой хүн уургаараа дохиж байв](MNT 91) || Энэ язгуураас *dokiya* [doki-ya] 'дохио', *dokiyur* [doki-yur] 'дохиур', *dokilja-* [doki-lja] 'дохилз-' гэх мэт үгс үүсчээ. || Cf. AT *tokī* 'to knock smth, to weave' (Clauson 467) || Kha, Bur. *doxi-*, Ord. *doʰxi-*, Oir. *dokʰ-*

Дохио |dokiya|[= doki-ya] *'дохих үйл хөдөлөл'* || Ж= *'qariyu anu deger-e-eče dokiya bolumui'* [хариу нь дээрээс дохио болмуй](EE 58a) || х о р ш : *'дохио зангаа', 'дохио тэмдэг'* || Kha. *doxʰō*, Ord. *doʰxiō*, Bur. *doχyō*, Oir. *dokān*

Дохиур |doqiyur|[= doki-yur] *'цохиур', 'саваа'* || Ж= *'kögörge-yi* ***doqiyur****-iyar ese deledbesü busud-tača ilyal inu yayun j-a aqu'* [хэнгэрэгийг дохиураар нь эс цохивоос бусадаас юуны ялгаа байх билээ](Sub. I:4b) || Kha. *doxlūr*, Ord. *dokχūr*, Oir. *dokūr*

Дочиг |dočiy|{< Tib. *'dod chags*} *'шунал тачаал'* (энгийн хар ярианд эр хүний дусалыг ийн нэрлэх болжээ) || Kha. *totšig*

Дө* |dö| *'дөрөв'* гэсэн тооны анхдагч язгуур. Энэхүү язгуураас *döči* [*dö-či] 'дөч', *döne* [*dö-ne] 'дөнө', *dör* [*dö-r] 'дөр' зэрэг үүсмэл язгууруд үүсч, уламаар тэдгээрээс дам *'дөрөв'*-ийн утгыг хадгалсан шинэ үгс үүсчээ.

Дөлгөөн |dölügen|[< *dölü-gen] *'номхон', 'амагалан тайван'* || Cf. Turk. *dolek* || Ж= *'suu-tan degedüs nigüleskü örüšiyekü sedkil-iyer ulus-iyan ayui-a* ***dölegen-e*** *bariysan-u tula'* [суутан дээдэс нигүүлсэх өршөөхүй сэдхэлээр уласаа агуу дөлгөөн удирдсан тул](Jig. 17) || х о р ш : *'намуун дөлгөөн', 'номхон дөлгөөн'* || Kha. *dolgōn*, Ord. *dolō(n)*, Bur. *dulgyēn*, Oir. *dolān*

Дөлөсгө- |dölüsge|[= dölüs-ge] х у у ч : *'дууриах', 'дагах'* || *'ene türmegei ken-ü üges-tür* ***dölüsgüjü****, aqa kü ün-i aman dü'üren ügüleyü'* [энэ хэний түрэмгий үгэнд орж ах хүнийг ам бардам үгүүлнэ](MNT 276)

Дөнгө |döngge| *'ялтаны хүзүүнд өлгөх дундаа нүхтэй хүнд хавтагай мод'* || Ж= *'гав гинж* ***доигө*** *зүүсэн ялтангууд энд тэнд суун хоор зуураа буга хэмээх тоглоом тоглоно'* (Д. Намдаг, Ээдрээ) || Энэ үгээс *dönggele-* [dönggele] 'дөнгөл-', *dönggelegül-* [dönggele-gül] 'дөнгөлүүл-' гэсэн үг үүсчээ. || х о р ш : *'гав дөнгө'* || Ж= *'Чи бас* ***дөнгөлүүлэхдээ*** *орилоогүйгээ одоо бас суллагдахаа орилноо'* (Д. Намдаг, Ээдрээ)

Дөнө |döne|[= *dö-ne] *дөрвөн настай эр мал, адуусан амьтан.* Энэхүү үүсмэл язгуур дээр *-jīn* дагавар залгаж дөрвөн настай эм үхэрийг заасан нэр үүснэ. || Ж= *dönen üker* 'четырехлетний бык' (Mu. 143) || Kha. *dönön*, Ord. *dönö*, Bur. *dünen*, Oir. *dönʰn*

Дөр |dör|[= *dö-r] *'дөрөв'*-ийн утгыг хадгалсан үүсмэл язгуур. Энэ язгуураас *dörben* [*dö-r-be-n] 'дөрвөн', *dörmüsün* [*dö-r-müsün] 'дөрөмсөн' мэт үгс үүсчээ.

Дөрвө'н) |dörbe(n)|[= *dö-r-be] *'1 x 4 = 4'* || Cf. Turk. *dört* || Энэ үгээс *dörbegül* [*dö-r-be-gül] 'дөрөвүүл', *dörbel* [*dö-r-be-l] 'дөрвөл', *dörbeljin* [*dö-

дургүй нь хүрч](MNT) // *'Bodistv kejiy-e* ***duran taγalatala*** *Rajagraγ balγasun-dur aju'* [Бодисадва сэдхэлээ тайвширтал Ражаграх хотод сууж] (Burq. 34b) // *'Bodistv Gay-a ayula-dur kejiy-e-de* ***duran qanatala*** *saγuju'* [Бодисадва хэзээ сэдхэлээ ханатал Гаяа ууланд сууж](Burq. 35a) // *'Čiŋgis qahān ... nidün-ečе-'ēn nilbusun čuburi'ūlju,* ***duran alja'ād'*** [Чингис хаан ... нүднээсээ нулмис дуслуулан сэдхэл алдараад](MNT 173) // ***duran*** *ōrgūbe* [поднял настроение] (Mu. 145) // *durān* 'âme, coeur' (Ist. 28) // *duran* 'Gemüt' (LH 55) // *duran* 'temperament' (Zir. 99) || х о р ш : *'дур хүсэл', 'дур зорго', 'дур сонирхол'* || х э л ц : *'дур булаах'* (сэдхэл татах), *'дур гутах'* (дургүй хүрэх, сэдхэл алдарах), *'дур хүрэх'* (сэдхэл татагдах) || Энэ үгээс *durala-* [dura-la] 'дурла-', *duralal* [dura-la-l] 'дурлал', *dursi-* [dur-si] 'дурших' зэрэг үгс үүсчээ. || Kha. *durv*, Ord. *dura*, Bur. *duran*, Oir. *dur^{o}n*

Тусхай судалгаа: F. W. Cleaves, The Expression *dur-a qočarulčaju* in the Letter of Öljeitü to Philippe le Bel, HJAS 11, 1948, 441-455

Дуударам |dudsarm-a|{< Tib. *mdo dar ma*} *'тоншуур'* (олон жижиг зэс тавагтай цохилуур хөгжимийн зэмсэг)

Дуулга- |duγulγa|[= duγu-lγa] *'соносхох', 'мэдүүлэх'* || Ж= *'yorčiqun yabu-qun ilčin-e čerigūd-ūn noyad-ta čerig aran-a toyid-ta irgen-e* ***duγulγaqui*** *jarliγ'* [зорчин явах элчин, цэрэгийн дарга, цэрэг, ардууд, тойн нарт мэдүүлэх зарлиг](Khub. I:6) // *'Čiŋgis qahān ... du'ūlğaqui jarliğ tuŋqarun* [Чингис хаан ... мэдүүлэх зарлиг тунхаглав](MNT 278) || Kha. *dūlğʌ-*, Bur. *dūlğa-*, Oir. *dūlğv-*

Душман |dušman|{< Pers. *dušman*} *'дайсан'* || Cf. *dušman* 'враг', 'противник' (ДТС 161) || Ж= *'**dušman** bariba eme ereyi'* [женщина была враждебно настроена к мужчине](Mu. 146) || Kha. *dušmān*

Дувчин |dūbčin|{< Tib. *grub chen*} *'их бүтээлч', 'дээд шидийг олсон бисалгагч'* (ном бисалгаж, дээд шидийг олсон хүн. Эдүгээ энгийн ярианд хоосон мэдэмхийрч ярьдаг хүнийг нэрлэдэг ёгт нэр болжээ.)

Дүд |dūd|{< Tib. *bdud*} *'шулам'* (буяны үйлсэд тодхор хийгч зургаан зүйлийн амармаг тэнгэрийн нэг)

Дүй |dūi / dōi| *'бүсгүй дүү'* || Ж= *'Qada'ān neretei* ***dōi****-yi-bēn 'amitu kū'ūn-e bū kelele' ke'ējū asara'ūlba'* [Хадаан нэртэй бүсгүй дүүдээ амьтан хүнд бүү хэлээрэй хэмээн захиж харгалзуулав](MNT 85)

Дүйз |dūyiǰe|{< Chin. *duì zi*} *'уялга', 'хослол'* (өөр хоорондоо ижил, хос юмс)

Дүймэн |dūyiming|{< Tib. *btus ming*} *'түүвэр нэр'* (ном зохиолын доторхи хүнд хэцүү үгсийг түүвэрлэн тайлбарласан толь бичиг)

Дүлбаа |dulba|{< Tib. *'dul ba*} *'номходолго'* (цанидын таван аймаг сав ухааны нэг, гурван хөлгөний доод хөлгөний номын нэр.)

Дүйнхор |dūyinqor|{< Tib. *dus 'khor*} *'цагийн хүрд'* (Бурхан багшийн айлдсан цогт цагийн хүрдний үндэс хэмээх арван хоёр минган шүлэгт зохиолын хураангуй нэр. Цагийн хүрдний бурхан болох Дүйнхорын дүр байдал нь 4 улирал, 12 сар, 365 хоногийг бэлгэдсэн шинжтэй байдаг байна.)

Дүйцэн |düyičen|{< Tib. *dus chen*} *'их цаг'* (Бурхан багш эхийн умайд бүрэлдсэн, бурханы хутаг олж, гаслангаас ногчиж нирвааи дүр үзүүлсэн гурван том үйл даавхацсан бэлэгт сайн өдөр. Энэ өдөр хүрээ хийдүүдэд тахил тавиг засч, ерөөл магтаал уншин, хурал ном хурдаг.)

Дүл |dūli| *'дунд'* || Cf. Turk. *duš* || Cf. Man. *dülin* 'середина' (Цинциус I:222) || Ж= *üdür **düli-de** ese kürgebe'* [өдөр дунд эс хүргэв](MNT 177) // *'söni **düli** bolju bükü-dür ali ba yeke öčüken bügüdeger untaraysan-dur adalidqabasu'* [шөнө дунд болоход том жижиг бүгдээр унтсантай адил](Burq. 27b) // *ödür düli* 'middi' (Ist. 28) // *söni düli* 'midnight' (Ras.291 A1) // *ūdür düli* 'время после полудня' (IM M120) // *süni düli* 'полночь' (IM M137) || Kha. *döl*, Oir. *dul*

Дүлба |dulba|{< Tib. *'dul ba*} *'номходхохуй', 'сахилга'* (доод хөлгөний санваартаны сахих ёс журам)

Дүлэд |düled| *'эгнэгт', бүрмөсөн', 'улам', 'нэн'* || Ж= *'mayui kümün ed-tü bolbasu ele **düledte** mayui aburi-tu boluyu'* [муу хүн эд хөрөнгөтэй болвол улам муу авиртай болюу](Sub. III:1) // *'Оŋ qan **düled** nadača činaru aju'ū'* [Он хан надаас бүрмөсөн цааш эргэсэн ажгуу](MNT 170)

Дүн |düng|{< Chin. *dōng*} *'өвөл'* (өвөлийн ид дунд үе) х о р ш : *'дүн өвөл'*

Дүнжингарав |düngǰün γarbu|{< Tib. *dung skyong dkar po*} *'цагаан лавайг тэдхэгч'* (1678 онд Богдхан уулын орой дээр нь түүний эзэн сахиус болох Дүнжингарав овоог босхожээ)

Дүнз |dünǰe|{< Chin. *dūn zi*} *'тулгуур мод'* (холтосыг нь авч зассан бүдүүн мод)

Дүнс |düngse|{< Chin. *dōng shēng*} *'тамих'* (гаансанд хийж, цаасан ороож татдаг хатаасан тамих) || Kha. *düŋsə*, Bur. *düŋse*

Дүнчүүр |dünčüür|{< Tib. *dung phyur*} *'зуун сая'* (9 оронтой тоо)

Дүр |düri|[= dür-i] *'дүрс хэлбэр', 'овор төрх'* || Ж= *'tüg tümen od-tur kürtele **düri dürsü** bolqu üges'* [түг түмэн жилд дүр дүрс болох үгэс](Chang. 39) // *'quγur-un dayun-ača nom-un qayaly-a-yin qoyar **düri-ber** duradqan üyiledkekü tōrū aǰuγui'* [хуурын дуунаас номын хаалгын хоёр дүрээр дурдхан үйлдэх төр ажгуу](Burq. 2a) || х о р ш : *'дүр зураг', 'дүр төрх'* || Kha *dür*, Ord. *düru*, Bur. *düre*, Oir. *dür*

Дүрвэ- |dürbe| *'зугатах', 'дайжих', 'зайлах'* || Ж= *'Mergid-ün ulus Seleŋge müren hürü'ū söni-de **dürbejü'*** [Мэргэдийн хүмүүс Сэлэнгэ мөрөн рүү шөнөөр](MNT 110)

Дүрвэл |dürbel| х у у ч : *'митарал', 'цөхөрөл', 'саатал'* || Ж= *'mayui **dürbel** kiged mayui üyiles'* [муу дүрвэл хийгээд муу үйлс](Sub. VIII:19b) // *'**dürbel** mital ügegüi-e ulus quriyaysan'* [дүрвэл миталгүй үгүй улас хураасан] (Qqor I:17) // *'hPagspa blam-a **dürbel** ügei ayiladqaqui-dur qayan yekede bayarlaǰu'* [Пагба лам дүрвэлгүй айлдахуйд хаан ихэд баярлаж](OM 4b)

Дүрс |dürsü|[= dür-sü] *'дүр', 'хэлбэр'* (эртний бичигийн дурасхалуудад язгуур нэгтэй *'дүр'* гэдэг үгтэйгээ хоршиж хэрэглэгдсэн жишээ цөөнгүй байна.) || Ж= *'dörben dalai-dur kürtele **düri dürsü** bolyan yabuyulbasu'* [дөрвөн далай хүртэл дүр дүрс болгон явуулвал](Taq. IVa) || х о р ш : *'хэлбэр дүрс'* ||

Kha. *dürsə*, Ord. *dürsül*, Bur. *dürse*, Oir. *dürsᵊn*

Дүү |degü| *насаар бага хүн* || Ж= *'aqa **degü** joqilduju'* [ах дүү *зохиолдож*] (Öl]. 27) // *'aqa-nar **de'ü**-ner eyetü[l]düjü'* [ах дүү нар эвлэлдэж](MNT 36) // *egečl **de'ü*** [старшая и младшая сестра](Mu. 151) // ***deü** 'младший брат'* (IM M135) // ***diyü** ökün 'jüngere Schwester'* (LH 57) // ***deün** 'younger brother'* (Ras. 200 B26) // *nim nikenlē aqa **dü** bolbalar* [стали друг другу братьями](Mu. 256) // ***dü** 'сестра'* (IM 436) || х о р ш : *'ах дүү'*, *'эгч дүү'* || Kha, Ord, Bur, Oir. *dü*

Дүүдүү |düdüü|{< Chin. *dōudou}* *'элэгэвч'* (өмөнө тал нь битүү, доогуураа задгай хувцас)

Дүүпүү |deüfü|{< Chin. *dóu fu}* *чанаж хандалсан буурцагийн гурилын хөвсийг шахаж царцаасан хоолны хольц* || Kha. *düpü*

Дүүшин |dügüšin| х у у ч : *'бүрэнхий'* || Ж= ***dü'üšin** bolju, ayisu qoyidu tede haran baru'ān boldaju, bayiju qočorba'* [бүрэнхий болж, хойноос айсуй байгаа тэдгээр хүмүүс бараантаж харагдаад ард хоцоров](MNT 91) || Oir. *düšin*

Дэ* |*de| *'дээр', 'дээд', 'дээш'* гэсэн утгыг хадгалсан анхдагч язгуур. Энэхүү анхдагч язгуураас *deb* [*de-b] 'дэв,' *debe* [*de-be] 'дэвэ', *deg* [*de-g] 'дэг', dege [*de-ge] 'дэгэ' гэх мэт үүсмэл язгуур гарч, уламаар тэдгээрээс *debji-* [*de-b-ji]'дэвж-' *debši-* [*de-b-ši] 'дэвш-', *debere-* [*de-be-re] 'дэвэр-', *degde-* [*de-g-de] 'дэгд-', *degji-* [*de-g-ji] 'дэгж-', *degedü* [*de-ge-dü] 'дээд', *degegür* [*de-ge-gür] 'дээгүүр', *degeji* [*de-ge-ji] *'дээж', degere* [*de-ge-re] 'дээр', *'degegši* [*de-g-(g)-ši] 'дээш' гэх зэрэг олон шинэ үг үүсчээ.

Дэв I |deb|[= *de-b] *'дэвжих', 'дээшлэх'* утга заасан үүсмэл язгуур || Cf. Man. *dewi* 'взмахивать' (Цинциус I:228) Энэхүү үүсмэл язгуураас *debji-* [*de-b-ji] 'дэвж-', *debere-* [*de-be-re] 'дэвэр-', *debši-* [*de-b-ši] 'дэвш-' зэрэг үгс үүсчээ.

Дэв II |debe|{< Tib. *sgrib}* *'мүдхэр'* (сэдхэл оюун нь будангуйрсан хүн)

Дэвтэр |debter|{< Tib. *deb-ther* < Pers. *daftār* < Gr. *διψθερα}* *'ном', 'цомог', 'боть'* || Cf. Turk. *däftär* 'das Heft' (Радлов, III:1692); Man. *debtelin* 'тетрадь' (Цинциус I:227) || Ж= *'yeke jüg-ün ayui delger tegüs tuγuluγsan udqa-yi medegülküi neretü sudur-un qoyar **debter** nom'* [их зүгийн агуу дэлгэр төгөс туулсан утгыг мэдүүлэхүй нэрт сударын хоёр дэвтэр ном](Turf.11) || х о р ш : *'дэвтэр ном'* || Kha. *defter*, Ord. Bur. *debter*, Oir. *dekᵊr*

Дэвэс- |debis| *'газараар дэлгэх'* || Ж= *'ebesün-ü üjügür-i dotuγši-da qandu-yul-un **debisčü**'* [өвөсний үзүүрийг дотогш хандуулан дэвэсч](Burq. V51a) // *'qančubān derelejü, qormai-bān **debüsčü*** [ханцуйгаа дэрлэж, хормойгоо дэвэсч] (MNT 254) // ***debisbe** debisker* 'постелил подстилку' (Mu. 139)

Дэвэсхэр |debisker| *'дэвэсдэг юм'* || Ж= *ger-ün **debisker*** [гэрийн дэвэсхэр] (Jun. 1) // *'yurbaγula **debüsker** beledügsen-dür Gautama jong bilig-iyer medejü'* [гуравуул дэвэсхэр бэлдхэсэнд Гаутама зөн билигээрээ мэдэж](Chimeg 32a) // *debüsger* 'matelas, tapis' (HY M49) // *debisker* 'подстилка' (Mu. 139) // *debesker* 'Polster' (LH 55) // *debisker 'bedding'* (Ras.204 B3) || х о р ш : *'нутаг дэвэсхэр', 'ор дэвэсхэр', 'олбог дэвэсхэр', 'хөнжил дэвэсхэр'* || Kha. *dewesχer*, Ord. *dewisᵏχer*, Bur. *debisχer*, Oir. *dewᵊskᵊr*

Дэг I |deg|[= *de-g] *'дэлэгэх'*, *'дээшлэх'* гэсэн утгыг хадгалсан үүсмэл язгуур. || Cf. Man. *deg-* 'долняться' (Цинциус I:228) Энэхүү язгуураас *degde-* [*de-g-de] 'дэгж-', *degji-* [*de-g-ji] 'дэгд' зэрэг үгс үүсчээ.

Дэг II |dig|{< Tib. *sgrig pa}* *'эсгэд тогтсон журам'*, *'дараалал'* || х о р ш : *'дэг журам'*

Дэгд |digde|{< Skr. *tigta}* *'гашуун'* (нарийхан иштэй, хөх өнгийн хонхон цэцэгтэй, гашуун амттай эмийн ургамал)

Дэглэм |diglem|{< Tib. *bsgrigs lam}* *'эсгэдлэх мөр'*, *'дэг ёс'* (Бурхан шашины санваартануудын мөрдвөл зохих сахил) || х о р ш : *'дэглэм журам'* || Kha. *deglem*

Дэл I |del| *адууны сэрвээ дагаж ургасан урт хилгас.* || Cf. Turk. *delhen 'грива'* (Щербак 2005, 33); Man. *delin* || Ж= *'söni adu'ün-u'ān kiji'ār-a kürčü, morin-u'ān del de'ēre helige-bēr-iyēn kebtejü'* [шөнө адууныхаа захад хүрч, мориныхоо дэлэн дээр элэгээрээ хэвтэж](MNT 128) // *del* 'crinière' (HY M49) || х о р ш : *'дэл сүүл'* || Kha. Ord. Oir. *del*

Дэл* II |del|[< *de + l] *'дэлгэх'* гэдэг үгийн анхдагч язгуур. Энэхүү язгуураас *delbe* [delbe] 'дэлбэ', *delde-* [delde] 'дэлдэ-', *delge-* [del-ge] 'дэлгэ-' гэх мэт үүсмэл язгуур салбарлан гарч, улам тэдгээрээс илүү олон үг салаалан гарчээ. || Ж= *'debürkü togo ān-i delegei šinaga bolju'* [дэвэрэх тогооны дэлбэгэр шанага болж](MNT 77)

Дэлбэ |delbe|[= del-be] *'дэлбий'*, *'дэлбэр-'* гэсэн утгыг агуулсан үүсмэл язгуур. Энэхүү язгуураас *delbege* [del-be-ge] 'дэлбээ', *delbeger* [del-be-ger] 'дэлбэгэр', *delbegene-* [del-be-gene] 'дэлбэгэнэ-', *delbere-* [del-be-re] 'дэлбэр-' гэх мэт олон үг үүсчээ || Ж= *'mayui nayur usun-a dügürdebesü nigen eteged mayad delberekü'* [муу нуур усаар дүүрвэл нэг талаараа магад задарах](Sub. VII:10b) ||

Дэлбэг |delbeg| х у у ч : *'жолоо'*, *'цулбуур'* || Ж= *'Hö'ēlün-üjin-i Yesügei-ba ātur delbege-deče kötöljü'* [Есүгэй баатар Өэлүн үжиний цулбууруас хөтөлж] (MNT 56)

Дэлгэ- |delge|[= del-ge] *'дэлгэрэх'*, *'тархаах'* гэсэн утгыг агуулсан үүсмэл язгуур || Ж= *'eldeb čečeg-üd-i delgen sačubai'* [элдэв цэцэгүүдийг тараан цацав] (Burq.45b) // *'tedüi Sa'āri-ke'ēr-i delgen bawūju'* [төдөлгүй Саарь хээрт тархан бууж](MNT 193) // *delgebe* 'breitete aus' (LH 56) || Энэхүү язгууруас *delgeče* [del-ge-če] 'дэлгэц', *delegei* [dele-gei] 'дэлхий', *delgemel* [del-ge-mel] 'дэлгэмэл', *delger* [del-ge-r] 'дэлгэр', *delgere-* [del-ge-re] 'дэлгэр-' гэх мэт үг үүсч, бас тэдгээрээс нийлмэл бүтэцтэй өөр шинэ үгс үүссэн байна.

Дэлгэр |delger|[= del-ger] *'өргөн'*, *'уужим'*, *'элбэг'* || Ж= *'ene üge čögen ber bögesü yabiy-a inu ayui delger'* [энэ үг хураангуй ч гэсэн үр өгөөж нь агуу өргөн](Chang. 40) // *'naran metü gege'ēn, na'ūr metü delger sedkiltü'* [нар мэт гэгээн, нуур мэт уужим сэдхэлт](MNT 254) // *delger* 'vaste' (HY M49) || х о р ш: *'өргөн дэлгэр'*, *'удам дэлгэр'*

Дэлгэр- |delgere|[= del-ge-re] *'түгэх'*, *'тархах'* || Ж= *'öngge ünür sayitu eldeb čečeg delgeren bayiqui'* [өнгө үнэр сайт элдэв цэцэг дэлгэрэн байхуй]

(Burq. 2a) // *'tergel saran metü amurlin* ***delgeregsen*** *linqu-a'* [тэргэл саран мэт амирлан дэлгэрсэн линхуа](Burq. 61a) // ***delgerebe*** *šitaqsan γal* [загоревщийся огонь распространился](Mu.141) || Энэ үгээс *delgerenggüi* [del-ge-re-ŋgüi] 'дэлгэрэнгүй' *delgeregül-* [del-ge-re-gül] 'дэлгэрүүл-' гэх зэрэг үгс үүсчээ. || х о р ш : *'өрнөн дэлгэрэх', 'мархан дэлгэрэх'* || Kha, Ord, Bur. *delger*, Oir. *delgʻr*

Дэлгэрэнгүй |delgerenggüi|[= del-ge-re-ŋgüi] *'өргөн дэлгэр'* || Ж= *'burqan-nuγud-i üjegsen joriy-iyar* ***delgerenggüi****-e maγtaju qutuγ ber γuγubai'* [бурхадуудыг үзсэн зоригоороо дэлгэрэнгүй магтаж](Burq. 33b) || Kha. *delgereŋgüi*

Дэлд- |deled| *'цохи-', 'дэлэс-'* || Ж= *'öber jayuraban bulyalduju ugilaldun ebčegüben* ***deledbei****'* [өөр зуураа тэмцэлдэж, уйлалдан чээжээ балбав](Sub. 64b) // *'qubi-yu'ān ǧuya inu* ***deledčü****, quburi nambalis buru'ūlqui-lu'ā'* [хурдан хувийнхаа гуяыг нь гуядаж, гүвээ толгодыг даван дутаахад](MNT 55 // *alaqan* ***deletbe*** [рукоплескал](Mu. 97) // *deledbe* 'schlug' (LH 56) // *čamī ken* ***dēletbe*** [qui t'a battu?](Ist. 27) || х о р ш : *'цохиж дэлдэх'* || Kha. *deldə-*, Ord, Bur. *delde-*, Oir. *deldʻ-*

Дэлд |delde|[= del-de] *'дэлдэгэр'* гэсэн утгыг агуулсан үүсмэл язгуур. Энэхүү язгуураас *deldegene-* [del-de-gene] 'дэлдэгэнэ', *deldeger* [del-de-ger] 'дэлдэгэр', *deldeyi-* [del-de-yi] 'дэлдий-', *delden* [del-de-n] 'дэлдэн' гэх зэрэг үгс гарсан байна.

Дэлхий |delekei|[dele-gei / dele-kei] *'газар дэлхий'* (*'өргөн дэлгэр'* гэсэн утгатай үг) || Cf. Man. *delegej* 'обширный' (Цинциус I:233) || Ж= *'****delekei****-yin eǰen Činggis qaγan tngri-yin joriy-i daγan'* [дэлхийн эзэн Чингис хаан тэнгэрийн зоригийг даган](Hin. 3) // ***delegei****-yi supuryad-iyar qo'o-da čimejü* [дэлхийг суваргадаар сайхан чимэж](Chu Yung Kuan B) // *'****delekei*** *edö'ē belen bolu*ǧ*san-dur nököčejü ya'ūn tusa bolqu bi'* [эдүгээ дэлхий бэлэн болсонд](MNT 201) || Kha. *delχī*

Дэмбэрэл |demberil|{< Tib. *rten 'brel*} *'шүтэн барилдлага'* (юмс үзэгдэлийн хоорондын шүтэн барилдсан холбоо) || х о р ш : *'бэлгэ дэмбэрэл'* || Kha. *demberel*, Ord. *demberil*

Дэмч |demči|{< Tib. *dem chi*} *'сүмийн харгалзагч'* (сүмийн тэргүүн хамбын туслах, аж ахуйн захирагчийн албан тушаалтан) || Kha, Ord. *demtši*, Oir. *demtšʻ*

Дэмчиг |demčig|{< Tib. *bde mchog*} *'дээд амгалант'* (гурван нүүр, арван нэгэн мутартай, хуяг дуулгатай, хоёр хөлөөрөө ад чөдхөрийг дэвсэн дарж байгаа нууц тарнийн ёсны гол бурхан)

Дэн I |diyan|{< Chin. *dián*} *'буудал'* (замын буудал, хоноглох буурчийн газар) || х о р ш : *'дэн буудал'*

Дэн II |deng|{< Chin. *dēng*} *'гэрэл'* (бурхан тахилын өмөнө асаадаг хөвөн голтой, том цөгөцтэй зул) || Kha, Ord, Bur, Oir. *deŋ*

Дэнлүү |denglü|{< Chin. *dēng lung*} *'бүрхүүлтэй дэн'* || Kha. *deŋlü*

Дэнс |dengse|{< Chin. *děng zi*} алт, мөнгө хэмжих хэмжүүр || Kha, Oir. *deŋsə*

Дэнчин |dengčing|{< Chin. *ding qian*} барьцаанд тавьсан эд юм || Kha. *deŋtšin*

Дэргэ derge *1. 'өвөр', 'хажуу' 2. довольно* || Ж= 1. *'Način noyan imayi* ***derge*** *ayir-a kelge-dür yabumuhad'* [Начин ноён түүнийг дэргэдээ хишигт явуулаад] (Chang. 14) // *'degedüs-ün* ***derge*** *čayada yabuyad'* [дээдэсийн хойно өмөнө яваад] (Chang. 35) || Ж= 2. *'doγolaγsan jürüken-i* ***derge*** *mökör bolju'* [догдолсон зүрхний дотно нөхөр болж](MNT 277)

Дэргэд dergede[=derge-de] *'өвөр', 'хажуу'* || Ж= *'tergegür-ün* ***dergede*** *emekün činahan kebtekü ebečin kümün-i üjejü'* [замын хажууд энэлэн шаналан хэвтэх өвчтэй хүнийг харж](Burq. 8b) // *Ögödei qan ečige-yin* ***dergede*** *aju'* [Өгөдэй хан эцгийн дэргэд аж](MNT 255) // ***dergede kebtebe*** [лежал около него](Mu. 141) // *dergede* 'neben' (LH 56) || Kha. *derged*, Ord., Bur. *dergede*. Oir. *dergad*

Дэвэл debel *'эмэгт. зах. хүн хормойтой гадуур хувцас'* || Cf. Man. *dekeli* 'одежда' (Цинциус I:231) || Ж= *'Bodisiv al kars-a* ***degel*** *emüsčü qamuγ tngri-ner-ün ayimay-γar küregelegülǰü'* [Бодисадва улаан шаргал нөмөрөг өмөсч, хамаг тэнгэр нэрийн аймагаар хүрээлүүлэн] (Burq. 7a) *'beye teri'ütü,* ***de'ël*** *jaqatu kiγin'* [бие толгойтой, дээл захтай нь сайн](MNT 33) // *de'el* 'robe' (HY M49) // *dël* 'шуба' (Mu. 141) // *dël* 'верхнее платье' (IM 436) // *debil emüsütü* [il s'habille](Ist. 26) // *debel* 'Kleid' (LH 55) || х о р ш : *'дээл хувцас'* || Kha. Ord. *dël*, Bur. *degel*. Oir. *degel*

Дээр degere[=*de-ge-re] *'дор'* гэсэн үгийн эсрэг утгатай үүсмэл язгуур. Энэхүү үүсмэл язгуураас *degerede-* [*de-ge-re-de] 'дээрд-', *degerelke-* [*de-ge-re-(l)ke] 'дээрэлхэ-', *degerenggüi* [*de-ge-re-ŋgüi] 'дээрэнгүй' гэх зэрэг нийл-мэл бүтэцтэй үгс үүсэн байна. || Ж= *'süm-e-yin ger-ün dotur-a yadan-a* ***deger-e*** *ba dour-a'* [сүмийн дотор гадана, дээр доор](Qqor. I:9) // *'Činggis qahān-nu haǰa ür* ***de'ëre*** *tengeri-eče ǰaγa'atu töregsen Börte-činō aǰu'u'* [Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяатай төрсөн Бөрт чоно ажгуу](MNT 1) // ***de'ëre*** *tenggiri-yin jorig-i kündülen daqaju'* [дээр тэнгэрийн зоригийг хүндэлэн дагаж] (KMQB A13)

Дээс degesü хилгасаар томож хийсэн оосор || Cf. Man. *desün* 'веревка' (Цинциус I:238) || Ж= *'niruγun-u yasun* ***degesün*** *görügsen metü'* [нурууных нь яс томсон дээс мэт](Burq. 38b) // ***degesün*** *kebelitü kemebesü köbegüken čay-taγan* ***degesün*** *büsetü tulada bolai'* [дээсэн хэвлийт хэмээвээс хүүхэд цагтаа дээсэн бүстийн тул болой](Chimeg 20b) // *de'esun* 'corde' (HY M49) // *burantaγun dësün* [веревка бурундука] (Mu.126) // *dësün 'ficelle, corde'* (Ist. 27) // *dêsün* 'горе' (Ras.202 A8) || х о р ш : *'дээс бурантаг', 'дээс шидмэс', 'олос дээс'* || Kha. *dës*, Ord. *dësu*, Bur. *dëhen*, Oir. *dës'n*

E

Еврей |yevrei|{< Rus. *еврей* < Gr. *εβραίος*} *'жүүд'*

Евро |yevro|{< Rus. *евро* < Gr. *ευρώπη*} 'ёвро' (Европын холбооны дундын мөнгөн тэмдэгт)

Европ |eüropc|{< Rus. Европа < Gr *ευρω*} *'ёвроо'* (Атлантын далай, Ази тивийн хоорондох өрнөдийн оронуудыг багтаасан тив)

Егүзэр |yüge]eri|{< Skr. *yogācāra*} *'үнэн арчуи мөрийг эрхшээгч'* (анхандаа бүддийн гүн ухааны нэгэн урасхалын нэр байгаад хожим тарнийн номд гүнзгий нэвтэрсэн хүнийг нэрлэх болжээ. Энэ урасхалын том сүм Зүүн Түрэгстаны Хар Хочо-д байсан бөгөөд хожим Халхад *'Егүзэрийн хийд'* гэж бас байжээ.) || Ж= ***'yogačaris-un yirtinčü-de suryaydayu'*** [ёгочарисын ертөнцөд сургагдаюу](Bod. 14a) // ***'aqa güüsi-de yogačari güüsi čola öggün'*** [ахмад гүүшид ёгочари цол өгөн](ET 86a) || Энэ үг нь яваандаа *'хашир'*, *'их юм үзсэн'* гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ || Kha. *yögč:ör*

Егүүдхэ- |yegüdke-| *х у у ч* : *'юулэх'*, *'солих'*, *'алах'* || Ж= ***'beye-ben yegüdkejü bögesü kümün-ü jayayan-dur törübesü uǰayur-tur törüyü'*** [биеэ егүүдхэвээс, хүний заяанд төрвөөс язгуурт төрюү](Turf. XII) // ***'gurban šöni qonolduju, ye'üdkelduǰü. šöni kebte'ül atugai'*** [гурван шөнө хоноглоод солилцож, шөнө хэвтүүл болтугай](MNT 192) // ***'tere qatun yegüdkegsen čaγ-tur kegür-i inu bükūli ongyulaysan ajuγu'*** тэр хатан алагдсан үед хүүрийг нь бүтэнээр нь онголсон ажээ](ET 82a) // ***'jorig-iyan ülü üǰü'ülen ja'urmaliq ye'ütke'esü'*** [зоригоо үл гарган замын дунд өөрчилвөөс](KMQB A5) || Kha. yegüdxə-, Oir. *yüdᵊχᵊ*

Егүүдхэл |yegüdkel|[= yegüd-ke-l] *'үхэл'* || Ж= ***'yirtinčü daqin-u itegel ünen joqiyaqui mör-tür getülgegči-yi yegüdkel ügei degedü sakimuni*** [ертөнц дахины итгэл үнэнийг зохиохуй мөрт гэтэлгэгчийг үхэлгүй дээд шигэмүни](Arj. III:12) // ***'degedü lam-a yegüdkel ügei včir bey-e-yin egüden-i negeǰü'*** [дээд лам егүүдхэлгүй очир биеийн үүдийг нээж](ET 102a) || Kha. *yegüdxel*, Oir. *yüdᵊχəl*

Ембүү |yüvembüü|{< Chin. *yuán bǎo*} *'өлгий мөнгө'* (мөнгөн гүйлгээнд хэрэглэдэг хэвд цудхасан алт, мөнгө) || Ж= ***'Тэр лам хадаг ембүү аваад цааш тавьжээ'*** (Ц. Дамдинсүрэн, Хууч яриа) || Kha. *yembū /yümbū*, Ord. *yimbū*, Oir. *yömbū*

Ер(эн) |yiren| **'9 х 10 = 90'** || Ж= ***'yeren yurban jigür eber*** [ерэн гурван жигүүр эвэр](Turf. 31) // ***yeren minqan*** 'девяноста тысяч' (Mu. 390) // ***yiren 'девяносто'*** (IM 450) // ***yiren*** 'neunzig' (LH 78) || Kha. *irə / iren*, Ord. *yire*, Bur. *yere(n)*, Oir. *yirᵊn*

Ерлө |yerüle| *'бүгэдийг эзэмших'*, *'хамагийг эрхшээх'* || Ж= ***'šašin-dur oruγsad-un sedkil bütügen irügekü-dür ber yerülen bursang quvraγ-un tulada irügekü tere ba'*** [шашинд орогсодын сэдхэлийг бүтээн үйлдэхүйд хамаг бурсан хуварагуудын тул ерөөхүй тэр ба](BT 158b) // ***'urida Ta luen delekei-yi yerülen medegsen-dür erke kučün inu delekei-dür delgereǰü'*** [урид Да Юан дэлхийг эрхшээн мэдсэнд эрх хүч нь дэлхийд дэлгэрч](KMQB A17) Энэ

үгийн бүтэцийн талаар A. Mostaert *'verülen universellement* ou *en général* ea *un converbum modale de verüle- embrasser la totalité'* хэмээн дурдсан бий. (*Le materiel Houa I i lu de Houng-ou*, 47)

Ерөндөг |yeründeg| *'номходлоч' 'дарлага'* || Cf. Uig. *jürüntük* 'лекарство' (ДТС 287) || Ж= *'bi basa yeründeg bolyan irüger talbiluyai'* [би бас ерөндөг болгон ерөөл тавьлаа](ET 11a) Kha. *yöröydög*, Ord. *yörönd*ök

Ерөө- |irüge|[irü-ge]{< hirü-ge} *'сайн сайханыг бэлэгдэн хүсэх', 'ерөөл хэлэх'* || Cf. Turk. *irü* 'знак' (ДТС 212) || 'Энэ үгийн *irü* гэсэн язгуур нь үгтэй ёр (уридчилан таамаглаж буй пүүдүйн шинж төлөв) гэсэн үгтэй язгуур нэг бололтой. || Ж= *'ilaš-in-dur oruysad-un sedkil büdügen irügekü'* [шашинд орогсолын сэтгэл бүтээн ерөөх](BT157a) // *'tere biraman edü tedü irügeged'* [тэр бирман олий тодий ерөөгөөд](Chimeg 17b) || х о р ш : *'хараараж ерөөх'* || Kha. *jorð-*, Ord. *ðrð-*, Bur. *jurð-*, Oir. *yörð*

Ерөөл |irügel/ irüger|{< *irü-ge-r*} *'сайны бэлэгдэлийн үг'* || Ж= *'erten-ü irüger-ün küčün'* [эртний ерөөлийн хүч](Burq. 22a) // *'tegüni iregülün čidaqu erten-ü irüger bui buyu'* [түүнийг ирүүлэн чадах эртний ерөөл бий болоу](ET 18b) // *hirēr ögbe üündü tengri* 'бог наградил его' (Mu. 185) || х о р ш : *'ерөөл бэлэг', 'хараал ерөөл'* ||Kha. *yörðl*, Ord. *ðrðl*, Bur. *yürðl*, Oir. *yörðl*

Ертөнц |yirtinčü|{< Tib. *'jig rten* (орчилон) + *čü*} *'орчилон дэлхий'* Cf. AT *jer* 'земля' (ДТС 257), *yēr 'ground'* (Clauson, 954) Буддийн ном сударт *'сав ертөнц', 'ишм ертөнц'* гэсэн ойлголт байдаг || Ж= *'saba yirtinčü-yi arilyan irügēkü'* [сав ертөнцийг арилган ерөөх](BT1 57a4) // *'ene ertinčü-yin kü'ün amitan'* [энэ ертөнцийн хүн амьтан](KMQB A8) // *'yirtinčü dakin-a takin maytaydaqu-yin burqan'* [ертөнц дахинд тахин магтагдахуйн бурхан](ET 21a) // *ene hirtünčin čimeg* [украшение этого мира](Mu. 157) || х о р ш : *'хорвоо ертөнц', 'орчилон ертөнц'* || Kha. *yörtöntsə, yörtömtsə* Ord. *yörtömtši*, Bur. *yürtemse*, Oir. *yirtmtši*

Золго- [jolγa|[= Jol-γa] *'уулзах', 'дайралдах'* || Cf. Man. *ǰola* 'приветствовать' (Цинциус I:262) // *ǰolǧo-* 'встречать' (Цинциус I:263) || Ж= *'hoi dotora uriāŋqadai kū'ün čō'ē buǧu alaju, qahirǧas inu, abid inu širaǰu bükü-yi* ***ǰolǧaǰu***' [ой дотор урианхадай хүн цаа буга алж, хавирга, хошногыг нь шарж байхтай дайралдаж](MNT 12) // *ǰolqaba* 'verlor' (LH 1271) || Орчин үеийн монгол хэлэнд уламжилалт заншлаар гар зөрүүлэн мэндлэхийг ийн нэрлэж байна. Энэ үгээс *ǰolγaɗaya-* [ǰolγa-ɗaγa] 'золгоцгоох', *ǰolγaldu-* [ǰolγa-ldu] 'золголдох', *ǰolγalta* [ǰolγa-lta] 'золголт', *ǰolγayul-* [ǰolγa-γul] 'золгуулах' гэх мэт нийлмэл бүтэцтэй үгс үүссэн бий. || х о р ш : *'мэндлэн золгох', 'учиран золгох'*

Золиг [ǰoliγ|[= ǰoli-γ] *'золиос'* (овчин зовлон, гай барзадыг зайлуулахын тул гурилан хүн хийж, тусхай ёслол үйлдэн муу зүг рүү хаях шашины зан үйл. Энгийн ярианы хэлэнд зөөлөн хараалын үгээр хэрэглэгддэг) || Ж= *'Чи яасан хар золиг вэ?'* (Д. Нацагдорж, Цагаан сар ба хар нулмис) Kha. *dzolig*, Ord. *džolik*, Bur. *zolig*, Oir. *zolɣ*

Зон [ǰon| 'ард олон' || Cf. Turk. *jon 'люди'* (Радлов, III:416); *ǯon* 'народ' (Цинциус I:264) || Ж= *'эгээс үр хүүхэд төрсөөр, үрээс үүд өрх үүссээр хүн нь зон болж яваа'* (Ц. Дамдинсүрэн, Буурал ижий минь) || х о р ш : *'хүн зон', 'зон олон'* || Kha. *dzoŋ*, Bur, Oir. *zoŋ*

Т у с х а й с у д а л г а а : Х. Пэрлээ, *'Зон'* хэмээх үгийн тухай, ХЗ 14, 1980, 15-16

Зонторог [ǰonturuγ| х у у ч : *'хор хөнөвөл', 'уршиг'* || Ж= *'sayin kümün mayui-luγ-a nōkūče-besü mayui-yin* ***ǰonturuγ*** *inu kürümüi'* [сайн хүн муутай нөхцөвөл муугийн уршиг хүрнэ](Sub IV:11) // *'ma'ün kü'ün-nü* ***ǰonturuǧ****-tur ükükü kü'ün büle'ē'* [муу хүний уршигаар үхэх хүн бөлгөө](KMQB B23) // *ǰonturuq* 'malheur, désastre, calamité' (HY M68)

Зонхов |zongqaba|{< Tib. *tsong kha pa} 'сонгинын ам'* (Шарын шашиныг үндэслэгч Лувсандагба */blo bzang grags pa/* (1357-1419)-ыг төрсөн газарынх нь нэрээр тийн нэрлэдэг.

Зоорь [ǰoγoorі|{< Chin. *jiā oer} 'агуулах'* (хоол хүнэс удаан хадгалах газар) || х о р ш : *'хөрөнгө зоорь'* || Kha. *dzōir*

Зоос |ǰoγus|{< Chin. *jiāo-zi} 'төмөр мөнгө'* (голдоо дөрвөлжин нүхтэй, нүүрэн дээрээ үсэгтэй дүгэрэг хавтагай мөнгөний нэгж. Орчин үед *мөнгө, төгөрөг* гэсэн ерөнхий утгаар хэрэглэдэг.

Зори- [ǰorі| *'чиглэх', 'шийдэх'* || Cf. AT. *jorī-* 'идти, ходить' (ДТС 274) || Ж= *'ayuγulqui qurča mešēs-iyer* ***ǰoriǰu*** *qurdun-a bos kemen ayuyulqui'* [аюултай хурц мэсээ чиглүүлэн хурдан бос хэмээн айлгахуй](Burq. 56a) // *'Yesügei quda kendür* ***ǰoriǰu*** *ayīsula'ā'* [Есүгэй худ хэнд зорьж ирэв](MNT62) // *ǰoriba* 'направил' (Mu.208) || Энэ язгуур дээр *-γ, -lγa, -lta, -may, -γul* гэх мэт дагавар залгаж *ǰoriγ* [ǰori-γ] 'зориг', *ǰorilγa* [ǰori-lγa] 'зорилго', *ǰorilta* [ǰori-lta] 'зорилт', *ǰorimay* [ǰori-may] 'зоримог', *ǰoriγul-* [ǰori-γul] 'зориул-' гэх зэрэг үгс үүсч, тэдгээрээс улам олон шинэ үг үүсчээ. || Kha. *dzorĭ-*, Ord. *džori-*, Bur. *zori-*, Oir. *zör-*

Зориг [ǰoriγ|[= ǰori-γ] **1.** *'хүсэл'* **2.** *'эрэмгий шинж'* || Ж= **1.** *'minu enerin asaraqui* ***ǰoriγ****-tur adali bolumui'* [миний энэрэн асарах хүсэлтэй адил болмуй] (Тор.9) // *'kü'ün amitan de'ēre tenggiri-yin* ***Jorig****-i kündülen'* [хүн амьтан дээд

тэнгэрийн хүсэлийг хүндэлэн](KMQB A2) || Ж= **2.** *'Ataibuq-a qataɣu* ***Joriytu bayatur Jirüketü'*** [Атайбуха хатуу зоригт баатар зүрэхтэй](Hin. 18) // *joriq* 'volonté' (HY M68) || х о р ш : *'зориг зүрэх', 'зориг самбаа' // 'дур зориг', 'итгэл зориг', 'урам зориг'* || Kha. *dzorig*, Ord. *džorig*, Bur. *zorig*, Oir. *zörɪg*

Зорч- [jorči / yorči] *'яв-', 'нааш цаашаа яв-'* Энэ үгээс *jorčiyči* [jorči-ɣči] 'зорчигч), *jorčiyul-* [jorči-ɣul] 'зорчуул-' зэрэг үг үүсчээ || Ж= *'ayul ügegüli-e čilel ügei amuyulang-a* ***jorčiqun*** *boltuɣai'* [аюулгүй ядаралгүй амагалан явах болтугай](Bod. 18a) // *'Sorqan-šira-yin ger erin Onan müren hürü'ü* ***yorčiba'*** [Сорхан шарын гэрийг эрж Онон мөрөн тийш явав](MNT 84) // ***'yorčiqun*** *yabuqun ilčin'* [нааш цаашаа явах иргэн](Khub. I:4 || // ***yorči*** *'иди'* (IM 450) // *yorčiba* 'ging, reiste' (LH 77) // ***yorčiqu*** 'to go' (Ras.188 C25) || Kha. *dzortšī-*, Bur. *zortšī-*, Oir. *zor-*

Зос [josu|{< Chin. *zhěshí*} *'улаан будаг'* (шороон будаг) || Kha. *dzos*, Ord. *dzoso*

Зохи- [joki|{< joqi} *'нийцэх', 'тохирох-'* || Cf. Man. *ǯoki* 'подходящий' (Цинциус I:262) || Ж= *'načiɣai eke nayiran* ***joqiju'*** [назгай их найр зохиож](BT 167a) // *'Yesüi neretei, nadača de'ēre, qan kü'ün-e* ***Jokiqui*** *aji'āi je'* [Есүй нэртэй надаас илүү, хаан хүнд тохирох хүн бий](MNT 155) Энэхүү язгуур дээр *-ldu, -mǰi, -ra, -s, -ya* зэрэг дагавар залгаж, *joqildu-* [joqi-ldu] 'зохилд-', *joqimǰi* [joqi-mǰi] 'зохимж', *joqira-* [joqi-ra] 'зохир-', *joqis* [joqi-s] 'зохис', *joqiya-* [joqi-ya] 'зохио-' гэх зэрэг үгс үүсчээ. || Kha. *dzoxī-*, Ord. *dzoˈxi-*, Bur. *zoxi-*, Oir. *dzoki-*

Зохилд- [jokildu|{< joqi-ldu} *'зохицуулах', 'эвлэлдэх'* || Ж= *'quvraɣ-ud nasu turqaru eye* ***joqilduɣad'*** [хуварагууд насан турш зохицоод](BT159b) // *'jiči müd* ***jokilduya'*** *ke'ēgdejü Qorijin qatun, Qu'ūrčin qatun jirin-i iču'āju* [жич даруй зохицуоё гэж Хорижин хатан, Хуурчин хатан хоёрыг буцааж](MNT 132)

Зохимдуу [jokimdaɣu|{< joqi-mda-ɣu} *'найрсаг'* || Ж= ***'joqimdaɣu*** *sedkil'* [найрсаг сэдхэл](Taq. 28a)

Зохимж [joqimǰi|[= joqi-mǰi] *'тохиромж', 'зохис'* || Ж= *'ebesün usun-u* ***joqimǰi****-bar adūsun tejē'ülü'ēd'* [өвөс усны зохисоор адуу малаа тэжээгээд] (KMQB A 27) || Kha. *dzoximdz*ⁱ

Зохио- [jokiya|{< joqi-ya} *'бүтээх', 'тохируулах'.* Энэ үгээс язгуураас *jokiyayul-* [joki-ya-ɣul] 'зохиолго-', *jokiyal* [joki-yal] 'зохиол', *joqiyalɣa-* [joqi-yalɣa] 'зохиолго-' зэрэг үгс үүссэн байна || Ж= *'quɣur dayun-u kög* ***jokiyaǰu'*** [дуу хуурын хөг зохиож](Burq. 46b) // *'bodi jirüken-dür* ***jokiyaɣsan*** *körüg čimeg'* [боди зүрэхэнд бүтээгдсэн хөрөг чимэг](Burq. 53b) // ***joqi'āba*** *defteri* [сочинил книгу] (Mu. 208) || х о р ш : *'зохион бүтээх'* || Kha. *dzoxiō-*, Ord. *dzoˈxō-*, Bur. *zoxyō-*, Oir. *zokā-*

Зохиол [jokiyal|[< joqi-ya-l] *'бүтээл'* || Ж= *'arban qoyar* ***jokiyal*** [арван хоёр зохиол тэргүүтэн](EE 15b) || х о р ш : *'зохиол бүтээл', 'зохиол туурвил' // 'бичиг зохиол', 'ном зохиол',* || Kha. *dzoxiōl*, Ord. *ǰoˈχōl*, Bur. *zoχyōl*, Oir. *zokāl*

Зохионгуй [jokiyangɣui|[= joqi-ya-ŋɣui] *'зохиол', 'үйл'* || Ж= *'arban qoyar jokiyangɣui üyiles'* [арван хоёр зохионгуй үйлс](Burq. 41b)

Зохир- [jokira][= Joqi-ra] *'зохицуулах', 'эвтэлдэх'* || Ж= *'delekei ulus joqiraju tōbšigeridūged'* [дэлхий улас зохицолдон түвшидээд](Taq. 15b)

Зохис [jokis][= joki-s] *'зохимжтой', 'найруу'* || Ж= *'čikin-dür jokistu quyurun dayun'* [соносохуйд зохистой хуурын аялгуу](Burq. 29b) // *joqisi'ār talbiba yamayi* [положил вещи как следует](Mu. 208)

Зөв [jōb] 1. *'зохистой'* 2. *'жинхэнэ', 'яг'* Энэхүү язгуур дээр *-de, -dü, -le, -ši, -tū* дагавар залгаж, *jōbde-* [jōb-de] 'зөвд-', *jöble-* [jöble] 'зөвлө-', *jöbši-* [jöbši] 'зөвш-', *jöbtū-* [jōb-tū] 'зөвт-' гэх мэт үгс үүсч, улам тэдгээрээс илүү олон үг салаалан гарчээ || Ж= **1.** *'jöb yabuysan sayin ner-e inü olan-a temdegtei-e uqaydaysabar'* [зөв явсан сайн нэр нь олоноо сайтар мэдэгдсээр](Hin. 42) // *'eteged jōb-i ilyayči eyimū uqayan bolbasu ene bilig bramid bolai'* [бууруу зөвийг ялгагч ийм ухаан бол билиг бармид болой](Turf. 3) // *'ta tus qan-iān tebčin yadağsan sedkil tanu jōb büi'* [та өөрийн хаанаа тэвчин ядсан чинь зөв буй](MNT 149) || Ж= **2.** *'jōb dalan doluyān nasun-dur-iyān ebedčin-iyēr ügei bolǰuyu'* [яг далан долоон насан дээрээ өвчинөөр таалал төгөсчээ](Hin 36) || Ж= *eǰen inü jōb es-e bolǰu kōbegün inü ečige-yügen or-a tüšibesü'* [эзэн нь таалал төгөсч хүү нь эцэгийнхээ суудалд сууваас](Chang. 25) // *jōb* 'хорошее дело' (IM 439) // *jōb* 'говорить правду' (IM M133) || х о р ш : *'зөв бууруу', 'зөв зүйтэй'* || хэлц: *'jöb es-e bol-'* /зөв эс болох/ (таалал төгөсөх) || Kha. *dzöw*, Ord. *dzöb*, Bur. *züb*, Oir. *zōw*

Т у с х а й с у д а л г а а : F. W. Cleaves, The Expression *jōb ese bol-* in the SHM, HJAS 11, 1948, 311-320

Зөвлө- [jöble] 1. *'зөвдөх', 'зөв болгох'* 2. *'тохирох', 'зохицуулах'* Энэ үгээс *jöblegen* [jöb-le-gen] 'зөвлөгөөн', *jöblel* [jöb-le-l] 'зөвлөл', *jöblemǰi* [jöb-le-mji] 'зөвлөмж' зэрэг үгс үүсчээ. || Ж= **1.** *'učir čay-i medegči, činegen-i medegči, jöblekü-yi medegči tere yeke boyda'* [учир цагийг мэдэгч, чинээг мэдэгч, зөвлөхийг мэдэгч тэр их богд](Burq.1b) Ж= **2.** *'qabur namur-tur küyiten qalayūn jöblekü'* [хавар намарт халуун хүйтэн нь тохирох](Burq. 7b) || х о р ш : *'заааж зөвлөх'* || Kha. *dzōwōl-*, Ord. *džöblö-*, Bur. *züble-*, Oir. *zöwᵊl-*

Зөвхөн [jöbken][= jōb-ken] *'зөв' + 'хөн'* Энэ үг нь *'хөөрхөн', 'сайхан'* гэдэгийн нэгэн адил хүч нэмэх үүрэгтэй *'хан'* дагавартай үг бөгөөд анхандаа *'зөв'* (зөвөөс зөв) гэсэн утгатай байсанаа хожим одоогийн хэрэглээний утгад шилжжээ. || Ж= *'tere metü arilyan yabuyči kümün jöb* ***jöbken*** *degegši odumui'* [тэр мэт гэмээ арилган явагч хүн зөв зөвхөн дээш одно](Sub. VIII:14b)

Зөвшөө- [jöbšiye][= jōb-šiye] *'зөвшөөрөх', 'сайшаах'* || Ж= *'bida ber endeče morilaju qamsay-a kemen ōčijü ilegsen-i činü* ***jöbšiyejü'*** [бид эндээс хөдөлж, хамтарая хэмээн өчиж илгээсэнийг чинь зөвшөөрч](Ar. II:13) // *'ene üge-yi jöbšiyejü Jürčedei, Arqai qoyar-i alginčila'ūlju* [энэ үгийг зөвшөөрч, Жүрчидэй, Архай хоёрыг толгойн харуулд тавьж](MNT 185) || Kha. *dzöwšō-*, Ord. *džöbšō-*, Bur. *zübšō-*, Oir. *zöwšā-*

Зөн [jöng]{< Chin. *zhuān*} *'тоосхо'* (шатаасан туйпуу)

Зөнтөг [jönteg][jön-teg] *'мулгуу', 'зөнөг'* || Ж= *'uqā ügegüi* ***jönteg*** *mayui'* [ухаангүй, зөнөг муу](Turf VII:5) // *'энэ* ***зөнөг*** *өвгөн нь уучих гээд болдоггүй'*

(Ч. Лодойдамба, Тунгалаг тамир)

Зөө* |jöge| *'зөөлөн', 'дулаан'* гэсэн утгыг хадгалсан язгуур. Энэ язгуураас *jögeg* [jöge-g] 'зөөг', *jögede-* [jöge-de] 'зөөд-', *jögel-* [jöge-l] *'зөөл', jögelen* [jöge-len] 'зөөлөн', *jöges-* [jöge-s] 'зөөс-' гэх зэрэг үүсмэл язгуур үүссэн байна.

Зөөг |jögeg / Jögen |[= Jöge-g / jöge-n] *'сэрүүн', 'жихүүн'* || Ж= ***'jögen*** *qalayun-u čay-tur nimlayun jujayan-i kemleged'* [халуун хүйтэнийг цагт нимгэн зузааныг тохируулаад](Chang. 16) // *'šiljirin bükü boroğōn-a, šilgüdken bükü* ***jö'ēn****-e, čidqun bükü qura-da'* [шивэрэн бүхий бороонд, чичирүүлэн бүхий жихүүнд, цудхан бүхий хурд](MNT 230) // *jögen* 'froid' (HY M68) // *jōn* 'холодный' (IM 439) // *jöyen* 'froid' (Ist. 39) // *ǯäbisbä* 'быть холодным' (IM M133) // *jöen bolqui* 'kalt werden' (LH 1273) // *jöen* 'cold' (Ras. 205 D2) || Орчин цагийн монгол хэлэнд халуун байсан юм хөрч *бүлээн* болсоныг илэрхийлнэ. Kha. *dzōg,* Ord. *džōs,* Oir. *zōg*

Зөөлөн |jögelen|[= jöge-len] *'хамуу'* гэдэгийн эсэрэг утгатай үг. || Ж= ***'jögelen*** *köbseg oron-dur lagšan nairay-iyar čimegdejü'* [зөөлөн хөвсгөр оронд лагшин найрагаар чимэгдэж](Burq. 2a) // ***jögelen*** *irayu dayutu Dibangkar-a burqan'* [зөөлөн яруу дуут Дивангар](Burq. 6b) // *'torlug Tayaŋ* ***jö'ōlen*** *büyü či'* [ядуу дорой Таян чи зөөлөн буюу](MNT 189) // *jö'ēlen* 'mou, flexible' (HY M68) // *jö'ēlen* 'мягкий' (Mu. 209) // *jōlen* 'mou' (Ist. 39) // *jōlän* 'soft', 'tender' (Zir. 109) // *jölen* 'soft' (Ras.203 C4) || х о р ш : *'намуун зөөлөн', 'уян зөөлөн', 'хамуу зөөлөн'* || Kha. *dzōlöŋ,* Ord. *džōlön,* Bur. *zōlen,* Oir. *zōlᵊn / dzōlᵊn*

Зуд |jud| *'зутар-'* гэдэг үгийн язгуур (өвөлийн салхи шуурга, хүйтэнээс болж зутарах) || Cf. Uig. *judun* 'snow-storm, blizzard' (Schwarz 320); *joduy* 'беда, бедствие' (ДТС 286), *zud* 'гололедица', 'бескормица из-за гололедицы' (Щербак 2005, 68) || Ж= *'qobur* ***jud-i*** *qola ilejü'* [ховор зудыг холдуулж](BT 167a9) || х о р ш : *'зуд мурхан', 'ган зуд'* || Kha. *dzud,* Ord. *džud,* Bur. *zud,* Oir. *zuᵘ*

Зул |jula|{< Turk. *jula* < Skr. *jwāla*} *'дөл'* (тахилын өмөнө асаадаг жижиг дэн) // Pl. *julas* || Cf. Turk. *jula* 'факел, свеча' (Радлов, III:553), AT *jula* 'факел, светильник' (ДТС 278), AT *yula* 'torch, lamp' (Clauson 919) || Ж= *'mön kei öčügüken* ***jula****-yi sönegeyü'* [мөнхүү салхи өчүүхэн зулыг унтараана](Sub. IV: 4b) // *jula* 'lampe' (HY M69) // *sönebe* ***jula*** 'свеча погасла' (Mu. 325) // *jula* 'фонарь' (IM 439) // *jula* 'lamp' (Ras.204 B25) || х о р ш : *'зул хуж'* || Kha. *dzul,* Ord. *džula,* Bur. *zula,* Oir. *zulᵘ*

Зулгаа- |julγaγa|[= jul-γa-γa] *'мам-', 'салга-'* || Cf. Turk. *jul-* 'отнимать' (ДТС 277) || Ж= *'ойн араатаны нүд, ногоон гал шиг гялалзан, архиран урхиран хүүр* ***зулгаах*** *чимээ дуулдаж'* (Б. Ринчен, Заан залуудай) || х о р ш : *'татаж зулгаах'* || Kha, Ord. *dzulğā-,* Bur. *zulğā*

Зулзага |julǰaγ-a| *араатан, жигүүртэний нялх төл* || Ж= *'šiγaǰiγai-yin* ***julǰiγan*** *eke-yügen üsün-i isüjü'* [шаазгайн зулзага эхийнхээ үсийг зүсч](Sub. V:4b) // *juljayan* 'цыпленок' (Mu. 211) // *juljiqan* 'Vogeljunges' (LH 1272) || Kha, Ord. *dzuldzağa,* Bur. *zulzağa,* Oir. *zulzᵘğᵛn*

Зуун |ǰaγun| *'10 x 10 = 100'* // Pl. *ǰaγud* || Ж= *'tabun **ǰayun** kümün-e dayaydaqui gičkigür-i ǰarim ber-e yaǰar-a sonosdaqui dayutu-yi egüdkegülbei'* [таван зуун хүн даах гишгүүрийг хагас бээр газарт соносогдох дуутыг байгуулав] (Burq. 7b) // ***ǰa'ūn*** *minqan* 'сто тысяч' (Mu. 203) // *ǰawun* 'cent' (Ist. 38) // *ǰawūn* 'hundert' (LH 1271) || Kha. *džūŋ*, Ord. *džūn*, Oir. *zūn*

Зуур- |ǰiγura| *нунтаг зүйлийг шингэнтэй хольж найруулах* || Cf. Turk. *juγur-* || Ж= ***ǰuruqsan*** *qulir* 'dough' (Ras. 205 B4) // *maya ügei **ǰūraba** yuluri* [замесил тесто без закваски](Mu. 234) || х о р ш : *'зуурч нухах'* || Kha. *dzūr-*, Ord. *džūra-*, Bur. *zūra-*, Oir. *zūr-*

Зуух |ǰuuq-a|{< Chin. *záo huo*} *гал түлдэг төмөр хайрцаг* || *'хуучин даалимбан дээлтэй хорчгор өвгөн **зуухны** аман дээр сууна'* (Д. Намдаг, Цаг төрийн үймээн) || х о р ш : *'гал зуух'*, *'зуух яндан'* || Kha. *dzūx*, Ord. *džūxa*, Bur. *zūxa*, Oir. *zūχɒ*

Зүг |ǰüg| *'чиг'*, *'тийш'* (Орчилонгийн орон зайг хөндөлөөшөө дөрөв хуваасаны нэг нь зүг, найм хуваасаны нэг нь зовхис болно. Монголчууд зүг чигийг *'дөрвөн зүг'* (өмөнө / хойно, баруун / зүүн), тэдгээрийн хооронд *'дөрвөн зовхис'* (баруун хойд / зүүн хойд, баруун урд / зүүн урд) гэж хуваан үздэг. Мөн *'арван зүг'* гэж байдаг нь *4 зүг, 4 зовхис* болон *дээд, доод* зүгийг багтаасан ойлголт юм. || Ж= *'sayin-u aldar inu bükü arban **ǰüg-tür** aldaršituγai'* [сайн алдар нь бүх арван зүгт алдарштугай](BT 161a) // *'hülegsed-i boǧōli-duya. **ǰüg ǰüg** qubiālduya'* [үлдэгсэдийг нь боол болгож, тал тал тийш хуваж авцгаая](MNT 154) // *ǰüg* 'direction' (HY M69) // *ǰüg* 'сторона' (Mu. 211) // *ǰüg* 'side', 'direction' (Zir. 110) || х о р ш : *'зүг чиг'* || Kha. *dzüg*, Ord. *džüg*, Bur, Oir. *züg*

Зүд-* |ǰüde| *'ядар'* гэсэн утгатай *'зүдэр'* гэдэг үгийн анхдагч язгуур || Cf. Turk. *jüd-* 'нагружать, навьючивать' (ДТС 283) Тус язгуураас *ǰüdeg* [ǰüde-g] 'зүдэг', *ǰüdegü* [ǰüde-gü] 'зүдүү', *ǰüdegür* [ǰüde-gür] 'зүдүүр', *ǰüdel* [ǰüde-l] 'зүдэл', *ǰüdengi* [ǰüde-ngi] 'зүдэнги', *ǰüdere-* [ǰüde-re] 'зүдэр-' гэх зэрэг үгс үүсч улам тэдгээрээс олон шинэ үгс дам үүсчээ. || Ж= *'ülemǰi maši ayuǰu **ǰüdeǰü** qamuγ nöküd-iyen čiγulγaǰu ögüler-ün'* [маш их айж зүдэрч, олон нөхөдөө цуглуулан үгүүлэрүүн](Burq. 54b)

Зүдэр- |ǰüdere|[= ǰüde-re] *'ядарах'*, *'зовох'* || Kha. *dzüder*, Ord. *džüdere*, Bur. *züder*, Oir. *züdᵊr-*

Зүлд I |ǰülde| *'ангийн хишиг'* (ангийн бие эрхтэний төлөөлөл болсон толгой, уушиг, зүрэх, мөгөөрсөн хоолойг нь нийлүүлсэн багц. || Ж= *'a'ūšigitu **ǰildü**, arasun inu abču'* [уушигт зүлд, арисыг нь авч](MNT 13) Проф. I de Rachewiltz дээрхи үгийн гол утгыг *'the essential portion of the animal'* гэж томъёолсон байна. (*The Secret History of the Mongols*, 2004, 258) || Kha. *dzüld*, Ord. *džülde*, Bur. *zülde*

Зүлд II |ǰüldü| х у у ч : *'гавъяа'* || Ж= *'ǧurban kö'ūn-ü amin aburaǧsan **ǰüldü'*** [гурван хүний амь аварсан гавъяа](MNT 214-39)

Зүмбэрэл |ǰümbürel|{< Tib. *rdzu 'phrul*} *'рид хувилгаан'* (эртний энэдхэгт наян дөрвөн шидтэн амьтаны тусын тул элдэв ид шидийг үзүүлсэн үйлийг ийн нэрлэж байжээ)

Зүрчид [jürčid] *'мунгүүс угсааган'* (Сунгар мөрөн, Хар мөрөний сав газар тариалан, мал аж ахуй эрхлэн амь зуудаг түнгүүс угсааны үндэстэн. 1635 он хүртэл тэднийг *Зүрчид'* хэмээн нэрлэдэг байжээ.)

Зүрэх [jürüke] 1. *цусны эргэлтийг зохицуулах гол эрхтэн'* 2. *'зориг', 'сэдхэл'* || Cf. Turk. *jürāk* 'das Herz' (Радлов, III:600), AT *jürāk* 'сердце' (ДТС 286), Uig. *jürāk* 'heart' (Schwarz, 807); Man. *ǯürügu* 'сердце' (Цинциус I:278) || Ж= 1. *jürüke 'сердце'* (IM 439) // *ǰirüge* 'сердце' (IM M132) **2.** Ж= *'qatayui-tu üge-yin sumun-i dügürgeǰü qarbuγsan-iyar ǰirüken minü ebedbesü'* [хатуу үгийн сумыг дүүргэж харвасанаар зүрэх минь өвдвөөс] (Burq. 14a) // *'Čimbai, Čilawūn qoyar kū'ud inū ōrō ǰirüke-bēn ebedčü'* [Чулуун, Чимбай хоёр хүү нь өр зүрэхээ өвдөхөж](MNT 84) // *jürüken* 'cœur' (HY M69) // *ǰürke* 'Herz' (LH 1273) || х о р ш : *'зүрэх зориг', 'зүрэх сэдхэл', 'элэг зүрэх'* || х э л ц : *'зүрэх алдах'* (халширах), *'зүрэх гаргах'* (зориглох), *'зүрэх өвдөх'* (өрөвдөх), *'зүрэх ухэх'* (айх) || Kha. *dzürex*, Ord. *džürex*, Bur. *zürxe*, Oir. *zürkʰn*

Зүрэхний тольт [jürüken-ü tolta] *монгол хэлний анхны хэлзүйн бүтээл* (1243 онд төвөдийн эрдэмтэн Гунгаажалцангийн зохиосон монгол хэлний зүйн бичиг)

Зүү* [jegü] *'зүүд'* гэдэг үгийн анхдагч язгуур. Тус язгуур дээр *-den, -le* дагавар залгаж, *jegüden* [jegü-den] 'зүүд', *jegüle-* [jegü-le] 'зүүл-' гэсэн үгс үүсчээ.

Зүүд [jegüdün][= jegü-dün] *'нойрон дунд орж ирэх хий дүрслэл'* || Ж= *'yučin qoyar jüyiltü mayui ǰegüdün ǰegüdüleǰü seriged'* [гучин хоёр зүйлийн муу зүүд зүүдэлж сэрээд](Burq. 54b) // *'bi ene sōni ǰewüdün ǰewüdülebe'* [би энэ шөнө зүүд зүүдлэв](MNT 63) // *je'üdün* 'rêve' (HY M67) // *jüdü* 'сон' (Mu. 212) // *jüdün* 'dream' (Zir. 110) || х о р ш : *'зүүд нойр', 'зүүд зэрэглээ'* || Kha. *dzüd*, Ord. *džüde*, Bur. *züde*, Oir. *züdʰn*

Зүхэл [jükeli] х у у ч : *'махилга', 'майлга'* (Муу ад тодхорыг зайлуулахын тул ан амьтаны арис махны дээжийг тэнгэрт өргөх эртний зан үйл) || Ж= *ǰewüredei urida jükeli-dü[r] orun büle'ē'* [Жэгүүрдэй урид тахил тайлгад орсон бөлгөө](MHT 44) || х о р ш : *'хараал зүхэл'*

Т у с х а й с у д а л г а а : L. Bese, The Shaman Term *Jükeli* in the *Secret History of the Mongols*, AOH 40, 1986, 241-248 // М. Хашимото, *Монголын нууц товчоон* дахь *jügeli* гэдэг үгийн гарал үүслийн тухай, *Mongolica* 14, 2004, 235-237

Зэв I [jibe]{< Chin. *xiè*} *металын исэлдэлээс гарсан улаавтар хаг* || Cf. *ǯebi* 'ржавчина' (Цинциус I:281) || Kha. *dzew*, Bur. *zebe*, Oir. *zew*

Зэв II | *'харвах сумны хурц үзүүр', 'зэвсэг'* // Pl. *ǰebes* (Sub. III:11) || Cf. Man. *ǯewe* '*стрела*' (Цинциус I:281) || Ж= ***ǰebe dora unaǰu ög'*** [харвах сумны дор унаж өг](Alt.20) // *'aman čağān qula-yi minu aman niru'ū qarbuğsan-u tula ǰebe nereyī[d]čü'* [ам цагаан хулын минь нурууг харвасаны тул зэв хэмээн нэрлэж](MNT 147) // *'bidan-i ese itegeǰü, ǰer ǰebe-yi quriyaǰu'* [биднийг эс итгэж, зэр зэвсэгийг хурааж](KMQB B23) // *ǰebeten* 'вооруженные копьями' (Mu. 204) || Kha. *dzew*, Ord. *džew*, Bur. *zebe*, Oir. *zewʰ*

Зэд |Jed|{< Tib. *'gyed'*} *'мүгээл'* (өглөгийн зээдээс сүм хийдэд өргөсөн зүйлийг хуралын лам нарт түгээх үйл) || Kha. *dzed*, Oir. *zedə*

Зэдхэ- |Jedke|[= Jed-ke] х у у ч : *'саатуул-'*, *'хори-'* || Ж= *'ayisurun ja'ūra čeri'ūd-te jedkügdeǰü'* [ирэх зуураа цэрэгүүдэд саатуулагдаж](MNT 197)

Зэдхэр |Jedker|{< Jedke-r *'хориг'*, *'саад'* || Ж= *'čerig ayan-u ūyile jedkūr boluyad'* [цэрэг дайны явдалд саад болоод](Hın. 20) || Kha. *dzedxer*, Oir. *zetk'r*

Зэдхэгэр |Jedküger| *'маяцан'*, *'майз'* || Ж= *'dal-a modud-un emün-e niǰiged erdini kib-iyer čimegtü jedküger talbiǰu jedküger dutum-dur agaru čindan terigüten čay čay-tur tülekü küǰis-i bariysan'* [дал модны өмөнө тус тусд нь эрдэнийн хивээр чимсэн тавцан тавьж, тавцан тутамд агар зандан тэргүүтэн цаг цагт шатаах хүжисийг барьсан](Burq. 46b)

Зэм |Jem| *'гэм'*, *'буруу явдал'* Энэхүү язгуураас *jemle-* [jem-le] 'зэмлэ-' гэсэн үйл үг үүсч, уламаар түүнээс хэд хэдэн үг дам үүсчээ. || х о р ш : *'гэм зэм'*, *'ял зэм'* || Kha. *dzem*, Ord. *dzime*, Bur. *zeme*, Oir. *zem'*

Зэмлэ- |Jemle|[= jem-le] 1. *'буруушаах'* 2. х у у ч : *'амь хороох'*, *'алах'* гэсэн үгийн эерүүлсэн илэрхийлэл. Халхчууд мал алахыг *'муулах'* гэж хэлдэг нь энэ үгтэй утга нэг билээ. || Ж = 2. *'ger-ün ümere Jetei, Jelme qoyar muqular qara hüker jemlen alaǰu* [гэрийн хойно Жэтэй, Зэлмэ хоёр зэмлэн алж](MNT 214) МНТ-г судалсан эрдэмтэд энэ үгийг *'мэлж алах'*, *'мэслэн алах'*, *'төхөө-рөх'* гэсэн утгаар буулгажээ. || х о р ш : *'зэмлэн буруушаах'*

Зэндмэнэ үз Чандмани

Зээ |jege| *'төрсөн охины хүүхэд'* || Cf. Turk. *jegān* 'племянник' (ДТС 252) || Ж= *'ba oŋgirad irgen erte üdür-eče je'ē-yin jisün, ökin-ü öŋgeten ulus'* [манай онгирад иргэн эрт цагаас нааш зээгийн зүс, охины өнгөтөн улас](MNT 64-1) || х о р ш : *'ач зээ'* || Kha. *dzē*, Ord. *dzē*, Bur, Oir. *zē*

Зээрэмбэ |Jeramba|{< Tib. *rtsis ram pa*} *'зурхайд маш хэтэрхий'* (тоо, зурхайн ухаанд гаргуун суралцсан хүнд олгодог эрдэмийн дээд цол)

Зээтүү |Jegetüü|{< Chin. *juė tou*} *'ёотуу'* (нэг талдаа үзүүртэй газар ухах багаж) || Kha. *dzētü*, Ord. *dzētü*

И

Ивээ- |ibege|[= ibe-ge] *'энэрэл өршөөл үзүүлэх'* || Ж= *'teŋgeri kü **ihe'ēbe** je'* [тэнгэр ч ивээлээ](MNT 145) // *'tenggiri bayasun **ihēget'*** (KMQB A15) // *tengri tüni **hibēbe** dušman tulada* [tengri оказал ему помощь перед лицом врага](Mu. 347) || х о р ш : *'ивээн тэдхэх'* Kha, Oir. *iwē-*, Ord. *iwegē*, Oir. *iwā-*

Ивээгд- |ibegegde|[= ibe-ge-gde] *'ивээлд багтах'* || Ж= *'tngri-de **ibegegdejü** ōljei qutuγ kürteged'* [тэнгэрт ивээгдэж өлзий хутаг олоод](Taq. 32b) // *'tere čaqača inaqšida tenggiri-de **ihēgdejü'*** [тэр цагаас нааш тэнгэрт ивээгдэж] (KMQB B4)

Ивээл |ibegel|[= ibe-gē-l] *'хайр энэрэл'* || Энэ үг нь авианы түүхэн хувьсалынхаа явцад *ibegel > ihe'ēl > ihēl > i'ēl > e'ēl > ēl* гэсэн үе шатыг дамжсаар өнөөгийн *'ээл'* гэдэг үг болсон боловч монгол бичигийн хэлэнд хэвшин тогтсон *iwēl* [< ibegel] гэдэг нь давхар хэрэглэгдсээр иржээ. || Ж= *'itegel **ibegel** ügegün edeger amitan-i aburaqu-yin tulada'* [итгэл ивээлгүй эдгээр амьтаныг аварахын тул](Burq. 20b) // *'hači qari'ūlqu-yi teŋgeri ǧajar-un **ihe'ēl** medetügei'* [ач хариулахыг тэнгэр газар мэдтүгэй](MNT 163-15) Мөн дундад үеийн монгол хэлэнд *ibegen* [ibege-n] 'ивээн' гэсэн хувилбартай байсан нь зарим дурасхалд тэмдэглэгдэн үлджээ. // *yeke suu ǰali-yin **ibegen-dür'*** [их суу залийн ивээл дор](Khub.II:2) // *'tenggiri-yin ǰorig-i daqaǰu olon-dur **ihe'en** bolu'ad'* [тэнгэрийн зоригийг дагаж олонд ивээл болоод](KMQB A22) // *'эээндээ **ээлтэй** отог олондоо өлзийтэй сайхан сав хийж сурагтун'* (Б. Ринчен Заан залуудай) || х о р ш : *'ач ивээл'*, *'хайр ивээл'* || Kha, Oir. *iwēl*, Ord. *iwegēl*, Oir. *iwāl*

Игдури- |iγduri-| х у у ч : *'дээшлүүл-'*, *'дэвш-'* || Ж= *degegši **iγduriγulǰu** bingǰang bolγan tüsigdeged'* [дээш дэвшүүлж бинжан 'цол' болгон түшигдээд] (Hin. 40)

Игтүни- |igtüne| х у у ч : *'хичээ-'*, *'чармай-'* || Ж= *'To'oril-qan öterlen **igtünejü'*** [Тоорил хан яаравчилан хөдөлж](MNT 133)

Ид |ide| *'дээд хүч чадал'*, *'арга ухаан'* || Cf. Turk. *idā* 'искусство', 'ловкость' (Räsänen 169) || Ж= *'Ард олны дунд Заяын гэгээний ер бусын **ид** шидийн тухай цуу яриа тарааж'* (Ч. Лодойдамба, Тунгалаг тамир) // *'Их Зөвлөлт улс **ид** хүчээ гаргаж'* (Ц. Дамдинсүрэн, Маршал Чойбалсангийн 50 насны ойд зориулсан ерөөл) || х о р ш : *'ид шид'*, *'ид хав'* || Kha, Oir. *id-*, Ord. *ide-*, Bur. *edi-*

Идүр- |idüre| х у у ч : *'ойрох-'*, *'дөхөх'* || Ж= *'qahān-dur-iyān neyilen **idüre-jü** irebei ba'* [бид хаандаа ойртон нийлж ирвээ](MNT 146)

Идээ |idege|[= ide-ge] *'хоол'*, *'идэш'* || Ж= *'bi ber yeke **idegen-i** ülü iden edürtür arča-yin nigeken ür-e ba nigen tuturγan terigüten-i idesügei'* [би их хоол үл идэн, өдөрт арцын ганцхан үрэл болон нэг ширхэг цагаан будааг идэе] (Burq. 38a) // *'aqa-nar de'ū-ner tabu'ūla adūsun **ide'ē**-bēn qubiāldurun'* [ах дүү тавуулаа адуусан идээгээ хуваацгаан](MNT 23) // *idēn* 'nourriture (Ist.36) // *ese šingebe **idēn** tūndü* [пища у него не переварились](Mu. 166) // *sain **ide'ēn*** 'хорошая пища' (Mu. 316) // Орчин үеийн монгол хэлэнд энэ үгийн утга нь явцуурч

зөвхөн хүндэдхэлийн хоолыг нэрлэх болжээ. || х о р ш : *'идээ ундаа', 'идээ цагаа', 'идээ шүүс'* || Kha. *idē*, Ord. *idegēn*, Bur. *edyē*, Oir. *idān*

Идээл- |idegele|[= ide-ge-le] х у у ч : *'хооллох'* || Ж= *'qurim qurimlaγčid-ta uriγdaǰu uridu yosuγar* ***idegeleǰü'*** [хурим хуримлагчидад уригдан урид ёсоор хооллож](Burq. 34b)

Иж I |iǰi|{< Chin. *i-chih*} *'зарлиг'* (хатан хааны зарлиг) || Ж= *'senšhiŋud-de bariǰu yabu'ai* ***'iǰi*** *ögbi'* [бомбын шашины санваартануудад барьж байгаа хатан хааны зарлиг](Ph: Dharmabala 1321:13)

Иж II |iǰi|{< ****idi***} *'бүрэн бүтэн'* гэсэн утга илэрхийлсэн язгуур || Ж= *'иэгэн бүрэн бүтэн* ***иж*** *болгож өргөө гэрээ чимсэн'* (Б. Ринчен, Нууцыг задаруулсан захидал) Энэ үгээс *iǰil* [iǰi-l] 'ижил' гэдэг үг үүсчээ. || х о р ш : *'иж бүрэн'*

Ижил |iǰil|[= iǰi-l]{< ****idi-l***} *'адил', 'бүрэн'* || Ж= ***'iǰil*** *kikči eme* [дружащая женщина](Mu. 195) || *iǰilde-* [iǰil-de] 'ижилд-', *iǰilse-* [iǰil-se] 'ижилс-', *iǰilsi-* [iǰil-si] 'ижилш-' гэх зэрэг үгс үүсчээ. || х о р ш : *'ижил дасал', 'хань ижил'* || Kha, Ord. *idžil*, Bur. *ežil*, Oir. *idžil*

Ижилд- |iǰilde / iǰilid|[= iǰi-l-de] *'ижилших', 'дасах'* || Ж= *'bilǰigür-i kedüi be teǰigebesü nuta* ***iǰilidqui*** *qamiy-a bui'* [билзуухайг хэдий тэжээвч яг ижилших нь хаа буй](Burq. 10a) *// 'aqa de'ū-dür sayi* ***iǰilidülčen*** *bükü-dür aqa bütügei qorumud bayi'* [ах дүүд сая ижилдэн бүхийд ах хоромхон тэвчих болтугай] (MNT131) || х о р ш : *'ижилдэн дасах'*

Ийл- |heyile| х у у ч : *'зугатаа-', 'зайл-'* || Ж= *'e'ūden-neče činü* ***heyīlü'ēsü*** *eliged anu edkeǰü gēdkün* [үүднээс чинь зайлваас элэгийг нь эсгэж](MNT 137) *// Alağ, Naya'ātan Širgü'ētü-ebügen-ü kö'ūd inü* ***heyīlügsed*** *irebei* [Алаг, Наяатан ширээт өвгөний хүвгүүд дутаан одогсод](MNT 149)

Ил I |ile| *'илэрхий', 'далд бус'* || Cf. Uig. *il* 'Osten, Worderseite' (Gabain 310) || Ж= *'buqa'ū-bān usun huru'ū urusqan ni'ūr* ***ile*** *kebtebe'* [дөнгөв усруу урасхан нүүрээ ил гарган хэвтэв](MNT 81) *// 'ile bolba tūnlē üile'* [работа стала ему ясной](Mu.195) *// ilä* 'clear' (Zir. 107) || Энэхүү язгуур дээр *-čile, -/d/ke, -/r/kei, -re, -de/te* зэрэг дагавар залгаж, *ilečile-* [ile-čile] 'илчил-', *iler-* [ile-r] 'илэр-', *ilerkei* [ile-r-kei] 'илэрхий', *iledte* [ile-(d)te] 'илтэд' гэх мэт үгс үүссэн байна || х о р ш : *'ил тод'* || Kha, Oir. *il*^{a}, Ord. *ile*, Bur. *eli*

Ил II |ili| *'бугын тугал'* || Cf. AT *ili* 'new-born deer' (Starostin, 501) || Kha. *il*, Ord. *ile*, Bur. *eli* Oir. *ilə*

Ил III |il / el|{< Pers. *īl*} *'улас', 'нүүдэлчин аймаг'* || Ж= *'yeke Mongγol ulus-un dalai-in qan-u ǰrlγ* ***il*** *bulqa irgen-dür kürbesü büsiretügei'* [Их Монгол уласын далайн хааны зарлиг өөрийн болон харийн иргэнд хүрвээс биширтүгэй](Их Монгол уласын хааны тамга) Алтайн хэлний хүрэээнд авч үзвэл *il ~ äl* гэсэн үг ихэнхи түрэг хэлэнд *'улас', 'ард түмэн', 'аймагуудын холбоо'* гэсэн утгатай байжээ. Монгол хаад XIII зууны дундуур Перст байгуулсан уласаа *'ил-хаант улас'* хэмээн нэрлэсэн нь одоогийнхоор бол *'Холбооны хаант улас'* гэсэн маягийн утгыг илэрхийлж байсан бололтой. Зарим эрдэмтэн түүнийг *gür qayan* гэсэнтэй адил утгатай гэж үзсэн буй. (Д. Банзаров, *Собрание сочинений*, М., 1955, Примечания № 299, 300 стр. 312-314)

Ил- I |il|{< **bili} *гараараа тааган илбэх.* || *ilbi* 'гладить' (Цинциус I:306) Энэхүү *изгууралс ilbi-* [il-bi] 'илбэ-', *iligeči* [ili-geči] 'илээч', *iligesü* [ili-gesü] 'илээс' гэх мэт үгс үүсчээ || Ж= *'barayun yar-iyar öber-ün üsün-i* ***bilibesü*** [баруун гараараа өөрийн үсийг илвээс](Burq. 58b) // *'ke'ēli minü* ***bilijū*** [хэвэлийг минь илж](MNT 21) || х о р ш : *'илж тааглах'* || Kha. *ilə-*, Ord. *ilbe-*, Bur. *elbe-*, Oir. *il-*

Ил-* II |ile| *'илгээх', 'явуулах'* || Ж= *'ildeb önggete gürüs ögčü ilebesü ker be soyurqaquyi tngri-yin kūčün qayan-u suu medetügei kemēn Muskaril qorči-yi* ***ilebei*** [элдэв өнгийн үнэт чулуу өгч илгээвээс хэрхэн соёрхохыг тэнгэрийн хүч, хааны суу мэдтүгэй хэмээн Мусхарил хорчийг илгээв.](Ar. 1289) // *'Amarmay tngri-yi ūjere* ***ilebei'*** [амармаг тэнгэрийг үзүүлэхээр илгээв](Chimeg 22a)

Илаар |ilaγar| *'эдгэрэл'* (хүнд өвчин туссаны хойно эрүүлжин эдгэрэх // 'cured from illness' (Lessing, *Mongolian-English Dictionary*, 402) || Ж= *'ebečin-niyen subilaju* ***ila'ār*** *boltala'* [овчиневн сувилж эдгэрэх болтол](KMQB B9) // *'bi* ***ila'ār*** *buyu'* [би зүгээр байна](MNT 131) // *'* ***ileri*** *bolba ebečinēse'* [его болезнь стала лучше](Mu. 196)

Илбэ |yelwi|{< Uig. *jilwi* < Skr. *yelwī*} *'ховс'* || Cf. Turk. *jelwi* 'волшебство', 'колдовство' (ДТС 255), AT. *yélwi* 'sorcery, witchcraft' (Clauson 919) || Ж= *'yirtinčū-yin ene jiryalang būgūde* ***yelvi****-dür adali'* [ертөнцийн энэ жаргалан бүгэд илбэ мэт](Burq. 33a) Kha. *ilbe*, Ord, Bur. elbe, Oir. *ilwi*

Илгээ- |ilege|{< *ile + ge*} *'явуул-', 'хүргэ-'* || Ж= *'ögülejü* ***ilegegsen*** *üge-yi tegūs ögülejü ögčü očūgūken yaširyun-i suyurayulbai'* [хэлж дамжуулсан үгийг нь бүрэн хэлж өгөөд, зарим гашуун үгийг нь орхив](Burq. 28b) // *'Dobun-mergen de'ü-yū'ēn ūjere* ***ilēbe****'* (MNT 6) // ***ilebe*** *emeyi eredür inu'* [послал женщину к мужу](Mu. 195) || Kha. *ilgē-*, Bur. *elgē-*, Oir. *ilgā-*

Илд |ildü / ūldū| *'сэлэм'* // Pl. *ildüs* || Ж= *'ülemji bayātur kūčüten üješi ügei doyšin čiraitan* ***üldü*** *jida eldeb meses bariysan'* [үлэмж баатар хүчтэн үзэшгүй догшин царайтан илд жад элдэв мэс барьсан](Burq. 55) // *hildü* 'меч' (Mu. 184) || х о р ш : *'илд сэлэм'* || Kha. *ildə*, Ord, Bur. *yülde*, Oir. *jildə*

Илдар |ildar| *'таширан', 'байдал төлөв', 'ялдам'* || Ж= *'busud-un* ***ildar****-i ūlū qaraqu bōgesū'* [бусадын байдалыг үл харах бөгөөс](Burq. 1b) // *'narmai yeke ulus-iyan engkejigūlūn jiryayuluysan terekū* ***ildar-a*** *yerüngkei qan qaračus-un jiryalang anu tengri-ner-ūn erketū qormusta-yin jiryalang-luy-a adali boljuqui'* [нармай их уласаа энхжүүлэн жаргуулсан тэрхүү ялдамд хаан харцасын жаргалан нь тэнгэр нэрийн эрхэт хурмастын жаргалан лугаа адил болно](ET 39a)

Илжиг |elǯigen| *адууны омогийн нэг төрөл* || Cf. Turk. *elžegen* 'осел' (Щербак 2005, 34); Man. *elžig* 'осел' (Цинциус II:447) || Ж= *'bars-un arasun nemleg-sen* ***eljigen*** *tariyan idegsen-ü qoyin-a alaydaǰuyui* [барын арис нөмөрсөн илжиг тариа будаа идсэнийхээ дараа алагджээ](Sub. V:2b) // *eljigen* 'âne' (HY M53) // *oqoba ere eljigen eme* ***eljigeni*** [осел покрыл ослицу](Mu. 267) // *eljige* 'осел' (IM 437) // *elčigā* 'осел' (IM M126) // *keherīn* ***eljigen*** 'wilder Esel' (LH 68) // *eljigēn* 'donkey' (Ras. 12) // *elšigen* 'осел' (Qaz. Po197) // *eljigen* 'ass' (Zir.101)

|| Kha. *ildzig*, Ord. *eldžige*, Bur. *elžege*, Oir. *eldžəŋne*

Илжир- |il|jire / il]ara | *'ялзар-'* || Cf. Turk. *ilčire-* 'гноиться' (Räsänen 171) || Kha. *ildžir-*, *yaldzar-*, Ord. *ildžire-*, Bur. *ilzar-*, Oir. *ildžĭr-*

Илэвт |ilübte| х у у ч : *'аятай'* || Ж= *'olon ulus-a amuğulaŋ elčin-e ber yabuqui-a* ***ilübte*** *büi'* [олон уласад амагалан байж, элчин явахад аятай буй] (MNT 280)

Илэдхэ- |iledke|[= ile-(d)ke] *'илэрхийл-'* Энэ үгээс *iledkel* [ile-(d)ke-l] 'илдхэл' гэсэн үг үүсчээ. || Ж= *'mayun-u sedkil qamiy-a* ***ilidkeldükün'*** [муугийн сэдхэл хаа илэрэх](Sub. V:10a) || Kha. *ildxe-*, Ord. *iledkχe-*, Bur. *elidχe-* Oir. *ildχə-*

Илэр- |ilere|[= ile-re] *'ил гарах'*, *'илэрхий болох'* || Ж= *'ер эднийг ажих тусам ер бусын байдал* ***илэрч'*** (Д. Намдаг, Цаг төрийн үймээн) || х о р ш : *'илэрэн гарах'* || Kha. *iler-*, Ord. *ilere-*, Oir. *ilər-*, Bur. *elir-*

Илэрхий |ilerkei|[= ile-r-kei] *'ил байгаа'* || Ж= *'talaγar yabuγuluγsan* ***ilerkei*** *temdeg'* [талагар явуулсан илэрхий тэмдэг](EE 208a) || Kha. *ilerxī*, Ord. *ilerʲχī*, Oir. *ilərkə*, Bur. *elirχei*

Им |im| *'тэмдэг'* (чихний хайчилбар тэмдэг) || Cf. AT *im* 'знак' (ДТС 205), *im* 'sign' (Clauson 155) || х о р ш : *'им тамга'* || Kha, Ord, Oir. *im*

Има* |ima|{< *in} *'тэр'*, *'түүн'* || ганц тоот 3-р биеийн төлөөний нэрийн шууд бус тийн ялгалаар ялгалагдах үндэс. *imada* [ima-da](Loc.), *imadur* [ima-dur](Dat.), *imača* [ima-ča](Abl.), *imayi* [ima-yi](Acc.), *imabar* [ima-bar](Instr.), *imaluγa* [ima-luγa](Com.) || Ж= *'****imada*** *bariju ayai altan gerege al tamγatai'* [түүнд бариж байгаа алтан гэрэгэ улаан тамгатай](Teh. b7) // *'****imadur*** *ögügsen ... šiltege-yi mön yosuγar ayultuγai'* [түүнд өгсөн шилтгээнийг мөн ёсоор хадгалтугай](Bus. H8) // *'tendekin irgen* ***imayi*** *maši kündülen'* [тэндэхийн хүмүүс түүнийг маш хүндэлэн](Chang.12) // *'****imadača*** *jirγuγan köbegüd törüg-sen ajuγu'* [түүнээс зургаан хүвүүд төрсөн ажээ](Hin.36) // *'ali ber üyiles-i* ***imaluγ-a*** *eyetüldün ajuγu'* [аливаа үйлийг түүнтэй эвлэлдэн хийх ажээ](Chang. 14)

Имада |imada|[= ima-da] *'түүнд'* (эртний монгол хэлний гуравдугаар биеийн төлөөний үгийн орших тийн ялгалын хэлбэр) || Ж= *'****imada*** *bariju ayai altan gerege al tamγatai* [түүнд өргөн барьж байгаа гэрэгэ алтан тамгатай] (Teh. I:b) // *'****imada*** *qariyatan emčü irge ber tumda'ā ülde'ējü'* [түүнд харьяатан өмч иргэдийг бүрэн үлдээж](MNT 186)

Имай |imayi|[= ima-yi] *'түүнийг'* (эртний монгол хэлний гуравдугаар биеийн төлөөний үгийн заах тийн ялгалын хэлбэр) || Ж= *'tendekin irgen* ***imayi*** *maši kündülen'* [тэндэх хүмүүс түүнийг маш хүндэлэн](Chang. 12) // *'****imayi*** *tergen-eče čirčü bawūlju'* [түүнийг тэрэгнээс чирч буулгаж](MNT 101:1)

Имиж |imiži|{< Eng. *image*} *'ийм иж'*, *'дүр төрх'* (Тухайн хүний бусадаас ялгагдах өвөрмөц дүр төрхийг илэрхийлэхэд энэ үгийг хэрэглэдэг)

Имлэ- |imle-|[= im-le] *'имэр-'* || Ж= *'urul-iyān ködelgen* ***imleyü'*** [уруулаа хөдөлгөн имэрюү](Sub III:12) // *'quruγu-bar urul-iyan* ***imlekü'*** [хуруугаар уруулаа имэрэхүй](Burq. 61) || Kha. *imer-*, Ord. *imere-*, Oir. *imʲr-*

Импичмент |impičement|{< Eng. *impeachment*} *'импийчмент'*, *'итгэл хүлээлгээх'* (төр, засагийн удирдлага, улас төрийн хүрээнийхэний үйл

ажиллагааг үнэлэн олонхийн саналаар шийдэх хэлбэр)

Импорт |import|{< Rus. *импорт* < Eng. *import*} *'импорт'* (гадаадаас эд бараа оруулах)

И-мэйл |imeyl|{< Eng. *e-mail* (electronic mail)} *'и-мэйл', 'цахим шуудан'*

Ин* |in|{< *hin < **φin*} *'мэр хүн'* (гуравдугаар биеийн ганц тоот төлөөний үгийн язгуур. Энэхүү төлөөний нэрийн хувилах үндэс нь *in-* 'ин', *ima-* 'има' болно. || Ж= ***'in-u** beye deki qoruqai-ača anggida busud amitan qamiy-a idekün'* [түүний бие дэх хорхойгоос бусад амьтан хаанаас идэх] (Sub.VII) // ***'in-u** metüs či'ün-dür ülibei'* [түүний мэт хүмүүс цүүнд орохоор үлдэнэ](MNT 156)

Ина* |ina| *'наашаа'* гэсэн үгийн анхдагч язгуур. Энэ язгуураас *inay* [= ina-γ] 'янаг', *inaysi* [= ina-(γ)si] 'наашаа' гэх мэт үгс үүсчээ. || Ж= *'terigüleši-ügei čay-ača **inayši-da** delekei ulus samayuraysan-u qoyin-a Činggis qan törüjü'* [толгойлогчгүй болсон цагаас нааш дэлхий улас самуурсаны хойно Чингис хаан төрж] (Qqor. I:33) // *inayši ire* [иди сюда](Mu.196)

Инаг |inaγ|[= ina-γ] *'янаг', 'ойр', 'дотоно'* (*ina* 'наашаа' гэсэн язгуураас үүссэн үг. Анхандаа *'ойр', 'дотоно'* гэсэн утга илэрхийлж байгаад хожим *'сэдхэлийн амараг'* гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ || Cf. Turk. *inak* 'друг, приятель' (Радлов, I:1439), *inaq* 'cordial', 'friendly', 'harmonious' (Schwarz 770) || Ж= *'kitad irgen-ü Altan qan-nu itegelten **ina'ūd** Moŋğol-un ebüges ečiges-i baragsan Qara-Kitad jüyin irgen aju'üi je'* [хитад иргэний Алтан хааны итгэлтэн дотоно нөхөдүүд Монголын өвөгөс эцэгсийг барсан Хар Хитадын жүйн иргэн ажээ](MNT 266) // ***inaq** bolba noyandu* [он был заместителем бека](Mu. 196) || х о р ш : *'янаг амараг'* || Kha. *yanag*, Ord. *inak*, Bur. *inag*, Oir. *inīg*

Инагш |inayši|{= ina-γši} *'нааш'* (эртний бичигийн дурасхалуудад их төлөв цаг хугацааны утгыг илэрхийлж байна) || Ж= *'terigüleši-ügei čay-ača **inayši-da** delekei ulus samayuraysan-u qoyin-a Činggis qan törüjü'* [толгойлогчгүй болсон цагаас нааш дэлхий улас самуурсаны хойно Чингис хаан төрж](Qqor. I:33) // *'Bayasqulang oron-i oluy-a **inayši'*** [Баясхалант ороныг олохоос нааш](BT 162b) // *'Činggis qayan-u uruγ-ud dōčin tabun od-ača **inayši'*** [Чингис хааны урагууд дөчин таван жилээс нааш](Ölj. 25) // *hasa ülčan temečeldü'ē inaqši-da* [асуулцан маргалдахаас нааш](Ph.Bud. IIb) // *inayši ire* [иди сюда](Mu.196)

Ингэ |ingge| *нас гүйцсэн эм тэмээ* || Cf. Turk. *ingän* 'kamel / верблюдица' (Räsänen 172) || Ж= *botayalaba **ingen*** [верблюдица принесла верблюжонка] (Mu. 122) || Kha. *iŋge*, Ord. *enge*, Bur. *engi*, Oir. *iŋgə*

Индра |indar-a|{< Skr. *indra*} *'индараа', 'зуун өглөгт', 'хурмаст'* (тэнгэр нарыг захиран ертөнц дэлхийг хамгаалагч хурмаст тэнгэр)

Индранил |indranil-a|{< Uig. *indiranil* < Skr. *indranīla*} *'индарааний'*, (тунгалаг цэнхэр гэрэл цацаруулсан энэхүү эрдэнийн чулуу нь долоон зүйл үнэт чулууны нэгэнд багтдаг)

Индүү |ingdeü|{< Chin. *yùn dǒu*} *'илүүр'* (бөс барааны чийгийг эгшээж, атираа нугалааг тэнийлгэдэг халуун илүүр)

Индэр |yender|{< Chin. *yan tai er*} *'жүжигийн тавцан'* (илдхэл, лекц хийхэд зориулсан тавзантай ширээ) || Kha. *inder*, Ord, Bur. *yender*

Инж |inJi|{< Chin. *ying jié*} *'хуримын бэлэг'* // Pl. *inJes* (хурим хийхэд охины талаас уридчилан хүргэх бэлэг) || Ж= *'taiyiu-da **inJe** bolyan ögčlgi'* [хатан эзжид инж болгон өгчээ](Chang 34) // *'Sengge aq-a-da **inJes** bolu[n] ögteJü'* [Сэнгээ ахад инж болон очиж](Jig.3) // *'Qabiči-ba'ātur-un eke-yin **inJe** ireg[se] n-i Bodončar tataju büle'ē'* [Хабичи баатарын эхийн инж ирсэнийг Бодончар авч билээ](MNT 43) || Kha. *inʤə*, Ord. *indzi*, Bur. *enze*, Oir. *indz*ⁱ

Инженер |inJener|{< Russ. *инженер* < Eng. *engineer*} *'инжинээр'* (машин, техникийн өндөр мэргэжилтэн)

Инжаан |inJiyang|{< Chin. *yin jiang*} *'инжаан', 'мөнгөний дархан'* (Монгол хэлэнд алт, мөнгөний дарханыг нэрлэнэ)

Инжир |inJir|{< Turk. *inǰir* < Pers *anǰīr*} *'инжир', 'удамбар'* (халуун оронд ургадаг нэгэн төрөл жимэсний мод) || Cf. Turk. *inzīr* 'винная ягода', 'смоковница' (Радлов, I:1454) || Ж= *inJir* 'fig' (Ras. 202 B11) || Kha. *indžir*, Oir. *indžᵘr*

Иновац |innovaci|{< Eng. *innovation*} *'иноваац'* (шинэ санаа сэдэж, шинэ арга технологи хэрэглэсэнээр өндөр үр ашиттай шинэ бүтээл, эд баялагийг бий болгох үйл ажиллагаа)

Институт |institute|{< Rus. *институт* < Lat. *institutum*} *'институүт'* (тодорхой мэргэжилээр дээд боловсорол олгодог дээд сургууль болон эрдэм шинжилгээний хүрээлэнг ийн нэрлэж байв)

Институци |instituci|{< Rus. *институция* < Lat. *institution*} *'институүц' 'эрх бүхий байгууллага'*

Интернет |intrnet|{< Eng. *internet* (inter + net)} *'интернээт'* (мэдээлэлийн цахим сүлжээ)

Интерпол |interpol|{< Rus. < Fr. *Interpol* (Organisation Internationale de Police Criminelle)} *'интерпоол'* (гэмт хэрэгтэй тэмцэх олон уласын цагдаагийн байгууллага)

Интерьер |interiyer|{< Rus. *интерьер* < Fr. *interieur*} *'интереэр', 'дотоод засал'* (аливаа барилга байгууламжийн дотор талын архитектурын шийдэл)

Интоор |ingtoor|{< Chin. *yīng tao er*} *'интоор'* (сарнайн овогийн бутлаг жимэсний мод) || Ж= Kha. *iŋtōr*,

Инфляци |infliaci|{< Rus. *инфляция* < Eng. *inflation*} *'инфлиаац'* (үнэ ханшийн бууралт)

Инэрү |inaru| х у у ч : *'тавиг тайлга'* || Ж= *'Ōrbei, Soqatai jirin yekes-e ǧaǰaru **inerü** ǧarugsan-dur'* [Өрбэй Сохадай хоёр ихэсийн газар тавиг тайлга гарсанд](MNT 70)

Т у с х а й с у д а л г а а : I de. Rachewiltz, The Expression *Qajaru Inerü* in Paragraph 70 of the *Secret History of the Mongols*, OUMEIX V:2, 1992, Ulaanbaatar, 337-343 // Д. Цэрэнсодном, *'Монголын нууц товчоон'* дахь *'yekes-ün γaǰaru inerü'* хэмээх хэллэгийн тухай, *'Антоон Мостаэрт ба Монгол судлал'*, Уб., 2011, 318-320

Иога yoga||{< Skr. *yoga*} *'ёог'* (бие эрхтэнээ эрүүлжүүлэх дандарын ёсны бисалгалтай хөдөлгөөнт дасхал)

Ипотек |ipotek|{< Gr. *υποθήκη*} *'ипоотек'* (газар, барилга байгууламж зэрэг үл хөдлөх хөрөнгөө барьцаа болгож зээл авах)

Ирваа |irbaγ-a|{< Chin. *ér bái wǔ*} *'ирваа', 'тэнэг', 'бүтэлгүй'* (мэдэж, чадах юм бага, бүтэл муутай хүн)

Ирвэс |irbis|{< Uig. *irbiz*} || Cf. Turk. *irbiz* 'леопард' (ДТС 211), *irbis* 'leopard', 'tiger' (Räsänen 173) || Kha. *irwis*, Ord. *erwis*, Oir. *irwᵊs*

Иргуйл- |irγuila| х у у ч : *'хазайх', 'гажуудах'* || Ж= *'ulus-un üyile es-e ber irγuilabasu ǒbesūben tǒbšigeridüyü'* [төрийн үйл эс гажуудвал өөрийн хэрэг ч түвширнэ](Taq 18b6)

Иргэн |irgen| *'ард', 'хүмүүс', 'харц', 'харъяат'* // Pl. irged || Cf. Man. *irgen* 'people', 'the common people' (Norman, 150); Эртний монгол хэлэнд *'албат ард'* гэсэн утгатай хэрэглэгдэж байжээ. Ж= *'olan qari-yin **irgen** imayi ečige metü kündülen ajuγu'* [олон харийн түүнийг эцэг мэт хүндлэх ажээ](Jig.3) // *'Tüŋgelig ǧoroqan huru ü nigen bölög **irgen** newīljü'* [Түнхэлиг горхи руу нэг хэсэг хүмүүс нүүж](MNT 5-3) // *'qaraču **irgen** ejen ügei yakin yabumui'* [харц иргэн эзэнгүй яаж явах](ET 63b) // *'qahan tüšimel qaračus **irgen**'* [хаан түшмэл харц иргэн] (KMQB A9) // *bölük irgen* 'толпа людей' (Mu.123) // irgen 'Leute' (LH 1256) || х о р ш : *'ард иргэн'* || Kha. *irgen*, Ord. *ērgen*, Bur. *ergen*, Oir. *irgᵊn*

Т у с х а й с у д а л г а а : С. Калужински, О значении слов *irgen* и *obog* в *'Сокровенном сказании'*, ОУМЭИХ III, т. II, 1977, 79-85 // Т. Д. Скрынникова, *'Oboq'* и *'irgen'* в контексте *'Сокровенного сказания'*, *Mongolica* 1 (22), 1990, 92-102 // P. Rykin, The Social Group and its Designation in Middle Mongolian: The Concepts *irgen* and *obog*, *Forum for Anthropology and Culture*, 1, 2004, 183-210

Иргэн оргон |irgen oγan| х у у ч : *'албат харъяат'* || Ж= *'olan **irgen oryon** bügüde-yin aburaγči itegel ibegel ügei bolun odumui'* [олон ард иргэдийн аварах итгэл ивээлгүй болон одмуй](Taq. 20b) // *'Seŋgüm-ün eme kö'ǖ, **irge orga** selte dawūlīju abču'* [Сэнгүмийн охид хөвүүд, албат харъяат нарыг олзлон авч](MNT 162) // *'qotala **irgen oryan** yayiqaldun'* [олон харъяат албадууд гайхалдан](ET 81b) || Проф. I. de Rachewiltz энэ үгийг *'people'* хэмээн орчуулжээ (*The Secret History of the Mongols*, I. 2004, 81)

Иридвараис |iredwarans|{< Fr. *Roi de France*} *'Францын хаан'* || Энэ үг илхаан Өлзийтөөс Францын ван Гоо Филипп-д илгээсэн захидалд ганцхан удаа тохиолддог. || Ж= *'**Iridivarans** sultan-a erteneče ta bürin Virangud irgen-ü sultad manu sayin elinčeg sayin ebüge sayin ečige sayin aqa-dur amiralduju qola ber bǒgesū oyir-a metü sedkijü'* [Францын хаанд, эртнээс нааш франк иргэний хаад та бүхэн бидний сайн элэнц, сайн өвөг, сайн эцэг, сайн ах нартай найрамдаж, хол боловч ойр мэт сэдхэж](Öljˇ)

Ирич- |iriče| х у у ч : *'ангижирах', 'салга-'* || Ж= *'**hiričekü** yü üyile-deče hiričebei bi'* [ницах үйлээс ницав би](MNT 178) // *'eme kö'ǖd-eče manu **hiri-če'ūljü**'* [эм хөвүүдээс минь салгаж](MNT 123

Ис |isu| *нааддаж нигтарсан хөө тортог* || Cf. Turk. *ys* 'запах,' 'угар' (Räsänen 167), AT. *iš* 'soot, dirty smoke' (Clauson 254), Uig. *is* 'smoke, gas' (Schwarz, 749) || Kha. *is*, Bur. *ehe*, Oir. *iš*

Ис- |is| *гашилж исгэлэн амттай болох.* Энэхүү язгууртаас *isüg* [is-g] 'исэг', *isül* [is-l] 'исэл', *isüldü-* [is-ldü] 'исэлд-', *isge-* [is-ge] 'исхэ-', *isleg* [is-leg] 'ислэг', *iskületg* [is-küleng] 'исхэлэн', *isümeg* [is-meg] 'исмэг' гэх мэт олон үг

салбарлан гарчээ. || Kha, Ord. *es-*, Bur. *ehē-*, Oir. *is-*

Исгэр- |isger| *явцуу нарийн зайгаар хийн урасхал түрэн гарахад үүсэх дуу авиа* || Cf. AT. *üškür* 'to whistle' (Clauson 260) || Kha. *isxer-*, Ord. *isᵏxir- / esᵏxir-*, Bur. *ešxer*, Oir. *iskər-*

Ислам |islam|{< Rus. *ислам* < Arab. *islām* < *samala*} *'ислаам', 'лалын шашин'*

Исхэлэн |isküleng|[= **is**-küleng] *исээж хатуурсан* (айраг тараг г. м.) || Kha. *isxeleŋ*, Ord. *esᵏχüleŋ*, Oir. *iskᵏləŋ*

Исү |isü| х у у ч : *'сэгсийлгэх'* || Ж= *'emüsügsen čimeg-üd-iyen tayilju üsün-iyen jisün-iyen **isüjü** unan bosun üküdküjü'* [зүүсэн чимэгээ тайлж, үс зүсээ сэгсийлгэж унан босон муужирч](Burq. 29) // *'üsün-iyen jisün-iyen **isüjü** örü jirüken ebedkü metü ugilaju'* [үс зүсээ сэгсийлгэж, өр зүрэх өвөдөх мэт уйлж](Burq. 37b)

Исэр || iseri|{< Chin. *yǐ zi*} х у у ч : *'суудал', 'сандал'* (түшилэгтэй намхан суудал) || Ж= *'Sorqan-šira-yin ger-tür, tergen-dür, **iseri-yin** doro kürtele neŋǰiǰü'* [Сорхан шарын гэрт, тэргэнд, суудалын дор хүртэл нэгжиж](MNT 86) // *'quda bolilčabasu mör yarbasu jögebesü **iseri** orašiyulbasu'* [худ бололцвол, мөр гаргавал, суудалд суувал](Turf. 37:14) // *'sečen sutai tayiqu **iserin** dotur-a eyin ögüler-ün'* [цэцэн сутай эх хатан суудал дээрээсээ ийн үгүүлэрүүн](ET 37b) // *iseri* 'lit, banc' (HY M64)

Итгэ- |itege| *'найдах', 'үнэмших'* || Ж= *'tegün-e ken **itegeǰü** takil-i üyiled-besü tegün-dür mayui törül-ün ayul ülü boluyu'* [түүнд хэн итгэж тахил өргөвөөс түүнд муу төрөлийн аюул үл болно](Burq. 47a) || Kha. *idxe-*, Ord. *etege*, Bur. *etige-*, Oir. *itkə-*

Итгэл |itegel| *'найдвар'* || Ж= *'γurban yirtinčü-yin **itegel** olan jayun buyan-iyar bütügsen'* [гурван ертөнцийн итгэл олон зуун буянаар бүтсэн](Burq. 25a) // *'**itegel** ügei'ü nököd'* [итгэл үгүй нөхөд](MNT 201) // *'**itegel** ügei setkibe tüni* [думал о нем с недоверием](Mu. 198) || х о р ш : *'итгэл найдвар', 'итгэл үнэмшил'* || х э л ц : *'итгэл алдах'* (итгэлийг хөсөрдүүлэх), *'итгэл даах'* (итгэхэд найдвартай), *'итгэл олох'* (итгэл хүлээх), *'итгэл эвдэх'* (итгэл алдах) || Kha. *idxel*, Ord. *etegel*, Bur. *etigel*, Oir. *itkəl*

Их хөлгөн |yeke kölgen| *Бодисадвагийн хөлгөн судар* (Төвөд, Монголд дэлгэрсэн бүддийн номлолын хөлгөн). Skr. *Mahayana.* || Ж= *'**yeke kölgen** nom-un gün ayui üjel yabudal-i uqayulqui Čary-a Avatar-a neretü sastir'* [их хөлгөн номын гүн агуу үзэл явдалыг ухуулах Чарияа аватара нэрт шастир](BT 166a)

Ихэр |iker|{< ike-r} *'хос', 'өөр хоорондоо адил'* (*'ихэр'* гэсэн үг нь нэгэнт *'хоёр'* гэсэн утга илтгэж байгаа учир *'хоёр ихэр'* гэвэл *'дөрөв'*, *'гурван ихэр'* гэвэл *'зургаа'* гэсэн утга заана.) || Cf. Turk. *iki* 'два' (Радлов, I:1417), *iki* 'zwei' (Gabain 310), *iki* 'два', 'оба' (ДТС 206), AT. *ekki* 'pair, twin' (Clauson 119), *eχir* 'двойня', 'близнецы' (Щербак 2005, 36); Man. *ikirē* 'двойня' (Цинциус I:300) || Ж= *ikir* 'двойни' (Mu. 195) // *'Буудалын гуанзны тогооч **ихэр** хүүхэд төрүүлээд чөлөөтэй байгаа гэнэ'* (Ц. Дамдинсүрэн, Хоцорогдсон эмгэнийг сурвалжилсан тэмдэглэл) || Kha. *iχer*, Ord. *eᵏxer*, Oir. *ikʲr*

ičege [ICC-gc] .

үгс үүсчээ. || Ж= *'merged es-e* ... .

IX:11b) // ***hičibe*** *ünēse* [стыдился его](Mu. 164) .

M153) *hičibe* 'schämte sich' (LH 74) || х о р ш : *'ичиж зовох'*, *'аижс ичих'* || Kha. *itši-*, Ord. *etše-*, Bur. *eše-*, Oir. *itš-*

Ичгүүр |ičigüri|[= iči-güri] *ичмээр байдал* || Ж= ***'ičegüri*** *ügegün eljigen-ü miq-a qudaldumui'* [илжигний мах ичгүүргүй худалдах](Sub. V:IIIb) // *'qari irgen-ü bui bükü-dür ger jayuraban kilingleldün abasu* ***ičegüri*** *buyu'* [харь хүн байхад гэр дотороо хэрэлдвэл ичгүүр буюу](ET 31a) // ***hičüri*** 'bashful' (Ras. 203 C13) || х о р ш : *'ичгүүр сонжуур'* || Kha. *itšgür*, Ord. *etšigür*, Bur. *ešegüri*, Oir. *itšür*

Ичу- |ičи| *'буцах'*, *'ницах'* || Ж= *'ariyun yabudal-dur orun baraǰu nögügede* ***ičun*** *ülü üyiledkü bi'* [ариун явдалд орон нөгөөгөөс үл буцан үйлдэх](Taq. 40a) // *'jarimūd irgen-i* ***ičuğāba***' [зарим иргэдийг буцаав](MNT 73)

Ичэри |ičeri| х у у ч : *'нууц'*, *'ичмээр'* || Cf. Turk. *ičäri* 'внутри' (Радлов I:1415) || Ж= *'qatud-un ayimay-i* ***ičeri*** *odqu metü bolyaǰu'* [хатадын аймагийг нууцаар одох мэт болгож](Burq. 17) // ***ičeritü*** *eme* [стыдливая женщина] (Mu.194) || Ord. *etšir*, Bur. *ešer*, Oir. *itš'r*

Ичэриг |ičerig|[= ičeri-g] х у у ч : *'нууцгай'* || Cf. Turk. *ičräk* 'внутренный' (ДТС 202); *'ičireg üges-i doriyun keleleyü'* [нууц үгсийг ихээр хэлнэ](Sub. III:11a)

Иш |išі| *'эм хүн'*, || х о р ш : *'иш хатан'*

Кадастр |[kadaster|{< Rus. *кадастр* < Eng. *cadaster*} *'кадаастер', 'бүрохэл , 'лавламж'* (газар ашиглалттай холбогдох бүрдхэл)

Казино |kazino|{< Rus. *казино* < It. *casino*} *'казийно'* (мөрийтэй тоглоомын нэг төрөл)

Кайф |kayif|{< Arab. *kayf*} *'кайф', 'сэдхэл хөдөлөл'* (Угтаа хар тамихны үйлчилэлээр сэдхэлийн таашаал авахыг ийн нэрлэж байгаад хожим *'сэдхэл ханамж'* гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ)

Какао |kakavo|{< Rus. *какао* < Sp. *сасао*} *'какао', 'шоколадын ундаа'*

Капрон |kapron|{< Rus. *капрон* < Eng. *capron* < Lat *capra* 'ямаа' (анхандаа ямааны сүүний найрлага ордог байсан учир)} *'капроон', 'нийлэг эд'*

Карго |[kargo|{< Sp. cargo} *'каарго'* (улас хоорондын ачаа тээш)

Караоке |karaoke|{< Eng. *karaoke* < Jap. *kara* 'хоосон' + *oke(sutora)* 'оркестр' = [тоглогчгүй оркестр]} *'карооке'* (үгийг нь харж аяыг нь тохируулан дуулах төхөөрөмж)

Каратэ |karate|{< Jap. *karate* 'нүцгэн гар'} *'караатэ'* (зэвсэггүйгээр биеэ хамгаалах тулааны урлаг)

Карнавал |karnaval|{< Rus. *карнавал* < Fr. *carnaval* < It. *carnevale*} *'карнаваал'* (гудамж, талбайд зохион байгуулдаг олоныг хамарсан дуу бүжигийн цэнгээнт наадам)

Карт |kart|{< Rus. *карта* < Ger. *Karte*} *'каарт', 'зураг', 'баримт', 'үнэмлэх'*

Карша |karša|{< Skr. *kāsāya*} *'шар нөмөрөг'* (лам хүний гадуур өмсдөг шар торгон нөмөрөг) || Ж= *'üde čay-tur bodistw al* ***kars-a*** *degēl etüsčü'* [үдийн цагт Бодисадва улаан дээл өмөсч](Burq. 7)

Каск |kask|{< Rus. *каска* < Fr. *casque* < Sp. *casco* 'дуулга'} *'кааск', 'дуулга'* (толгойдоо өмөсдөг хамгаалалын дуулга)

Касс |kass|{< Rus. *касса* < It. *cassa* < Lat. *capsa*} *'каас'* (мөнгө, тасалбар олгох цэг)

Кассет |kasset|{< Rus. *кассета* < Fr. *cassette*} *'касээт', 'хуурцаг'*

Каталог |kataloγ|{< Rus. *каталог* < Fr. *catalogue* < Gr. *καταλογο*} *'катлоог', 'цэс', 'жагсаалт'*

Катеринг |katerin|{< Eng. *cathering*} *'кэйтерин'* (хэрэглэгчидэд хоол хүргэх үйлчилгээ)

Католик |katolig|{< Rus. *католик* < Gr. *καθολικός*} *'катоолиг шашин'* (Христийн шашины үндэсэн гурван чиглэлийн нэг)

Кафе |kafe|{< Rus. *кафе* < Fr. *cafē*} *'кафе', 'жижиг зоогийн газар'*

Квадрат |kvadrat|{< Rus. *квадрат* < Lat. *quadratus*} *'кавдараат', 'тэг дөрвөлжин'*

Квот |kvot|{< Rus. *квота* < Lat. *quota*} *'ковоот'*, *'тогтоосон хувь хэмжээ'*

Керамик |keramik|{< Rus. *керамика* < Ger. *Keramik* < Fr. *céramique* < Lat. *keramos* < Gr. *κεραμικά*} *'кераамик'*, *'ваар эдлэл'*

Кесарево |kesarevo|{< Rus. *кесарево* < Lat. *caesarea* 'зүсэх'} *'хийсвэр'* (хэвлий дэх хүүхэдийг мэс засалын аргаар авах эмнэлэгийн арга)

Кибер |kiber|{< Eng. *cyber-netics*} *'кийбер' ('интернетийн сулжээ'* гэдэг уттаар хэрэглэгдэж байна) || Ж= *'кибер хамгаалалт'*, *'кибер халдлага'*

Кизилбаш |kisilbaš|{< Turk. *qïzïl* 'улаан' + *baš* 'толгой'} *'улаан толгой'* || Ж= *Kisilbaš na ur* (MNT 158)

Кило |kilo|{< Rus. *кило* < Fr. *kilo* < Gr. *κιλό*} *'хил'* (*хундийн жингийн нэгэж*)

Килигү |kiligü / qilayu|{< hilayū > ilayū > ila'ū > ilu'ū > ilū > yalū} *'ялуу' (тэрэгний арал)* || Ж= *'Daridai-odčigin de'ü inü kiligü dergečejü ayïsuqui-dur Hö'ëlün-üjin ügülerün'* [Даридай отчигин дүү нь тэрэгний хажуугаар зэрэгцэж ирэхэд Өэлүн үжин үгүүлэрүүн](MNT 56)

Кинари |kinari|{< Skr. *kimnara*} *'хувилсан сахиусан тэнгэр'* (хүн ч биш, адуусан ч биш элдэв дүрсээр хувилж явдаг) // Pl. *kinaris* (Tara 20) (Эртний энэдхэгийн үлгэр домогт морин толгойтой, хүний биетэй лусын амьтаныг *'кинари'* гэдэг байжээ) || Ж= *'küsel-ün tačiyangyui-yi tarqay-a edügüi-e ber aylaytur kinari-yin ökin-e iregdejü'* [хүсэл тачаангуйг тархаахгүйгээр аглагт кинарын охинд хүргэгдэж](Burq.3b)

Кино |kino|{< Rus. *кино* < Ger. *kino*} *'киноо'*, *'дэлгэц'*, *'сүүдэр ший'*

Кир* |kir / ker| *'хиргах'*, *'хэрчих'* утгыг хадгалсан анхдагч язгуур. Энэхүү язгууралс *kirya* [kir-ya] 'хирга-', *kerči* [ker-či] 'хэрчи-', *kirüge* [kir-(ü)ge] 'хөрөө' гэх зэрэг үгс үүсчээ.

Кирил |kiril|{< Rus. *кириллический* < Bol. *кирилл*} *'кирийл бичиг'*

Клип |klip|{< Rus. *клип* < Eng. *clip*} *'килийп'*, (дууны агуулгыг тусхасан кино зураглал)

Клиринг |kliring|{Eng. *clearing*} *'килийринг'*, *'суудхал'* (харилцагч байгууллагуудын тооцоог бэлэн мөнгөөр бус, даансаар суудхах үйл ажиллагаа)

Клонаци |klonaci|{< Eng. *clone* < Gr. *klon*} *'колонаац'*, *'салаалах'*, *'эс хувилах'* (нэг төрөлийн ургамал, амьтаны эсийг хувааж, үргүй үржүүлэгийн замаар удамшилыг нь хадгалсан шинэ хувилбар гаргаж авах арга)

Клуб |klub|{< Rus. *клуб* < Ger. *Klub*} *'күлүүб'* (зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулах газар)

Код |kod|{< Rus. *код* < Fr. *code* < Lat. *codex*} *'коод'* (томъёолсон тэмдэг)

Кока-кола |koka kola|{< Rus. *кока-кола* < Eng. *coca-cola*} *'кока-кола ундаа'*

Коктейл |kokteil|{< Rus. *коктейль* < Fr. *cocktail* // Eng. *cocktail*} *'коктэйл'* (тахианы сүүл)} (Тус ундааны сэргээх чадалыг сүүлээ өргөсөн тахиагаар төлөөлүүлэн илэрхийлжээ) *'коктэйл'*, *'олон жимэс хольсон ундаа'*

Коллеж |kolleji|{< Rus. *колледж* < Eng. *college*} *'коолеж'* (бакларын сургалт явуулдаг сургалтын байгууллага)

Колони |koloni|{< Rus. *колония* < Lat. *colonia*} *'колооны'*, *'эрхшээл дэх улас'* (бусад ороны улас төр, эдийн засагийн эрхшээлд орсон улас орон)

Комбинзон |kombinzon|{< Rus. *комбинезон* < Fr. *combinaison*} *'комбинзоон'* (өмөд, цамц нь үргэлж, углаж өмөсөх ажилын увдас)

Коммент |koment|{< Eng. *comment*} *'комээнт', 'шүүмж дүгнэлт'* (интернетийн орчин дахь мэдээлэлд хариу өгөх үйлдэлийг коммент хэмээн орчуулалгүй хэрэглэсээр байна.)

Комисс |komis|{< Rus. *комиссия* < Lat. *commissio*} *'комийс' 'ажилын хэсэг'* (тодорхой үүрэг даалгавар хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн ажилын хэсэг)

Компани |kompani|{< Rus. *компания* < Fr. *compagnie*} *'компаань'* (үйлдвэр, худалдааны хувь нийлүүлсэн байгууллага)

Компот |kompot|{< Rus. *компот* < Fr. *compote*} *'компоот', 'даршилсан жимэс'*

Компьютер |kompyuter|{< Rus. *компьютер* < Eng. *computer*} *'компьютер', 'цахим машин'*

Конвенц |konvenci|{< Rus. *конвенция* < Lat. *conventio*} *'конвээнц', 'хэлцэл', 'зөвшилцөл'* (улас хоорондын тодорхой асуудалаар санал нэгдсэн гэрээ хэлцэл)

Конгрес |kongres|{< Rus. *конгресс* < *Kongress* < Lat. *congressus*} *'конгрээс', 'их хурал', 'парламент'*

Конкурс |konkürs|{< Rus. *конкурс* < Fr. *congress* < Lat. *concursus*} *'коонкурс', 'уралдаант шалгаруулалт'*

Консерв |konseriv|{< Rus. *консервы* < Fr. *conserves*} *'консээрев', 'нөөшилсөн хүнс'*

Консорциум |konsorcium|{< Rus. *консорциум* < Lat. *consotrtium*} *'консоорциум', 'холбоо'* (адил төрөлийн үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн байгууллага хамтын ажиллагаагаа уялдуулах хэлбэр)

Консул |konsul|{< Rus. *консул* < Lat. *consul*} *'коонсол', 'төлөөлөгчийн газар'* (гадаад оронд харьяат иргэдийнхээ эрх ашигийг хамгаалах үүрэгтэй төлөөлөгчийн газар)

Контейнер |kontener|{< Rus. *контейнер* < Eng. *container*} *'контэйнер', 'чингэлэг'* (эд бараа агуулах төмөр чингэлэг)

Концепц |koncept|{< Rus. *концепт* < Eng. *concept* < Lat. *conceptum*} *'концээпц', 'цогц ойлголт', 'гол санаа'*

Концерн |koncerni|{< Rus. *концерн* < Eng. *concern*} *'концээрн', 'холбоо', 'нэгдэл'* (үйлдвэр, санхүүгийн байгууллагуудын нэгдэл)

Концерт |koncert|{< Rus. *концерт* < Ger. *konzert* // Fr. *concert* < It. *concerto*} *'концээрт'* (урлагийн олон төрөлийг багтаасан тоглолт)

Концесс |konces|{< Rus. *концессия* < Lat. *concessio*} *'концээс'* (газарын баялаг, үйлдвэр, үйлчилгээний газарыг бусадад ашиглуулж, төлвөр авах гэрээ)

Коньяк |konyak|{< Rus. *коньяк* < Fr. *cognac*} *'коньяак'* (усан үзэмийн хатуу дарас)

Коран |koran|{< Rus. *коран* < Arab. *qurān*] *'кораан'* (исламын шашины ариун ном)

Корпораци |korporaci|{< Rus. *корпорации* < Lat. *corporation*} *'корпораац', 'нэгдэл'* (үйлдвэр, аж ахуйн байгууллагуудын хувь нийлүүлсэн нэгдэл)

Корупци |korupci|{< Rus. *коррупци* < Eng. *corruption* < Lat. *corrupto*} *'коррупци', 'авлига', 'хээл хахуульч'* (албан тушаал, эрх мэдэл, хөрөнгө мөнгөө нэмэхийн тул нөлөө бүхий этгээдэд авилга өгөх)

Косметик |kosmetik|{< Rus. *косметика* < Fr. *cosmétique*} *'космээтиг', 'гоо сайханы бараа'*

Костюм |kostiyum|{< Rus. *костюм* < Fr. *costume* < It. *costume*} *'костюум'*, (Монгол хэлэнд зөвхөн албан ёсны хослол хувцасыг илэрхийлдэг)

Котлет |kotlet|{< Rus. < *котлета* < Fr. *côtelette*} *'катлээт'* (татсан мах хавчуулсан бин)

Кофе |kofe|{< Rus. *кофе* < Eng. *coffee* < Arab. *qahwe*} *'коофе'* (кофейнтэй цай)

Көлти |költi|{< Uig. *kolti* < Sogd. *kwrty* < Skr. *koti*} *'үй олон', 'живаа'* || Cf. Turk. *kolti* 'десять миллионов' (ДТС 311) || Ж= *'jayun* ***költi*** *ökin tngri-ner-iyer küriyelegüljü'* [зуун живаа охин тэнгэрээр хүрээлүүлж](Burq. 60a) // *'yučin jiryuyan* ***költi*** *qorin dörben nayud šimnu-nuγud'* [гучин зургаан живаа хорин дөрвөн наяд шимнусууд](Burq. 64b)

Кран |kran|{< Rus. *кран* < Ger. *Krahn*} *'караан', 'өргүүр'* (өндөр байшин барилга барихад материал дээш гаргадаг өргүүр)

Крем |krem|{< Rus. *крем* < Gr. *crême*} *'кэрээм', 'түрхлэг тос'* (монгол хэлэнд зөвхөн нүүр, гарын арчилгааны тосыг ийн нэрлэнэ)

Кристал |kristal|{< Rus. *кристалл* < Ger. *Kristall* < Lat. *krystallos*} *'кристаал', 'талст'*

Күнз |**küngjü**|{< Chin. *k'un fu-tzu*} *'Күнзийн сургаалыг үндэслэгч* (эртний хитадын их сэдхэгч, гүн ухаантан м. э. ө. 551-479)

Күрс |kurs|{< Rus. *курс* < Lat. *cursus*} *'күүрс', 'анги', 'дамжаа'*

Күртка |kürtke|{< Rus. *куртка* < Pol. *kurtka*} *'күүртэг', 'гадуур хүрэм'*

Кэбид |kebid|{< Uig. *käbit* < Sogd. круδ} *'дэлгүүр'* || Cf. AT *kebit* 'лавка', 'магазин' (ДТС 290), *kebit* 'shop' (Clauson, 688), *kebit* 'shop' (Clauson 688), *kebit* 'лавка' (Щербак 1997, 126) || Ж= *'ger jasabasu* ***kebid*** *delgebesü'* [гэр засвал дэлгүүр нээвэл](Turf. g15) // *kebit* 'boutique' (HY M70)

Л

Лаа |la|{< Chin. *la*} *'тос'* (хэвлэж цудхасан урт нарийхан тосон дэн) || Kha, Ord, Oir. *lā*

Лаагуу |laγuu|{< Chin. *là hǔ*} *'өдхөн тос'* (шингэн багатай өдхөн хоол, унд) || Ord. *lāğu*

Лаажуу |laǰuu|{< Chin. *là jiāo*} *'халуун чинжүү'* (хоолонд хэрэглэдэг халуун ногоо)

Лааз |laǰa|{< Chin. *lá zi*} *'шилэн лонх'* (шингэн зүйл хийдэг төмөр сав) || Kha. *lādz*

Лаак |lak| {< Rus. *лак* < Fr. *lacre* < Lat. *lacca* < Arab. *lakk*} *'лаак', 'чий', 'маажин'* (өнгөлөгч гилгар түрхлэг)

Лаборатори |labortori|{< Rus. *лаборатория* < Ger. *laboratorium* < Lat. *laboratorium*} *'лабортоор'* (туршилт, шинжилгээ хийх газар)

Лав |lab| *'өргөл'* (бурхан тахилын өмөнө тавих хүндэдхэлийн өргөл) || Ж= *'Авisig-un **lab**-dur qoyar yeke altan mandal-un deger-e qonin-u qoryul-un tedüi nuke-ügei subud obuyalan čomurliy ǰokiyaysan ba'* [авшигийг өргөл дээр хоёр их алтан мандалын дээр хонины хорголын төдий нүхгүй сувадыг овоолон цоморлиг цогцлоосон ба](Сумадираднаа, Todur-qai toli)

Лавай |labai|{< Uig. *labai* < Chin. *luo-pai*} *бүрээ хорхойн хисаа* || Ж= *'**labai** linqu-a terigüten öljei-tü qutuytu belges yaruysan-i üjeǰü'* [лавай, линхуа тэргүүтэн өлзий хутагт бэлгэ гарсаныг үзээд](Burq. 43b) Sub VI:2a || Kha. *lawai,* Ord. *lawā*

Лавир |labri|{< Tib. *bla bre*} *'дээгүүрхи матлага'* 1. бурхан шүтээний өмөнүүр хөндөлөн ташуулдан татсан хөшиг 2. том лам хуварагуудын суудалын дээгүүр татах ваадан)

Лавран |labrang|{< Tib. *bla brang*} *'ламын өргөө'* (1708 онд Доронод Төвөдөд Жамьяншадав Агваанзундуйн байгуулсан Лаврандашчил *(blab rang bkra shis 'khyil)* хийдийн нэрийн хураангуй нэр) || Kha. *lawraŋ,* Ord. *lawuraŋ*

Лавшаа |labša|{< Rus. *лапша*} *'лавшаа', 'хэрчсэн гурил'* (хэрчсэн гурилтай шөл)

Лавшиг |labsiγ|{< Tib. *la pa shag*} *нөмгөн өмөсдөг захгүй ёст дээл* || Kha. lawšig, Ord. *lawatšak,* Oir. *lawšɨk*

Лагерь |lager|{< Rus. *лагерь* < Ger. *Lager*} *'лаагер', 'цэрэгийн хүрээ', 'байрлах газар'*

Лагша |lagša|{< Skr. *lakṣa*} *'шинж тэмдэг'* || Ж= *'tngri-ner-ün önggetü Kačalin-daka-dur adali ǰögēlen köbseg oron-dur **lagša** nairaγ-iyār čimegdeǰü'* [тэнгэр нэрийн өнгөт качалиндака /нимгэн зөөлөн нэхмэл даавуу/ шиг зөв зөөлөн оронд лагша найрагаар (ихэс дээдсийн 32 шинж) чимэгдэж](Burq.2)

Лагшин |laγsin|{< Skr. *lakšaṇa*} *'бие цогцос', 'бие махбод', 'эрүүл мэнд'* || Ж= *'ǰögelen köbseg oron-dur **lagšan** nairaγ-iyar čimegdeǰü'* [хөвсгөр зөөлөн оронд лагшин найрагаар чимэгдэж](Burq. 2a) || х о р ш : *'бие лагшин'* || Kha. *laxšiŋ,* Ord, Bur. *lagšan*

Лазан |laʃang|{< Tib. *bla btsong*} *'дээвэр чазчих'* (аливаа ажил төрөлд хойрго, залхуу хандах байдал) || х о р ш : *'лазан залуу'*

Лазер |lazer|{< Rus. *лазер* < Eng. *laser*} *'лаазерын туяа'* (мэс засал, үйлдвэрлэлийн орчинд хэрэглэдэг өндөр давтамжтай туяа)

Лай I |lai|{< Chin. *lā*} *'хог'* (лаг шавар) || Ж= *'худагийн лай'* (худагийн ёроолын хөх өнгийн лаг шавар) || Kha. Ord. *lā*, Oir. *lā*

Лай II |lai|{< Tib. *las*} *'үйлийн үр'* (бие, хэл, сэдхэлээр тарьсан нүгэлт үйлийн үр) || х о р ш : *'лай ланчиг'*, *'үйл лай'* || Kha, Bur. *lai*

Лал |lalu|{< Tib. *kla klo*} *'тэрс үзэл'* (харийн шашин суртахууны үзэл)

Лалар |lalar|{< Skr. *lalātanetra*} *'магнайн нүд'* (цохондоо ганц нүдтэй Махешвар бурханы нэр. Хожимоо хөнгөн хараалын үг болжээ)

Лам |blama|{< Tib. *bla ma*} *'дээд багш'* (амьтаныг зовлонгоос ангижруулж, амар амгаланд хүрэх замыг заагч багш. Эдүгээ аливаа хуварга, санваартаныг заасан ерөнхий нэр болжээ.) || Ж= *'sasgiyab bandida bayši čorjiv degedü lam-a joqiyaju tarniči toyin Sonom gar-a orčiyulbai'* [сажа бандида багш цорж дээд лам зохиож, тарнич тойн Соном гара орчуулав](Sub.I:1b) || х о р ш: *'лам хувараг'* || Kha. *lam*, Ord, Bur. *lama*, Oir. *lamɒ*

Ламп |lamp|{< Rus. *лампа* < Fr. *lampe* < Gr. *λαμπός*} *'лаамп'*, *'чийдэн'*, *'цахилгаан дэн'*

Лан |lang|{< Chin. *liāng*} *10 цэн буюу 37,3 граммтай тэнцэх хүндийн хэмжээ* || Kha, Ord, Oir. *laŋ*

Лангуу |langɣuu|{< Chin. *lán gui*} *'дэлгүүрийн хорго'*, *'бараааны тавиур'* || Kha. *laŋgū*

Ландарма |landarm-a|{< Tib. *glang dar ma*} IX-X зууны үед төвөдийн бурханы шашиныг усадхасан Удумзамбо хааны нэр. Хожим түүний нэр хараалын үг болжээ || Kha, Ord. *laŋdarma*

Ланз |lanʃa|{< Skr. *ranja*} *эртний энэдхэг үсэг* || Kha. *laŋdzɒ*, Ord. *laŋsa*, Bur. *lanza*

Лантуу |langtuu|{< Chin. *lang tou*} *'том алх'* (цохиж дэлдэх том алх) || Kha, Ord. *laŋtū*

Ланчиг |lančiɣ|{< Tib. *lan chags*} *'өр төлөөс'* (урид төрөлдөө үйлдсэн муу үйлийн төлөөс) || х о р ш : *'лай ланчиг'*

Ларз |larʃa|{< Tib. *gla rtsi*} *хүдэрийн заар* || Bur. *larza*

Лац |lača|{< Tib. *la cha* < Skr. *lañch*} *'тамга'* (битүүмжилэлийн зориулалттай тусхай үсэг, тоо бүхий наалдуулдаг тэмдэг) || Kha. *latsɒ*, Ord. *latsa*

Либерал |liberal|{< Rus. *либерал* Fr. *liberal* < Lat. *liberalis*} *'либерааl'* (эвтэрэнгүй үзэл)

Лиг |lig |{< Rus. *лига* < Eng. *league* < Lat. *ligare*} *'лийг'* (нэг чиглэлийн баг, холбоодын хамтарсан үйл ажиллагаа)

Лидэр |lideп{< Tib. *sle tres*} *'найлзуур'* (эмэнд ордог исхэлэн амттай нэгэн зүйл ороонго) | Kha. *lider*, Ord. *lidir*

Лизинг |lizing|{< Rus. *лизинг* < Eng. *lease*} *'лийзинг'* (эд зүйлсийг түрээсээр авах)

Лийр |liir|{< Chin. *li er*} *лийр* (саргай цэцэгийн төрөлийн тураг модны жимэс) || Kha. *līr*

Лимбэ |lingbu|{< Tib. *gling bu*} *'бишхүүр'* (олон нүхтэй урт нарийхан үлээвэр хөгжимийн зэмсэг) || Kha, Ord. *limbū*, Bur. *limbe*, Oir. *lembə*

Лин |ling|{< Tib. *gling*} *'mue'* (Төвөдийн Амдоо нутагийн Хөх нуур, Хатан голын эх орчимын газарын нэр)

Линж |lingji|{< Chin. *lìng chih*} *'зарлиг'* (хун тайжийн гаргасан зарлиг) || Ж= *'Küngjüši süm-e-dür* ***lingji*** *ögbei.* ***Lingji*** *manu ji-ön jirɣuγan on luu jil qabur-un terigün sara-yin qorin tabun-a Gon yim gau-da bükäi-dür bičibei'* [Күнзүши сүмд зарлиг өргөв. Зарлиг ману жи-ён-ий зургаадугаар он, луу жилийн хаварын эхэн сарын хорин таванд Гон йим гау-д байхдаа бичив](Arug 19, 20)

Линз |linz|{< Rus. *линза* < Ger. *linse* < Lat. *lens*} *'лийнз', 'галт шил', 'мэшил'*

Линхуа |lingqu-a|{< Uig. *linqu-a* < Chin. *lián huā*} *'бадам цэцэг'* (гүехэн усны мандал дээр дэлгэрэн ургадаг анхилам үнэрт цэцэг) || Ж= *'**linqu-a** čečeg-iyer čimegtü nayur-un dotur-a qun yalayun terigüten eldeb šibayud-iyar dügürčü'* [линхуа цэцэгэн чимэгт нуурын дотор хун галуу тэргүүтэн элдэв шувуудаар дүүрч](Burq. 2a) // *'**lingqu-a** sayuri-tu altan umai-tu'* [линхуа суурьт алтан умай] (Chimeg 14a) || х о р ш : *'бадам линхуа* [< Tib. pad ma] *линхуа'* || Kha. *liŋhua*, Ord. *liŋχawa*, Bur. *linχobo*, Ord. *liŋxʷwā*

Лит |lit|{< Tib. *le'u tho*} *хуанли* (зурхайн цаг тооны бичиг) || Kha. *lit*, Bur. *lite*

Литр |liter|{< Rus. *литр* < Fr. *litre*} *'лийтер'* (шингэн зүйлийн хэмжүүр)

Лифт |lift|{< Rus. *лифт* < Eng. *lift*} *'лийфт'* (өргүүр шат)

Лицензи |licenzi|{< Rus. *лицензия* < Lat. *licentia*} *'лицээнз'* (эрхийн бичиг)

Лиш |lisi|{< Tib. *li shi*} *'башир цэцэг'* (үрийг нь эмэнд хэрэглэдэг хадаас хэлбэртэй цэцэгт ургамал) || Kha. *liš*, Oir. *liš*

Ловон |lobun|{< Tib. *slob dpon*} *'сургаалын багш'* (дацангийн хурал номын үйл ажиллагааг удирдан зохицуулах тушаалтан) || Kha. *lowoŋ*

Логик |logic|{< Rus. *логика* < Lat. *logica*} *'лоогиг', 'учир шалтгааны ухаан', 'учир зүй',*

Ложистик |logistik|{< Rus. *логистик* < Eng. *logistics*} *'ложийстиг'* (хэрэгцээт мэдээлэл, технологи, бараа бүтээгдэхүүнийг жинхэнэ эх үүсвэрээс нь аль болох бага зардалаар хэрэглэгчидэд хүргэх бүх шат дамжилгыг багтаасан үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хэрэгжилт)

Лозваа ||{< Tub. *lo tsa ba*} *'хэлмэрч', 'орчуулагч'*

Ломбо |lombu|{< Rus. *пломба* < Fr. *plomb*} *'хар тугалга'* (тугалгаар хийсэн лац тэмдэг. Орчин цагийн монгол хэлэнд эмтэрч, цоорсон шүдний бөглөөсийг ийн нэрлэх болжээ) || Kha. *lombo*

Лонх |longqu|{< Chin. *liang hu*} *'усны сав'* (шингэн зүйл хийдэг жижиг амсартай, нарийхан хүзүүтэй шавар ваар) || Ж= *longqa* bouteille' (HY M73) || Kha. *loŋxŏ*, Ord, Bur. *loŋxo*, Oir. *loŋχo*

чадалыг сэргээж, аливаа ажил үйлсийг санасан ёсоор нь бүтээдэг сэдхэлийн хөлөг. || х о р ш : *'хийморь лүндаа'* || Kha. *lüŋdā*

Лүндэн |lüngdeng|{< Tib. *lung bstan*} *'эш үзүүлэх', 'зөгнөн бэлгэдэх'* (ирээдүйд болох үйл явдалыг зөгнөн хэлсэн айлдвар) || х э л ц: *'лүндэн буулгах'* (хожимын явдалыг уридчилан зөгнөсөн айлдвар. Орчин цагийн монгол хэлэнд *'тушаал', 'шаардлага'* гэсэн утгаар хэрэглэдэг) || Kha. *lüŋdeŋ*, Bur. *lünden*, Oir. *luŋdᵇn*

Лүү |lüü|{< Chin. *lǒu*} *'хувин'* (тариа будааны жин хэмжээг тогтоох сүлжиж хийсэн сав) || Kha, Ord. *lū*, Oir. *lū*

Лүүз |lüüje|{< Chin. lòuzi} *'гоожуур', 'юулүүр'*

Лха |lha|{< Tib. lha} *'тэнгэр'* || х о р ш : *'лха тэнгэр'*

Лхагва |lhaγba|{< Tib. *lhag pa*} *Лхагва* (долоон хоногийн гурав дахь өдөрийн нэр // нарны аймагийн есөн гарагийн нэг) || Skr. *budha* 'буд') || Kha. *lhagva*

Лхарамба |lharamba|{< Tib. *lha rams pa*} *'Лхасын маш хэтэрхий'*. (Энэ нь төвөд хэлний *'lha ldan rab 'byams pa'* гэсэн үгийн хураангуй. Төвөдийн Лхасын хийдэд ном хаялцаж, гавжийн дамжаа барьсан хүнд олгодог цол. || Kha. *lhāramba*

Лэнсий |lensüi|{< Chin. *liŋ sui*} *'аар саар', 'жижиг сажиг'* || Kha. *leŋsī*

Люванз ||{< Chin. *liū wánz*} *'хуурсан бөөрөнхий мах'* (бөөрөнхий мах, шарсан төмөс, пүнтүүзтэй холимог хуурга)

Люстр |liyuster|{< Rus. люстра < Fr. lustre} *'люустер'* (чийдэнгийн гоёмсог бүрхүүл)

Люцайхуй ||{< Chin. *liū cài hui*} *'холимог шөл'* (бөөрөнхий мах, шарсан төмөс, пүнтүүзтэй холимог шөл)

Лянхуа үз Линхуа

М

Маажин |maJing|{< Chin. *ma jiàng} .лаак* (маалингын тосоор хийсэн өнгөлөгч шингэн) || Kha. *mādžiŋ*, Oir. *mādžı*

Маалинга |mayalingyu|{< Chin. *ma lian}* *нэгэн зүйл ургамал* (утас, тос гаргаж авах өвөслөг ургамал. Хожим маалингын бүдүүн утасаар нэхсэн нэхмэл шуудайг ийн нэрлэх болжээ) || Kha. *māliŋǧa*

Маань |mani|{< Skr. *mani}* *'үнэт эрдэнэ', 'наран'* (Буддийн шашины өдөр тутамын гол уншилга) || Ж= *'jirüken-ü tolta-yin tayilburi üsüg-ün endegü-rel-ün qarangqui-yi arilyaγči oytaγui-yin mani'* [зүрэхний толтын тайлбар, үсэгийн эндүүрэлийн харанхуйг арилгагч огторгуйн наран](ОМ 26а) || х о р ш : *'маань мэгзэм'* || Kha. *mānī*, Ord, Bur, Oir. *māni*

Маапаан |mapan|{< Chin. *má fan}* *'эсдэрээ', 'төвөг', 'будилаан'* || Kha. *māpāŋ*

Маар |mayar|{< Chin. *mă er}* *'тэвх'* (утасан хөгжимийн чавхдасыг хөндийрүүлэгч тэвх)

Маарамба |maramba|{< Tib. *sman rams pa}* *'маарамба', 'маш хэтэрхий эмч'* (уламжлалт эмчилгээний арга ухаанд мэргэшсэн хүнд олгох цол) || Kha. *māramba*

Маатан |matang|{< Chin. *má tāng}* *'маатан'* (үр тарианы нунтагаар хийсэн наалдамхай чихэрлэг идээ) || Kha, Oir. *mātaŋ*

Маахай |maqai|{< Chin. *mián huē}* *'маахай'* (нэхмэл бөсөөр хийсэн шаахай) || Kha. *māxai*, Ord. *māxā̄*

Маахуур |maquur|{< Chin. *má huā}* *'маахуур'* (үрийн тосонд чанасан мушгиа боов) || Kha, Ord. *māxūr*

Мааюуз |mayuuja|{< Chin. *mā yu zi}* *зөөлөвч* (унааны нуруун дээр тохдог зузаан зөөлөвч) || Kha. *māyūdz*, Ord. *māyūs*

Мааюур |mayuur|{< Chin. *mā yá er}* *'маалингын суеэ'* (тосонд чанасан олон давхарласан чихэрлэг боов) ||

Мага |maγ-a| х у у ч : *'магад', 'чухам'* || Ж= *'šilam-dur oraysad tanu metüs maγ-a ünen sedkilten ariyūn aran'* [шиламд орогсод таны мэт чухам үнэн сэдхэлтэн ариун ард](Ar. III) // *'sōni maǧa qa'ā qono[qu] aju'ū'* [шөнө чухам хаа хонодог ажгуу](MNT 31)

Магада |magada|{< Skr. *magadha}* *'эртний уласын нэр'* (Одоогийн доронод энэдхэгийн Бихар мужид м. э. ө. 350 - м. э. 450 онд оршин тогтонож байсан улас. Нийслэл нь Ражагриха гэдэг хот байжээ) // *'rasiyan-i asiylan kereglegčid Magada ulus-tur törül abudqun'* [аршааныг ашиглан хэрэглэгчид Магад уласт төрөл авагтун](Chimeg 9b)

Магистр |magister|{< Rus. *магистр* < Ger. *Magister* < Lat. *magister}* *'магийстер'* (баклаврын дараах ахьсан түвшиний сургалт дүүргэсэн хүн)

Магнаг |mangnuγ|{Chin. *măngló}* *'ман могой луу'* (алт, мөнгөн утас оруулж нэхсэн луу, могой хээтэй торго) || х о р ш : *'магнаг торго', 'таж магнаг'*

Магнат |magnat|{< Rus. *магнат* < Lat. *magnatus*} *'магнаат', 'толгой баян'* (нэгэн төрөлийн их хэмжээний хөрөнгө баялагийг эзэмшигч)

Мадаг |madaγ|{< Tib. *ma dag*} *'үсэгийн алдаа'* (Орчин үеийн монгол хэлэнд их төлөв бичиг зохиолын алдааг ийн нэрлэнэ) || х о р ш : *'алдаа мадаг'* || Kha. *madag,* Ord. *madak*

Мажий- |*maǰiyi*|{< Tib. *ma chis pa*} *'нас бар-'* || Kha. *madžī-*

Мажоритар |maǰoritar|{< Fr. *majoritaire*} *'мажартаар', 'дийлэнхи', 'олонхи'* (сонгуулийн нэг тойрогт нэр дэвшин өрсөлдөгсөдөөс хамагийн олон санал авсан хүнийг парламентийн гишүүнээр сонгох тогтолцоо)

Майдар |mayidar|{< Uig. *maydari* < Skr. *maitreya*} *'асарагч', 'энэрэнгүй', 'ивээлт'* (Бурхан багшийн найман шадар шавийн нэг бөгөөд түүнийг ирээдүй цагт заларах бурхан хэмээн үздэг.) || Ж= *'yirtinčü-eče nögčigsen gem ügei **mayidari** sedkil-i bišilγan'* [ертөнцөөс нөхөцсөн гэмгүй энэрэнгүй сэдхэлт] (Burq. 57a) || х о р ш : *'цам майдар'* || Kha, Bur. *maidar,* Ord. *mādar,* Oir. *mād̄r*

Маймаа үз **Наймаа**]

Макро |makro|{< Eng. *macro* < Gr. *makros*} *'маакро', 'их', 'том'* Энэ үг орчин үеийн монгол хэлэнд их төлөв хэвээрээ хэрэглэгдэж байна. || *макро эдийн засаг*

Мал |mal|{< Turk. *mal* < Pers. *māl*} *'хөрөнгө'* || Cf. Turk. *mal* 'имущество' (Радлов, IV:2035), AT *mal* 'имущество', 'богатство' (ДТС 335), Uig. *mal* 'commodity', 'goods' (Schwarz, 876) Энэ үг монгол хэлний эртний дурасхалуудад бараг тохиолддоггүй, харин араб үсэгээр тэмдэглэсэн Мукаддимат ал-Адаб толийн монгол хадмал орчуулгад *'эд баялаг'* гэсэн утгатай байна (Н Поппе, *Монгольский словарь Мукаддимат ал-Адаб,* М-Л, 1938, 232) Хожим монгол оронд мал арилжааны хэрэгсэл болсон үеэс *'эд баялаг'* гэсэн утгаа алдаж, *'эд мал', 'мал идээ'* гэсэн холбоо үгээр хэрэглэгдэж байсанаа уламаар одоогийн утгад бүрэн шилжжээ. || Ж= *'ǰayan, morin, temegen terigüten **mal** aduγusun-i toγolasi ügegüy-e ergüged'* [заан, морь, тэмээ тэргүүтэн мал адгуус тоолшгүй өргөөд](ET 44b) // *'ulus irgen **mal** aduγusun-i alaǰu'* [улас амьтан мал адгуусыг алж](Chimeg 41a) // *'**mal** inu tabi ese güyičekül-e köbegüd-eče inu tabin **mal** güyičegejü bariy-a'* [мал нь тавь эс гүйцвэл хүвүүдээс нь тавин мал гүйцээж бария](QJ A2a) || х о р ш : *'мал хөрөнгө', 'мал сүрэг'* || Kha, Ord, Bur, Oir. *mal*

Малгай |malaγai|{< *maqaqlai*} *'толгойн өмөсхөл'* || Cf. Man. *maxalá* 'шапка' (Цинциус I:522) || Ж= *'Jelme **maqalai**, ǧutusun, de'ēl qubčasun-iyān bügüde-yi tailǰu'* [Зэлмэ малгай, гутал, дээл хувцасаа бүгэдийг тайлж](MNT 145) // *maqalai* 'шапка' (Mu. 233) // *maqalai* 'tall headgear', 'hood', 'cap' (Ras. 205 B39) // *malγai* 'cap', 'hat' (Zir.115) || х о р ш : *'малгай толгой'* || Kha, Bur. *malgaǐ,* Ord. *malaǧa,* Oir. *maχlā̄ / malχā̄*

Мам |mamu|{< Tib. *ma mo*} *'эм шулам'* (энэ үг монгол хэлэнд хараалын утгатай хэрэглэгдэж иржээ) || Kha. *mam*

Мамба |mamba|{< Tib. *sman pa*} *'эмчийн дацан'* || Kha, Ord. *mamba*

Ман* |man| *'бид'* (олон тоот гуравдугаар бнейн төлөөний нэрийн үндэс. Энэхүү үндэс нь нэрлэх (nominative)-ээс бусад бүх тийн ялгалын үндэсэнд тохиолдоно. || Ж= ***мани*** *sayin ečige'* [бидний сайн эцэг](Abaga I) // *'kö'üd-ü'ēn **man-a** nökör se'üder bolgasu'* [хүвүүдээ бидэнд нөхөр сүүдэр болгоё] (MNT 214) // *'üdür büri **man-dur** irejü'* [өдөр бүр бидэн дээр ирж](MNT 31) // *'edü'ē **man-i** tarqa'ülun baraju'* [эдүгээ биднийг тархаан явуулж](MNT 83) // *'**man-ača** door-a yisün ba arban üy-e bolqui-a'* [биднээс доош ес, арван үе болохуй](ET V:48b) // *qari dayisun **man-luy-a** yakin nökücekü* [харийн дайсан бидэнтэй хэрхэн нөхцөх](ET VI:56b)

Мана I |manu|{< Chin. *mă năo*} *олон зүйл өнгөтэй үнэт чулуу* || Kha. *mana*, Oir. *man*^{n}

Мана II |mana| *'бүдэг', 'бүрхэг'* || Энэ язгуураас *manan* [mana-n] 'манан', *manara-* [mana-ra] 'манар-' гэх мэт үгс үүсчээ || Ord. *mana*

Мана- |mana| *'хамгаал-', 'хар-'* || Энэхүү язгуураас *manaya* [mana-ya] 'манаа', *manayači* [mana-ya-či] 'манаач', *manayūl* [mana-yūl] 'мануул' зэрэг үгс үүсчээ. || Kha, Ord, Bur. *mana-*, Oir. *man*^{n}*-*

Манагар |manayar|[= man(a)-yar] *'өглөө', 'шинэ өдөр'* (*'нар мандаж, шинэ өдөр эхлэх'*-ийн бэлгэдэл болгон *manduqu* [man-du-qu] гэдэг үгийн язгуураас тус үгийг үүссэн гэж зарим судалаачид үздэг. || Ж= ***'manaǧar** erte mör-tür olon adu'ün-dur nigen görümele kö'ün kü'ün ge'ü sa'ān aqu-yi jolǧaju'* [өглөө эрт зам зуур адуун дунд нэгэн сайхан залуу хөвүүн гүү сааж байхтай таарч](MNT 90) // *'üdeši **manayar** qayačal ügei ülü uyidun taqiyad'* [өглөө үдэшгүй үл уйдан тасаралгүй тахиад](Chang 16) // *manaqar* 'matin' (HY M74) // ***manaqār** erte irebe tedendü* [на завтра утром пришел к ним](Mu. 233) // *manayār* 'Morgen' (LH 70) // *manaqār* 'demain' (Ist. 52) // *manaqār* 'tomorrow' (Ras. 201 A25) // *manyar* 'полдень' (IM M116) // *maŋyar* 'завтра' (IM M150) // *manaqār* 'tomorrow' (Ras.201 A25)

Манал |manal|{< Tib. *sman lha*} *'оточ бурхан'* (Өвчин эмгэгийн холын урхаг шалтгааныг таниж, аливаа өвчин үүдэх гурван хор, гурван гэмийг арилган үйлдэх бурханы нэр. || Kha. *manal*, Oir. *man*^{n}*l*

Манан |manan| *усны уурын бөөгнөрөл* || Cf. Uig. *manan* 'fog', 'mist' (Schwarz, 878); Man. *manā* 'туман' (Цинциус I:526) || Ж= ***manan** ügei bolba köke* [небо очистилось от туман](Mu. 233) // *manan* 'mist' (Ras.186 C3) || х о р ш : *'манан будан'* || Kha, Bur. *manan*, Ord. *mana*, Oir. *manār / manɒŋ*

Мангаалам |mangyalama|{< Skr. *maṅgalam*} *'өлзий хутаг орших болтугай'* (Энэ үгийг их төлөв ном сударын эцэст ерөөл болгон бичдэг)

Мангал |mangyal|{< Skr. *maṅgala*} *'өлзий хутаг', 'зол жаргал'* || Kha, Ord. *maŋǧal*

Мангас |mangyus| *'хүний махан хүнэстэн'* (үлгэр домогийн амьтан) || Cf. Turk. *maŋyys* 'вампир, чудовище' (Räsänen 327) || Ж= *'em-e **mangyus**-nuyud-ta bariydaysan qudaldučid-i kičiyenggüi-ber aburayad'* [эм мангасуудад баригдсан худалдаачидыг хичээн авараад](Burq. 4a) || х о р ш : *'мангас махчин'* || Kha. *maŋǧas*, Ord. *maŋgus*, Oir. *maŋǧvs*

Мангир |manggir| *'зэрлэг сонгино'* || Cf. Turk. *maŋyrsun* 'полевой чеснок' (Räsänen 327) || Ж= *'eke Üjin-nü qaliyārsun* ***maŋgirsun****-iyār teji'ēgsed kö'ūd qad bolura kürbi'* [Үжин эхийн халиар мангираар тэжээгдсэн хувүүд хаад болоход хүрэв](MNT 74) || Kha, Bur. *maŋgir*, Ord. *maŋgis*, Oir. *maŋgirsᵒn*

Манго |maŋgo|{< Rus. *манго* < Eng. *mango* < Port. *manga* < Tamil. *mān kāu* /модны үр/} *'маанго'* (халуун оронд ургадаг голдоо том хавтагай ястай, шар ногоон халистай, чихэрлэг шүүстэй амтат жимэс) || Kha. *māŋgō*

Мандал |mandal|{< Skr. *maṇḍala*} *'хот мандал', 'шидэт хүрээ'* (Ядам бурханыг хүрээлсэн олон бурхадын цогц. Түүнчилэн бүддийн шашины ёсонд бурханы өмөнө дугуйруулан өрсөн тахил тавигийг ч бас мандал гэдэг) || Ж= *'gal* ***mandal****-iyar takil-i üyiled'* [гал мандалаар тахил үйлд](Burq. 40a) || х э л ц: *'тахил өргөх'* (бурхан шүтээний өмөнө хүндэдхэлийн аршаан идээ, арц хүжийг ёслон тавиглах шашины зан үйл) || Kha, Ord, Bur. *maŋdal*, Oir. *mandᵒl*

Мандарваа |mandaru-a|{< Skr. *mandharva*} *'диваажингийн таван модны нэг'*

Мандат |mandat|{< Rus. *мандат* < Lat. *mandatum*} *'мандаат', 'эрхийн батламж'*

Манекен |maneken|{< Rus. манекен < Fr. *mannequin*} *'манекин'* (хувцасны загвар өмсгөдөг хиймэл хүн)

Манж |manju| *'түнгүүс угсаатан'* (Манж гэдэг нь их одоогийн зүүн хойд хитадад газар тариалан, мал аж ахуй эрхэлэн амь зуудаг түнгүүс утсааны үндэстэний нэр. Нэрийнх нь хувьд гэвэл тэд бүр хитан уласын үеэс *'Зүрчид'* хэмээн нэрлэгдэж байгаад XVII зууны дундаас *'Манж'* хэмээн нэрлэгдэх болжээ. Манж нар 1616 оноос Чин улас хэмээх эзэнт гүрэнийг байгуулж, 285 жил оршин тогтоноод 1911 задаран унажээ.

Манжин |manjing|{< Chin. *mán jing*} *амтлаг үндэстэй хүнсний ногоо* || Kha. *maŋdžiŋ*, Ord. *mandzin*, Oir. *mandᵒn*

Манз |manʒa|{< Tib. *mang ja*} *'олоны цай'* (сүм хийдийн лам нарт хурал номын дундуур өгдөг цай идээ) || Kha. *maŋdzʊ*, Ord. *mandza*

Манзшир |manǰušir|{< Skr. *maṇjuśrī*}*'зөөлөн эгшиг'* (Бүддийн шашины язгуурын гурван их бурханы нэг буюу оюун билигийн бурхан. Манзшир бурханыг баруун мутартаа мунхагийн харанхуйг арилгагч билигийн илд, зүүн мутартаа удвал цэцэг барьж, очир завилгаагаар саатан суугаагаар дүрсэлдэг) || Tib. *'jam dbyangs* 'жамъян' || Ж= *Šanta-diu-a bi ber* ***Manǰuširi*** *Bodistv-un sayin tus-a kürgedegsen-iyer'* [Шантидева би Манзушир Бодисадвагийн сайн тусыг хүртсэнээр](Bod. 163a) || Kha. *maŋdzšir*, Ord. *mandžušari*, Oir. *manzᵘšir*

Манивил |manibel|{< Rus. *мануал* < Eng. *manual*} *'маньвэл', 'энгийн'* (машины моторыг энгийн аргаар хөшиж эргүүлэн асаадаг тахир төмөр хэрэгсэл) || Орчин цагийн монгол хэлэнд албадан шаардахыг *'манивилдэх'* хэмээн шилжсэн утгаар нэгэн үе хэрэглэдэг байв. || Kha. *maniwil*

Маникюр |manikur|{< Rus. *маникюр* < Fr. *manicure* < Lat. *manus* 'гар' + *curare* 'арчлах'} *'маникүүр'* (хумас засаж, будах мэргэжилийн ажиллагаа)

Манин |manin|{< Tib. *ma ning*} *'хиоцгон', 'саармаг'* (эр, эм бэлгэ хосолсон шинж: сахал үс бүхий эр шинж давамгайлсан хүнийг *'эр хиоцгон'*, хөх мээм бүхий эм шинж давамгайлсан хүнийг *'эм хиоцгон'* гэдэг.) || х о р ш : *'манин хиоцгон'* || Kha, Ord. *manin*

Манлай |terigün| **1.** *'тэргүүлэгч'* **2.** *'магнай'* || Ж= **1.** *'bi ber binwadčin toyid-un **manglai** boltuγai'* [би бинвадчин тойдын тэргүүн болтугай](BT 167b) // *'qamuγ graγ-ud-un dotor-a-ača **manglai** boluγsan'* [хамаг гаригуудын дотроос манлай болсон](Chimeg 41b) || Ж= **2.** *Činging bai-bar **manglai**-yin yeke üsüg-i bičigülün* [Чингин байгаар толгойна их үсэгийг бичүүлэн](Hin 10) // *ebül-ün ćay-un jögeken söni **manglai**-ača sıγu-dača kölesün yarqui* [өвөл цагийн хүйтэн шөнө магнайгаас, сугаас хөлөс гарах](Burq. 36a) *Duwa-soqor **manγlai** dunda ğağča nidütü* [Дува сохор магнайн дундаа ганц нүдтэй](MNT 4) // *mang-lai* 'front' (HY M74) // *kölerbe **manglai*** [лоб покрылся потом](Mu.222) // ***manglai** 'Stirn'* (LH 70) // ***manqlai*** 'forehead' (Ras.198 B17) // ***manglai*** 'front' (Ist. 53) || Kha. *manγlaĭ*, Bur. *manlaj*, Ord. *mānlā, manmā*, Oir. *manmā*

Мансард |mansard| {< Rus. мансарда < Fr. mansarde] *'мансаард'* (сууц болгон ашигласан дээвэрийн хөндий)

Мантуу |mantuu|{< Chin. *mán tou*} *'исгэж жигнэсэн гурил'* || Cf. Turk. *mantu* 'пельмени, вареные на пару' (Радлов, IV:2022) || Kha. *manţü*, Ord. *mantū*

Мануул |manaγūl|[= mana-γūl] *'манаач'* || Ж= *'üked, qonid, aduγun-a ... sayin kümün **manayulsun** bolγan'* [үхэр, хонь, адуундаа ... сайн хүнээр манаач болгон] (Jig. 4) || Kha, Ord, Bur. *manūl*, Oir. *manᵒl*

Манхаг |mangquγ|{< Tib. *sman khug*} *'эмийн уут'* (эм тан хийх илгэн уут) || Kha, Ord. *manxuk*, Bur. *manxag*, Oir. *manχᵒg*

Маньяк |maniyak|{< Fr. *maniaque*} *'мунаг'* (далд барьж байсан хүсэл тачаалаа тогтоож дийлэлгүй илэрхийлэн мунаглах сэдхэхүйн доголдолтой этгээд)

Марал |maral| *'эм буга', 'согоо'* || Cf. Uig. *maral* 'deer' (Schwarz, 871) || Ж= *'**maral**-un ğodun ğutusutu'* [маралын годон гуталтай](MNT 114) // *'gergei inü Qo'āi-**maral** aji'ai'* [гэргий нь Гоа марал ажээ](MNT 1-3) // *maral* 'марал' (Mu. 405) // *maral* 'hirschkuh' (LH 69) // *maral* 'самка оленя' (Mu. 207), *mārāl* 'cerf' (Qaz, Pelliot, 565) || Kha, Ord, Bur. *maral*, Oir. *marᵒl*

Марафон |marafon|{< Rus. *марафон* < Gr. *μαραθωνιος*} *'марфоон'* (холын зайн гүйлт)

Маргад |marγad|{< Tib. *mar gad* < Skr. *markaṭa*} *номин ногоон чулуу* (номин ногоон өнгөтэй энэхүү эрдэнийн чулуу нь долоон зүйлийн эрдэнийн чулууны нэгэнд багтдаг) || Kha. *marğad*

Маргаадар |marγadar|{< *marγa edür*} *'маргааш', 'ирэх өдөр'* (Энэ үг нь зөвхөн аман ярианд хэрэглэгддэг) || Kha. *marğādar*, Oir. *maŋgᵘdᵘr / maŋgᵘdür*

Маргааш |*marγasi*|{< *marγa-si*} *'ирэх өдөр'* || Ж= *'Маргааш цагаан сарын шинийн нэгэн'* (Д. Нацагдорж, Цагаан сар ба хар нулмис)

Марз |marǰa| *хужир эрдэс хурсан газар* || Cf. Turk. *maračy* 'salz-steppe' (Räsänen 327) || Kha. *mardz*, Oir. *martsᵘ*

Мария |mariyan| *'мах', 'бие махбод'* || Cf. Turk. *marïm* 'тела' (ДТС 337); *'bey-e belder üstün **mariyan** bolju'* [бие хаа нь нь ус, мах болж](Taq.2a5) // *'miq-a **mariy-a** bayuraju'* [мах мариа шуугдаж](Chimeg 8a) // *'qahān söni **mariyā** qala'ūn qonoba ke'ēbi'* [хааны бие шоно халуурч хонов](MNT 265) || Орчин үеийн монгол хэлэнд *'махлаг'* гэсэн утга илэрхийлнэ || х о р ш : *'мах мариаа'* || Kha. *marlā*, Bur. *maryā*. Ord. *mirā*, Oir. *merā*

Марк |mark|{< Rus. *марка* < Ger. *mark*} *'маарк', 'тэмдэг', 'шуудангийн тэмдэгт'*

Марль |marli|{< Rus. *марля* < Fr. *marli*} *'маарал', 'самбай'* (сийрэг нэхээстэй бос)

Мармелад |marmelad |{< Rus. *мармелад* < Fr. *marmelade*} *'мармилаад', 'бүржмэл чихэр'*

Марфон |marafon < Rus. *марафон* < Gr. *μαραθωνιο*} *'марфоон'* (холын зайн гүйлт)

Маршал |maršal|{< Rus. *маршал* < Fr. *marechal*} *'мааршал', 'орлог жанжин'*

Маршрут |marsirut|{< Rus. *маршрут* < Ger. *Marschrute* < Fr. *marche* 'алхах' + *route* 'зам'] *'маршируут', 'аялалын зам'*

Массаж |massaji|{< Rus. *массаж* < Fr. *massage*} *'масааж', 'иллэг'*

Матар |matar|{< Uig. *matar* < Skr. *makara*} *'далайн мангас'* (Эртний энэдхэг домогт далайн мангасыг аварга загасны биетэй, зааны хошуутай, гөрөөсний эвэртэйгээр дүрсэлсэн байдаг байжээ) || Ж= *'čibil-tü šimnu-yin **matar** terigütü tuy inu quyuraju'* [нүгэлт шулмасын матарын толгойт туг нь хугарч](Burq. 64b) // *'dalai-yin kuǰayar-a **matar** naran-dur kölčikeǰü'* [далайн захад матар наранд ээж] (Chimeg 41a) || Kha. *matar*, Ord. *madar*, Oir. *mat°r*

Математик |matematig|{< Rus. *математика* < Gr. *μαθηματικά*} *'математиг', 'тоо бодлого'*

Материал |materiyal|{< Rus. *материал* < Ger. *material*} *'матираал', 'бөөс бараа', 'мэдээ баримт'*

Матрас |matras|{< Rus. *матрац* < Ger. *Matratze*} *'матараас', 'зузаан дэвсэхэр'*

Мафи |mafi|{< Rus. *мафия* < It. *mafia*} *'маафи'* (зохион байгуулалттай гэмт хэрэгийн бүлэглэл)

Мах |miqa| *'арис ясны завсар дахь нэхдэс'* || Cf. Man. *m'axa* 'мясо' (Цинциус I:522) || Ж= *'ödür-tür γurban qošiγun aduγusun-u **miqabar** tabiγla-basu'* [одөрт гурван хошуу малын махаар тахиваас](Taq. 23a3) // *'bey-e minü qatabasu ber **miqan** arasun yasun anggiǰirabasu'* [бие минь хатаж, мах, арис, яс нь салваас](Burq.51a) // *'dörben noqais-i kü'ün-nü **miqa**-'ār teǰi'ēǰü'* [дөрвөн нохосыг хүний махаар тэжээж](MNT 195) // *miqan* 'мясо' (Mu. 236) // *miχa* 'мясо' (IM 441, IM M150) // *miqa* 'Fleisch' (LH 71) // *miqa* 'chair' (Ist. 54) // *miġân* 'flesh', 'meat' (Ras.205 B45) // *miqān* 'flesh', 'meat' (Zir.116) || Kha. *max*, Ord. *maxa*, Bur. *mixa*, Oir. *maxən*

Маха |maha|{< Skr. *mahā*} *'их', 'дээд'* || *'их хөлгөн'* (*Mahāyāna*)

Махабод |maqabod|{< Skr. *mahābhūta*} *'их үүсэл', 'анхдагч элемент'* (Бурханы шашины ёсонд бүх юмны эх үүсвэр болсон гал, ус, хий, шороо, огторгуй гэсэн таван үндэсэн элементийг ийнхүү нэрлэдэг) || Ж= *'**Maq-a bodi** qayān terigūten nōkūd-i burɣū ūjel-eče qariyūlǰu'* [Махаболи хаан тэргүүтэн нөхөдийг буруу үзэлээс буцааж](Burq. 4b) Орчин үеийн монгол хэлэнд ч мөн язгуур элементийг ийнхүү нэрлэдэг || Kha. *maχbod*, Ord. *maχabut*, Bur. *maχabad*, Oir. *maχ°mūd*

Махагал |maqagala|{< Skr. *Mahākala*} *'сахиулсан бурхан'* (гурван толгой, зургаан мутартай дандарын ёсны хамагийн дээд сахиус) || Kha. *maχvğal*

Махаража |maqaraǰa|{< Skr. *mahārāja*} *'их хаан'* (ертөнцийн дөрвөн зүгийг сахигч сахиусан бурхан) || Ж= *'dörben **maqaraǰa** ɪngri-ner ber nökūd-iyer-iyen nigen-e Adakavanti balyasun-dur čiyulǰu'* [дөрвөн махаража тэнгэр нэр нөхөдтэйгээ Адакаванти хотод чуулж](Burq. 15a) // *'Qara-yaks-a neretü mangyus ridi qubilyan-iyar Dörben **Maqaranǰa** daki-ača nigen ökin ɪngri-yi qulyaǰu'* [Харякша нэрт мангас риди хувилгаанаар Дөрвөн Махаража дахь нэгэн охин тэнгэрийг хулгайлж](Chimeg 36a)|| Kha. *maχvraŋdzv*, Ord. *maxa-randža*

Махасамади |maqasamadi|{< Skr. *mahāsamadi*}, *'олоноо өргөгдсөн', 'дээд язгуур'* || Ж= ***Maqasabadi** qamuɣ-i teǰiyegsen-iyer bügüde aran-a qan eren ergügdeǰügüi'* [Махасамади хамагийг тэжээсэнээр бүх ард олондоо хаан болон өргөмжилөгдөж](Sub II:6a)

Махаяна |maqayan-a|{< Skr. *mahāyāna*} *'их хөлгөн'* (бүддийн шашины хоёр үндэсэн урасхалын нэг)

Махгал |maqagala|{< Skr. *mahākāla*} *'их хар'* (Бүддийн шашины ёсонд *'махгал'* хэмээх сахиусан бурханыг гурван толгой, зургаан мутартайгаар дүрслэсэн байдаг || Kha. *maχvğal*

Мацаг |mačay/bačaɣ|{< Tib. *ma tshugs*} *'идээ ундааны цээр'* (сар бүрийн 8, 15, 30-ны өдөр ном бисалгал хийх үеэр улаан идээ үл амсах шашины уламжилалт зан үйл) || х э л ц : *'мацаг барих'* (тодорхой хугацаанд махан идээ, хоол унд үл хэрэглэн цээрлэх) || Ж= *'өнөөдөрийн хувьд **мацаг** барьжээ' гэж залбиран овоохой руугаа гэлдэрнэ'* (Д. Намдаг, Цаг төрийн үймээн) || Kha. *matsag*, Ord. *matsak*, Bur. *basag*, Oir. *mats°g*

Машин |masin|{< Rus. *машина* < Fr. *machine*} *'машийн', 'автомат төхөөрөмж', 'тээвэр'*

Маяг I |mayiɣ|{< Tib. *ma yig*} *'эх загвар', 'үлгэр', 'хэлбэр дүрс'* || х о р ш : *'хэв маяг', 'маяг төлөв'* || Kha, Bur. *mayag*, Ord. *mayak*

Маяг II |mayiɣ|{< Tib. *smad yogs*} *'мадиг'* (лам хүний өмөсөх банзал) || Kha. *mayag*, Oir. *majvg*

Мебель |mebeli|{< Rus. *мебель* < Ger. *möbel* < Fr. *meubles*} *'мээбел', 'тавилга'* (хэрэглээний онцлогт тохируулан тодорхой загвараар зохион бүтээсэн тавилга төхөөрөмж)

Медаль |medal|{< Rus. *медаль* < Fr. *médaille* < Lat. *metallum*} *'мидаал' 'дурасхал, хүндэдхэлийн тэмдэг'*

Меланхолик |melonqoyilig|{< Rus. *меланхолиг* < Gr. *melas* 'хар бараан' + *cholē* 'уур'] *'мэлэнхойлог', 'уйдхарлаж гунигласан зан ааштай хүн'*

Менежер |meneǰer|{< Eng. *manager*} *'мээнэжер', 'удирдагч', 'зохицуулагч'* (үйлдвэр худалдаа, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг зохицуулан удирдагч)

Менежмент |meneǰment|{< Rus. *менеджмент* < Eng. *management*} *'мээнэжмент'* (зохион байгуулах арга ухаан)

Меню |menyu|{< Rus. *меню* < Fr. *menu*} *'меньюу', 'хоолны цэс'*

Мессеж |messeji|{< Eng. *message*} *'мээсеж', 'мэдээ', 'цахим зурвас'* (гар утасны товчилуурыг ашиглан дамжуулах богино зурвас)

Метал |metal|{< Rus. *металл* < Ger. *metall* < Gr. *μέτλλο*} *'митаал', 'төмөрлөг'*

Метр |metr|{< Rus. *метр* < Ger. Méter < Gr. *μετρώ*} *'мийтер'* (уртын хэмжүүр)

Метро |metro|{< Rus. *метро* < Fr. *metro* (metropolitan)} *'мэтроо'* (газар доорхи цахилгаан төмөр замын буудал)

Мигман |migman|[< Tib. *mig mangs*] *'олон нүдэт'* (60 ширхэг нүдтэй хөлөгт тоглоом)

Мигмар |miγmar|{< Tib. *mig dmar*} *'улаан нүдэн гараг'* буюу долоон хоногийн хоёр дахь өдөрийн нэр (нарны аймагийн есөн гаригийн нэг. || Skr. *angāraka* 'ангариг') || Kha. *migmar*

Микро |mikro|{< Rus. *микро* < Gr. *μικρός*} *'микроо', 'бичил', 'маш жижиг'* || *'микро район', 'бичил хороолол'* || (энэ үг одоогийн монгол хэлэнд их төлөв хэвээрээ хэрэглэгдэж байна.)

Микроб |mikrob|{< Rus. *микроб* < Gr. *μικρός* 'жижиг' + *βιος 'амьдарал'*} *'микрооб', 'бичил бие'*

Микроскоп |mikroskop|{< Rus. *микроскоп* < Gr. μικρός + σκπέω} *'микроскооб', 'бичил дуран'*

Микрофон |mikrofon|{< Rus. *микрофон* < Ger. *mikro 'жижиг'* + *phone 'микрофоон', 'дуу авиа'* < Gr. *μικρός* + *φωυη*} *'дуу өсгөгч'*

Мил |mili|{< Rus. *миля* < Eng. *mile*} *'мийл'* (1.693 м-тэй тэнцэх уртын хэмжээ)

Милаа- |miliya / maliya| *шинэ сүм дуган, хувцас хунар, цол хэргэм зэрэгийг баярлан тэмдэглэх* || Ж= *'Burqan-qaldun-i manaǧar büri* ***maliāsuǧai'*** [Бурхан халдуныг өглөө бүр милаасугай](MNT 103) || Kha. *milā-*, Ord, Bur. *milā-*, Oir. *melā-*

Мина |mina|{< Rus. *мина* < Fr. *mine*} *'мийнь', 'тэсэрэх цэнэг', дэлбэрэх хэрэгсэл'* (дэлбэлэх зорилгоор газарт булж, усанд сойдог хэрэгсэл)

Минаа |minaγ-a| *'машуур'* || Ж= *'je-yin nökör, je'ērde-yin* ***mina'ā*** *bolju'* [Зэ-гийн нөхөр, зээрдийн ташуур болж](MNT 255) // *mina'a* 'fouet' (HY M75) // *mina* 'нагайка' (IM M117) // *minā* 'плеть' (Mu.236, IM 441) // *mina* 'whip', 'scourge' (Ras.187 C19) // *mina'a* 'fouet' (HY M75) || Bur. *minā*, Ord. *milā*

Мянга(н) |mangya|{< miŋ-yan} *'10 x 100 = 1000'* || Cf. AT *miŋ* 'тысяча' (ДТС 344), Uig. *miŋ* 'thousand' (Schwarz, 920), *m'ayan* '1000' (Щербак 2005, 40); Man. *miŋan* 'тысяч' (Цинциус I:537) || Ж= *'jayayatu qayan soγurqaju qoγar mingγan sülüs .мянга бэлгэсэн ариун'* [Залат хаан сөөрхож хоёр мянган сүхэс чау өгсөв алхэ](Jig. 30) // *naiman ja'ün miŋan* 'восемьсот тысяч' (Mu. 244) // *manqal* 'tausend' (LH 70) // *miŋan* 'thousand' (Ras.201 B14) || Kha. Ord. *miŋgan*, Bur. *miŋgan*, Oir. *miŋγan*

Мянгат |mingdat|{< Tib. *min grags*} *'нэр алдар'* (Энэ нь анхандаа бурханы шашины өндөр цол хэргэмийг заасан нэр байсан бөгөөд орчин үед аливаа өндөр албан тушаалтаныг ерөнхийд нь нэрлэх болжээ) || х о р ш : *'миндаг шүмэгэл'* || Kha. *miŋdag*, Ord. *mindak*

Мянгас |mindasu|{< Chin. *miàn zi*} *'төрсөн утас'* (хүр хорхойн шүлсээр хийсэн торгон утас) || х о р ш : *'торго .миндас'* || Kha. *miŋdas*, Ord. *mindasu*, Bur. *mindahan*, Oir. *mindᵃsᵘn*

Минерал |mineral|{< Rus. *минерал* < Fr. *mineral*} *'минерааль'*, *'эрдэс'*

Минтүүз |mintuja|{< Chin. *miàn tiáo zi*} *нарийн хэрчсэн гурилтай шөл* || Kha. *mintüd*

Минут |minut|{< Rus. *минута* < Fr. *minute* < Lat. *minutus*} *'миҥууд'* (нэг цагийг 60 хувааснаы нэг хувь буюу 60 секундтэй тэнцэх цаг хугацааны нэгж)

Минчүү |minčü|{< Chin. *miàn chóu*} *нэгэн зүйл торгомсог даавуу* || Kha. *miŋtšü*

Мисир |misir|{< Uig. *misir* < Arab. *miṣrī*} *'Египет'* || Ж= *'Il qan-u čerigüd Misir-ün jüg morilabasu bida endece morilaju qamsaγa'* [Ил хааны цэрэгүүд Египетийн зүг мордвол бид энэтэх мордож нийлэе](Ar. II)

Мисс |miss|{< Rus. *мисс* < Eng. *miss*} *'мийс'*, *'гоо бүсгүй'*

Мита- |mita| *'цохорох'*, *'шантрах'* гэсэн утгыг хадгалсан язгуур. Энэ язгуураас *mital-* [mita-l] 'митал-', *mitara-* [mita-ra] 'митар-' гэсэн үндэсүүд үүсчээ. || Ж= *'tüyimer yal tülegen-eče ülü mitayu'* [гал түймэр, гай зовлонгоос үл шантарна](Taq. 57b) // *'mital ügegüi-e ulus quriγaγsan'* [улс ороноо шантаралгүй тохинуулсан](Qqor. II:17) || Ord. *mita-*

Митар- |mitara|[= mita-ra] *'нилэх'*, *'шантрах'* || *mitarasi-ügei* 'митаршгүй' || х о р ш : *'митарч шантрах'* || Kha. *mitar-*, Ord. *mitara-*

Мичид |mečid|{< Skr. *mecida*} *'од'* (сарны зурхайн 28 одны нэг) || х о р ш: *'од мичид'* || Kha. *mitšid*, Ord. *metšit*

Миш*- |misi|{< *mõši-} *'инээ-'* гэсэн утга бүхий язгуур. Энэхүү язгуураас *misilje-* [misi-lje] 'мишилэ', *misiye-* [misi-ye] 'мишээ-' гэх мэт үг үүсчээ.

Мишиха |mišiq-a|{< Hebr. *messiah*} *'тослогдсон'* (загалмайн шашины ёсонд их эрдэмтэй санваартан хүн өндөр дээд хэргэм хүртэхэд тос түрхэх ёсон байжээ. Нестор шашин уйгураар дамжин Монголд дэлгэрсэн тэр үед энэ үг нэвтэрчээ) || Ж= *Mišiq-a-in nom-dur oratuγai ketejü'* [Мишиха (загалмайтаны шашин)-гийн номд ортугай хэмээж](Ar. II)

Мишээ- |misi-ye|{< mõši-ye} *'инээмсэглэх'* || Ж= *'tergel saran metü amur-lin delgeregsen linqu-a metü temdegtei-e mõšiyejü sayuqui-yi üjejü'* [тэргэл саран мэт

амирлан дэлгэрсэн линхуа адил илэрхийеэ мишээж суухыг үзэж](Burq. 61a) // ***mōsiyekūi*** *čirai-ban ülü adügülün'* [мишээх царайгаа үл үзүүлэн](Taq. 35b) || Kha. *mišē-* Bur. *mešeyē-*, Ord. *miš'ē-*, Oir. *mišā-*

Могой |moγai| *урт нарийхан биетэй, мөлхөгч хорхой* || Ж= ***moγai-a*** *jayuγdaγsan quruγun-i oγtolun yadabasu amin-daγan kürtemüi'* [могойд хазуулсан хуруугаа тайрч эс чадваас аминдаа хүрнэ](Sub. VIII:15b) // *'čadqulaŋ* ***mōgai*** *γa širğu asu ülü bolqu berke šiğui'* [цадхалан тогой ч шургаж үл болох бэрх шугуй] (MNT 102) // *moqai* 'serpent' (HY M76) // *ala* ***moγai*** [пестрая змея](Mu. 97) // *moγā* 'змея' (IM 442, IM M150) // *moγai* 'Schlange' (LH 70) // *moγa* 'змея' (Qaz. Po 202) / *mūqā* 'Serpent' (Qaz. Pe 567) // *moqai* 'snake' (Ras.199 C13) // *moγāi* 'snake' (Zir.116) || Kha. *mogoĭ*, Bur. *mogoj*, Ord. *mogō*, Oir. *mogā*

Мод |modun|{< **mō-dun*} *урт иштэй, навч болон шилмүүстэй олон наст ургамал* || Cf. Man. *mō* 'дерево' (Цинциус I:540) || Ж= *'čambu* ***modun-u*** *següdertür sayuju'* [замба модны сүүдэрт сууж](Burq. 40b) // ***modun-u*** *geši'ūd quguru tatalaju'* [модны мөчир хуга татаж](MNT 132) // *modun* 'дерево' (Mu. 237 / IM 442) // *mōdun* 'wood', 'timber' (Zir.116) // *modon* 'дерево' (IM M150) // *modun* 'tree' (Ras. 202 A16) || х э л ц : *'модоо барих'* (хоосорох) || х о р ш : *'мод бут', 'ой мод'* Kha, *mod*, Ord. *mudu*, Bur. *modo*, Oir. *mod*n*, Mngr. *mōdi*

Мод |moda|{< Rus. *мода* < Fr. *mode*} *'моод', 'загвар'* (Энэ нь зөвхөн хувцасны хэлбэр загварын тухайд хэрэглэгдэнэ

Модгалавана |modgalavana|{< Skt. *maudgalyāyana*} *'өөрөө төрсөн Модгалын хүвүүн', 'Молон тойн'*. (Шагжамуни бурханы дотоно шавийн нэг) || Ж= ***mogdalayana*** *teriğuten arqand-tu ber jobolang boluγsan buyu'* [модгалавана тэргүүтэн архадад зовлон болсон буюу](BT 162b)

Модель |model|{< Rus. *модель* < Fr. *modele* < Lat. *moulus*} *'модээл', 'үлгэр загвар', 'загвар өмөсөгч'*

Модем |modem|{< Rus. *модем* < Eng. *modem* (**mo**dulator + **dem**odulator)} *'модээм'* (Компьютер бүр тухайн орчиныхоо сүлжээнд бүрэн холбогдож чаддаггүй тул телефон холбоо зэрэгийг ашиглан аналог болон тоон дохиог хөрвүүлдэг тусхай төхөөрөмж ашигладаг. Түүнийг *'модем'* гэнэ.

Молекул |molekel|{< Rus. *молекула* < Fr. *molecule*} *'молекүүл', 'бодисын бусцар хэсэг'*

Молл |moll|{< Eng. *mall*} *'моол', 'худалдааны төв'* (арилжаа худалдаа, үзвэр үйлчилгээний олон газарыг багтаасан цогцолбор төв)

Молор |molur|{< Pers. *bulur*} *'болор чулуу'* || ***'bolur*** *saba-dur dabtamal altan tüsürügsen metü'* [болор савыг давтмал алтаар дүүргэсэн мэт](Burq. 45) || || Kha, Ord, Bur. *molor*, Oir. *mol*r*

Монгол |mongγol| «*Монгол*» гэдэг нэрийн гаралын тухай асуудал эртнээс нааш гадаад, дотоодынхоны анхааралыг ихээхэн татсаар иржээ. Тухайлвал, *'Хар татаарын хэрэгийн товч'* (1237) хэмээх түүхэн сурвалж бичигт «*монгол*» уг үгийг *'мөнгө'* гэдэг үгээс гаралтай гэж тэмдэглэсэн байдаг байна. Хожим XVIII зууны үед зохиосон *'Гангын урасхал'* (1725) хэмээх сурвалж бичигт «*мон*», «*гол*» гэсэн хоёр үгээс бүтсэн гэж дурдсан байдаг бол Рашипунцагийн

зохиосон *'Балор эрих'* (1775) хэмээх зохиолд *'мундашгүй* хэмээх үгийн эхний *«мун»*, *«гал улас»* хэмээх үгийн доторхи *«гал»* гэсэн хоёр үгээс бүтсэн гэж дурджээ.

Эрдэм шинжилгээний хүрээнд гэвэл, нэрт эрдэмтэн Д. Банзаров одоогийн Өвөр Монголын нутагт байгаа *Мон* уулын нэртэй холбож үзсэн бол японы монголч эрдэмтэн Широ Хаттори *'мөнх'* гэдэг үгтэй, хятадын эрдэмтэн Доронотив *'мөнх гал'* гэдэг үгтэй. Элдэнтэй, Оюундалай, Асаралт нар *'мөнх + тэнгэр + гал'* гэдэг үгтэй. Их мянгаадай Иринчин *'мон'* + *'уул'* (олон тооны дагавар) гэдэг үгтэй, Цэцэнмөнх *'мон'* + *'хор'* гэсэн үгтэй тус тус холбож үзсэн байна. Бас зарим судалаачид монгол үндэстэнийг зориудаар доромжилон *'мангас'* гэдэг үгтэй холбож үзсэн өрөөсхөл хандлага ч бас бий. Мөн *'монгол'* гэдэг үгийг тэмдэглэсэн хитад ханзын зарим салаа утгыг харгалзан *'умар зүгийн бүдүүлэгүүд'* гэж тайлбарлах нь бий. Энэ мэтчилэн уг үгийн гаралын талаар олон янзын санал гарсан хэдий ч одоо хүртэл нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нэгдмэл санал гараагүй хэвээрээ байна. (Энэхүү материалыг доктор Э. Пүрэвжав бэлтгэсэн болно.)

Т у с х а й с у д а л г а а : Д. Банзаров, О происхождении имени *'монгол'*, *'Собрание сочинений'*, М., 1955, 167-174 // Намжилцэвээн, *'Монгол'* гэдэг нэрийн тухай, Уб., 1959; Ч. Хасдорж, *'Монгол'* гэдэг нэрийн тухай, Уб., 1960

Монди |mongdi|{< Tib. *mo'dre*} *'эм чөдхөр'* (эдүгээгийн ярианы хэлэнд хөнгөн хараалын үгээр хэрэглэгддэг)

Монитор |monitor|{< Eng. *monitor* < Lat. *monitor*} *'монитоор'* (хинах дэлгэц)

Мониторинг |monitoring|{< Eng. *monitoring*} *'монитооринг'*, *'орчины хиналт'*, *'хөндлөнгийн хиналт'*

Монополь |monopol|{< Rus. *монополия* < Eng. *monopoly* < Lat. *monopōlium*} *'монопоол'* (давуу эрх эдлэх, дангаар ноёрхох)

Монтаж |montaž|{< Rus. *монтаж* < Fr. *montage*] *'мантааж'* (кино халис, зураг дүрс зэрэгийг эвлүүлэх)

Монш |mongsin|{< Tib. *rmongs zhen*} *'сармагчины зулзага'* (энэ үг монгол хэлэнд *монди*-ийн нэгэн адил хөнгөн хараалын үгээр хэрэглэгддэг)

Моргеж |morgeji|{< Rus. *моргаж* < Eng, Fr. *mortgage*} *'мооргеж'*, *'барьцаат зээл'* (орон сууцны томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, тэдгээрийг худалдах, худалдан авах үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх нэг хэлбэр)

Морил- |morila| *'морд-'*, *'хөдөл-'* || Ж= *'Il qan-u čerig-üd Misir-ün jüg* ***morilabasu*** *bida endeče* ***morilaju*** *qamsaya'* [Ил хааны цэрэгүүд Египетийн зүг мордвол бид эндээс мордож нийлэе](Ar II) // *Qotula qahān bolu'ād, Qada'āntaiši qoyar Tatar irgen-dür* ***morilaba*** [Хотол хаан болоод Хадаан тайш хоёр татаар иргэнд морилов](MNT 58) || Kha, Bur. *moril-*, Ord. *morilo-*

Мотор |motor|{< Rus. *мотор* < Ger. *motor* < Lat. *motor*} *'мотоор'*, *'хөдөлгүүр'*

'der allmächtige Gott' (LH 70) // *mõngke* 'eternal', 'everlasting' (Ras.198 A2 || х о р ш : *'ашид мөнх'*, *'өнө мөнх'*, *'үүрд мөнх'* || Kha. *möŋx^{a}ó*, Ord. *möŋ^{a}xõ*, Bur. *müŋxe*, Oir. *mõŋk^{a}*

Мөөг |mõgü| *дооД ургамал* (ой шугуй, хээр талд ургадаг навч цэцэгтүй, шүхэр мэт хэлбэртэй бактерийн төрөлийн ургамал) || Cf. Chin. *mó gu* || Kha, Oir. *mõg*, Ord. *mõgõ*, Bur. *mõge*

Мөөлд- |mõgeled| *'дэлд-'*, *'цохи-'* || Ж= *'Temüjin Burqan de'ēre-če bawūju, e[b]če'ū-bēn mõ'ēledčü ügülerün'* [Тэмүжин Бурхан халдун дээрээс бууж, чээжээ дэлдэн үтүүлэрүүн](MNT 103)

Мөр |mõr| *'газарт үлдсэн хөлийн улны ор'*, *'зам'*, *'замнал'* || Ж= *'ba urida mõr jasan yabusuγai kemen õgüleldübei'* [Бид өмнөх замаа засан явая хэмээн үтүүлэлдэв](Burq. 15b) // *'bidan-u qaǧačaqu ǧaruǧsan* ***mör*** *mütkin yabuju'* [бидний салж одсон мөр мөшгин явж](MNT 172) // ***mör*** *dēre bosqaqsan balγasun* [выстроенный на улице дом](Mu.239) // *mör* 'путь' (IM. 442, IM M150) // *mör* 'way', 'road' (Ras.202 A1) // *mõr* 'way', 'road', 'path' 'Kund.148) || х о р ш : *'ул мөр'*, *'зам мөр'* || Kha, Ord, Oir, *mõr*, Bur. *mür*

Мөргө- |mõrgü| *'толгойгоороо цохих'*, *'мэргүүнээ бөхийх'* || Ж= *'kölgen-ečegen bayuju aday-tur inu* ***mörgübei'*** [хөлгөнөөсөө бууж хөлд нь мөргөв](Burq. 32b) // *mõrgübe tengridü* [преклонился перед тенгри](Mu. 240) || х о р ш : *'мөргөж сөгдөх'* || Kha, Ord. *mörgö-*, Bur. *mürge-*, Oir. *mörg^{a}-*

Мөргөл |mõrgül|[= mõrgü-l] *'сүсэглэн мөргөх үйл'* || Ж= *'qonsim Bodistv-un nom Tar-a-yin* ***mõrgül'*** [хоншим бодисадвагийн ном Тара-гийн мөргөл](Bud 1a) || х о р ш : *'эргэл мөргөл'* || Kha. *mörgöl*, Ord. *mörgül*, Bur. *mürgel*, Oir. *mörg^{a}l*

Мөс I |mölsün|{< *mõl-sün} *хөлдөж хатуурсан ус* || Ж= *'nimgen* ***mölsün*** *deger-e gečkikū šitū emigegdekūi kemejügü'* [нимгэн мөсөн дээр гишгих шиг айна хэмээжээ](Taq. 6a2) // *'e'ülen arilju, eke naran üjegsen metü* ***mölsün*** *arilju'* [үүл арилж, эх наран үзсэн мэт мөс арилж](MNT 238) // *mölsün* 'glace' (HY M76) // *mölsün* 'лёд' (Mu. 171) // *mölsün* 'glace' (Ist. 55) // *mölsün* 'Eis' (LH 70) // *mölsün* 'ice' (Ras.198 A21) || х о р ш : *'мөс цас'* || Kha. *mös*, Ord. *mösü*, Bur. *mülhe(n)*, Oir. *mös^{a}n*

Мөс II |mösü| *'сумны иш'* || Ж= *'nijī'el* ***müsüd*** *quǧuludqun ke'ejü ögbe'* [нэг нэг сумыг хугалагтун хэмээн өгөв](MNT 19)

Мөх- |mökü| *'сөнөх-'*, *'усдах'*, *'үхэх'*, *'сүйрэх'*. Тус язгууртаас *mökügül-* [mökü-gül] *'мөхүүл'*, *mökül* [mökü-l] 'мөхөл', *mökürі-* [mökü-ri] 'мөхөр' гэсэн үг үүсчээ. || Ж= *'яс сөнөж, отог* ***мөхөх*** *аюул тохиолддог зовлонг санахад үнэхээр бэрх'* (Б. Ринчен, Заан залуудай) || Kha. *mõxə-*, Ord. *mõ^{a}xõ-*, Bur. *müxe-*, Oir. *mök-*

Мөхөл |mökül|[= mökü-l] *'сөнөл'*, *'сүйрэл'* || Ж= *'энэхэн дэлхий дахинаараа* ***мөхөлгүй*** *мандсаар байхыг'* (Д. Намдаг, Цаг төрийн үймээн) || х о р ш : *'мөхөл сэхэл'*, *'үхэл мөхөл'* || Kha. *möxöl*

Мөхөр |mökürі|[= mökü-ri] *'сөнө-'* Энэ үгээс *mökürigül-* [mökürі-gül] 'мөхөрүүл' гэсэн нийлмэл бүтэцтэй үг үүссэн байна

Мөхөрүүл- |mökürigül| х у у ч : *'сөнөө-'*, *'гэсхээ-'* || Ж= *'türūn-ü dobtulǧān-dur ese ege'ērügsen kü'ūn-i* ***mökörі'ūlüye'*** [түрүүний довтолгоонд эргэж

оролцсон хүнийг гэсхээе](MNT 153) // *'tus qan-iyān ğartağsad haran-i* ***mököri-'üldekün'*** [өөрийн хааныг гардан барьсан ардуудыг цаазлагтун](MNT 149)

Мөч |mөči| *'мочир', 'салаа'* гэсэн үгийн язгуур. Энэ язгууpаас *möčilge* [mөči-lge] 'мөчлөг', *möčir* [mөči-r] 'мөчир' гэсэн үг үүсчээ. || Ж= *'**Möči**-bedü'ün irebei'* [Мөч бүдүүн ирэв](MNT 120-22) || х о р ш : *'ye мөч'* || Kha. *mötšĭ*, Ord. *mötšö*, Bur. *müse*, Oir. *mötš*

Мөчир |mөčir|[= mөči-r] *'модны салаа'* || х о р ш : *'салаа мөчир'* || Kha. *möčir*, Ord. *mötšür*, Bur. *mušer*, Oir. *mötš'r*

Мужаан |muǰiyang|{< Chin. *mù jiang*} *'модны дархан'* || Kha. *mudžāŋ*, Ord. *mudžaŋ*

Мулт* |multu| *'мултар-', 'сугар-'* гэсэн үгийн язгуур. Тус язгууpаас *multul-* [multu-l] 'мултал-', *multura-* [multu-ra] 'мултар-' гэх мэт үг үүссэн байна. || Kha. *multŭ*, Ord. *multu*, Bur. *multa*

Мултал- |multul|[= multu-l] *'шувтла-', 'майл-'* || Ж= *'hünür minü hünüsčü yabu ke'ēn čamča-ban **mültülǰü'*** [үнэрийг минь үнэрлэж яв хэмээн цамцаа мулталж](MNT 55) || Kha, Bur. *multal-*, Ord. *multul-*, Oir. *mulᵊl-*

Мун* |mun| *'мунхаг'* гэсэн утгыг хадгалсан анхдагч язгуур Энэхүү язгууpаас *mungqa-* [mung-qa] 'мунха', *muntani-* [mun-tani] 'мунгина-', *munggina-* [muŋ-gina] 'мунгина-' гэх зэрэг үндэс үүсч, бас тэдгээрээс цааш олон үг салаалан задарчээ. || Ж= *'munuγsan mör'* [балархай мөр](Burq. 40b)

Мунаг |munaγ|{< Tib. *mun nag*} *'харанхуй', 'мунхаг'* Орчин үеийн монгол хэлэнд *'зөнөг', 'буруу зөнөсөн'* гэсэн утгаар хэрэглэгддэг. || х о р ш : *'мунаг зөнөг', 'мунаг тэнэг'* || Kha, Oir. *munag*, Ord. *munuk*

Мунтани- |muntani| х у у ч : *'мунгина-', 'мэгдэж сандар-'* || Ж= *'sayin nökör **muŋtaniǰu** ayisun aǰu'ū'* [сайн нөхөр минь мэгдэж сандаран ирсэн ажгуу](MNT 93)

Мунха* |mungqa|[= mun-qa] *'мунхаг'* гэдэг үгийг үүсмэл язгуур. Энэхүү язгууpаас *mungqaγ* [muŋ-qa-γ] 'мунхаг', *mungqara-* [muŋ-qa-ra] 'мунхар' зэрэг үйл үг үүсчээ.

Мунхаг |mungqaγ|[= mun-qa-γ] *'тэнэг', 'маанаг', 'гэнэн'* || Ж= (***mungqaγ**-ud-un dumda bayasun nayadulčayad merged-ün emün-e emigen bultariyčin ... deger-e šidütü üker bolai'* [мунхагуудын дунд баясан наадагчид, мэргэдийн өмнө эмээн булгагчид ... дээрээ шүдтэй үхэр болой](Sub III:4a) // *mungqaq* 'peu intelligent, stupide' (HY M76) // *munγaq* 'невежественный' (IM 442) || х о р ш : *'мунхаг харанхуй', 'тэнэг мунхаг', 'эргүү мунхаг'* || Kha. *muŋkᵊag*, Ord. *muŋxak*, Bur. *muŋxag*, Oir. *muŋχg*

Мур* |mur| 'муруй' гэсэн утгыг хадгалсан анхдагч язгуур. Энэ язгууpаас *murči-* [mur-či] 'мурч', *muriγana-* [muri-γana] 'муригана', *murilǰa-* [muri-lǰa] 'мурилз', *murui* [muru-i] 'муруй' гэсэн үгс үүсчээ.

Муруй |murui|[= mur-ui] *'махир', 'шулуун бус'* || Ж= *tübšin bolba **murui*** 'кривое стало прямым' (Mu. 357)) // *moroi* 'искривленный' (IM M150) // *murū* 'кривой' (Mu. 241) || х о р ш : *'муруй саруй', 'махир муруй'* || Kha. *murī*, Ord. *murᵊī*, Bur, Oir. *muŕū*

Мурчи- |murči-|[= mur-či] *'мурий болох'* гэсэн үг бөгөөд түүнээс *murči-yana-* [mur-či-yana] 'мурчигана', *murčiyar* [mur-či-yar] 'мурчгар', *murčilja-* [mur-či-lja] 'мурчилз-' гэсэн нийлмэл бүтэцтэй үгс үүссэн байна.

Мусульман |musulman|{< Rus. *мусульманин* < Turk. *musulman* < Pers. *muslimān* < Arab. *muslim*} *'мусулмаан'* (ислаамын шашинтан)

Мутар |mutur|{< Skr. *mudrā*} *'тэмдэг'* (*'гар'*-ын хүндэдхэсэн нэр) || Ж= *'yurban erdinis-ün belge-yin **mutur-un** qurɣun'* [гурван эрдэнийн бэлгийн мутарын хуруу](Tara 10) || Kha. *mutar*, Ord. *mutur*, Oir. *mut^{u}r*

Муу |mayu / mayui / mayun| *'сайн'* гэдэгийн эсрэг утгатай үг. // Pl. *mayus*. Энэхүү язгуураас *mayujira-* [mayu-jira] 'муужир-', *mayula-* [mayu-la] 'муул-', *mayuqan* [mayu-qan] муухан', *mayusiya-*, [mayu-siya] 'муушаа-' гэх мэт үгс үүсчээ. || Ж= *'**mayui** kümün ed-tü bolbasu ele düledte **mayui** aburi-tu boluyu'* [муу хүн баяжвал улам муу авирт болно](Sub. III:1b) // *'dotora minu **mawūi** buyu'* [дотор минь муу болов](MNT 68) // *ma'u* 'mauvais' (HY M74) // ***mayui*** 'schlecht' (LH 69) // ***ma'ū** kibe tůndü* [причинил ему вред](Mu. 234) // *ma'ū* 'скупой', 'дурной' (IM 441) // *mau* 'bad' (Ras.203 A19) // *mū* 'плохой' (Mu. 242) || хорш : *'муу муухай'* || Kha, Ord, Bur, Oir. *mū*

Муур |muur|{< Chin. *máo er*} *мийн овогийн гэрийн тэжээвэр амьтан* || Kha, Bur. *mūr*

Муутуу |muutuu|{< Chin. *mú tū*} *олосоор хийсэн нэгэн зүйлийн зөөлөн цаас* || Ж= *'нэг бага цонхыг хоёр давхар **муутуугаар** битүүлэн нааж'* (Д. Нацагдорж, Ламбугайн нулмис) || Kha, Oir. *mūtū*

Мух* |muqu| *'мухар'* гэсэн утгыг хадгалсан язгуур. Энэхүү язгуураас *muquyar* [muqu-yar] 'мухгар', *muqulja-* [muqu-lja] 'мухалз-, *muquyi* [muqu-yi] 'мухуй-', *muqur* [muqu-r] 'мухар' гэх зэрэг үгс үүсчээ.

Мухар |muqur|[muqu-r] *'мохоо', 'үзүүргүй', 'уг'* || Cf. Turk. *mokur* 'тупой' (Радлов, IV:2121) || *'**muqular** qo'ā hüker yeke gerlüge de'ēre ergüjü, köljü jikdüjü'* [мухар гоо үхэр их гэр дээр өргөж, хөллөн зүдхэж](MNT 121-12) || Энэхүү үүсмэл үгээс *muqurda-* [muqu-r-da] 'мухард-', *muqurla-* [muqu-r-la] 'мухарла-' гэх мэт нийлмэл бүтэцтэй үгс үүсчээ. || х о р ш : *'мухар сохор'* || Kha, Bur. *muxar*, Ord. *muxur*, Oir. *mux^{u}r*

Музей |muzei|{< Rus. *музей* < Fr. *musée* < Lat. *museum*} *'музий'* (үзмэрийн газар)

Мүми |mumi|{< Rus. *мумия* < Ger. *Mumie* < Lat. *momia* < Arab. *mūmiya*} *'мүүми', 'зандаршуулсан шарил'*

Мүндэ |münde/munda| *'мөн', 'харин', 'түүнчилэн'* || Ж= *'**mün-de** Tarğutai-yi ende-če talbiju ilējü'* [мөн Таргудайг эндээс тавиж явуулж](MNT149)

Мүү |mü|{< Chin. *mǔ*} *10 пунтай тэнцэх талбайн нэгэж тариан талбайг хэмжих нэгэж*

Мэгд- |megde| *'айж сандарах'* || Ж= *'arslan-u dayun-i sonosuysan ünegen-dür adali ayuju **mengdejü** nigen nigen-ečegen buruyuyilbai'* [арслангийн дуу соносон үнээ шиг мэгдэн бие биеэсээ салж зугатана](Burq. 60b) || х о р ш : *'айж мэгдэх', 'сандарч мэгдэх'* || Kha, Oir. *megd^{u}-*, Ord, Bur. *megde-*

мэргэн ухааныг дээдэлдэг байсан тул энэ үгний нэрд олонтаа хэрэглэдэг байсаныг МНТ-ноос харж болно. Ж= *Qoridar-mergen* (MNT 2), *Borjigidai-mergen* (MNT 3), *Dobun-mergen* (MNT 6), *Bargudai-mergen* (MNT 8), *Qorilardai-mergen* (MNT 8) || х о р ш : *'цэцэн мэргэн'*, *'мэргэн түрсэн'* || Kha, Ord, Bur. *mergen*, Oir. *merɣ'n*

Мэс |mes| *'ирт зэвсэг'* // Pl. *meses* (Burq. 55a) || Ж= *'yar-tayan ildü* ***mese-yi*** *bariysan'* [гартаа илд мэс барьсан](Burq.65a) // *'üge ayalyu inu* ***mese****-dür adali'* [үг аялгуу нь ирт мэсийн адил](Chimeg 12b) // *'tede kiliyle'ēsü ö'ēr-ün* ***mese****-dür-iyēn ükükün'* [тэд хилигнэвээс өөрийн мэсэндээ үхэх](MNT 270) || х о р ш : *'хутагч мэс'* || Kha, Oir. *mes* Ord, Bur. *mese*

Мэх |meke| *'арга заль'*, *'ов'* || Cf. Man. *meke* 'обман' (Цинцинус I:566) || Энэхүү изгууралс *mekele-* [meke-le] 'мэхлэ-', *meketü* [meke-tü] 'мэхэт' гэх мэт үг үүсчээ. || х о р ш : *'арга мэх'*, *'заль мэх'*, *'ов мэх'* || Kha. *mex*, Ord. *meᵏxe*, Bur. *mexe*, Oir. *mekə*

Мягман үз Мигман
Мягмар үз Мигмар
Мялаа- үз Милаа
Мянга үз Минга
Мяндаг үз Миндаг
Мяндас үз Миндас
Мянтууз үз Минтууз
Мятар- үз Митар-

Н

Наа* |naγa| *'нааш'* гэдэг үгийн анхдагч язгуур. Тус язгууpаас *naγaysi* [naγa-(γ)si] 'наашаа', *naγadu* [naγa-du] 'наад', *naγaγur* [naγa-γur] 'наагуур', *naγana* [naγa-na] 'наана' гэх мэт зүг чиг заасан үгс үүсчээ.

Наа-* |niγa| *'наалдуулах'*, *''нийлүүлэх* || Ж= *'Jamuqa hura'ū-yin qoyar eber **ni'āju**, nükelejü, dawūtu yor-iyān Temüjin-e ögčü'* [Жамуха бирууны хоёр эвэр нааж, нүхлэж хийсэн дуут сумаа Тэмүжинд өгч](MNT 116) // *niγāba yamayl* [склеил вещь](Mu. 258) || Kha, Ord, Oir. *nā-*, Bur. *ńjā-* Dag, Mngr. *nlā-*

Наагуур |naγaγur|[= naγa-γur] *'наад талаар'* (*'цаагуур'* гэдэгийн эсрэг утгатай үг) || Ж= *'нарийн хөгжимийг дуугаргаж, **наагуур** цаагуур нь бүжиглэе дээ'* (Ц. Нацагдорж, Шансонет) || Kha, Ord, Bur. *nāgūr*

Наад |naγadu|[= naγa-du] *'цаад'* гэдэгийн эсрэг утгатай үг (үгүүлэгч этгээдэд ойр тал) || Ж= *'гандангийн **наад** хүр уруу бууж ирмэгц, уран тачаангуйн хурц илдийг боловсруулахын эрдэмийг судалсан авилгач хүүхэн Иүй Бай-хуа хэмээх Цэрэнлхам'* (Д. Нацагдорж, Ламбугайн нулмис) || х о р ш : *'наад цаад'* || Kha, Ord. *nād*, Bur. *nāda*, Ord. *nādu*

Наад- |naγadu| *'цэнгэлдэх'*, *'зугаацах'*. Энэ язгууpаас *naγaduγči* [naγadu-γči] 'наадагч', *naγadum* [naγadu-m] 'наадам', *naγaduγai* [naγadu-γai] 'наадгай' гэх мэт үгс үүсчээ. || *'tere metü qubilγan-u **naγadun**-iyar naγadču'* [тэр мэт хувилгааны наадамаар наадаж](Burq. 53b) // *'küčüten qabutan čeri'üd anu **na'ādum** metü busaniqdabai'* [хүчтэн хавтан цэрэгүүд нь наадам мэт буснигдав](KMQB A4b) // *'eke-yügen dergede sitaračaju **naγadun** bükü-dür'* [эхийнхээ дэргэд шатардан наадаж байхад](ET 75b) // *čeügen nādba* [играл в поло](Mu.132) // *nāduba* 'шутил' (IM 442) // *čeügen nātba* 'играл в поло' (Mu. 132) // *nātba* 'spielte' (LH 71) // *nādu* 'play' (Zir.118) // *nāduba* 'шутил' (IM 442) || Kha, Oir. *nādɒ-*, Ord. *nādu-*, Bur. *naada-*

Наадам |naγadum|[= naγadu-m]{< *naγadu-n*} *'өргөн олоны баяр цэнгэл'* || Ж= *'gür ulus **naγadun** čenggen-iyer nasu aburi-da nasulan jiγaγtuγai'* [гүрэн улас наадам цэнгэлээр насан туршдаа наслан жаргатугай](BT 167a3) // *'güčüten qabutan čeri'üt anu **na'adum** metü busaniqdabai'* [хүчтэн хавтан цэрэгүүд нь наадам мэт буснигдав](KMQB A4b) // *nādun* 'игра' (Mu. 247, IM M151) // *nādum* 'забава' (IM 442) // *nādum* 'шутка' (IM 151) // *nâdanči* 'player' (Ras.203 C3) || *'баяр наадам'*, *'найр наадам'*, *'тоглоом наадам'* || Kha, Ord. *nādam*, Bur. *nādan*, Oir. *nād*m*

Наана |naγan-a|[= naγa-na] *'цаана'* гэдэгийн эсрэг утгатай үг (*'наад талд'*, *'өмнө'* гэсэн утга илдхэнэ) || Ж= *'гүүн зэлний **наана** хувингаа тавиад эргэж харан зогсож байгаа хүүхэн нүдэнд минь тусмагц бүх юм мартагдаж бараг л гүйх шахан тэр зүг алхав'* (Ч. Лодойдамба, Солонго) || х о р ш : *'наана цаана'* || Kha, Ord, Bur. *nāna*

Нааш |naγaysi|[= naγa-(γ)si] *'цааш'* гэдэг үгийн эсрэг утгатай үг. (үгүүлэгчийн зүг хандсан утга илэрхийлнэ) || Ж= *'олон адуу нь ... энд тэнд*

хэвтэж, хол ойр зохсож, нааш цааш явж байна' (Д. Нацагдорж, Алуу манаад) || х о р ш : *'нааш цааш'* || Kha. *nāš*, Ord. *nāsi*, Bur. *nāša*, Oir. *nārān*

Навс |nabsa|{< Tib. *nab bzo*} *'өмөсхөл'* (бурханы гадуур нөмөргөх өмөсхөл)

Навч |nabčі| *мод, ургамалын мөчирөөс салаалан ургадаг хавтагай ногоон эрхтэн* || Cf. Man. *parči* 'лист' (Цинциус I:585) || Ж= *'delgeregsen linqu-a-yin* ***nabčin-dur*** *adali nidütü'* [дэлгэрсэн линхуатай адил нүдтэй](Burq. 17a) // ***nabčin*** *deledčü ba ülyaba modunāsa* [ударами сбивал с дерева листья](Mu. 244) // *nabčin* 'feuille' (Ist. 55) // *nabčin* 'leaf of a tree' || х о р ш : *'навч нахиа'*, *'навч цэцэг'* || Kha. *nawtš*, Ord. *nabši* , Bur. *nabša*, Oir. *naptšɨ*, Dag. *larči*

Нагаан |nayan|{< Rus. *наган* < Dutch. *Nagant*} *'нагаан буу'* (Бельгийн зохион бүтээгч Л. Наганы бүтээсэн хүрдэн дамартай гар буу)

Нагар |nagar|{< Skr. *dewanāgarī*} *эртний энэдхэг үсэг*

Нагарвай үз **Narbai**

Нагац |nayača| *'эхийн талын садан төрөл'* || Cf. Man. *nağasu* 'дядя по матери' (Цинциус I:576) || Ж= *'Olqunu'ūd irgen-dür* ***nağaču*** *nar-ača inu ökі ğuyusu' ke'ēn Temüjin-ni abu'ād yorčiba'* [Олхунууд иргэнд нагац нараас охин гуйя хэмээн Тэмүжинийг аваад явав](MNT 61) || Kha. *nağats*, Bur. *nağasa*, Oir. *nağ"ts"*

Нажид |najid|{< Tib. *nad byed*} *'зовлон'*, *'зүдүүр'* || х э л ц : *'нажидаа эдлэх'* (зовлон эдлэх)

Най* I |nayi| *'найз'*, *'найр'*, *'найд-'* зэрэг үгсийн анхдагч язгуур. Тус язгуураас *nayida-* [nayi-da] 'найд-', *nayija* [nayi-ja] *'найз'*, *nayir* [nayi-r] 'найр' гэх мэт үгс үүсчээ. || Kha. *nai*

Най* II |nai| *'найм'* гэсэн тооны нэрийн язгуур. Тус язгуураас *'найм'*, *'ная'* гэсэн тооны үг үүсчээ. Энэхүү язгуур нь *'найм'*-ын утгаа хадгалж байгаа жишээ эртний зарим дурасхалд хадгалагдан үлджээ. || Ж= *'aqui ulus-un* ***nayadayar*** *yeke ejen Ayurbarvada qayan-u ǰrlγ-iyar'* [ахуй уласын найм-дугаар их эзэн Аюурбарвада хааны зарлигаар](BT 166b4) || Ж и ч : Аюурбарвада буюу Буянт хаан бол 1311-1320 онд хаан ширээнд суусан Монголын *наймдугаар* их хаан билээ.

Найд- I |nayida|[= nayi-da] Энэ үг эртний бичигийн дурасхалуудад *'amaarhax'*, *'xardax'* гэсэн утгатай тохиолддог. || Ж= *'öbere-ün ed-iyen bara-yulqu-yin tulada öber-tegen kü* ***nayidaysan'*** [өөрийн хөрөнгөө барахын тул өөрөө өөртөө өшөөрхөн](Sub. IX:7b) // *'nidün-dür-iyēn ğaltu, ni'ūr-tur-iyān geretü ke'ēn Tayiči'ūd aqa de'ū-de'ēn teyīn ele* ***naidağdan*** *aǰu'ū'* [нүдэндээ галтай, нүүрэндээ гэрэлтэй хэмээн тайчуудын ах дүү нартаа тийнхүү атаархагдан ажгуу](MNT 82) *'Бурхан багшин арван зохионгуй үйл'* гэдэг зохиолд уул үг мөн ийм утгаар хэрэглэгдсэн бий.

Найд- II |nayida|[= nayi-da] *'итгэх'*, *'нийцтэй байх'* || Cf. Man. *najda-* 'надеяться' (Цинциус I:578) || Энэ үгээс *nayidaburi* [nayi-da-buri] найдвар', *nayidalγa* [nayi-da-lγa] 'найдлага', *nayidangγui* [nayi-da-ŋγui] 'найдангуй' зэрэг үг үүсчээ. || х о р ш : *'итгэж найдах'* || Kha. *naidɒ-*, Ord. *nāta-*, Bur. *naida-*, Oir. *nād-*

Найз |nayiǰa|[= nayi-ǰa] *'дотоно нөхөр'* Энэ үгээс *nayiǰala-* [nayi-ǰa-la] 'найзла-', *nayiǰarqa-* [nayi-ǰa-rqa] 'найзарх-' зэрэг үгс үүсчээ. || х о р ш : *'найз нөхөр' // 'анд найз'* || Kha. *naidz*, Ord. *naidža*, Oir. *nādz*

Наймаа |naimai|{< Chin. *mài mài} 'худалдаа', 'арилжаа'* || Ж= *'энэдхэг, төвөд, сартуулын худалдаачин шуугилдан, **наймаа** хийж'* (Б. Ринчен, Цогт тайж) || х о р ш : *'арилжаа наймаа'* || Kha, Bur. *naimā*, Oir. *māmā*

Найман |naiman|[= *nai-ma-n]{< *naj-ma-n} '2 х 4 = 8'* || Энэхүү тооны нэрийн анхдагч язгуур нь **naj*, үүсмэл язгуур нь *naiman* [naj-ma-n] 'найман'. Ж= *'aqui ulus-un **nayadayar** yeke eǰen Ayurbarvada qayan'* (BT 166b) *// 'minu ene buyan-iyar qamuy amitan **naiman** čöle ügei orod-ača tonilju'* [миний энэ буянаар хамаг амьтан найман чөлөөгүй ордоосоо зайлан одож](BT 156b6) *// 'širǧa ağtatan **naiman** mori[d] ger-ün dergede bayīǰu'* [шарга агттай найман морьд гэрийн дэргэд байж](MNT90) *// **naiman** nasulaba temēn* [верблюду исполнилось восемь лет](Mu. 244) || Kha, Bur. *naiman*, Ord. *nāma*, Oir. *nām*

Найр |nayir|[= nayi-r / nayira] *'зохилдоон', 'эе эв', 'цэнгээн'* Энэ үгээс *nayiray* [nayi-r-γ] 'найраг', *nayiramda-* [nayi-r-mda] 'найрамд-', *nayiral* [nayi-r-l] 'найрал', *nayirla-* [nayi-r-la] 'найрла-', *nayirsay* [nayi-r-saγ] 'найрсаг' гэх зэрэг олон үг салбарлан гарсан байна || Ж= *'yaǰar usun-u **nayir** ǰoqistu amun künesün'* [газар усны таарамж зохист хоол хүнэс](Hin. 23) *// kü'ün ǰaraǰu qamtu'ār ireǰü ali ba **nayir**-iyan ügülemü'* [хүн илгээж хамтаар ирж, аливаа эв эвээ хэлэлцмү] (KMQB A28) || х о р ш : *'найр наадам', 'найр наргиан', 'найр хурим', 'найр цэнгэл'* || Kha, Bur. *nair*, Ord, Oir. *nār*

Найраг |nayiraγ|[= nayi-ra-γ] *'яруу сайхан'* || Ж= *'lagsan **nayiray-iyar** čimegdegsen bey-e-tü'* [лагшин найрагаар чимэгдсэн биет](Burq.50) || х о р ш : *'шүлэг найраг'* || Kha. *nairag*, Ord. *nārag*

Найралд- |nayiraldu|[= nayi-ra-ldu] *'зохилдон нийцэх'* || Ж= *'kög dayun metü **nayiralduysabar'*** [хөг дуу мэт найралдсаар](Chang. 54)

Найрамд- |nayiramdu|[= nayi-ra-mdu] *'нөхөрлөх', 'эвлэлдэх'* || Ж= *'qan qaraču-yin **nayiramdayu** törü'* [хаан харцын найрамдуу төр](Taq.19a3) || Kha. *nairamdɒ-*, Ord. *nāramta-*, Bur. *nairamda-*

Найруул- |nayiraγul|[= nayi-ra-γul] *'эвлүүлэх', 'нийцүүлэх'* || Ж= *'qitad-un ayalyus-ača mongyol-un ayalyus-tur **nayirayulyan** orčiyuluyad'* [хитад хэлнээс монгол хэлэнд найруулан орчуулаад](Jig. 36) *// 'erdenis-iyer **nayirayuluysan** altan čimeg'* [эрдэнэсээр найруулсан алтан чимэг](Sub. IX:13b)

Нал |nal|{< Tib. *nal* < Skr. *nīla} 'улаан', 'нал эрдэнэ'* (улаан өнгөт эрдэнийн чулуу)

Нал- |nala| *'хажуулдах', 'хазайх'* Энэ язгуураас *nalayi-* [nala-yi] 'налай-', *nalanggi* [nala-ŋgi] 'наланги', *nalarqai* [nala-rqai] 'налархай', *nalayar* [nala-γar] 'налгар', *nalamayi-* [nala-ma-yi] 'налмай', *nalayu* [nala-γu] 'налуу', *nalčiyar* [nal-či-γar] 'налчигар' гэх мэт олон үг үүсчээ.

Налархай |nalarqai|[= nala-rqai] *өдхөн өвөс ургамалын налж унасан зай завсар* || Ж= *'ebesün-ü **(n)alurqai-bār** Onan müren ö'ēde möčgiǰü* [өвөсний налархайгаар Онон мөрөн өөд мөшгиж](MNT 88). (Мин уласын эхээр МНТ-

ны уйгуржин монгол болон дөрвөлжин үсэгээр бичсэн эхийг харьцуулан хитад ханз үсэгээр буулгахдаа тухайн үгийн эхний *na*-г *a*-гаар буулгасанаас *alurqai* гэсэн зохиомол хувилбар үүсчээ. || х о р ш : *'уян налархай'* || Kha, Bur. *nalarxai*, Ord. *nalurxâ*

Нам* |nam|{< *nim* < **min*} *'би'* гэдэг төлөөний үгийн шууд бус тийн алгалын үүсмэл язгуур. Өвөг монгол хэлний ***min*** гэсэн язгуур нь авиа солигдох, ижилших хувьсалын уламаас *nim* гэсэн шатыг дамжин ***nam*** болсоныг сонгодог бичигийн өмнөх болон дундад үеийн монгол хэлний бичигийн дурасхалууд тусхасан байна. || Ж= *'Senggüm anda **nama** naidaju hüldebe je či'* [Сэнгүм анд чи надад атаархаж үлдэв](MNT 181) // *'ta köbegüd minu **namayi** taqiqu sedkil yayun ügei aqu'* [хүвгүүд та нарт намайг хүндлэх сэдхэл яагаад үгүй болов](Chang.17) // *'či ... **nama-lu'ā** nököčejü'* [чи ... надтай уулзаж] (MNT 205) // *nimdu* (Hin. 51)

Наманчил- |namančila|{< Skr. *namo + (n)čila*} *'мэхийх'*, *'бөхийх'* || (Бүддийн čсонд биширэл хүндэдхэлээ бие, хэл, сэдхэл гураваар илэрхийлэх зан үйл) || Ж= *'oduysan gem-iyen **namančilamui**'* [өнгөрсөн гэмээ наманчилмуй] (Burq. 13a) // *buru'ü bö esü **namančilan** sögöd!* [буруу бөгөөс наманчилан сөгд!] (MNT 245) || х о р ш : *'наманчилан залбирах'*, *'наманчилан мөргөх'* || Kha. *namaŋtšil-*, Ord. *namaŋtšila-*, Bur. *namaŋšal-*, Oir. *nämᵊntšᵊl-*

Т у с х а й с у д а л г а а : Ш. Чоймаа, *'Монголын нууц товчоон'*-д буй нэгэн санскрит үгийн тухай, *'Энэтхэг-Монголын сурвалж соёлын хэлхээ холбоо'*, Уб., 2005, 152-156

Намба |namba|{< Tib. *rnam pa*} *'хэлбэр дүр'*, *'хэв байдал'* || х о р ш : *'намба мөрх'* || Kha. *namba*, Ord. *nambâ*

Намбага |nambuqa| х у у ч : *'хөхүүр'*, *'намаа'* (багавтар ширэн хөхүүр буюу борви) || Ж= ***nambuqa** sa'ūluga-bān ke'ēr-e bogūju talbiba'* [хөхүүр суулгаа хээр боож тавив](MNT 90) // *'tulum namuy-a kegeliten'* [тулам намаа хээлтэй] (Burq.55b) // ***nanbuya*** 'bucket of leather' (Ras. 204 B20)

Намбалис |nambalis| х у у ч : *'дээгүүр'*, *'нэвт'* || Ж= *'qurdan Qubiyu'ān guya inu deledčū, quburi **nambalis** burūlqui-lu'ā qoyina-ča inu gurba'ūla uda'āralduba'* [хурдан Хувийнхаа гуяыг нь ташуурдаж гүвээ даван дутаахад хойноос нь гуравуул дараалан нэхэв](MNT 55). I. Rachewiltz энэ үгийн бүтэцийг *qučilis* {< quči-lis}, *čegūlis* {< čegü-lis} зэрэг үгтэй харьцуулан үзээд *'дээгүүр'* гэсэн утгаар буулгажээ (*Secret Hisory of the Mongols*, 2044, 11, 307)

Намжир I |namjor|{< Tib. *rmam 'byur*} *'дүр байдал'* (орчин үед төв ихэмсэг байдалыг хэлнэ) || Kha, Oir. *namdzir*, Bur. *namžar*

Намжир II |namjar|{< Tib. *snam sbyar*} *'карша дээл'* (лам нар хурал хурах, ном унших үедээ өмсдөг шар хүрэм)

Намобуддаяа |namobuddhaya|{< Skr. *namobuddhaya*} *'бурханд мөргөмү'*

Намодарма |namodharmaya|{< Skr. *namodharmaya*} *'номд мөргөмү'*

Намогуру |namoguru|{< Skr. *namoguru*} *'багшид мөргөмү'*

Намсарай |namsarai|{< Tib. *rnam sras*} *'асар сонсогчийн хүвүүн'* (Дөрвөн махаража, арван догшидын нэг болох эд баялагийг хайрлагч Намсарай

бурханыг баруун мутартаа ялгуусан туг, зүүн гартаа эрдэнээр бөөлжсөн хулгана барьж, амаа жимийсэн байдалтайгаар дүрсэлсэн байдаг ажээ)

Намтар |namtar|{< Tib. *rnam thar*} *'сайтар тонилох'* (хутагт хувилгаад орчилонгийн амьдаралаас ангижирч нирваанд хүрч, бодь хутагийг олох тухай үгүүлсэн түүх. Хожим аливаа хүний амьдаралын замналыг тоочин үгүүлсэн түүхийг нэрлэх болжээ) || х о р ш : *'намтар түүх'* || Kha, Ord, Bur. *namtar*, Oir. *namt'r*

Нангиад |nangγiyad|{< *namgiya* < Chin. **nam kia + d* (Pl)} *'өмөнөдийнхөн'* (Жүрчидийн алтан уласын үед Хөх мөрөнөөс урагш оршин суух өмөнөдийн хитад хүмүүсийг ийнхүү нэрлэж байжээ. Эдүгээ бичиг зохиолд *'хитад'* гэсэн өргөн утгаар хэрэглэх болжээ.) Ж= *'naran uryuqui* ***nangγiyas****-un γajar'* [наран ургах хитад газар](Ölj. 28) // *'edü'ē* ***nanggias*** *moritan čeri üd uruqši yabuju'* [эдүгээ хитад морьтон цэрэгүүд урагш явж](KMQB B20) || Kha. *naŋgiād*

Нандин |nandin|{< Tib. *nang brten*} *'дотоод шүтээн', 'эрхэм', 'ариун'* || Ж= *'найз нөхдийн гэрээр орж,* ***нандин*** *сэтгэлийн үгээ ярилцав'* (Ц. Дамдинсүрэн, Ян Райнисын ном) // *'ховор* ***нандин*** *ном судар элэгэндээ тэвэрэн'* (Б. Ринчен, Цогт тайж) // *'итгэлийн эрхэм* ***нандин*** *үг'* (Ч. Лодойдамба, Манай сургуулийнхан) || х о р ш : *'ариун нандин', 'нарийн нандин', 'ховор нандин', 'эрхэм нандин'* || Kha. *naŋdiŋ*

Нанжвандан |namjivangdan|{< Tib. *rnam bcu dbang ldan*} *'арван зүйлийн эрх төгөссөн'.* (гол төлөв оршуулгын ёслолд хэрэглэдэг нар, сар, ланз үсэг бүхий нэгэн зүйл хадаг)

Нанжин |nanjin|{< Chin. *nán jīng*} Нанжин (хотын нэр) || Ж= *'нанжин гахай гөлөм', 'нанжин чавга'* || Kha. *naŋdžin*, Ord. *nandžiŋ*

Нано |nano|{< Fr. *nannie*} *'1 метрийг 1 00 000 000* (зуун сая) *хуваасаны нэгтэй тэнцэх хэмжигдэхүүн'* || х о р ш : *'нанотехнологи'* (nanotechnology), *'нано-материал'* (nanomaterial)

Нанчид |nangčid|{< Tib. *nang mchod*} *'дотоод тахил'* (тарнийн ёсны нууц авшиг лугаа барилдсан тахилын эд. Орчин үед *'сацалын арих'* гэсэн утгаар хэрэглэж байна.) || х э л ц : *'нанчид хүртэх'* (архи уух) || Kha. *naŋtšid*, Bur. *nanšad*

Нарвай |narbai/narmai| *'хөвчин', 'даяар'* (Монгол бичигийн дурасхалд тухайн үгийн *'nayarbai', 'narbai'* гэсэн хувилбар тохиолддог) || Ж= ***'nayarbai*** *gür ulus nayādun čenggen-iyēr nasu aburi-da nasulan jiryaturai'* [хөвчин улас гүрэн наадам цэнгэлээр насан туршдаа наслан жаргах болтугай](BT167a) // *'yeke Mongyol ulus-un qan-i* ***narbai-yi*** *nigedkegülün'* [Их Монгол уласын хаан дэлхийг нэгэдхэн](Hin. 3) // ***'narbai*** *yeke ulus-i jirγlang-tan bolγabai'* [нармай их уласыг жаргалтай болгов](ET 86b) || Хожимын ном зохиолд *narmai* {= narbai ~ narmai} гэсэн хувилбар хэрэглэгдэх болжээ || Ж= *'yeke bay-a noyad terigülen* ***narmai*** *yeke ulus-i quriyan čuylayulju'* [их бага ноёд тэргүүлэн нармай их уласаа хураан цуглуулж](ET 91b) || Kha, Bur. *narmai*, Kalm *narmā*

Наргил |nargil|{< Skr. *narigili*} *'коконат'* (халуун оронд ургадаг гоолиг иштэй, өдлөг навчтай, том самартай мод) || Cf. *narjil* 'coconut palm' (Schwarz, 927) || Kha. *nargil*

Нарийн |narin| *'бүдүүн'* гэсэн үгийн эсэрэг утга (*'нарийхан', 'эрхэм нандин'*) || *'ayula-yin tedüi terigütü asuru* ***narin*** *qoyolai-tu'* [уулын чинээ толгойтой, асар нарийн хоолойтой](Turf. 6) // *'**narīn** aburitu buyu'* [нарийн авирга буюу](MNT 243-5) // *'gün* ***narin*** *niyuča tarni-yin saba bolqu-yin tula'* [гүн нарийн нууц тарнийн сав болохын тул](ET 20a) // ***narin*** *gedesün* [тонкие кишки](Mu. 246) // *narin* 'тонкий' (IM M151) // *narin* 'mince' (Ist. 56) // *narin 'dünn'* (LH 71) // *narin* 'slender' (Ras.203 A3) // *nārin* 'thin', 'fine' (Zir118) || х о р ш : *'нарийн нандин', 'нарийн нимбай', 'нарийн нягт', 'нарийн чанд', 'нарийн ширийн'* // *'бүдүүн нарийн'* || Kha, Ord. *narīn*, Bur. *narin*, Oir. *nar'n*

Нартан |nartan|{< Tib. *snar thang*} *хийдийн нэр* (1153 онд Төвөдийн Дашлхүмбэ хийдийн ойролцоо байгуулсан гаадамбын хийдийн нэр)

Насос |nasos|{< Rus. *насос*} *'нацоос', 'хөөрөг'* (хий, шингэн зэрэгийг шахаж, сорох хөөрөг)

Наурыз |nauris|{< Kaz. *наурыз* < Pers. *navaroza* 'шинэ өдөр'} *'наурийз'* (хижирийн тоололын дагуу тэмдэглэдэг исламын шашинтны шинэ жилийн баяр)

Нацагдорж |nacuydorǰi|{< Tib. *sna tshogs rdo rje*} *'элдэв очир'* (дэлбэгээ хумьсан линхуа мэт дүрстэй зөрүүлсэн очир нь бат бэх эрх хүчний бэлгэдэл юм.) || Skr. *Vajra* 'очир' || Бат бэхийн бэлгэдэл болсон энэ үг хүний нэрд өргөн хэрэглэгддэг.

Нацизм |nacism|{< Rus. *нацизм* < Ger. *Nazismus*} *'нацийзем'* (фашистын Германы национал-социалист үзэл баримтлал, хэт үндсэрхэг үзэл)

Начигай |načiγai| 1. *'газар дэлхий'* || Ж= *'namur-un sara metü nayar-tu buyan-iyar* ***načiγai*** *eke nayiran ǰoqiǰu'* [намарын саран мэт буянаар дэлхий эх найр зохирч](BT 167a2) Проф. F. Cleaves гэсэн ***načiγai*** *eke* үгийг *Mother Earth* хэмээн орчуулжээ. (HJAS 17:1/2, 1954, 85) A. Mostaert энэ үгийг *etügen* гэдэг үггэй холбон тайлбарлажээ. Мөн оросын эрдэмтэн Г. Н. Румянцев уул үгийг *etügen ~ itügen ~ nitügen* гэсэн хувьсалын үр дүнд үүссэн байх гэж үзсэн байдаг. (Д. Банзаров, Собранне сочинений, М., 1955, Примечания № 81, стр. 268)

Т у с х а й с у д а л г а а : A. Mostaert, *Le mot Natigay / Načigai chez Marco Polo, Oriente Poliano,* Rome, 1957, 95-101

Начин |način / lačin| *нэгэн зүйл махчин шувуу* || Cf. AT. *lačin* 'falcon' (Clauson 763), Turk. *lačīn* 'сокол' (ДТС 332), Uig. *lačin* 'falcon' (Schwarz, 856) || Ж= *lačin* 'white falcon' (Ras. 200 A22) // *lačin* 'сокол' (Qaz. Po 203) // *'**начин** шонхор шувуу нь намагийн дээгүүр эргэлдээд байнаа'* (Д. Нацагдорж, Цэнхэрлэн харагдах) Эртний монголчууд эрэмгий шаламгайн бэлгэ тэмдэг болсон энэ шувууны нэрийг хүний нэрд хэрэглэсэн нь цөөнгүй. Ж= ***Način**-ba'ātur-un kō'ūd Uru'ūdai, Maŋgutai nereten būle'ē'* [Начинбаатарын хүвүүд Уругуудай, Мангуудай нэртэй билээ](MNT 46) || х о р ш : *'начин шонхор'* || Kha, Ord. *natšiŋ*, Bur. *našaŋ*, Oir. *natš'n*

Нашигай |nasiγai| *'назгай', 'залхуу'* || Ж= *'mayuqan* ***nasiγai*** *morid'* [муухан хашин морьд](Jig 33) // *našiya* 'лень', 'нерадние' (IM M151) // *našiγai* 'лень' (IM 442) // *našqai* 'faul' (LH 71) // *našqa* 'lent' (Ist. 56) || Kha. *nazgai*

Ная(н) |naya(n)|[= naja(n)] *'8 × 10 = 80'* || Ж= ***'nayan qoyar nasulaju ǰöb es-e boluγsan-u qoyin-a*** [наян хоёр наслаад таалал төгөссөний хойно](Chang.28) || Kha, Bur. *nayan*, Ord. *naya*, Oir. *najn*

Наяд |nayad|{< Uig *nayut* < Skr. *nayuta*} *'зуун сая', 'хизгааргүй'* (100 дүнчүүр буюу 12 оронтой тоо) || Ж= ***'nayud költi galab-ud-tur ǰayun kelen-iyer kelejü baran ken čidaqu'*** [зуун сая живаа галавуудад зуун хэлээр хэлж баран хэн дийлэх](Burq. 53b) || Kha. *nayɒd*

Негр |neger|{< Rus. *негр* < Fr. *negre* < Lat. *niger*} *'нээгер'* (хар аристан)

Нейлон |neyilon|{< Rus. *нейлон* < Eng. *nylon* (NY /New York/ + Lon / London/) *'нейлоон'* (нийлэг эд бараа)

Нерв |nerv|{< Rus. *нерв* < Lat. *nervus*} *'нээрев'* (мэдэрэлийн үйл ажиллагаа)

Нефть |nefti|{< Rus. *нефть* < Tur. *nefte* < Gr. *naphta*} *'нээфт', 'газарын тос'*

Ни* |ni / ne| *'нэг'* гэсэн тооны үгийн анхдагч язгуур. Дээрхи хоёр хувилбарын эхнийхээс нь *nige* 'нэг', *niǰi* 'нижи' гэсэн үүсмэл язгуур, хоёрдохоос нь *neyi* [ne-yi] 'ний' гэсэн үүсмэл язгуур тус тус салаалан гарч, тэдгээрээс олон шинэ үг цаашид салаалан гарсан байна.

Нигсалз- |niγdalǰa| *'сагсалз-', 'навсалз-'* || Ж= *'Belgüdei dargi oγotur qoŋγor-tur tarbaγad ačiǰu, nigsaγalǰatala yabuγan kötöljü irebe'* [Бэлгүүдэй дарги хонгорт тарвага зурам сагсалзтал ачиж явганаар хөтөлж ирэв](MNT 90)

Тусхай судалгаа: F. W. Cleaves, F. W. The Verb *isayljayul-un/ nisayljayul-un* in Two Mongolian Letters Patent of 1725 and 1726, *Gedanke und Wirkung*. Festschrift zum 90. Geburtstag von Nikolaus Poppe, {AF 108}, Wiesbaden, 1989, 76-82

Нигүүлс- |nigūlse| *'энэрэн хайрла-'* || Ж= *'yeke **nigüleskü** sedkil-e ködelgeg-dejü'* [их нигүүлсэхүй сэдхэл хөдөлгөж](Burq.7a) *//'**ni'ūleskü** sedkil-i'ēr olon-ni amurli'ūlu'ād'* [нигүүлсэхүй сэдхэлээр олоныг амарлуулаад] (KMQB A7) || х о р ш : *'энэрэн нигүүлсэх'* || Kha. *nigūls-*, Ord. *nigūles-*

Нигүүлсэгч |nigūlesügči|[= nigūles-gči] *'энэрэгч'* || Ж= *'naran saran-u deger-e sayuysan yeke **nigülesügči**'* [нар сарны дээр суусан их нигүүлсэгч](Ал. III:12)

Нид-* |nidu/ nidū| *'ницлах', 'нидлах', 'нүдэх'* гэх мэт уттыг хадгалсан анхдагч язгуур. Энэхүү язгуураас *niduγa-* [nidu-γa] 'нидаа-', *nidula-* [nidu-la] 'нидал-', *nidur-* [nidu-r] 'нудар-', *nidüre-* [nidü-re] 'нидэр-', *nidüker-* [nidü-ker] 'нидхэр-' гэх мэт үг үүсч, тэдгээрийн заримаас *nidürge* [nidü-rge] 'нидэргэ', *nidurγa* [nidu-γa] 'нударга' гэх зэрэг нийлмэл бүтэцтэй үгс дам үүссэн байна.

Нидал- |nidula| *'ямь масла-', 'худха-', 'эргүүл-'* || Ж= *'čeügēn čila'ūn-i čawūlun, če'ēl usun-i **nidulun***' [цэгээн чулууг цуулан цээл усыг эргүүлэн авай] (MNT 209) || Орчин цагийн хэлэнд зөвхөн *'алах', 'хидах'* гэсэн утга илэрхийлнэ. || Kha. *n'ādal-*,

Ниж* |neǰi| *'нэг'* гэсэн утгатай үүсмэл язгуур. Энэхүү үүсмэл язгуураас *niǰiged* [niǰi-ged] **'нижгээд'** гэсэн үг үүсчээ.

Нижгээд |niǰiged| 'нэг нэг' || Ж= *'od būri **niǰiged** tümen ülegü sükes arbidqan'* [жил бүр нэг нэг түмэн сүхэс арвижуулан](Jig 8) *// edür-tür arča-yin **niǰiged** ür-e tegün-ü qoyina **niǰiged** tuturγan tegün-ü qoyina **niǰiged** künǰid terigüten-i idebei.*

*[өдөрт арцын үр нэг нэг, түүний хойно тутарганы үр нэг нэг, түүний дараа гүнжидийн үр нэг нэгийг идэв](Burq. 38b) // 'nǰi'el müsüd quǧuludqun' [нэг нэг сум хуталагтун](MNT19) // 'gü'ün tutum **nǰeget** setkilten bui' [хүн бүр өөр өөр бодолтой](KMQB A13) // irebe **nǰed** qošād [пришли раз и два](Mu. 197) || Kha. nidžged, Bur. nežēd, Oir. nedžād*

Ний* |neyi| *'нийлэх', 'нэгдэх'* гэсэн утгатай язгуур. Энэхүү язгуураас *neyiče-* [neyi-če] 'нийц-', *neyid* [neyi-d] 'нийд', *neyigem* [neyi-gem] 'нийгэм', *neyil-* [neyi-l] 'нийл-', *neyis-* [neyi-s] 'нийс', *neyite* [neyi-te] 'нийт' гэх мэт үндэс үүсч улам тэдгээрээс *neyičegül-* [neyi-če-gül] 'нийцүүл-', *neyidke-* [neyi-(d)ke] 'нийдхэ-' *neyislel* [neyi-s-le-l] 'нийслэл', *neyitele-* [neyi-te-le] 'нийтлэ-' гэх мэт олон үг салбарлан гарсан байна

Нийвий |niibi|{< Chin. *ni bā} 'шавар'* (шавар нилах хавтагай мод) || Kha. *nīwī*

Нийгэм |neyigem|[= neyi-ge-m] *'олон түмэн', 'хамтлаг'* || Ж= *'Бүх дэлхийн **нийгэм** жүрчмын нөхөр мөн'* (Д. Нацагдорж, Шинжилэх ухаан) || Kha. *nīgem*, Ord. *nīgūn*

Нийл- |neyile|[= ne-yi-le] *'нэгдэх', 'хамтарах'* || Ж= *'Qasar ... aqa-yu'ān ke'ēn Čiŋgis qahān-i erin ... Baljuna-da Čiŋgis qahān-dur **neyīlebe'*** [Хасар ... ахыгаа хэмээн Чингис хааныг эрэн ... Балжунад Чингис хаанд нийлэв](MNT 183) // Ж= *'amtatu Gangga mören-ü usun ber dalai-dur **neyilebesü** quǰirtu boluyu'* [Ганга мөрөний амтат ус ч гэсэн далайд нийлвэл давастай болно] (Sub.IV:11b) Энэ үгээс *neyilbüri* [neyi-lbüri] 'нийлбэр', *neyilemǰi* [neyi-le-mǰi] 'нийлэмж', *neyilče* 'нийли', *neyilegül-* 'нийлүүл' зэрэг үгс үүсчээ. || х о р ш : *'нэгдэн нийлэх'* || Kha, Oir. *nīl-*, Ord, Bur. *nīle-*,

Нийслэл |neyislel|[= neyi-(s)le-l] *'нийлэн нэгдэх газар'* (уласын төв хот) || Ж= *'идээшин дассан **нийслэл** хотын олон амтат сайхныг их л мөрөөдөж'* (Д. Нацагдорж, Уул усны охин) || Kha, Bur. *nīslel*

Нийт |neyite|[= neyi-te] *'хамаг', 'бүгэд'* || Ж= *'qan-iyan kündülekü törü-yi **neyite** bolyaju'* [хаанаа хүндэлэх төрийг бүхэний болгож](Taq. 8b2) // *'urida mongqol kitad **neyite** būkūi-dūr mongqol qa'ān delekei-yi ejelejü'* [урид монгол хитад хамт байх үед монгол хаан дэлхийг эзэлж](KMQB A6) || х о р ш : *'бүх нийт'* || Kha, Oir. *nīt*, Ord, Bur. *nīte, nītü*

Нийц |neyiče|[= neyi-če] *'эе эв'* (бусадтай найрсагаар зохиццон тохирох байдал) || Ж= *'хундага өргөж сэтгэлд нь **нийцэх** сайн үг хэлмээр санагдаж өндийв'* (Л. Ванган, Эрхий Мажиг) || Kha. *nīts*, Ord. *nītši*, Bur. *nīse*, Oir. *nītsi*

Никель |nikel|{< Rus. *никель* < Ger. *Nickel} 'нийкел', 'диц'* (толь мэт гилгар гадаргатай металь)

Никотин |nikotin|{< Rus. *никотин* < Fr. *nicotine} 'никотийн', 'тамихны хор'* (тамихны хорыг 1560 онд Францад тамих анх авчирсан дипломатч Никот (Nicot)-ын нэрээр нэрлэжээ)

Нил |nil|{< Skr. *nīla} 'хөх'* || х о р ш : *'нил хөх'* (бүхэлдээ хөх өнгөтэй)

Ним* 1 |nim|{< **min} ганц тоот нэгдүгээр биеийн төлөөний нэрийн эртний үндэс.* (Өвөг монгол хэлний **min* гэсэн язгуур нь авиа солигдох

хувьсалын уламаас *nim* гэсэн шатыг дамжсаныг батлах сонирхолтой жишээ *'Үлгэрийн далай'* сударт тодорхой туссан бий.) || Ж= *'Saribudari tere-ber **nima**-yi nom-dur oruyulun'* [Шарибудари тэрвээр намайг номд оруулан](ÜD XV:56) // *'degedü nom-ud-i **nima-dur** üjügülbesü aliba küsegsen-i öggümüi'* [дээд номуудыг надад үзүүлвэл аливаа хүссэнийг өгнө](ÜD I:4) // *'či yayun-u tulada söni dülide **nima-ača** buruydabai kemen asaybasu'* [чи яагаад шөнө дунд надаас зугатаав хэмээн асуувал](ÜD XIII:47) // *'**nima-luya** temečeldügsen-dür bi ber tedegeri ečüljü bürün'* [надтай тэмцэлдсэний учир би тэднийг дуусгана] (ÜD XIII:48)

Ним* II |nim| *'нимгэн'* гэдэг үгийн анхдагч язгуур. Энэхүү язгуураас *nimge* [nim-ge] 'нимгэ', *nimla* [nim-la] 'нимла' гэх мэт үндэс салаалан гарчээ.

Нимба |nimba|{< Tib. *bsnyen pa*} *'шадарлах'* (ядам бурханыг шүтэх бисалгалын үйл) || Kha. *ńamba*

Нимбэг |nimbege|{< Skr. *nimbūka*} *халуун оронд ургадаг анхилам үнэр, гашуун амт, хатуу халистай жимэс* || Kha. *nimbeg*

Нимгэ |nimge|[num-ge] *'нимгэн'* гэдэг үгийн үүсмэл язгуур. Энэ язгуураас *nimgele* [nim-ge-le] 'нимгэл-', *nimgen* [nim-ge-n] 'нимгэн' гэх мэт үндэсүүд үүссэн байна.

Нимгэн |nimgen| *'зузаан'* гэдэгийн эсрэг утгатай үг. || Cf. Man. *nemkun* 'тонкий' (Цинциус I:621) || Ж= *'**nimgen** mölsün deger-e gečkikü'* [нимгэн мөсөн дээр гишгих](Taq. 6a1) // *'örgen **nimgen** keletü ulayan bimba urultu'* [өргөн нимгэн хэлтэй, улаан бимбын уруултай](Burq. 28b) // *nimgen* 'mince' (HY M79) // *'nimgen* 'тонкий' (Mu. 257) // *nimgen* 'тонкий', 'слабый' (IM 442) // *nämgän* 'тонкий', 'нежный' (IM M151) // *nimgen* 'thin', 'fine' (Ras. 203 A12) || х о р ш : *'нимгэн зузаан'* || Kha, Ord. *miŋgen,* Ord. *nimgen, nemgen,* Bur. *nimgen,* Oir. *nimgən*

Нимла* |nimla| *'нимгэн'* гэсэн утгатай үүсмэл язгуур. Энэхүү язгуураас *nimlayun* 'нимлуун' гэсэн үг үүсчээ.

Нимлуун |nimlayun|[= nim-la-yun] *'нимгэн'* гэсэн үгийн нэгэн хувилбар || Ж= *jögen qalayun-u čay-tur **nimlayun** jujayan-i joqiyan kemleged'* [халуун дулааны цагт нимгэн зузааныг тохируулаад](Chang. 16)

Нин шош |ning šoša|{< Tib. *snying zho sha*} *'зүрэхэн шош', 'чавга'* (халуун оронд ургадаг, урт иш, зузаан навч, цагаан цэцэг, хар жимэстэй бутлаг ургамал)

Нинж |ningjin|{< Tib. *snying rje*} *'их нигүүлсэхүй', 'өршөөхүй'* (Бурханы ном бүхэний уг үндэс нь асарахуй, энэрэхүй, нигүүлсэхүй, баясахуй гэсэн дөрвөн цаглашгүйд багтдаг бөгөөд түүнийг ерөнхийд нь *нинжийн сэдхэл* хэмээнэ гэж бүддийн сургаалд номложээ. Эдүгээ энэ үгийг *'нинжин сэдхэл'* хэмээн товчилон хэлэх болжээ. || Kha. *niŋdžin*

Нирав |nirba|{< Tib. *gnyer ba*} *'хадгалагч'* (сан хөмөрөг, эд хөрөнгийн эрхлэгч) || Kha. *niraw,* Ord. *nirwa*

Нирваан |nirvan|{< Uig *nïrvan* < *nyrβ'n* < Skr. *nirvāṇa*} *'гаслангаас нөгчсөн', 'орчилонгоос тонилсон'.* (Бүддийн ёсонд уур хилэн, эргүү мунхаг, атаа хорсол, худал хуурмаг, хүсэл тачаал, зугаа цэнгэл зэрэг нисваанисын

хороос ангижирч, төгөс жаргалангийн оронд төрөх үйлийг *'нирваанд хүрэх'* гэж хэлдэг. Хожимоо дээд богдсын таалал төгсөхийг *'нирваан дүр үзүүлэх'* гэдэг болжээ) || Ж= *'**nirvan** daqi jirγalang-ud-i törügülügči'* [нирваан дахь жаргаланг төрүүлэгч](ВТ 165а5) || х о р ш : *'нирваан дүр'* || х э л ц : *'нирваанд хүрэх'* (нисваанисын хороос ангижирч, төгөс жаргалангийн оронд төрөх) || Kha. Ord, Oir. *nirvān*

Нисал- |nisal| *'хаях', 'тулгэх'* || Ж= *'beyebēn köser-e **nisalqui** ködege-dür qočorγsan jïγad metü'* [биеэ хөсөр хаявал газар хаягдсан загас мэт](Burq. 26а) || (Орчин цагийн монгол хэлэнд зөвхөн хурууныхаа үзүүрээр нударан цохих хөдөлгөөнийг хэлнэ.) || Ж= *'бүдүүн хуруугаар магнай дээр нь булуу болтол **нислахаас** гадана'* (Ч. Лодойдамба. Манай сургуулийнхан) || Kha, Ord. *nisal-*, Oir. *nis*l-*

Нисваанис |nisvanis|{< Uig. *nïzvanī* < Sogd. *nizβān* < Skr. *nisvāna*} *'гэсэлгэлийн шалтгаан', 'орчилонгийн хүлээс'* (Бурханы шашины номлолд нисваанисыг *'шунал тачаангуйн', 'урин хилэнгийн', 'эргүү мунхагийн', 'омогийн', 'атаа найдангуйн'* гэж таван зүйлд хуваадаг байжээ. Бүддийн сургаалд *'уур хилэн', 'шунал тачаал', 'тэнэг мунхаг'* зэрэг арван муу үйлийг *'нисваанисын хор'* гэдэг) || Ж= *'**nisvanis**-a yutayay-daysan-i amurliyulqui čay inu bolju amui'* [нисваанисд гутаагдсаныг амирлуулахуй цаг нь болж амуй](Burq. 4а) || Kha. Ord, Oir. *nisvānis*

Т у с х а й с у д а л г а а : Коссе, А. Д. Термин *nisvanis* 'суета мирская' в старописьменном монгольском тексте эпохи Юань. *Arban qoyar jokiyangγui* «Двенадцать деяний Будды», *'Проблемы исторического развития монгольских языков'*, СПб., 2007, 82-85

Ниш- |nisi| х у у ч : *'жанч-', 'гэсхээ-'* || *'jasaγ dabaγsad-i barïju **nišitügei!**'* [цааз зөрчигсөдийг барьж гэсгээтүгэй](MNT 199) // *'čerig-ün to'ötu kü'ün jïrüke yada'asu **nišiqui-a** ere-dür harban müsüd ürge'üljü, süke, oγāli, kirü'ē, ši'üči ere-yin jer jebseg jasa'ülju'* [цэрэгийн бүрдхэлтэй хүн зүрэх шантарваас гэсхээх эрчүүдэд арван сум үүрүүлж](MNT 240)

Ниша(п) |niša|{< Pers. *nišān*} *'тамга', 'батламж'* || AT *nišan* 'признак', 'отпечаток' (ДТС 359) || Ж= *'jarliγ-un yosuγar ülü ayiqun aldaqun ta kemen al **nisan**-tu bičig ögbei'* [зарлигийн ёсоор та айх алдах зүйлгүй хэмээн улаан тамгат бичиг өгөв](Turf 26:13) // *'nidan-i oon qabur endeče **nišan** abči odqu bölüge'* [ноднин жилийн хавар эндээс тамга авч одох бөлгөө](Qqot.G120) // *'qas **nisan**'* [хас тамга](Нп. 41) Энэ үг манж хэлэнд малын *тамга* гэсэн утгаар хэрэглэгдэж байжээ.

Нишингэ |nisinggü|{< Skr. *ikṣyāku*} *'чихэр өвөс'* || Kha. *nišiŋgə*

Ноднин |nidonun|{< *nido* 'өнгөрсөн) + *on*} *'өнгөрсөн жил'* (Дундад үеийн монгол хэлний бичигийн дурасхалуудад *nidoni on / nidoni hon* гэж байгаагаас үзвэл тухайн үгийн бүтэцэнд байгаа *on* 'он' гэсэн үг нь өмнөх үгэндээ шингэн орсоныг харуулж байна. Эдүгээ бид заримдаа *'ноднин жил'* гэж ярьдаг нь уттаа *'өнгөрсөн' + 'он' + 'жил'* гэж давхарлан хэлж байгаа хэрэг юм.) || Ж= *'bi **nidoni** ćima-da ese'ü ügülele'ē'* [би ноднин чамд эс хэл лүү] (MNT 104) //

*'**nidani** oon qabur endeče nišan abču odqu bölüge'* [ноднин жилийн хавар эндээс тамга авч явсан билээ](Turf. 23) // *'**nidoni** hon-nača ebečin nemenggü bolǰu'* [өнгөрсөн жилээс өвчин нь нэмэгдэх болж](KMQB B7) // ***nidani** hon 'last year'* (Ras. 201 A4) // ***nidani** 'previous year'* (Zir.119) || Kha. *nodniŋ / n'adnan*, Ord. *nidonon*, Bur. *n'odonon*, Oir. *nidn'nīn*

Ноё* |noya| *'ноён'* гэсэн үгийн анхдагч язгуур. Энэхүү язгуураас *noyad* [noya-d] 'ноёд', *noyala-* [noya-la] 'ноёл-', *noyalɣ* [noya-lɨɣ] 'ноёлог', *noyamsig* [noya-m-sig] 'ноёмсог', *noyan* [noya-n] 'ноён', *noyaqan / noyakin* [noya-qan / noya-kin] 'ноёхон', *noyarqa-* [noya-rqa] 'ноёрх-' гэх мэт үгс үүсчээ. Зарим судалаачид энэ үгийг хитад хэлний *'lao ye'* гэдэг үгээс гаралтай гэж үзсэн байдаг. Харь гаралтай үгээс энэ мэт олон үг салбарлан үүсэх нь ховор.

Ноёл- |noyala|[= noya-la] *'эрхшээх'* || Ж= *'bayajiqu **noyalaqu** qoyar-iyar beyes-ečegen es-e ele anggiǰiraɣulbasu'* [баяжих, ноёлох хоёроор бие биеэсээ эс ялгарваас](Taq. 5b) // *'ke'ēr-ün üyīle ke'ēr-e kü **noyalaqu** būle'ē. Ger-ün üyīle ger-tür kü **noyalaqu** būle'ē'* [хээрийн үйл хээртээ ноёлох, гэрийн хэрэг гэртээ ноёлох билээ](MNT 277) // ***noyalaba** irgenü jüre* 'повелевал среди людей' (Mu. 260) || Kha, Bur. *noyol-*

Ноёлог |noyaliɣ|[= noya-lɨɣ] *'ихэс дээдэс', 'өндөрөөс өндөр'* || Ж= *'yeke ner-e-dür kürügsed **noyanliɣ-un** uridus'* [их нэр алдарт хүрсэн ихэсийн уридас] (Chang. 38) // *'**noyaliɣudun** taqimdaɣu yosun'* [ихэсийн тахимдуу ёс](Taq. 7b) || Kha. *noyŏlog*, Kha. *nojolig*, Bur. *noyolig*, Oir. *noǰ'lɒg*,

Ноёмсог |noyamsiɣ| *'ноён зантай'* || Ж= *'**noyamšiğ** aburitu tula noyakin oboğtan bolba'* [ноёмсог авиртайн тул ноёхон овогтон болов](MNT 46-2)

Ноён |noyan|[= noya-n] *'дээд түшаалтан'* // Pl. noyad (Yis. 3) || Cf. Man. *nojon* 'начальник' (Цинциус I:604) || Ж= *'Način **noyan-u** sōyūgsen ūges-i sedkiǰü'* [Начин ноёны соёрхсон үгсийг ухаарч] (Chang.19) *//'namayi tümen-ü **noyan** bolu'āsu ya'ūn jirğalaŋ bui'* [намайг түмэний ноён болговоос юуных нь жаргал байхав](MNT 121) // *bazarun noyan* [заведывающий рынком](Mu.115) // *noyan* 'князь' (IM 443, IM M152) // *noyan* 'officier, functionnaire public' (HY M80) // *noyan* 'Fürst', 'Herr' (LH 73) // *noyan* 'seigneur', 'maître' (Ist. 58) // *noyin* 'the prince' (Ras.198 B28) || х о р ш : *'баяд ноёд', 'хаад ноёд'* || Kha, Bur, Ord. *noyon*, Oir. *noǰ'n*

Ноёнтон |noyantan|[= noya-n-tan || *'дээд ноён'* || Ж= *'Musavir noyantan'* [Мусавир ноёнтон](Qqor. II:5) || Kha. *noyonton*

Ноёхон |noyakin| *'залуу ноён'* || Ж= *'noyamšiğ aburitu tula **noyakin** oboğtan bolba'* [ноёмсог авиртайн тул ноёхон овогтон болов](MNT 46) || Oir. *noǰ'χɒn*

Нокаут |nokaut|{< Rus. *нокаут* < Eng. *knock-out* 'цохиж гаргах'} *'нокаут'* (боксын дэвжээн дээр өрсөлдөгчөө муужиртал цохиж унагаах)

Ном I |nom|{< Sogd. *nwm* < Gr *νόμος*} 1. *'эрдэм', 'сургаал', 'засаглал'*, 2. *үдэж дэвтэрлэсэн судар* /Pl. *nomud*/ (Burq. 6a) || Skr. *dharma* 'дарма' || Ж= 1. *'Sugavadi ulus-tur nom nomlaqu dayun sonosdan aǰuɣui'* [Сугавади оронд ном номлох дуу соносдох ажгуу](BT 158b1) // *nom* 'loi, doctrine' (HY M79) || Монголчууд энэ үгийг их төлөв *'сургаал, номлол', 'эрдэм мэдлэг'* гэсэн утгаар

хэрэглэж ирсэн бөгөөд яваандаа тэдгээр сургаал номлолыг агуулсан судар шастирыг бас тийн нэрлэх болжээ. || Энэ үгээс *nomči* [nom-či] 'номч', *nomla-* [nom-la] 'номло-', *nomtan* [nom-tan] 'номтон', *nomtu* [nom-tu] 'номт' гэх мэт үгс үүсчээ. || х о р ш : *'ном зохиол', 'ном сонин', 'ном сударʼ, 'ном товхимол', 'ном хэвлэл' // 'буян нам', 'хурал ном'* || Kha, Ord, Bur, Oir. *nom*

Ном II |nom|{< nam} *'номхон', 'намуун'* гэсэн үгийн утгыг хадгалсан анхдагч язгуур. Энэ язгуураас *nomi* [nomu-i] 'номой', *nomuqa* [nomu-qa] 'номхо' гэх мэт үүсмэл язгуур үүсчээ.

Номин |nomin|{< Tib. *mi men*} *'ногоолин эрдэнэ'* (гүн цэнхэр өнгөтэй, жижиг цагаан толботой, гоёл чимэглэлд хэрэглэдэг эрдэнийн чулуу) || х о р ш : *'номин ногоон'* || Kha, Bur, Ord. *nomin*, Oir. *nom'n*

Номло- |nomla|[= nom-la] *'сургаал айлдах'* || Ж= *'Sugavadi ulus-tur nom **nomlaqu** dayun sonosdan ajuγui'* [Сугавадийн оронд ном номлох дуун соносдох ажээ](BT 158b1) || Kha. *nomol-*, Ord. *nomno-*, Bur. *nomono-*, Oir. *noml^{n}-*

Номхо* |nomuqa|[= nam-qa] *'номхон'* гэсэн үгийн утгыг хадгалсан үүсмэл язгуур. Энэ язгуураас *nomuqad-* [nomu-qa-d] 'номход-', *nomuqan* [nomu-qan] 'номхон', *nomuqar-* [nomu-qa-r] 'номхор-' зэрэг үгс үүсчээ.

Номход- |nomuqad|[= namu-qa-d] *'номхон болгох'* || Ж= *'mayun ed-tü bolbasu omuyšiqu-yin šiltayan sayid ed-tü bolbasu **nomuqadqu-yin** šiltayan'* [муу хүн хөрөнгөтэй болвол онгирохын шалтгаан, сайн хүн хөрөнгөтэй болвол номхорохын шалтгаан](Sub. 10b)

Номходхо- |nomuqadqa|[= nomu-qa-dqa] *'номхоруулах'* || Ж= *'ingri-ner-i nomuqadqayad'* [тэнгэр нэрийг номходхоод](Burq.54a) // *'šimnus-i **nomuqad-qaγsan** neretü'* [шулмасыг номходхосон нэрт](Sub. 65a) || Kha. *nomxodxo-*, Ord. *nomoǧodχo*, Bur. *nomǧodχo-*

Номхон |nomuqan|{< *nam-(u)qan} *'намуун дөлгөөн', 'зөөлөн тогтуун'* (үйл хөдөлөл, зан авирын намуун дөлгөөнийг заасан утгатай үг) || Cf. Turk. *namaγan* 'смирный' (Räsänen 354); Man. *nōmān* 'медлительный' (Цинциус I:604 || Ж= *'toyin kümün-ü usqal **nomuqan** amurliγsan γou-a yabudal-iyar yabun'* [тойн хүний усхал номхон амирласан гоо явдалаар яван](Burq. 31a) // *'**nomu-qan** sayid-i ba höri-ü keče üs-i nomuqad-qan surqan atuqai'* [номхон сайдууд болон хөөрүү хэцүүсийг номходхон сурган атугай](KMQB A12) // *'**namaγan** kibe čaliq morini* [усмирил горячего коня](Mu. 245) // *nomoǧan 'quiet'* (Ras.203 C8) || х о р ш : *'номхон дөлгөөн', 'номхон хүлцэнгүй'* || Kha. *nomxon*, Ord. *nomoxon*, Bur. *nomǧon*, Oir. *nomχ^{o}n*

Ноо* |noγa| *'ноос'* гэсэн үгийн анхдагч язгуур. Энэхүү язгуураас *noγalu-γur* [noγa-lu-γur] 'ноолуур', *noγaqai* [noγa-qai] 'ноохой', *noγarqai* [noγa-r-qai] 'ноорхой', *noγasun* [noγa-(r)sun] 'ноос' гэх мэт үгс үүсчээ.

Ноос |noγasun|{< *noγa-(r)sun} *мал, амьтаны биеийн гадуур бүрхсэн зөөлөн унгас.* || Cf. Man. 'зеленый' (Цинциус I:603) || Ж= *'eγitü qala'ūn-a **nuŋǧasun** dotora ker da'ūsqu'* [ийм халуун өдөр ноосон дотор хэрхэн дуусах] (MNT 86) // *'eyitü jun-u qalaγun-a kümün-i **ungγasun**-dur yakin niγumui'* [ийм зуны халуунд хүнийг унгасанд дотор хэрхэн нууна](ET 28a) // *nuŋǧasun* 'wool' (Ras. 205 C1)

|| х о р ш : *'ноос ноолуур'*, *'ноос үс'* // *'унгас ноос'* || Kha, Ord, Oir. *nōs*, Bur. *nōhon*, Oir. *nōsᵒn*

Норм |norma|{< Rus. *норма* < Lat. *norma*} *'нооромˈ*, *'хэм хэмжээ'*

Норов |norbu|{< Tib. *nor bu*} *'эрдэнэ'* (үнэт эрдэнийн чулуу)

Ностальги |nostalgi|{< Rus. *ностальгия* < Gr. *nostos* 'гэртээ харих' + *algos* 'өвчин'} *'эх нутагаа санагалзан уйтгарлах'*

Нот I |not|{< Rus. *нота* < Fr. *note* < Lat. *nota*} *'ноотˈ* (дуу хөгжимийн ая, хэмийг заасан тэмдэг)

Нот II |not|{< Rus. *нота* < Fr. *note* < Lat. *nota*} *'ноотˈ* (дипломат албан бичиг)

Нотариат |notayat|{< Rus. *нотариат* < Ger. *notarius* < Lat. *notarius*} *'нотираадˈ* (аливаа баримт бичгийг баталгаажуулах алба)

Ноу-хау |nowu-hawu]{< Eng. *know-how*} *'ноу-хауˈ* (техник, технологи эзэмших арга ухаан, ур чадварын цогц чанар)

Нөгөө |nögüge| *'өөрˈ*, *'дараагийнˈ* (Энэ үгийн өнөөгийн бүтэц нь *nögügē* > *nögü'ē* > *nögö'ö* > *nögō* гэсэн авианы хувьсалын үр дүнд үүсчээ.) || Ж= ***'nögüge*** *törül-dür ber yurban mayui jayayan-u jobalang ülü kürten'* [хойд төрөл-дөө гурван муу заяаны зовлон үл хүртэн](BT 161a) // *'qoyar kürdütei tergen* ***nögö'ē*** *kürdübēn qugura'āsu newün yadayuˈ* [хоёр дугуйтай тэрэгний нэг дугуй нь хугарвал хэрхэн нүүх](MNT 177) || Kha, Ord, Oir. *nögö*, Bur. *nügö*

Нөгөөдөр |nögügedür|{< nögüge edür} *'нөгөө өдөр'*, *'маргаашийн дараах өдөр'* || Ж= ***'nökö'e edür*** *basa nekere oduya'* [бас нөгөөдөр нэхэхээр явая] (KMQB B22) || Kha. *nögödör*, Ord. *nögödür*, Bur. *nügödör*, Oir. *nökāᵈr*

Нөгчи- |nögči| *'өнгөрөн од'*, *'хагацан одох'* || Ж= *'yirtinčü-eče* ***nökčigsen*** *gem ügei mayidari sedkil'* [ертөнцөөс хагацан одсон гэмгүй итгэлт сэдхэл] (Burq. 57a) // *nökči-* 'passer' (HY M80) // *bi tünēse* ***nökčibe*** [я имею отвращение к нему] (Mu.118) // *'sin takiy-a jile nirvan-dur* ***nögčibei'*** [шин тахиа жил нирваанд одов] (ET 22b) || Kha. *nöxtši-*, Bur. *nügše-*, Ord. *nögtši-*, Oir. *nöktš-*

Нөгчөө- |nögčiye| *'үхүүл-'* *'одуул-'*, *'өнгөрүүл-'* || Ж = *'čisu ülü gargan* ***nökči'ējü***, *yasu inu ile bü gēdkün'* [цус үл гарган үхүүлж, ясыг нь ил бүү хая] (MNT 201) // *'Čiŋgis qahān Iluqu-yi* ***nökčiyēdkün****! ke'ēn Tolun čerbi gartaju,* ***nökči'ētügei****! ke'ēn jarliğ bolba'* [Чингис хаан Илуху-г үхүүлэгтүн! Толун чэрби гардан үхүүлтүтэй хэмээн зарлиг болов!](MNT 267) // *söni düli* ***nökči'ēsü*** *Čiŋgis-qahān dotora-'ān sergüjü'* [шөнө дунд өнгөрвөөс Чингис хааны ухаан сэргэж' (MNT 145)

Нөх-* |nökü| *'нэмэх'*, *'орлох'*, *'сэлбэх'* || Ж= *kesek* ***nökebe*** *dēli* 'нашил заплату на шубу' || Энэхүү язгуур дээр *-büri, -če, -d, -r, gesü, -lte* зэрэг дагавар залгаж, *nökübüri* [nökü-büri] 'нөхвөр', *nöküče* [nökü-če] 'нөхөц-', *nökün* [nökü-d] 'нөхөд', *nökür* [nökü-r] 'нөхөр', *nökügesü* [nökü-gesü] 'нөхөөс', *nökülte* [nökü-lte] 'нөхөлт' гэх мэт үгс үүсч, уламаар тэдгээрээс өөр шинэ шинэ үндэс салбарлан гарчээ || Kha. *nöxə-*, Ord. *nöᵘxö-*, Bur. *nüxö-*, Oir. *nökᵘ-*

Нөхөр |nökür|[= nökü-r] *'анд найз'* (бие биеэ нөхөх хүн) || Cf. Man. *nüxö* 'друг' (Цинциус I:609) Ж= *'orčilang-dur* ***nökür*** *kemegdekü qamiy-a bui'*

[орчлонд нөхөр хэмээгдэх хүн хаа буй](Burq. 24b) // *'jočin-dur* ***nökür-ün*** *degel-i dekčü'ü kündülegsen belge-yi üjegülümüi* '[нохорийнхоо дээлийг төчнөд дэлхий хүндэлсэний тэмдэг үзүүлэх](Sub.V:4a) // *'se'üder-ece busu* ***nökör*** *ügei* '[сүүдэрээс өөр нохоргүй] (MNT 77) // *nökör* 'compagnon', 'ami' (HY M80) // *nöker* 'друг' (Mu. 261, IM M152) // *nökür* 'друг' (IM 443) // *nöker* 'compagnon' (Ist. 58) // *nökör* 'associate comrade' (Ras. 200 C11) || Б. Я. Владимирцов энэ утгыг *'нөхөрлөхөө дур дуртэзрээ зээндээ дүүгээ өөдөө албат'* гэсэн утга илэрхийлж байсан гэж үзсэн бол Масао Мори *'бүх дүүгээ зээндээ зорилсон албат'* гэсэн утгатай гэжээ. || х о р ш : *'nökür segülder'* // *'анд нохор' 'найз нөхөр', 'хань нөхөр'* || х э л ц : *'nökür sirolya'* (английн олзноосоо хуваж хүртдэг байсан уламжилалаас үүдсэн хэллэг) Энэ хэлцийг I. de Rachewiltz *'friend the roast'* хэмээн орчуулсан буй. || Kha, Ord. *nöxör*, Bur. *nüxer*, Oir. *nökar*

Т у с х а й с у д а л г а а : Б. Я. Владимирцов, Монгольское *nökür*, Доклады Академии наук СССР, Серия В, 1929, 287-288 // Mori Masao, *Nökör* kōjosetsu, Tohogaku, No 5, 1952, 56-58

Нөхө- |nöküče|[= nökü-če] *'үлэх', 'учирах', 'холбогдох'* || Ж= *'mayui gergei mayui nökür kiged mayui qad-hu-a ken j-e* ***nökütekün'*** [муу эхнэр, муу нохор хийгээд муу хаанд хэн учирах](Sub. V:7a) // *'erdem-ten-dür ... erdem-i tayalayčin* ***nökütemüi*** [эрдэмтэнд ... эрдэмийг эрхэмлэгч л учирна](Sub. VI:12b) // *'sayin nökör-e tusa bo[l]su ke'ün* ***nökötejü*** *irebe bi'* [сайн нөхөртөө тус болоё хэмээн учирахаар ирлээ би' (MNT 92) // *'ma'ün-lu'a* ***nökütegsen*** *nere-tür üüi oron'* [мууд холбогдсон нэр үл зүүн](KMQB A20) || Энэхүү үйл үгээс *nökütel* [nökü-če-l] 'нөхцөл', *nöküteldü-* [nökü-če-ldü] 'нөхцөлд-', *nökütegül-* [nökü-če-gül] 'нөхцүүл-' гэх зэрэг нийлмэл бүтэцтэй үгс үүсчээ. || Kha. *nöχtsə-*, Ord. *nöʰχŏtši-*, Bur. *nüχese-*

Тэ* |te| *үгүүлэгчийн оршин буй газар, үгүүлэн буй цагаас харьцангуй хол зайтай газар орон, цаг хугацааг төлөөлөн заасан язгуур.* Тус язгууpаас газар орон заасан *tende* [te-(n)de] 'тэнд' зүг чиг заасан *teyisi* [te-yi-si] 'тийш', цаг хугацааг заасан *teǰiye* [te- ǰiye] 'тэзээ' гэсэн үгс үүсчээ. Дээрхээс гадана нэрийг төлөөлөн заах *tere* [te-re] 'тэр', *tede* [te-de] 'тэд', *tegün* [te-gün] 'түүн', нэрийн шинжийг төлөөлөх *teyimü* [te-yi-mü] 'тийм', тоо хэмжээг заах *tedüi* [te-düi] 'тэдий', үйлийн шинжийг заах *teyin* [te-yin] 'тийн' зэрэг үгс үүссэн бий. || Ж= *'degedü arši-nar-a yabuγdaγsan **teyimü** oron-dur asuru sayitur orošin saγuǰu'* [дээд арши нарт явагдсан тийм оронд асар сайнаар оршин сууж] (Burq. 2b) // *'Bodistv **teyin** qatud-un ayimaγ-i üǰebesü'* [Бодисадва хатадын аймагийг тэгэж үзвээс] (Burq. 17a) // *'**tedüi** toγatan ǰida baribasu'* [тэдий тоотой жад барьвал] (Burq. 57a)

Тэвч- |tebči| *'орхих', 'хаях'* || Ж= *'maγui aran-a könügegdegsen γaǰar-a sayid-i üǰebesü ber **tebčiyü'*** [муу хүнд хөнөөгдсөн газар сайчуудыг үзвээс орхино] (Sub. V:9b) // *qola **tebčibe** dēli* [далеко бросил шубу](Mu. 301) || Орчин цагийн

'тэнцэдхэ', *tengčegü* [teng-če-gü] 'тэнцүү', *tengčel* [teng-če-l] 'тэнцэл', *tengkege* [teng-ke-ge] 'тэнхээ', *tengkel* [teng-ke-l] 'тэнхэл', *tengkelig* [teng-ke-lig] 'тэнхэлэг', *tenggeče-* [teng-ge-če] 'тэнгэц', *tengne-* [teng-ne] 'тэгнэ', *tengnege* [teng-ne-ge] 'тэгнээ' зэрэг өдий төдий шинэ үгс үүсчээ. || Kha, Ord, Bur, Oir. *teŋ*

Тэн* II |tene| *'тэнийх'* гэсэн утгыг хадгалсан язгуур. Тус язгуураас *teneger* [tene-ger] 'тэнэгэр', *tenegün* [tene-gün] 'тэнүүн', *teneyi-* [tene-yi] 'тэний-' зэрэг үндэс гарчээ

Тэнгис |tenggis| *'далай'* || Cf. Turk. ***täŋiz*** 'море' (Радлов, III:10450, ДТС 552), *teŋiz* 'море' (ДТС 552), Uig. ***deŋiz*** *'sea'* (Schwarz 277) || Ж= *'**tenggis**-ün iruγar-i tuγulǰu irebe'* [тэнгисийн ёроолоор туулж ирэв](Sul. 12b) // *'**teŋgis** getülǰü irebe'* [тэнгис гэтэлж ирэв](MNT 1) || х о р ш : *'тэнгис далай'* || Kha. *teŋges*, Bur. *teŋgis* Oir. *teŋgıs*

Тэнгэли |tengkeli(g)|[teng-ke-li(g)] *'тэрэгний гол'* || Ж= *'tergen-ü **teŋgeli** quğus odba'* [тэрэгний гол хуга тусав](MNT 101)

Тэнгэр |tenggeri / tngri| *'диваажин', 'бурхан', 'огторгуй'* // Pl. *tenggeris* / tngris (BT 167a5) || Cf. Turk. *tägri / täŋgri 'небо', 'бог'* (Радлов, III:1039/1045, AT *täŋri* 'небо' (ДТС 544), AT. *teŋri* 'a very old word traced back to the Hsiung-nu. It seems originally to have meant *'the physical sky'* but very early acquired... came to mean *'heaven'* Uighur text consistenly spelt *'tŋri'* (Clauson, 523-24) || Ж= *'möngke **tngri-yin** küčün-dür'* [мөнх тэнгэрийн хүчинд](Khub. I:1) // *'teŋgeri-de ese ta'ālagdaba bida'* [тэнгэрт эс тааалагдав бид](MNT 143) // *'qaqča **tenggiri** medeyü'* [гагц тэнгэр мэдүү](KMQB A1) // *'**tengri** nasu öktügei čimadu* [даст тебе тенгри долголетие](Mu. 347) // *tengri čakimui* [молния](IM 448) // *tengri* 'Himmel' (LH 1270) // *tengri* 'dieu' (Ist. 68) // *tengäri* 'god', 'heaven' (Zir.137) // Ph. *dėŋri* 'Heaven' (Poppe, 52) || *'тэнгэр бурхан', 'тэнгэр газар', 'тэнгэр огторгуй'* || Kha, Ord. *teŋger*, Bur. *teŋgeri*, Oir. *teŋgər*

Тусхай судалгаа : М. П. Хомонов, О генезис слова *'тэнгри'* и *'огторго', 'Традиционный фольклор бурят'*, Улан-Удэ, 1980, 55-58 // Beffa M.-L & Hamayon, R. The Concept of *Tänggäri* in the Secret History of the Mongols, *'Монголын нууц товчооны 750 жилийн ойд зориулсан олон улсын бага хурал'*, Уб., 1995, 185-194 // S. Georg Türkisch / Mongolisch *tengri* 'Himmel, Gott' und seine Herkunft. *Studia Etymologica Cracoviensia*, vol. 6, 2001, 83-100

Тэнгэц- |tenggeče|[teng-ge-če] *'тэнцэх', 'дүйцэх'* || Ж= *'tngri-dür **tengge-čen** taqiqui-ača degedü ügei'* [тэнгэртэй дүйцүүлэн тахихаас дээд үгүй](Taq. 17a) || Kha. *teŋgets-*

Тэнз |tengse|{< Chin. téng zi} *хуласны төрөлийн модлог ургамал* || х о р ш : *'тэнзэн ташуур'* || Kha. *teŋdzə*

Тэний- |teneyi| *тэнэгэр болох, тэлэх* || х э л ц : *'нуруу тэний'* (бие амарах) || х э л ц : *'борви тэнийх'* (өсч том болох), *'гар тэнийх'* (өглөг өгөх), *'нуруу тэнийх'* (амарах), *'магнай тэнийх'* (баярлах), *'сэдхэл тэнийх'* (сэдхэл амарах) || Kha, Bur, Oir, Oir. *tenī-*

Тэнхим |tingkim|{< Chin. *tīng* 'том ороо' + kim} *'том ороо'* (олон хүн цугларч хуралдах том өрөө. Орчин үеийн монгол хэлэнд их сургууль дахь сургалт-судалгааны мэргэжлийн товийг нийн нэрлэнэ) || Kha. *teŋᵏxem*

Тэнхэлэг |tengkelig|[= teng-ke-lig] *'гол', 'төв'* || Ж= ***tenggelig*** *sümе-dür ireǰü mörgüǰü'* [гол сүмд ирж мөргөж](Dun.I:22) || х о р ш : *'гол тэнхэлэг'* || Kha. *teŋxᵏcleg*, Ord. *teŋgelik*

Тэнц- |tengče|[= teŋ-če] *'тэнцүү байх'* Энэ үгээс *tengčebüri* [teŋ-če-büri] 'тэнцвэр', *tenčegül* [teŋ-če-gül] 'тэнцүү', *tengčel* [teŋ-če-l] 'тэнцэл' гэх мэт үгс үүсчээ. || Kha, Oir. *teŋtsə-*, Ord. *teŋtši-*, Bur. *teŋse-*

Тэнэ- |tenü| *'дэмий хэсэх' сэлгүүцэх* || Энэ язгуураас *tenümel* [tenü-mel] 'тэнэмэл', *tenümekei* [tenü-me-kei] 'тэнэмхий', *tenegül* [tene-gül] 'тэнүүл', *tenegüčile* [tene-gü-čile] 'тэнүүчил', *teneg* [tene-g] 'тэнэг' гэх мэт үгс үүсчээ. || х о р ш : *'хэсээж тэнэх'*

Тэнэг |teneg|[= tene-g] *'мангар'* (ухаан санаа нь нэг зүйл дээр оноож тогтохгүй, энд тэнд тэнэж хэсэж явдаг) || Cf. Man. *teneg* 'глупец' (Цинциус II:236) || х о р ш : *'тэнэг мунхаг'* || Ж= *'төрийн хүний шинж биш,* ***тэнэг*** *мунхагийн явдал'* (Д. Намдаг, Цаг төрийн үймээн) || х о р ш : *'тэнэг мангуу', 'тэнэг мүлгүү', 'тэнэг мунхаг'*

Тэрбум |terbum|{< *ther 'bum*} *'арван дүнчүүр'* (арван оронтой тоо) || Kha. *terbum*

Тэргүү(н) |terigün| 1.*'толгой'*, 2. *'эхний', 'дээд'* || Ж= **1**. *'bars* ***terigütü*** *altan gerege ögčü'* [барын толгойт алтан пайз өгч](Chang.35) // *'selm-e-ber-iyen* ***terigün****-i anu čabčibai'* [сэлэмээрээ толгойг нь цавчив](ET 63b) // tergün 'голова' (IM 448) // *täriyün* 'голова' (IM M130) // *terün* 'Kopf' (LH 1269) // *tergün* 'tête' (Ist. 68) || Ж= **2**. *quluyan-a jil junu* ***terigün*** *sara-yin nigen šinede* [хулгана жил зуны тэргүүн сарын шинэд](BT 163a), *'arban orod-un eng* ***teri-gün*** *oron maši bayasqulang-tu neretü boluγu'* [арван ороны хамагийн дээд нь Маш баясхалант нэртэй буюу](BT 163a10) // *'gurban müred-ün* ***teri'ün*** *ken-e ber bü bawüludqun'* [гурван мөрөний эхэнд хэнийг ч бүү буулгагтун](NBT 179) || Энэ үгээс *terigüle-* [terigü-le] 'тэргүүл-', *terigüten* [terigü-ten] 'тэргүүтэн' зэрэг нийлмэл бүтэцтэй үгс үүсчээ. || х о р ш : *'толгой түрүү'* || Kha. *tergün / türü*, Ord. *terigün*, Ord, Bur, Oir. *türün*

Тэргүүл- |terigüle|[= terigü-le] *'удирдах', 'эхлэх'* || Ж= *'Anandati neretei ökin inü* ***terigülen'*** [Анандати нэртэй охин тэргүүлэн](Burq. 61a) // *'quluyan-a jil junu terigün sara-yin nigen šinedeče* ***terigülen*** *Bodistv-a čary-a avatar-un tayilbur-i Daidu daki čayayan suburγatu yeke süme-dür tamγa čoγulγaγulǰu'* [хулгана жил зуны тэргүүн сарын шинийн нэгэнээс эхлэн Бодичаряа-аватарагийн тайлбарыг Дайду дахь цагаан суваргат их сүмд бар сийлүүлж](BT 167b5)

Тэргүүлэгч |terigülegči|[= terigü-le-gči] *'удирдагч', 'толгойлогч'* || Ж= *'šimnusun küregen-i* ***terigülegči*** *noyan inu čibiltü šimnu-da ögüler-ün'* [шимнусын хүрээний толгойлогч ноён чивэлт шимнуст үгүүлэрүүн](Burq. 58a)

Тэргүүтэн |terigüten|[= terigü-ten] *'нар', 'тэрэг'* || Ж= *'daginas mayus terigüten nigüleskül sedkilten boltuyai'* [дагинас муус тэргүүтэн нигүүлсэхүй сэдхэлт болтугай](BT 158a5) // *'Ča'ādal, Batu teri'ūten bara'ūn ğar-un kō'ūd'* [Чагаадай, Бат тэргүүтэн баруун гарын хүвүүд](MNT 269)

Тэрлэг |terlig| *'холосовч'* (зуны нимгэн дээл) || Cf. Turk. *tārlik 'кошма под чапраком'* (Радлов, III:1072), *terlik* 'потник' (ДТС 555), AT. *terlik* 'smth which absorbs sweat' (Clauson 546), // *tārlik* 'sweaty' (Schwarz, 187) || Ж= *terlik* 'потник' (Mu. Suppl. P 407) || х о р ш : *'мэрлэг дээл'* || Kha. *terleg*, Bur. *terlig*, Oir. *terlıg*

Тэрс |ters| *'буруу үзэл', 'эсэрэг сургаал'* // Pl. tersūd || Cf. Turk. *tārs* 'противный, наоборот' (Радлов, III:1076) || Ж= *ters nomtan-i gesegekü-yin tulada'* [буруу номтоныг гэсхээхийн тул](Burq. 36a) // *'ters nomtan jayyn takil öglige-yi üyiledübesü'* [тэрс номтон зуун тахил өглөг үйлдвэс](Chimeg 32a) || Энэ үгээс *'мэрсүүд'* гэсэн олон тоот нэр үүссэн нь бүддийн ном зохиолд өргөн хэрэглэгддэг. || Kha, Oir. *ters*, Ord. *derse*

Тэрсүүд |tersegūd| *'мэрс буруу үзэлтэнүүд'* (бурханы шашины ёс уламжилалыг үгүйсгэх үзэл) || Ж= *'Sa-sky-a pandita Gün-dgah-rgyal-mc'an kemekü ber enedkeg-ün dumdadu oron-dur ögede bolǰu ters-ūd-ün yayiqaysan pandida luy-a šasin-iyan meljege talbiǰu yirü-yin dörben jūyil uqayan-iyar temčeldüged ters-ūd yartabai'* [Сажа бандида Гунгаажалцан хэмээх бээр энэдхэгийн дундад оронд өөд болж, тэрсүүдийн гайхсан бандидатай шашины мэлзээ тавиж, ерийн дөрвөн ухаанаар тэмцэлдээд тэрсүүд гартавай](OM 3a)

Тэрэг |terge| ачилга, уналтад зориулсан дугуйтай тээвэрийн хэрэгсэл || Cf. Man. *terge* 'телега' (Цинциус II:238) || Ж= *'ger tergen-iyen talbiǰu'* [гэр тэрэгээ тавиж](BT 160a12) // *'qoyar kūrdütei tergen nōgō'ē kürdü-bēn quğura'āsu newūn yadayu'* [хоёр хүрдтэй тэрэгний нэг хүрд нь эвдэрвээс хөдөлөн ядюу](MNT 177) // *tergen* 'телега' (Mu. 349) || х о р ш : *'мэрэг чарга', 'машин мэрэг', 'сүйх мэрэг'* || Kha. *tereg*, Ord, Bur. *terge*, Oir. *terg²n*

Тэрэгүүр |tergegür| х у у ч : *'мэрэгний зам'* || Ж= *'tergegür-ün dergede enelün šinalun kebtekü ebečin kümün-i üjeǰü'* [замын хажууд энэлэн шаналан хэвтэх өвчтэй хүнийг харж](Burq.8b) // *'teŋgiligetei tergen-i terge'ūr de'ēre bü te'ū-re'ūlsü'* [тэнгилигтэй тэрэгийг зам дээр бүү тээглүүл](MNT124) //*'mör ter-ge'ūr ne'ēlge ülgen'* [зам мөр нээлгэн](KMQB B4)

Тэрэм I |term-e| *'давхарлаг', 'асар', 'чачир орд'* // *тэрэм* 'the wooden grate of the walls of a felt tent (Lessing, 806) || Ж= *'Oŋ qan altan terme bosqaǰu'* [Он хан алтан асар босхож](MNT 184) // *tērme* 'tente' (Ist. 68) // *terme* 'tent' (Ras. 202 A10) || Kha. *terem*, Ord. *terme*, Oir. *termə*

Тэрэм II |term-e|{< Tib. *ther ma*} *'халцгай'* (анхандаа хонины ноосоор нэхсэн нимгэн даавууг нэрлэж байгаад хожимоо хатуу, зузаан цэмбэн даавууг нэрлэх болжээ).

Тэх |teke| *'эр янгир'* || Cf. Turk. *taka* 'козел' (Радлов, III:1016), AT *tekā* 'козел' (ДТС 550), *tekē* 'he goat' (Clauson 477); Man. *texe* 'козел' (Цинциус

II:236) || Ж= *oqraba teke* [козел блеял](Mu. 267) || Kha. *tex*, Ord. *de*ᵏ*xe*, Bur. *texe*, Oir. *tek*

Тээрэм |tegerme| тариа будаа нунтаглах хэрэгсэл // Pl. *tegirmed* (Khub. I:22) || Cf. Turk. *tägirmän* 'мельница' (Радлов, III:1035, (ДТС 548), *tägirmän* 'Mühle' (Gabain 339); AT. ***tegirme*** 'round, circular' (Clauson 488), *tegirmēn* 'a rotary mill for grinding corn' (Clauson 488) Энэ үг нь *tegirme* > *tegerme* > *te'erme* > *tērme* гэсэн хувьсалыг дамжсаар эдүгээгийн хэл аялгуунд *tērem* 'тээрэм' болжээ. || Ж= ***'tegirmen*** *orašiyulbasu'* [тээрэм байгуулваас](Turf. 15d) // ***tegirmenü*** *modun* [дерево мельницы](Mu. 345) // ***dägärmän*** *'мельница'* (IM M135) // ***termän*** *'mill'* (Zir.137) || Kha. *tērem*, Ord, Bur. *tērme*, Oir. *tērmə*

Удам |udum| *'төрөлийн үе'* || Ж= *'narbai ulus* ***udum-iyar*** *inu sayiǰirahuγui'* [нармай улас үе удамаараа сайн болох болтугай](Taq. 4b) || х о р ш : *'удам үгсаа', 'удам судар'* // *'үр удам'* || х э л ц : *'удам дагах'* (удамших), *'удам дамжих'* (үеэс үед дамжих), *'удам тасарах'* (удам залгах хүүхэдгүй болох) || Kha, Bur. *udam*, Ord. *udum*, Oir. *udᵊm*

Удамбар |udumbar|{< Uig. *udumbar* < Skr. *udumbara*} *өндөр иш, том дэлбээтэй ургамал* || Cf. Man. *udaǧan* 'смоква' (Цинциус II:248) || Kha. *udambar*, Ord. *udumbar*

Удаяана |udayana|{< Skr. *udayāna*} *'үргүүлэгч'* (Төвөдийн анхны хан хүү)

Удвал |udbala|{< Uig. *utpal* < Skr. *utpalā*} *'усан сараанаа'* (улаан өнгөтэй, анхилам үнэртэй цэцэг) || Ж= *'altan önggetü barayun yar-iyar* ***udbala*** *čečegtür adali gilbelün bükü ildü-ber rašivar-un önggetü üǰeskülengtü γou-a üsüniyen oytalju'* [алтан өнгөт баруун гараараа удвал цэцэг шиг рашиварын өнгөт үзэсхэлэнт гоо үсээ огтолж](Burq. 25a) // *'čaγan* ***udbala*** *kiged güimüda čečeg'* [цагаан удвал хийгээд гүмүда цэцэг](Chimeg 55b) || Kha, Bur. *udwal*, Ord, Bur. *udbal*, Oir. *udwᵊl*

Удган |*iduγan*|[= idu-γan] *'эм бөө'* || Cf. *idugan* 'female shaman' (Clauson 324), *iduq* 'священный' (Щербак 1997, 120); Man. *ugagan* 'шаманка' (Цинциус II:248) || Ж= *idugan* 'shamaness' (Ras. 205 C30) || Ж= ***'удган бөө нарын хуурмагийг мэдээд тэндээсээ зайлан одсон аж'*** (Д. Намдаг, Цаг төрийн үймээн) || х о р ш : *'бөө удган'* || Kha. *udbgan*, Ord, Bur. *udagan*, Oir. *udgᵊn*, Dag. *yadagaŋ*

Удир-* |uduri| *'жолоодох', 'залах'* гэсэн утгыг хадгалсан язгуур. Энэхүү язгуураас *udurid-* [uduri-d] 'удирд-', *uduriγulsun* [uduri-γul-sun] 'удиргуулсан' гэсэн үндэс үүсч уламаар олон шинэ үгс үүсчээ.

Удиргуулсун |uduriγulsun|[= uduri-γul-sun] *'уридчилан айлдах'* (ирээдүйд болох хэрэг явдалыг уридчилан айлдах) || Ж= *'amitan-u* ***uduriγulsun*** *itegel bodi jirüken-dür burqan bolqu-yin belge bui'* [амьтаны итгэл мөрөөдөл бодь зүрэхэн дэх бурхан болох бэлгэ буй](Burq. 48b)

Удирд- |udurid|[= uduri-d] *'жолоодох', 'залах', 'хөтөлөх'* Энэ үгээс *uduriduγači* [uduri-du-γači] 'удирдаач' *uduriduγči* [uduri-du-γči] 'удирдагч', *uduridumǰi* [uduri-du-mǰi] 'удирдамж', *uduridulγa* [uduri-du-lγa] 'удирдлага', *uduriduγul-* [uduri-du-γul] 'удирдуул', *uduridqal* [uduri-dqa-l] 'удирдхал' зэрэг үгс үүсчээ || Ж= *'ökid minü ta odču öčüken ǰalayu tere toyin-i öber-ün öber-ün erdem-iyen üǰegülǰü* ***uduridču*** *abču iredkün'* [охид минь та нар яваад өчүүхэн залуу тэр тойныг өөр өөрийн эрдэмээ үзүүлж, түүнийг залж авчирагтун] (Burq. 60b) // *'Oŋ qan-u miŋγan turqa'ūd-i* ***uduridun*** *Qori-šilemün taiši dobtul-tugai'* [Он хааны минган турхагийг удирдан Хори-шилэмүн тайшийг довтолтугай](MNT 170) || Энэ үгээс *uduriduγči* [uduri-du-γči] 'удирдагч', *uduridulγa* [uduri-du-lγa] 'удирдлага' зэрэг үгс үүсчээ. || Kha. *udirdᵊ-*, Ord. *udurid-*, Bur. *udarid-*

Удирдагч |uduriduγči|[= uduri-duγ-či] *'жолоодогч', 'манлайлагч'* (аливаа ажил үйлсийг удирдан жолоодох хүн) || Ж= *'ünen* ***uduriduγči*** *ögülegčid-ün naran učiraǰu'* [үнэн удирдагч үгүүлэгчидийн наран учирч](OM 7b)

Удирдлага |uduridulγa|[= uduri-du-lγa] *'жолоодлого', 'заллага'* || Ж= *'Бароны түрүүч цэрэг Баяр гүнгийн удирдлагаар довтлон ирлээ'* (Ч. Лодойдамба, Тунгалаг тамир) || Kha. *udirdlaġa*, Bur. *udaridalga* || Kha. *udirdlaġa*, Bur. *udaridalga*

Удирдхал |uduridqal|[= uduri-dqa-l] *'уридчилал', 'өмөнөдхөл'* (томоохон ном бүтээл, хөгжимийн зохиолын өмөнөдхөл хэсэг) || Kha. *udirdxal*

Узуур |uJaγur|[= uJa-γur] (< *hujayur*) *'уг гарал', 'язгуур'* || Cf. Turk. ***uza*** 'удлиняться', продолжаться долго (Радлов, I:1755) || Ж= *'**ujayur** inu gün-e ündüsülleyü'* [уг үндэс нь газарын гүнд үндэслэнэ](Hin. 50) // *'Čiŋgis qahan-u **huja'ur** de'ere teŋgeri eče jaya'atu töregsen Börte čino aju'u'* [Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяатай терсөн Бөртэ чоно ажгуу](MNT 1) // *tŭni **uja'ūri** setkibe* [думал об его происхождении](Mu. 361) // ***huJawūr*** 'Wurzel', 'Herkunft' (LH 76) // ***huja'ur*** 'racine' (Ist. 33) || Энэ үг нь өвөг монгол хэлний үеийн ***hujayur* гэсэн үгээс > *xujayur* > *hujayur* > *huja'ur* > *uja'ur* > *uju'ur* > *ujūr* гэсэн үе шатыг дамжин орчин цагийн хэл аялгуунуудад *udzūr, yadzūr, yodzōr* гэх мэт хувилбаруудтай хэрэглэгдэж байна || Kha. *udzūr*, Ord. *udzūr*, Bur. *uzūr*

Уй* |uyi| *'гашуудал', 'эмгэнэл'* гэсэн утгыг хадгалсан язгуур. || Ж= *'уй гашуун болсон нөхөд нь гурван хоног хүндэдхэн сахив'* (Д. Намдаг, Цаг терийн үймээн) Энэхүү язгуураас *uyid-* [uyi-d] 'уйд', *uyila-* [uyi-la] 'уйл' гэсэн хоёр үндэс үүсч, тэдгээрээс *uyid-*[uyi-d] 'уйд-', *uyila-* [uyi-la] 'уйл- гэсэн зэрэг үгс үүсч, тэдгээрээс олон шинэ үндэс салбарлан гарчээ. || х о р ш : *'уй гашуу'* || Kha, Ord, Bur. *ui*, Oir. *ū*

Уйд- |uyid|[= uyi-d] *'уйдхарлах', 'сэдхэл гуних'* || Ж= *'üdeši manayar qaya-čal ügei ülü **uyidun** taqiyad'* [өглөө үдэш хагацалгүй үл уйдан тахиад](Chang. 16) *//'edö'ē bidan-ača **uyīdqu** čag bolba'* [одоо биднээс уйдах цаг нь болов] (MNT 118) Энэхүү язгуураас *uyidqar* [= uyi-d-qar] 'уйдхар', *uyidanggi* [uyi-d-ŋgi] 'уйданги' гэх зэрэг үгс үүсчээ. || Kha, Ord, Bur. *uid-*, Oir. *ūdı*

Уйданги |uyidanggi|[= uyi-d-ŋgi] *'уйдамхай'* || Ж= *'Jamuqa anda **uyīdaŋga** ke'ēgden büle'ē'* [Жамуха анд уйдамхай хэмээгдэх бөлгөө](MNT 118)

Уйдхар |uyidqar|[= uyi-d-qar] *'сэдхэлийн шаналан'* || Ж= *'**uyidqar** ügei sedkiltü yeke Bodistv burqan'* [уйдхаргүй сэдхэлт их Бодисадва бурхан](Burq. 47a) // *'bügüde **uyidqar** ügei küdülen takiju'üi'* [бүгэд уйдхаргүй хүндэлэн тахижээ](KMQB A8) || х о р ш : *'уйдхар гуниг'* || Kha, Ord, Bur. *uidxar*, Oir. *ūd'χɒr*

Уйдхарла- |uyidqarla|[= uyi-d-qar-la] *'уйдхартай байх'* || Ж= *'ene edür bi čečeglig-tür **uyidqarlan** odsuyai'* [би өнөөдөр цэцэрлэгт уйдхарлан явая](Burq. 7b)

Уйл- |uyila /ugila|[= uyi-la] *сэдхэл хөдөлөлийн уламаас нулмис гарах* || Ж= *'jarim anu **uyilan** jarim anu ebčegüben deleddün'* [зарим нь уйлан, зарим нь чээжээ дэлдэн](Burq. 9a) // *'ere-yi minü aburatugai ke'ēn uŋšiju qayīlaju **uyīlaba**'* [эр нөхөрийг минь авхартугай хэмээн үглэж, уйлан хайлав](MNT146) // *'yasiyudaju **ugilayad'*** [гашуудаж уйлаад](Chimeg 19a) // *örēn **huilaba*** [сам заплакал] (Mu. 280) // *uilaba* 'плакал' (Mu.362 // IM 449) // *uilaba* 'плакать' (IM M115)

// bū uila! 'ne pleure pas!' (Ist. 71) // *uilaba* 'weinte' (LH 1261) // *uwila* 'weep' (Kund.150) || х о р ш : *'уйлж хайлах', 'уйлж майлах', 'уйлж унжих'* || Энэ язгууpаас *uyilayan* [uyi-la-yan] 'уйлаан', *uyilangna-* [uyi-la-ŋna] 'уйлагна', *uyilaldu-* [uyi-la-ldu] 'уйлалд', *uyilangqai* [uyi-la-ŋ-qai] 'уйланхай' зэрэг үгс үүссэн байна. || х о р ш : *'уйлж дуулах', 'уйлж майлах', 'уйлж унжих', 'уйлж хайлах'* || Kha. *uil-*, Ord, Bur. *uila-* Oir. *ūl*

Ул |ula| *'хөлийн тавaг', 'гуталын ёроол'* Cf. *ul* 'основание', 'фундамент' (ДТС 608); Man. *ula* 'подошва' (Цинциус II:257) || Ж= *'oroi-ača köl-ün* ***ula-dur*** *kürtele'* [толгойноос хөлийн ул хүртэл](Burq.62a) *//'maŋlai-yin kölesün* ***ula****-dur kürtele,* ***ula****-yin kölesün maŋlai-dur ğartala'* [духны хөлөс уланд хүртэл, улны хөлөс духанд хүртэл](MNT 254) // *ula* 'bottom of the foot' (Ras.199 A18) // *ula* 'sole' (Zir.139) || х о р ш : *'ул мөр'* || Kha, Oir. *ul*, Ord, Bur. *ula*

Ула* |ula|{< *hula* < *χula* < **φula*} *'улаан'* гэсэн өнгийн утгыг хадгалсан анхдагч язгуур. || Энэхүү язгууpаас *ulabur* [ula-bir] 'улбар', *ulay-a* [ula-ya] 'улаа', *ulai* [ula-i] 'улай-', *ulalǰa-* [ula-lǰa] 'улалз' гэх мэт үндэсүүд үүсчээ.

Улаа I |ulay-a| *'буухиа шуудан хүргэгчийн унаа'* (өртөө хооронд буухиа элчийг хүргэх уналга) // Pl. *ulayad* (Turf.16) || Cf. AT *ulay* 'вьючное животное', 'верховой конь' (ДТС 608), *ulā* 'подвода', 'телега' (Щербак 2005, 53) || Ж= *'čerig-ün* ***ula'ā*** *turu'āi üdü'ūi-e qayira-la[d]qun'* [цэрэгийн улаа уналга тураагүй байхад гамнагтун](MNT 199 || х о р ш : *'улаа шүүс'* (унаа хөсөг, хоол хүнс) || Kha. Ord, Bur. Oir. *ulā*

Улаа II |ulay-a|[ula-ya] *'улаан'* (цусны өнгө заасан үүсмэл язгуур.) Энэ язгууpаас *ulayabtur* [ula-ya-btur] 'улаавтар', *ulayana* [ula-ya-na] 'улаагана', *ulayaǰin* [ula-ya-ǰin] 'улаагчин', *ulayada-* [ula-ya-da] 'улаад-', *ulayan* [ula-yan] 'улаан' зэрэг шинэ үгс үүссэн байна. || х э л ц : *'улаа бутарах'* (эрүүл, баяр хөөртэй царайтай байх)

Улаан |ulayan|[= ula-yan]{< *hulayan* < *χulayan* < **φulayan*} *'гал'* болон *'цус'*-ны өнгө. || Cf. Man. *fulğan.* Энэ үгээс *ulayanda-* [ula-yan-da] *'улаанд', ulayantan* [ula-yan-tan] *'улаантан'* гэсэн үгс үүсчээ. || Ж= *'tögürig ulayan yurban nidütei'* [төгөрөг улаан гурван нүдтэй](Maha A) // *hula'ān de'ēltü eme kü'ūn* [улаан дээлтэй эмэгтэй хүн](MNT 146) // *hula'an* 'roige' (HY M61) // ***hula'an*** *ǰimis* 'красный виноград' (Mu. 187) // *hulān bor* 'красное вино' (Mu. 186) // *ulān görēsün* 'олень' (Mu. 363) // *hulān* 'rot' (LH 76) // *hulān* 'красный' (IM 438, IM M153) // *hulân* 'red' (Ras.202 B27) // *ulān* 'red' (Zir.140) || Kha, Ord, Bur. *ulāŋ*, Oir. *ulān*, Dag. *xulān*, Dung. *χulan*, Bao. *fulaŋ*, Mngr. *fulān*

Улаач |ulayači|[= ulaya-či] *'буухиа элчийн дагуул'* (өртөө хооронд буухиа элчийг газарчилан дагуулж хүргэх хүн) || Ж= ***'ulayači-dača*** *ögör-e dörben ulayad ögčü yorčiyultuyai'* [улаачаас өөр дөрвөн улаа өгч явуултугай](Turf. 16:7) // *ǰüg ǰüg-ün minğad minğad-ača ǰamučin,* ***ula'āčin*** *ğarğaǰu'* [зүг зүгийн мингадуудаас замчин, улаачин гаргаж](MNT 279)

Улай- |ulayi|[= ula-i] *'улаан өнгөтэй болох'* Энэ үгээс *ulayid-* [ula-i-d] 'улайд', *ulayilya-* [ula-i-lya] 'улайлга-', *ulayira-* [ula-i-ra] 'улайр-', *ulayis-* [ula-i-s] 'улайс-' гэх мэт үгс салаалан гарчээ. || Ж= *'šimnu-yin köbegün tere üge-yi*

maši ülü tayalan nidüben ***ulayiǰu*** *ögüler-ün'* [шимнугийн хувгүүн түүний үгийг эс таалан нүдээ улайлган үгүүлэрүүн](Burq. 58b) // *hulaiba qačarni* [его щеки покраснели](Mu. 187) || Kha, Bur. *ulai*, Ord, Oir. *ulā*

Улас |ulus| *'хүмүүс', 'улас төр, газар нутагийн хувид тусхаар тогтоносон орон* || Cf. Turk. *ulus* 'народ' (Радлов, I:1696), *ulus* 'Reich, Land' (Gabain 347), *ulus* 'селение' (ДТС 611), Uig. *ulus* 'country, people' (Schwarz, 589) || Ж= *'Qamuγ Mongyol* ***ulus-un*** *noyad-i Buqa-[s]očiqai quriγsan-dur'* [Хамаг Монгол уласын ноёдыг Буха сочихайд цугласан үед](Yis. 2) // *'qamug-un qahān,* ***ulus-un*** *eǰen bolǰu'* [хамагийн хаан, уласын эзэн болж](MNT 53) // *'olon* ***ulus*** *irgen-ü de'ere qan bolqarun'* [олон улас иргэний дээр хан болгон](KMQB A2) || х о р ш : *'улас амьтан', 'улас гүрэн', 'улас орон', 'улас төр'* || Kha. *ulɔs*, Ord. *ulus*, Bur. *ulas*, Oir. *ul^{u}s*

Улуг |uluγ|{< Turk. *ulug*} *'их', 'дээд'* || Ж= *uluγ* 'king', 'noble', 'eminent' (Zir. 140)

Улхан |ulqun| х у у ч : *'довцог толгой'* || Ж= *'Begter* ***hulqun*** *de'ēre širğa ağtatan yisün mori qaraju sa'ūn bükü-dür'* [Бэгтэр довцог дээр гарч шарга агттан есөн морио харж суухад](MNT 77) || Bur. *ulχun*

Ум ма ни бад ме хум |o ma ni bad me hum|{< Tib. *om mani pad me hum*} *'линхуа цэцэгийн дундах эрдэнэ'* (Бадма /линхуа/ цэцэг нь хувиршгүй тоотой дэлбээнд дэлгэрдэг учир Бурхан багш түүнийг шашиныхаа хувиршгүй мөнхийн бэлгэдэл болгон авчээ. *Ум мани бад ме хум* гэдэг уншилга нь *'бадамын цэцэгэн дундах бурхан багш'* гэсэн утгыг илэрхийлдэг бөгөөд эх болсон зургаан зүйл, хамаг амьтаныг энэрэн нигүүлсэх утгыг багтаасан жанрайсиг бурханы зүрэхэн тарни юм)

Ум ма хум |om ma hum|{< Tib. *om a hum*} *'умаахум'* (бурханы бие, хэл, сэтгэлийн бэлгэдэл болсон гурван үсэг)

Ум хумгүй |um hum ügei|{< Tib. *om hum + ügei*} *'ум хумгүй'* (*'хоёрхон маанийн үсэг уншиж ч амжилгүй'* гэсэн утгатай энэ үгээр *'яарч сандарах'* гэдэг утгыг илэрхийлдэг. || Ж= *'ум хумгүй зугатаах'*

Ума* |uma| *'умгар', 'умайх'* гэсэн утгыг хадгалсан язгуур. Энэхүү язгуураас *umai* [uma-i] 'умай', *umayi-* [uma-yi] 'умай-', *umaǰa-* [uma-ǰa] 'умалз-', *umaday* [uma-day] 'умдаг', *umayana-* [uma-γana] 'умгана-', *umayar* [uma-γar] 'умгар' гэх мэт үгс үүсчээ.

Умай |umai|{< **uma + j*} *'ихэс'* (үр тогтох сав) || Cf. Turk. *umai* 'хранитель младенцев' (Радлов, I:1788), AT *umaj* 'детское место' (ДТС 611), *umāy* 'placenta, afterbirth a small container which comes out a woman's womb after a birth' (Clauson 165) || Ж= *'Raquli-badir-a eke-yin* ***umai-dur*** *orubai'* [Рахули бадар эхийн умайд оров](Burq. 24a) // *'eke-yin* ***umai-dur*** *oruǰu arban saras boluγad'* [эхийн умайд орж арван сар болоод](Chimeg 9b) // *umai* 'Gebärmutter' (LH 1261) || Kha, Ord. *umā*, Bur. *umai*, Oir. *omā*

Т у с х а й с у д а л г а а : D. Sinor, *'Umaj'*, A Mongol Spirit Honored by the Türks, *'Proceedings of the International Conference on China Border Area Studies'*, April 22-29, 1984, Taipei, 1985, 1771-1781

Умдаг |umadag|[= *uma + dag} *'бага хэвлий'* (умайн дээд хэсэгт байх овгор өөхлөг хэсэг) || Kha. *umdag*, Ord. *umadag*, Oir. *omādəg*

Умзад |umjad|{< Tib. *dbu mdzad*} *'эхлэн эохиоч', 'тэргүүлэгч'* (Бурханы шашины хуралын уншилгыг голлон уншигч аргил, бүдүүн хоолойтой лам. Томоохон сүм хийдийн газар *'сул умзад', 'дацан умзад'* гэсэн хоёр янзын умзад байжээ.) || Kha. *undzad*, Bur. *unzad*

Уна- I |una / uŋ| *дээрээс дороги ойчих* || Ж= *'qong keriy-e-de ergülkü yasutu menekei kösör-e **unaǰuyui**'* [хон хэрээнд шүүрүүлсэн яст мэлхий газар унажээ](Sub. III:10a) // *'šiğui-yin amasar-a qošilig-un tedü i čagān gürü amasar-a bö[g]len unaju'* [шүгуйн амсарыг хошилогийн төдий цагаан чулуу бөглөн унажээ](MNT 80) // ***unaba** nilbusun nidünēse* [из него глаз выкатилась слеза] (Mu. 363) // *unaba* 'упал' (IM 449) // *unaba* 'to fall' (LH S24) // *una* 'fall' (Kund.150) || Энэ язгууртаас *unaya* [una-ya] 'унага', *unača* [una-ča] 'унац', *unalta* [una-lta] 'уналт', *unanggi* [una-ŋgi] 'унанги', *ungǰi-* [uŋ-ǰi] 'унжи-' гэх мэт олон үг үүсчээ. || Kha, Ord, Bur. *una-*, Oir. *un-*

Уна- II |unu| *'агт хөлөглөх', 'мордох'* || Ж= *'ta Bodistv-un **unuqu** morin-u köl-eče ergüdkün'* [та бодисадвагийн унах морины хөлөөс өргөгтүн](Burq.15b) // *'Belgüdei ogotur dargi qoŋgor-i **unuǰu** tarbağačilara odču büle'ē* [Бэлгүдэй оготор хонгорыг унаж тарвагачилахаар одож билээ](MNT 90) // ***unuba** ingendü* [поехал верхом на верблюдце](Mu.365) // *unuba* 'he mounted a horse' (LH S26) // *unuku* 'to ride' (Zir.140) || Энэ язгууртаас *unuya* [unu-ya] 'унаа', *unulya* [unu-lya] 'уналга', *unumayai* [unu-mayai] 'унамгай' зэрэг үгс үүсчээ.

Унага |unuyan|[= unu-yan] *'адууны нялх төл'* // Pl. *unuyad* (Turf. 53:16); *unukān* 'жеребенок' (Цинциус II:275) || Ж= *'qoyar dabayad nigen **unuyan**'* [хоёр даага, нэг унага](Turf. 53:4) // *'erte talbigsad **unuğan** eke-yü'ēn sün kököǰü'* [эрт тавьсан унага эхийгээ хөхөж](MNT 195) // *unayan* 'жеребенок' (Mu. 364) // *unaya* 'осленок' (IM 449) // *uŋya* 'осленок' (IM M124) // *unayan* 'Füllen' (LH 1258) || х о р ш : *'унага даага'* || Kha, Bur. *unaga*, Ord. *unagan*, Oir. *ung^{a}n*

Унага- |unaya|[= una-ya] *'ойчуулах'* || Ж= *'oytaryui daki naran sara-yi **unayan** čidabasu'* [огторгуй дахь нар сарыг унагаж чадвал](Burq. 64a)

Унгарил |ungyaril[= uŋya-ri-l-]{< *nuŋya-ri-l} *'модны хөвөн'* || Ж= *'modun-u **ungyaril**-i imerčü aman qabar čikin-ü nüked-eče sübeleǰü'* [модны унгарилыг имэрч, ама, хамар, чихний нүхээр сувлэж](Burq. 39a) // *'modun-u **ungyaril** öčügüken-e ködelgeg-dekü metü mayun-u aburi körbemtegü boluyu'* [модны унгарил өчүүхэн хөдөлөх мэт муугийн авир хөрвөмтгий болюу](Sub IV:12a)

Унгас |ungyasun|{< nuŋya-sun} *'ноос'* || Ж= *'ene basa eyītü qala'ūn-a **nuŋğasun** dotora ker da'ūsqu'* [ийм халуунд ноосон дотор хэрхэн тэсэх](MNT 86) // *'imayan-u ungyasun-i **unin** talbiysan arban qoyar ber-e'* [ямааны ноосны утаа тавьсан арван хоёр бэр](Chimeg 50b) // *buduqsan unqasun* [выкрашенная шерсть](Mu. 124) // *hečkegsen unqasun* 'нарезанная шерсть' (Mu.182) // *nunğasun* 'wool' (Ras. 205 C1) || х о р ш : *'унгас ноос'* || Kha. *uŋgas*, Ord. *uŋgusu*, Oir. *oŋgv^{s}n*

Унжуу |unǰiγu|[= uŋ-ǰi-γu] *'унжиж унах'* || Ж= *'yasu hüsü-bēn kemkerü unalduǰu, **hunǰi'ü** bayitala'* [яс үсээ хэмхэртэл унаж, унжуу санжуу болтол] (MNT 196)

Уни* |uni|{< *huni* < **funi*} *'утаа', 'униар'* || Ж= *'**unin** ō[ngge]tū'* [саарал өнгөт](Arj. I:8) // *'sayin ečige-yin činü nilqa nuntuğ **huni** butura'ūlčaju atuğai'* [сайн эцэгийн чинь багын нутаг утаа бургиулж байх байтугай](MNT 242) // *'imayan-u ungyasun-i **unin** talbiγsan arban qoyar ber-e burγudču'* [ямааны ноосны утаа тавьсан арван хоёр бэр зугатааж](Chimeg 50b) // *hunin* 'дым' (Mu. 187) // *'fumée'* (Ist. 34) // *huni* 'дым' (IM 438, IM M117) || Энэ язгууртаас *uniyar* [uni-yar] 'униар' гэсэн үг үүсчээ.

Униар |uniyar|{< *huni-yar*} *'будан', 'манан'* || Cf. Man. *onār* 'туман' (Цинциус II:20) || х о р ш : *'униар будан', 'утаа униар'* || Ж= *unin* 'fumée' (HY M61) || Kha. *uniār*, Ord. *unār*, Bur. *unyār*, Oir. *uñār*

Унц |unci|{< Rus. *унция* < Eng. *ounce* // It. *uncia*} *'унц'* (28,350 граммтай дүйх хүндийн хэмжүүрийн нэгэж)

Унш- |ungsi| 1. *'чангаар дуудах'* 2. бичиг, номын үг үсэгийг таниж дуудах || Ж= **1**. *'Temüǰin dürbeǰü ayisuqun irgen-dür Börte, Börte ke'ēn **uŋšiǰu** yabuqui-dur učiraǰu'* [Тэмүжин дүрвэн ирж байгаа хүмүүс рүү Бөрт Бөрт хэмээн чангаар дуудаж явсаар уулзав](MNT110) // *'Temüǰin-i ere-yi minü aburatuğai ke'ēn **uŋšiǰu** qayīlaǰu uyīlaba bi' ke'ēbe'* [Тэмүжинийг эрийг минь авартугай хэмээн дуудаж, хайлан уйлав би](MNT 146) || Ж= **2**. *ungšiba defteri* 'читал книгу'(Mu. 364) // *unšiku* 'read', 'call' (Zir.140) || Kha. *uŋši-*, Bur. *unša-* Ord. *umšə-*, Oir. *uŋš'-*

Ур* |ura| *'урлал', 'уран хийц'* Энэхүү язгууртаас *urala-* [ura-la] 'урла-', *uraliy* [ura-liy] 'урлаг', *uran* [ura-n] 'уран' гэх зэрэг үндэс үүсчээ || х о р ш : *'ур дүй', 'ур хийц', 'ур ухаан', 'гарын ур'* || Kha, Bur. *urɔ*, Ord. *ura*

Ураг |uruγ| 1. *хэвлийд бойжиж буй үр.* || Cf. Turk. *uruγ* 'seed, progeny' 2. *гэрлэлтээр дамжиж холбогдсон садан төрөл* || Ж= *'**uruγun uruγiγar** kedün kedün üyes-te kürtele ene dabariγunu buyan kürtügei'* [урагийн урагаар хэд хэдэн үе хүртэл энэ давирууны буян хүртүгэй](Mon. 1257:2) // ***urug**-un **urug** minu uqatuğai'* [урагийн ураг минь мэдтүгэй](MNT 103) // *uruq* 'qui est de la même famille' (HY 106) // *uruq* 'родственник' (Mu. 367) || х о р ш : *'ураг садан', 'ураг төрөл', 'ураг удам', 'худ ураг'* || х э л ц : *'ураг барилдах'* (урагийн холбоо тогтоох) || Kha, Bur. *urag*, Ord. *uruk*, Oir. *urʷg*

Урас- |urus| *шингэн зүйл гольдиролоор шилжих.* || Ж= *'sayin üyiles **urusqu** usun metü tasulši ügei iremüi'* [сайн үйлс урасах ус мэт тасаралтгүй ирнэ] (Chang. 47) // ***urusba** usun* [вода текла](Mu. 368) || Kha. *urʊs-*, Ord. *urus-*, Bur. *urda-*, Oir. *urʷs-*

Урасхал |urusqal|[= urus-qa-l] *'урасан өнгөрөхүй'* || Ж= *'urusqal-dur urusuyad nayuršiǰu ülü širgiyü'* [урасхалаар урасаад нуур болж үл ширгэюү] Hin. 50) || Kha. *urʊsxal*, Ord. *urudxal*, Bur. *uradxal*, Oir. *urʷsχol*

Урва- |urba| *'хөрвө', 'эргэх', 'солигдох'* || Ж= *'čikin-dür jokistu quyur-un dayun **urbaǰu** čingginaqui uyi dayun sonosdamui'* [хуурын зохист аялгуу уйдхартай жингэнэх аялгуугаар солигдон соносдов](Burq. 29b) // *'jada **hurbaǰu***,

mūd an-u de'ēre jada bolju'ū' [зад урваж мөд тэдний дээр зад болж] (MNT 143) // ***hurbaba*** *ni'ūri kederligēse* [его лицо отвернулось от грубости] (Mu. 187) // *urbaba* 'повернулся' (Mu. 366) || Энэхүү язгууpаас *urbayači* [urba-γači] 'урваач', *urbayana-* [urba-γana] 'урвагана', *urbayar* [urba-γar] 'урвагар', *urbayči* [urba-γči] 'урвагч', *urbal* [urba-l] 'урвал', *urbalya* [urba-lγa] 'урвалга', *urbalji* [urba-ljі] 'урвалж', *urbalja-* [urba-lja] 'урвалз', *urbalta* [urba-lta] 'урвалт', *urbayu* [urba-γu] 'урвуу' гэх мэт үндэс үүсчээ. || х о р ш : *'урваж шарвах'* (уулын бодол санаагаа өөрчилөх) || Kha, *urwɒ-*, Ord, Bur. *urwa-*, Oir. *urwᵒ-*

Уржи |urǰi| *'урид'* || Ж= *'Abul Maqmad Maqmud* ***urǰi-yin*** *yosuγar sujada-dur sayuju'* [Абул Махмад Махмуд уридын ёсоор сужад сууж](Bus. I.) // ***urǰi*** *hon* 'year before last year' (Ras. 201 A5)

Уржидар |urǰidur|{< *urǰi* 'урид' + *edūr* 'өдөр'} *'өчигдөрийн өмнөх өдөр'* || Ж= *urǰudur* 'третьего дня' (IM 449) // *urču üdür* 'позавчера' (IM M120) // *urǰi ödür* 'übermorgen' (LH 1259) // *urǰi ödür* 'before yesterday' (Ras. 201 A8) // *urǰā* 'day before yesterday' (Zir.141) || Kha. *urdžīdar*, Ord. *urdžidur*, Bur. *urzaderei*

Уржинан |urǰinun|{< *urǰi* 'урид') + *on* 'он'} *ноднингийн өмнөх жил* || Ж= *urǰi hon* [year before last year](Ras. 201 A5) // *urǰōn* 'year before last' (Zir.141) || Kha, Ord. *urdžinan*, Bur. *urzanan*, Oir. *urzᵒn dzil*

Урин |urin| *'хилин'* || Ж= *'**urin** gem-üd-i oγtolur-un'* [уурын гэмийг огтлон] (Maha. 6) || Kha, Bur, Oir. *ūr*

Ус |usun| *өнгө, амт, үнэргүй, тунгалаг шингэн* || Cf. Man. *oso* 'вода' (Циниус II:28) || Ж= *'ebesün* ***usun*** *dayan aduγun-i belčigeǰü'* [өвөс ус даган адуугаа билчээж](Jig.4) // *'če'ēl* ***usun*** *nidura-lu'ā čeügēn čilawūn čawūralu'ā'* [цээл ус цалгилаа, цэгээн чулуу цуурлаа] (MNT 72) // *usun* 'вода' (Mu. 368 / IM 449) // *usun* 'Wasser' (LH 1259) // *usun* 'eau' (Ist. 72) // *usun* 'water' (Zir.142) || Энэ язгууpаас *usula-* [usu-la] 'усла', *usuǰi-* [usu-ǰi] 'усж-', *usurqa-* [usu-rqa] 'усарх-', *usuči* [usu-či] 'усч' зэрэг үг үүсч, тэдгээрээс нийлмэл бүтэцтэй шинэ үгс салбарлан гарсан байна. || х о р ш : *'ус билчээр'*, *'ус мөрөн'*, *'ус нутаг'*, *'ус чийг'* // *'гол ус'*, *'нутаг ус'*, *'өөс ус'*, *'уул ус* || Kha. *usɒ*, Ord. *usu*, Bur. *uha(n)*, Oir. *usᵒn*

Ут- |utu| *'утааны үнэр шингэх'* (энэ язгууpаас *utaγ-a* [uta-γa] 'утаа', *utulγa* [utu-lγa] 'утлага' гэсэн үг үүсчээ. || Kha, Oir. *utɒ-*, Ord. *utu-*

Утаа |utuγ-a|[= utu-γa] *дутуу шаталтаас үүссэн эхүүн үнэртэй бодис* || Ж= *utuγa, utaγa(n)* (Ist. 889) || х о р ш : *'утаа униар'*, *'утаа май'*, *'утаа тортог'* || Kha, Ord, Bur, Oir. *utā*

Уулга |aγulγa|[= aγul-γa]{< *haγulγa* > *ha'ulγa* > *a'ulγa* > *u'ulγa* > *ūlga*} *'уулгал-'*, *'довтол-'* Энэхүү язгууpаас *u'ūl* 'уулга-' {< *a'ūlγa* < *ha'ūlγa* < **χaγūlγa*} гэдэг үг үүсчээ || Ж= *'bida teden-i* ***ha'ūluγa*** *ke'ēbe'* [бид тэднийг уулгалан довтолоё гэв](MNT 35) // *uridu morin* ***ha'ūlduqu*** [когда прежняя лощадь помчалась](Mu. 366) || Kha. *ūlgal-*

Уур I |aγur| *'хөөрөхүй'*, *'дэгдэхүй'* (халалтаас дэгдэх чийглэг манан) || Ж= *'aman qabar-ača* ***aγur*** *yabuqu usadču qoyar čikin-ü nüken-eče yeke dayun yarur-un'* [ам хамараас гарах уур устаж, хоёр чихний нүхнээс их дуу гарлаа](Burq.

36b) // *a'ur* 'air atmospherique' (HY M37) || х о р ш : *'уур манан'* || Kha, Ord, Bur, Oir. *ūr*, Dag. *aur*

Уур II |aγur| *'хилин'* || Ж= ***a'ūr**-iān darun yadaqu arslan metü'* [уураа даран ядах арслан мэт](MNT 78) // *a'ur* 'mortier' (HY M37) || 'х о р ш : *'уур омог', 'уур уцаар', 'уур хилин'* || Kha, Bur, Ord. Oir. *ūr*

Уур III |uur| *'уугуул', 'уулын'* (Энэ нь уттаа *uuγal, uul* гэсэн үгтэй язгуур нэгтэй, утга нэгтэй үг) || Ж= *'Čos kyi od-zer neretü kelemürči-lüge üy-e qoyar-un ary-a bilig-ün kičün-iyer **uur** mongγol-un ayalγu-bar nom-i delgeregüljükü'* [Чойжи-Одсэр нэрт хэлмэрчтэй үе хоёрын арга билигийн хүчээр уугуул монголын аялгуугаар номыг дэлгэрүүлжээ](OM 7b)

Уурга |uγa| морь мал цаламдан барих үзүүртэй бэхлэсэн хуйвтай урт мод || Cf. AT. *uruk 'rope'* (Clauson 215), *urga* 'шест с петлей для ловли лошадей' (Щербак 2005, 54) || Ж= *u'urqa* (1SH) // *urγa* 'веревка' (IM 449) || Kha. Ord. *ūrga*, Bur. *urga*, Oir. *ūrgv*

Уурла- |aγurla|[= aγur-la] *'хилигнэх'* || Ж= *'**aγurlaγsan** čir[a]i-yi ūjegüljü alar-a kürügči Maq-a-gali'* [уурласан царай үзүүлж алахаар хүрэгч Махагал](Maha. B) // *eke **a'ūrlaju**, tergen-eče bawü'ād'* [эх нь уурлаж, тэрэгнээсээ буугаад](MNT 244) || х о р ш : *'уурлаж загинах', 'уурлаж уцаарлах, 'уурлаж хилигнэх'*

Ух- |uqa| 1. *'малтах', 'онгилох'* || Cf. Man. *uχu-* 'выковыривать' (Цинциус II:255) 2. *'ойлгох', 'сэхээрэх'* Тус язгууртаас *uqayaji-* [uqa-γa-ji] 'ухааж-', *uqayal-* [uqa-γal] 'ухаал-', *uqayaliy* [uqa-γa-liγ] 'ухаалаг', *uqayan* [uqa-γan] 'ухаан', *uqayara-* [uqa-γa-ra] 'ухаар', *uqamsar* [uqa-msar] 'ухамсар', *uqayul-* [uqa-γul] 'ухуул-', *uqayulγa* [uqa-γu-lγa] 'ухуулга' гэх мэт үндэсүүд үүсч, уламаар тэдгээрээс илүү олон шинэ үгс үүссэн буй || Ж= **1**. Ж= *'Бид замдаа олж ирсэн сүүгээ нух **ухаж** хадгалаад хэд хоног цайгаа сүлэв'* (Ц. Дамдин-сүрэн, Хууч яриа) || Ж= **2**. *'sayin ūges-i merged-ün oyun-iyar **uqayu**'* [сайн үгсийг мэргэдийн оюунаар ойлгож](Sub. I:3b) // *'ede gurban kö'üd te'ün-ü'ēi būi je' ke'ēn eke-yū'ēn ečine keleldükü-yi eke anu Alan-gō'ā **uqaju**'* [эдгээр гурван хүвүүд түүнийх буй заа хэмээн эхээсээ далд хэлэлцэхийг Алангоа эх ойлгож] (MNT 18) // *'olon haran **uqatuqai** medetügei'* [олон хүн ойлготугай, мэдтүгэй] (KMQB A23) // *uqaba üileyi* [понял работу](Mu. 365) || х о р ш : *'ухаж малтах', 'ухаж төнхөх'* || Kha, Oir. *uxv-*, Ord, Bur. *uxa-*

Ухаан |uqaγan|[= uqa-γa-n] 1. *'хийсвэрлэн сэдхэх чадвар', 'хүн төрөлхитөний мэдлэг оюуны хурцтлал'* || Cf. Man. *ukān* 'ум' (Цинциус II:253) (Монголчууд энэдхэг, төвөдийн алдарт мэргэдийн зохиол бүтээлүүдийг *'дуун ухаан'* (хэл шинжилэл), *'учир шалтгааны ухаан'* (логик), *'тэжээхүй ухаан'* (анагаах ухаан), *'урлахүй ухаан'* (урлаг судалал), *'дотоод ухаан'* (гүн ухаан) хэмээн нэрлэсээр иржээ) 2. мэдэрэхүй || Ж= **1**. *'yeke boluγad **uqaγan** bilig inü busud-tača neng deger-e bolju'* [том болоод ухаан билиг нь бусадаас нэн илүү болж](Chang. 15) // *uqa'an* 'prudence, sagesse' (HY M106) || х о р ш : *'ой ухаан', 'оюун ухаан', 'ухаан санаа', 'ухаан мэдэрэл'* || х э л ц : *'ухаан сийлэх'* (хийж бүтээх арга замыг бодож олох), *'ухаан суух'* (аливаа юмын арга ухаан,

учир шалтгааныг бодож олох чадвартай болох) || Ж= 2. *'ухаан орсон чинь сэргийлэхэд шалан дээр морилж байв'* (Ч. Лодойдамба, Хугараагүй ноён нуруу) || х э л ц : *'ухаан алдах'* (ухаан балартах) || Kha, Bur, Ord, Oir. *uχāŋ*

Ухаар- |uqaγara|[= uqa-γa-ra]{< *uqaγap orи*} *'сэнхэрэх', 'ойндоо буулгах'* || Ж= *'юм **ухаарах** оюуны ам нээгдэх бур'* (Б. Ринчен, Гүнж) || Kha, Bur. *uχār-*

Ухагд- |uqaγda| *'ойлгогдох', 'ухаанд буух'* || Ж= *'nom-dur todqor kitü ketmen sudur-nuγud-tur nomlaγsan metü **uqaγdaqu'*** [номд тодхор хийнэ хэмээн сударнуудад номлосон мэт ойлгогдох](BT 157a2) || Kha. *uχagdɒ-*

Ухи-* |uki| х у у ч : *'дарж өмөсхө-'* || Ж= *'Hö'elün üǰin **ukitala** boγtalaǰu, hoǰitala būselejü'* [Өэлүн үжин малгайгаа дарж өмөсөөд, дээлээ шуун бүслээд] (MNT 74)

Уч |učiγ|{< ***uč-(i)γ*}** *'утасны үзүүр'* || Cf. Turk. ***uč*** *'конец'* (ДТС 603) || Kha, Ord. *utšig*, Ord. *utšik*

Учумаг |učumaγ| х у у ч : *'сум'* || Ж= *'Seŋgüm-i **učuma-'ār** eŋgesge qačar unatala qaǧdaǰu'* |Сэнгүмийг сумаар энгэсэг хацараа унатал харвуулж|(MNT 174)

Уя- |uya| *холбож тогтоох* || Ж= *'küǰügün-dür degesün yakin **uyaγdaqu** bölüge'* [хүзүүнд дээс яахан уягдах билээ](Burq.VIII:8b) // *yariqa **huyaba** noqaidu* [надел собаку ошейник](Mu.178) // *huyaba* 'закупорил' (IM 438) // *huyaba* 'band' (LH 77) // *huyagu* 'fasten', 'tie' (Ras.189 C7) || х о р ш : *'уяж хулэх'* || Kha. *uyɒ-*, Ord, Bur. *uya-*, Oir. *uj^{v}*

'raisins' (Ras.202 B8) // *üzüm* 'изюм' (IM M143) || Kha. *üdzem*, Ord. *üdžüm*, Bur. *üzem*, Oir. *üdz^{e}m*

Үзэсхэлэн |üǰeskülenɡ|[= üǰe-skü-leng] *'гоё үзэмж'* || Ж= *'ülemǰi you-a* ***üǰeskülengten*** *qatud-iyar qamuɣ ǰüg-eče küriyelegülǰü'* [тал бүрээсээ үлэмж гоо үзэсхэлэнт хатадаар хүрээлүүлж](Burq. 2b) // *'usun-u yowa* ***üǰesküleng'*** [усны гоо үзэсхэлэн](Chimeg 55b) || Kha. *üdzesxeleŋ*, Ord. *üdžis^{k}χüleŋ*, Bur. *üzeshelen*

Үйзэн |üyiǰeng|{< Chin. *wèi zhǎng*} *'үйзэн'* (Юань уласын үед хааны ордоныг хамгаалах цэрэгийн захирагч)

Үйл |üyile| *'ажил'*, *'явдал'* // Pl. *üyiles* (Khub. I:24) || Ж= *'sayin* ***üyile*** *üyiledkūi ber tendekin irgen imayi maši kündülen aǰuɣu'* [сайн үйл үйлдсэнээр тэндэхийн хүмүүс түүнийг маш хүндлэх ажээ](Chang. 12) // *'yeke* ***üyīle*** *tüšisü' ke'ēn soyurqaba'* [их үйл түшие хэмээн соёрхов](MNT 197) // *üile* 'affaire' (HY M108) // *üile* 'работа' (Mu. 375) // *üile* 'дело' (IM 449) // *üile* 'chose', 'affaire' (Ist. 72) || Эл язгууpаас *üyilečile-* [üyile-čile] 'үйлчил-' *üyiled-* [üyile-d] 'үйлд-', *üyiles* [üyile-s] 'үйлс' *üyiletü* [üyile-tü] 'үйлт' гэх зэрэг үндэсүүд үүсчээ. || х о р ш : *'үйл ажиллагаа'*, *'үйл лай'*, *'үйл там'*, *'үйл үртэс'*, *'үйл хэрэг'* || х э л ц : *'үйлээ эдлэх'* (урид хийсэн муу үйлийнхээ хариуд зовлон үзэх) || Kha. *üilə*, Ord, Bur. *üile* Oir. *ūlə*

Үйлд- |üyiled|[= üyile-d] *'хийх'*, *'бүтээх'* || Ж= *'mayui üyiles* ***üyiledkün*** *toyid-i balayad-un daruyas-ta noyad-ta dayayulǰu ögtügei'* [муу үйл үйлддэг тойдыг хотын дарга, ноёдод тушааж өгтүгэй](Khub. I:32) // *'takil öglige-yin üyiles-i tasurasi-ügei* ***üyiledüged'*** [тахил өглөгийн үйлсийг тасаралгүй үйлдээд] (Chimeg 27a) // *üile* ***üiletbe*** 'machte' (LH 1261) Энэ үгээс *üyiledbüri* [üyile-d-büri] 'үйлдвэр', *üyiledül* [üyile-dü-l] 'үйлдэл' *üyiledkün* [üyile-d-kün] 'үйлдэхүүн' зэрэг үгс үүсчээ.

Үйтэнхуар |üyitenɡquvar|{< Chin. *wō duàn huā er*} *'япон торго'* (товгор хээтэй зузаан торго) || Ж= *'Оюундарь ...* ***үйтэн хуар*** *дээл, сувдан даруулга, шанааны санжуурга, алтан ээмэг, минжин малгай гэхчилэнг шаардана'* (Д. Намдаг, Цаг төрийн үймээн)

Үл |üле / ülü| *'үлэмж'*, *'том'* гэсэн утгыг хадгалсан анхдагч язгуур. Энэхүү язгууpаас *ülüg* [ülü-g] 'үлэг', *ülemǰi* [üle-mǰi] 'үлэмж' гэх мэт үгс үүсчээ.

Үлд |üldü| *'илд'* || Ж= *'baraɣun yar-tayan* ***üldütei'*** [баруун гартаа илдтэй] (Maha. 11) // *'oŋgitu üldü-bēn bariba bi'* [онгит илдээ барив би](MNT 106) // *üldü* 'espèce de sabre' (HY M108) // *hildü* 'меч' (Mu. 184) // *üldü* 'меч' (IM 449, IM M122) // *yüldü* 'меч' (IM 450) // *hüldü* 'épée' (Ist. 35) // *üldü* 'Schwert' (LH 1257) // *üldü* (Musket' (Zir.144) || Kha. *ildə*, Ord. *üldü*, Bur. *yülde*, Oir. *üld^{e}-*

Үлд- |ülde| *'хөө-'*, *'мөшги-'* || Ж= *'Oŋ qan Togto'ā-beki-yi Barğuǰin-töküm jüg* ***hüldeǰü'*** [Он хан Тогтообэхийг Баргужин төхөм тийш мөшгин хөөж] (MNT 157) || х о р ш : *'үлдэж хоцор'* || Kha. *üldə-*, Bur. *ülde-*

Үлидхэ- |ülidke /ülüdke|[= ülid/ülüd + ke] 1. *'устха'*, *'дар-'* 2. *'чацуул-'*, *'жиш-'* || Cf. Turk. ölüt *'ал-'* || Ж= **1.** *'ğurban ǰa'ūd Mergid-i uruğ-un uruğ-a kürtele hünesü-'ēr keyistele* ***ülidkebe'*** [гурван зуун Мэргидийг урагийн урагаар нь үнэсэн товорог болтол дарав](MNT 112) || Ж= **2.** *'yeke qaryui bostala* ***ülidken***

amamnu ***hünir*** [запах рта](Mu. 100) // *hünür* 'запах' (IM 438, IM M153) // *hunuy* 'smell', 'odour' (Zir. 106) || х о р ш : *'үнэр амт'*, *'үнэр танар'* || х о р ш : *'үнэр авах'* (сураг чимээ сонсох, сэжиг авах), *'үнэр орох'* (өмхийрөх) || Kha, Bur. *üner*, Ord. *ünür*, Oir. *ün^{e}r*

Үнэс- |ünüs|[= ünü-s] *'таалан үнэрлэх'*, *'анхилам үнэрийг сэрж мэдэрэх'* || Ж= *'eldeb sayin ünürtü küjis ürgülji* ***ünüsden'*** [аливаа үнэр сайт хүж үргэлж сайханаар үнэртэнэ](Burq. 2a) // *'hünür minü* ***hünüsčü*** *yabu ke'ēn čamča-bān mültüljü'* [үнэрийг минь үнэрлэж яв хэмээн цамцаа мултлаж өгөхөд](MNT 55) // *hüniri* 'нюхал запах' (Mu. 192) || х о р ш : *'үнэсч үлгэх'*, *'үнэсч таалах'* || Kha. *üŋsə-*, Ord. *ünis-*, Bur. *ünede-*, Oir. *ün^{n}s-*

Үр |ür-e| 1. *'амьтан, үргамалын үржилийн эс'* 2. *'аливаа ажил үйлийн эцэсийн дүн'* // Pl. *üres* (Sul. 10b) || Cf. Turk. ***ürän*** *'семя, плодь, зерно'* (Радлов, I:1827) || Ж= 1. *'****ür-e*** *sačubasu ... ülü joqiqu'* [үр цацвал үл зохих](Turf. 15d) // *hüre* 'semences' (HY M62) // *jimišīn* ***hüren*** [зернышко винограда](Mu. 206) || х о р ш : *'үр зулзага'*, *'үр төл'*, *'үр хүүхэд'*, *'үр удам'*, *'үр жимэс'*, *'үр тариа'*, *'үр үндэс'*, *'үр шим'* || Ж= 2. *'sayin ači* ***ür-e*** *inü qoyidus uruγ-a kürkü šiltayan ene büyü'* [сайн ач үр нь хойчийн удамдаа хүрэх шалтгаан энэ буюу] (Chang. 39) || *'үр ашиг'*, *'үр дагавар'*, *'үр дүн'*, *'үр нөлөө'*, *'үр өгөөж'* || Kha, Oir. *ürə*, Ord. *üre*, Bur. *üri* Dung, Bao, Mngr. *jure*, Oir. *ür^{a}*

Үрэл ||{< Tib. *ril bu*} *'мөхлөг'* (адис жанлав, ариун зай шингэсэн бөөрөнхий мөхлөг) || Kha, Bur. *ürel*,

Үс |üsün|{< *hüsün*} *арисанд ургасан нарийн хилгас* || Ж= *'üjeskülengtü γou-a* ***üsün-iyen*** *oγtalju oγtarγui-dur oγorču'* [үзэсхэлэн гоо үсээ огтолж, огторгуйд хаяж](Burq. 25a) // *'nuğud, ğalawūd-un ödün* ***hüsün*** *anu burğalig časun metü butaraju'* [нугас, галууны өд үс нь бургалиг цас мэт бутарч](MNT 31) // *hüsün* 'cheveux' (HY M62) // *hüsün* 'волосы' (IM 438, IM M153) // *hüsün* 'cheveu' (Ist. 35) // *hüsün* 'Haar' (LH 76) // *hüsün* 'hair' (Ras.198 B15) // *üsü* 'hair of the head' (Zir.145) // *aldaraba üsün* 'его волосы распустились' (Mu.98) || *'үс ноос'*, *'үс сахал'*, *'үс хилгас'* || Kha. *üsə*, Ord. *üsü*, Bur. *ühen*, Oir. *üs^{ə}n*

Үтмэг |ütmeg|{< Uig. *ötmäk*} *'малх'* (хөрөнгөөр хөөлгөсөн гурилаар жигнэж хийсэн хөөмөл боов)

Үтэг |ütügen|[= ütü-gen]{< *hütügen* < *χütügen* < *φütügen*} *'нүх'* (эм бэлгэ эрхтэн) || Cf. *üt* 'дыра' ЭСТЯ 640), *üt* 'отверстие' (ДТС 629) || Ж= *ütügün* 'weibliche Scham' (LH 1258) // *hütügün* 'vulva' (Mu. 192) // *hütügün* 'vulve' (Ist. 35) // *hütgün* 'weibliche Scham' (LH 74) // *hütkün* 'pudendum of the female' (Ras. 199 A10) // *ütkün* 'vulva' (IM M119) // *ütügün* 'weibliche Scham'(LH 1258) // *hüdgün* 'weibliche Scham' (LH 74) // *üdkün* 'vulva' (Zir.142) || Kha. *üteg*, Ord. *ütügü*, Oir. *ütgən*, Mog. *utkun*, Oir. *ütg^{ə}n*

Үтэл |ütel-e| *'эгэл'*, *'жирийн'*, *'арай'* || Ж= *'öngge čirai-ban aldaju üsün-iyen sebsüyigsen* ***ütele ütele*** *amisqun yadan'* [өнгө царайгаа алдаж, үсээ сэгсийлгэн арай ядан амисхалж ядсан](Sub. 8b) || Bur. *üteli*

Үтэр |üter| *'хурдан'*, *'даруй'*, *'бушуу'* || Ж= *'nasuda teyin kü yabubasu ele* ***üter*** *qamuγ-i medegči bolumui'* [насандаа тийнхүү явбал](Sub. I:5b) // *'namayi*

Ф

Фабрик |fabrik|{< Rus. *фабрика* < Ger. *Fabrik* < Lat. *fabrica*} *'фаабрик'* (хонгон үйлдвэр)

Файл |fail|{< Eng. *file*} *'пайл'* (компьютерт хадгалсан нэгэн цогц материал)

Факс |faks|{< Rus. *факс* < Eng. *fax*} *'фаакс'* (*аливаа зураг, текстийг долгионоор дамжуулах хэрэгсэл)*

Фанатик |fanatik|{< Rus. *фанатик* < Lat. *fanaticus*} *'фанаатиг', 'хэнээрхэл', 'улайрал', 'биширэгч'*

Фасад |fasad|{< Rus. *фасад* < Fr. *facade*} *'фасаад', 'нүрэн тал'* (байшин, барилгын гудамж руу харсан нүүрэн тал)

Фен |fen|{< Eng. *fan* // Ger. *Föhn* < Lat. *favonius*} *'фээн', 'хөгжөөн дэмжигч', 'шүтэн биширэгч'* (урлаг, спортын уралдаан тэмцээнд оролцож буй тодорхой нэгэн баг болон тоглогчийг дэмжигчид)

Феникс |feniks|{< Rus. *феникс* < Gr. *phoinix*} *'фээникс', 'галт шувуу'* (үлэмж их гэрэл цацаруулан үхсэн ч гэсэн дахин амилж чаддаг, өнө мөнхийн бэлгэдэл болсон үлгэрийн галт шувуу)

Феномен |fenomen|{< Rus. *феномен* < Gr. *phainomenon*} *'феноменон', 'онцгой үзэгдэл'*

Феодал |feodal|{< Rus. *феодал* < Lat. *feodalis*} *'фийдал', 'хамжилгат ёс'*

Ферм |ferm|{< Rus. *ферма* < Fr. *ferme*} *'фээрэм'* (тодорхой чиглэлээр дагнасан үйл ажиллагаа явуулдаг хөдөө аж ахуйн хамтарал) || Ж= *'сүүний ферм', 'гахайн ферм'*

Фестивал |festival|{< Rus. *фестиваль* < Fr. *festival* < Lat. *festivus*} *'фистваал', 'баяр наадам'*

Физик |fizika|{< Rus. *физика* < Ger. *Physik* // Fr. *physique* < Gr. *φυσικὴ*} 'фийзиг' (бодисын зүй тогтолын судалал)

Физиологи |fiziologi|{< Rus. *физиология* < Gr. *φυσιολογία*} *'физлоог'* (бие организмын судалал)

Филармони |filarmon|{< Rus. *филармония* < Fr. *philharmonie*} *'филармоон'* (хөгжимийн хүрээлэн)

Философи |filosofi|{< Rus. *философия* < Gr. *φιλοσοφία*} *'филсооф', 'гүн ухаан'*

Фирм |firm|{< Rus. *фирма* < It. *firma*} *'фийрем', 'нүүс'*

Флаш {< Eng. *flash*} *'фалааш'* (багтаамж сайтай, санах ой бүхий авсаархан төхөөрөмж

Флегматик |flegmatig|{< Rus. *флегматик* < Gr. *phlegmatikos*} *'бүрэг номой'*

Фломастер |flomaster|{< Rus. *фломастер* < Eng. *flowmaster*} *'фалмаастар'* (өнгө өнгийн тосон бэхтэй будагч үзэг)

Флот |flot|{< Rus. *флот* < Fr. *flotte* < Sp. *flota*} *'фолоот', 'хөлөг онгоц'*

Фолдер |folder|{< Eng. *folder* 'хавтас'} *'фоолдер'* (компьютерийн санамжид хадгалагдаж байгаа материалуудыг утга агуулгаар нь багцлан хуваж, тодорхой нэр бүхий хавтасууд үүсгэх)

Х

Хаа- |qaγa| *'битүүлэх', 'халхлах', 'хориглох'* Энэхүү язгууpаас *qaγayda-* [qaγa-γda] 'хаагд-', *qaγaly-a* [qaγa-lγa] 'хаалга', *qaγalta* [qaγa-lta] 'хаалт', *qaγačayila-* [qaγa-čayi-la] 'хаацайл-' гэх мэт үгс үүсчээ. || Ж= *'qamuγ tngri-ner bügüdeger **qaγaǰu'*** [хамаг тэнгэр нэр бүгдээр хааж](Burq. 27b) // *'Odčigin-i ende-če, tende-če **qa'āǰu'*** [Отчигиныг энд тэндээс нь хааж](MNT 245) || х о р ш : *'хааж боох', 'хааж халхах'* || Kha, Ord, Bur, Oir. *xā-*

Хаагд- |qaγaγda|[= qaγa-γda] *'халхлагдах', 'түгжигдэх'* || Ж= *'aruγ-tur **qaγaγdaγsan** šibaγun* metü' [араганд түгжигдсэн шувуу мэт](Burq. 17b)

Хаалга |qaγalγa|[= qaγa-lγa] *'үүдийг нээж, хаах хавтас'* // Pl. *qaγalγas* (Burq. 14b) || Ж= *'nom-un **qaγaly-a-yin** gerel-iyer qatud-un ayimaγ-i šinǰileǰü'* [номын хаалгын гэрэлээр хатадын аймагийг ажиглаж](Burq. 17b) // *qa'alqa* 'battant de porte' (HY M85) // *qālγa* 'ворота' (IM 444) // *qahalqa* 'a gate' (Ras. 201 C22) || х о р ш : *'хаалга үүд'* || Kha, Ord, Bur. *χālğa,* Oir. *χālğɒ*

Цэмбэ |čengme|{< Tib. *phying ba*} *'эсгий'* (нэхээстүй үслэг зүзаан даавуу) || Kha. *tsembe*, Ord. *tšiŋme*, *tšimbü*, Bur. *sembe*

Цэн |čin|{< Chin. *ch'ién*} *'мөнгө зоос'* (лангийн аравны нэг буюу 10 пунтэй тэнцэх жин /3,7301 грамм/) || Kha. *tsenə*, Bur. *seŋ*

Цэрэг |čerig| *'байлдагч'* // Pl. *čerigūd* (Khub. I:5) || Монгол, түрэг хэлний дундын үг. Cf. AT. ***čerig*** 'troops' (Clauson 428), Uig. *čerik* 'soldier' (Schwarz, 357); Man. *čerig* 'война' (Цинциус II:421) || Ж= *'**čerig** aran-a toyid-ta irgen-e duyul-yaqui jarliy'* [цэрэг, ард, тойд, иргэдэд дуулгах зарлиг](Khub. I:6) // *'esergün-eče **čerig** haran qataraju, hergijü kürčü irejü'* [эсэрэг талаас цэрэг ардууд давхиж хүрч ирээд](MNT 100) // *čerik* 'armée' (HY M46) // *'olan **čerik**'* многочисленное войско' (Mu. 264) // *čerik* 'войско' (IM M132) // ***čirik*** 'Heer' (LH 1272) || х о р ш : *'цэрэг цуух'* || Kha. *tsereg*, Ord. *tširik*, Bur. *sereg*, Oir. *tserig*

Цэс |čes|{< Chin. *cè zi*} *'бүрэдхэл'* (нэрсийн жагсаалт)

Цэхэр |čeker| *'цэгээн'* || Cf. Uig. ***čeqir*** 'gray' (Schwarz, 358) || Kha. *tsexer*, Ord. *džŕxer*, Bur. *sexer*

Цэцэг |čečeg| уран тод *өнгөтэй* ургамалын эрхтэн || Монгол, түрэг хэлний дундын үг. Cf. Turk. *čäčäk* 'цветок' (Радлов, III:1988), AT. *čäčäk* 'цветок' (ДТС 143), *čäčäk* 'Blume' (Gabain 307), *čečeg* 'flowery, flower garden' (Clauson 404); Man. *čeček* 'цветок' (Цинциус II:422) || Ж= *'öngge ünür sayitu eldeb **čečeg** delgeren bayiqui'* [өнгө үнэр сайт элдэв цэцэг дэлгэрэн байхуй](Burq. 2a) // *čeček* 'fleur' (HY M46) // *čečegīn ūta* 'коробочка цветка' (Mu. 131) // *čeček* 'цветок' (IM 434) // *čičäk* '*цветок*' (IM M134) || х о р ш : *'цэцэг навч', 'цэцэг ногоо'* || Kha. *tsetseg*, Ord. *džitšik*, Bur. *seseg*, Oir. *tset*

Цэцэн |sečen| *'мэргэн'* || Cf. Man. *čečen* 'ум' (Цинциус II:422) || Ж= *'**sečen** biligten küčüten köbegüd činü tegün-e bökeyimüi'* [цэцэн билигтэн хүчтэн хүвгүүд

чинь түүнд бөхийнө](Burq. 58a) // *'anda* ***sečen*** *eketü törülki külüg töreǰü'* [анд цэцэн эхтэй, төрөлхийн баатар эр төржээ](MNT 201) // *čečen* 'умный' (IM 434) // *čäčän* 'умный', 'способный' (IM M132) || Эртний монголчууд цэцэн мэргэнийг дээдлэн бэлгэдэж, энэ нэрийг хүүхэддээ өгөх нь нийтлэг байсаны жишээг MNT-оос мэдэж болно. Үүнд: *Tumbinai-sečen* (MNT 47), *Dei-sečen* (MNT 61), *Suğu-sečen* (MNT 120), *Quyildar-sečen* (MNT 185) гэх мэт || х о р ш : *'цэцэн мэргэн', 'цэцэн цэлмэг'* || Kha. *tsetsen,* Ord. *džitšin, setšin,* Bur. *sesen,* Oir. *tsetsən*

Цэцэрлэг |čečerlig|[= čečeg-lig] *'цэцэрлэг'* (Анхандаа *čečeglig* байгаад гийгүүлэгч авианы солигдолын уламаас *čečerlig* болсон байна.) || Cf. Turk. *čečäklik* 'цветник' (Щербак 2005, 43) || Ж= *'küseg-seger yarqui ğalbavarags neretü modud-iyar küreyelegsen* ***čečeglig*** [хүссэнээр гарах галбарваас модоор хүрээлсэн цэцэрлэг](BT 157b) // *'čečeglig deki čambu modun-u següder-tür sayuǰu'* [цэцэрлэг дэх замба модны сүүдэрт сууж](Burq. 40b) || Kha. *tsetseg,* Ord. Bur. *seserlig*

Цээл |čegel| *'усны цунхээл', 'гүнзгий ус'* || Ж= *'gün* ***čegel****-ün dergede yabuqu metü'* [гүн цээлийн дэргэд явах мэт](Taq 6a) // ***'če'ēl*** *usun niduralu'ā'* [цээлийн ус цалгиллаа](MNT 72) || Kha, Oir. *tsēl,* Bur. *sēl*

Ч

Чавга |čibuγa| *'амтат жимэс'* || Монгол, түрэг хэлний дундын үг. Cf. Uig. *čubuqan* || Kha. *tšawagɒ*, Ord. *tšiwaga*, Bur. *šawga*, Kalm *tšiwgɒ*,

Чавганц үз Шимнанц

Чагна- |čingna-|{< **tïŋna*} *'чихээрээ соносох'* || Cf. Turk. *tynla- 'слушать'* (Радлов, III:1319), *tïŋla* 'слушать' (Щербак 2005, 45) || Ж= *'нүдээ нээлгүй **чагнан** хэвтэж байлаа'* (Б. Ринчен, Гүнж) || Kha. *tšagna-*, Ord. *tšiŋna-*, Bur. *šagna-*, Oir. *tšiŋnᵃ-*

Чагшаавад |čaγsabad|{< Skr. *śikṣapada*} *'сурталын шүтээн'* (бурханы шашин зан үйл, ёс сурталыг нарийн мөрдөх журамууд. Шашины санваартанууд цол зэрэгийнхээ дагуу өөр өөр ёс сурталыг мөрддөг байжээ) || Ж= *'büširel ügei **čaγsabad** ebdegsen nigen qulaγai toyin'* [биширэлгүй чагшаавад эвдсэн нэг хулгайч тойн](Turf. 10)

Чад- |čida| *'хийх', 'гүйцэтгэх', 'дийлэх'* Энэхүү язгуураас *čidabki* [čida-bki] 'чадавхи', *čidal* [čida-l] 'чадал', *čidamaγai* [čida-ma-γai] 'чадамгай', *čidamji* [čida-mji] 'чадамж', *čidaburi* [čida-buri] 'чадвар', *čidamaγ* [čida-maγ] 'чадмаг' зэрэг үгс үүсчээ. || Ж= *'ada tülegen-eče aburan tonilγaγulun **čidaquγu'*** [ад түлэгэнээс аваран зайлуулж чадах уу](Chang. 21) // *'γal anu usun-i **čidaqu** ügei'* [гал нь усыг чадахгүй](OM 22b) // *'Tayiči'ūd aqa de'ū-yīn ǧaši'ūn dawūsun yadan hači ken-e aburan **čidaqun** ū'* [Тайчууд ах дүүгийн гашуун зовлон дуусан ядан ач хэн авч чадах](MNT 77) // *čidaqu bolba* [стал способным](Mu. 133) || Kha. *tšadɒ-*, Ord. *tšida-*, Bur. *šada-*, Oir. *tšadᵇ-*

Чадал |čidal|[= čida-l| *'хүч тамир', 'чадвар'* || Энэхүү үүсмэл үг түрэг хэлэнд орсон байна. Turk. *čydal* 'сила, терпение' (Радлов, III: 2092) || Ж= *čidān* 'power', 'strength' (Zir. 95) || Kha. *tšadal*, Ord. *tšidal*, Bur. *šadal*, Oir. *tšidɒl*

Чадуу |čiduu|{< Chin. *zhá dāo*} *'заазуур'* (мах, гурил хэрчдэг хурц иртэй хутага)

Чакраварди |čakravardi|{< Uig. *čakiravrt* < Skr. *cakravartin*} *'хүрдэн эргүүлэгч'* (эртний энэдхэгт хүрд мэт туйлын хүчтэй эргэлддэг нэгэн зүйлийн зэвсэг эргүүлдэг дайчиныг ийнхүү нэрлэж байгаад хожим хүчирхэг хааныг нэрлэдэг болжээ) || Ж= *'dörben dvib-ün erketü **Čakravarti** qan'* [дөрвөн тивийн эрхэт Чакраварди хаан](Burq. 19b) || Kha. *tšakarvardi*, Ord. *dzagarvardi*

Чам |čim|{< *čin* < **tin*} Ганц тоот хоёрдугаар биеийн төлөөний *'чи'* гэсэн нэрийн шууд бус тийн ялгалын үүсмэл язгуур. || Ж= *'degedü včir **čima-dur** sögüdümü'* [дээд очир чамд сөгөдмүү](Manj. 81) // *'Dobun-mergen de'ū-de'ēn **čima-da** ǧuyuγa'* [Добун мэргэн дүү чамдаа гуйя](MNT 6) // *'bügüdeger **čimayi** qarančen sayun amui'* [бүгэдээр чамайг харан хүлээн сууна](Burq. 6b) // ***čima-dača** asayurun* [чамаас асуууун](Burq. 24b) // ***čima-lu'ā** miŋǧalaju eyetüldüjū* чамтай мингалж эвсэлдэе](MNT 209)

Чамар I |cimar|{< Tib. *phyi mar*} *'мостой малх'* (Бурхан тахилын өмөнө тавьдаг тосонд багсарсан арвайн гурилаар хийсэн өргөлийн идээ)

Чамар II |čimar| х у у ч : *'гэм буруу'*, *'зэмлэл'* || Ж= *'edö'ē qan ečige minū yambar* ***čimar-tur*** *minu čimadba'* [эдүгээ хан эцэг минь ямар гэмийг минь буруудхав](MNT 177) // *'bolǰal-un* ***čimar*** *edüi ügüleldüǰü'* [болзооноос хожимдсоны зэмлэлийг өдий хэлэлцэж](MNT 108) Энэ үгээс *čimarla-*[čimar-la] 'чамарлах-' гэсэн үйл үг үүсчээ.

Чамарла- |čimarla| *'зэмлэх'*, *'буруушаах'* || Ж= *'bolǰal ǧaǰar-a ǧurban üdür qoǰid bayiba ke'ēn qodulaqu-yi,* ***čimarlaqu-yi*** *Jamuqa de'ü medetügei'* [болзооны газартаа гурван хоног хожимдсон хэмээн яллан зэмлэхийг Жамуха дүү мэдтүгэй](MNT 108)

Чамин |čamin|{< Chin. *qiān men*} *'өмөнөд хаалга'* (Бээжин хотын өмөнөд үүдний дэргэдэх худалдааны гудамжнаас авчирсан тансаг барааг авсан газарынх нь нэрээр *'чамин'* хэмээн нэрлэж байжээ. Хожим хээнцэр гоё зүйлийг ийн нэрлэх болжээ)

Чанар |činar|{< **tinar*} *'амин сүлд'*, *'сэдхэл'* (хожимоо аливаа юмын дотоод бодит шинжийг заах болжээ.) || Ж= *'ǰürüken-eče töregsen eke-yü'ēn čimadqa ̄asu* ***činar*** *inu ǰekirčü'* [зүрэхнээс төрсөн эх юүгээн гомдоовоос сэдхэл нь хөрч] (MNT 254-53) || Kha. *tšanar*, Ord. *tšinar*, Bur. *šanar*, Oir. *tšinᵊr*

Чангаанз |čangyanǰa|{< Chin. *xìnggānzi*} *'хатаасан гүйлс жимэс'*

Чандар |čindar| *шатаасан шарилын унэс* || Kha. *tšaŋdar*, Ord. *tšindar*, Bur. *šaŋdar*, Oir. *tšindᵊr*

Чандаруу |čindaruu| *'үнэс нурам'* || х о р ш : *'үнэсэн чандаруу'*, *'үнэс нурам'* || Kha. *tšaŋdarū*, Ord. *tšindarū*, Bur. *šaŋdarū*

Чандмань |čindamani|{< Skr. *čintāmani*} *'хүсэлийг хангагч зэндмэнэ эрдэнэ'* (бүддийн ном зохиолд бие, хэл, сэдхэл гуравыг төлөөлсөн гурван дүгуй дүрсээр бэлгэдсэн хан төрийн долоон эрдэнийн нэг) || Ж= *'todqar arilqui* ***čindamani-yin*** *γurban tarni'* [тодхорыг арилгах чандманын гурван тарни](Bud. Col):1) // *'dalai-dur* ***cindamani*** *bui'* [далайд зэндмэнэ эрдэнэ бий] (OM 13a) || Kha. *tšandmani*, Ord. *tšindamuni*, Bur. *zendemeni*, Oir. *tšindᵊmāni*

Чансаа |činsaγ-a| *'яс чанар'* || Ж= *'Жомбоогийн гол мэдлэг бол аливаа морийг унаж тав гурван километр яваад тэр морины чанар* ***чансааг*** *бараг тоочиж чадна'* (Ц. Дамдинсүрэн, Морь шинжээч Жомбоо хүү) || х о р ш : *'чанар чансаа'* || Kha. *tšaŋšā*

Чантуу ||{< Chin. *ch'án-t'óu*} Анхандаа узбекуудыг ийн нэрлэдэг байсанаа хожим нь Дундад Азийнханыг нийтэд нь нэрлэх болжээ.

Чао |čau|{< Chin. *chāo*} х у у ч : *'цаасан мөнгө'* || Ж= *'tabun ǰayun* ***čau*** *sükes ōgūged'* [таван зуун цаасан мөнгө, мөнгөн ембүү өгөөд](Chang. 25)

Чаралба |čirulba|{< Tib. *phyi rol pa*} *'мэрсүүд'* (бүддийн шашины ёс жаягийг эсэргүүцэгч)

Чарга |čirγ-a|{< *čir-γa*} (цас, мөсөн дээр чирч, гулсуулдаг хэрэгсэл. Өөрөөр хэлвэл *čir-* 'чирэх' гэдэг үгээс гаралтай) || Cf. Turk. *syrγa* 'сани' (Räsänen 419) || Энэ нь уттаа *čire-* 'чир-' гэсэн үгээс гарсан бололтой. || Kha. *tšarga*, Ord. *tširga*, Bur. *šarga*, Oir. *tširgᵕ*

Час |čisa|{< Tib. *'chi gza*} *'үхэлийн гараг'* (хар зурхайн ёсонд юмс

үзэгдэлийн хоорондын харьцааг од гаригийн солбицолтой уялдуулан тайлбарладаг бөгөөд од гаригийн таван орчил, цаг хугацааны улиран давтагдах байдал нь тухайн хүний бие махбод, оюун сэтгэхүйд сөрөг нөлөөлдөгийг зурхайн аргаар тогтоож, тэр өдөрийг *муу өдөр* буюу *'час гариг'* гэж нэрлэдэг ажээ. Тухайлвал, бар, туулай жилтэнд *сугар гараг*, могой, морь жилтэнд *буд гараг*, үхэр, луу, хонь, нохой жилтэнд *бархасбадь гараг*, бич, тахиа жилтэнд *ангараг гараг*, гахай, хулгана жилтэнд *санчир гариг* муу өдөр буюу час гариг болно) || х о р ш: *'час өдөр'* || Kha. *tšas*

Чаур |čaγūr|{> *ča'ūr*} х у у ч : *'аян'* || Ж= *'ündür daba'ā daban, örgen mürеd getülün urtu* ***ča'ūr*** *ča'ūran, olon ulus-i'ān jibši'ērün'* [өндөр даваа даван өргөн мөхөн гаталан холын аян аялан олон уласыг түвшидхэн](MNT 254)

Чачир |čačir|{< Pers. *čādar*} *'acap'* (дөрвөн талтай том даавуун майхан) || Cf. AT. *čačïr* 'шатерь', 'палатка' (ДТС 135) || Ж= *'salalčaqui qurim qurimlaya ke'ēldüjü, yeke* ***čačir*** *bosqaju'* [салахын хурим хуримлая хэмээлцэн том асар босхож](MNT 275) // *čadur* 'палатка' (Mu. 130) // *čačir* 'tent' (Ras.202 A7) || Kha. *tšatšir,* Oir. *tsätš[i]r*

Тусхай судалгаа: H. Serruys, *Cacir, Cacar, Cadr* 'tent' in Mongol, ZS 17, 1984, 76-81

Чемодан |čemodan|{< Rus. *чемодан* < Pers. *jāmadān*} 'чимдаан' (аялал, зугаалгад авч явдаг түгжээтэй хөнгөн хайрцаг)

Чи |či|{< *čin* < **tin*} *'чи'* (хоёрдугаар биеийн төлөөний үгийн ганц тооны язгуур) || Энэхүү төлөөний нэрийн тийн ялгалаар ялгалагдах үндэс нь *čin-* 'чин', *čim-* 'чим', тийн ялгалаар ялгалагдсан хэлбэр нь *čimada* (Loc.), *čimadur* (Dat.), *čimača* (Abl.), *čimayi* (Acc.), *čimabar* (Instr.), *čimaluya* (Com.) болно. || Ж= *'ele mayui sedkiltü* ***či*** *namayi yakin čidaqu'* [ийм муу сэдхэлт чи намайг хэрхэн дийлэх](Burq. 40b) // *'Temüjin* ***či*** *ulus-un ejen bolu'āsu'* [Тэмүжин чи уласын эзэн болвол](MNT 121) || Kha, Ord, Oir. *tši,* Bur. *ši*

Чивил |čibil| *'хор хөнөөл', 'нүгэл'* || Cf. Turk. *čibil* || Ж= *'edüge bi amaramay yirtinčü-yin ejen inü* ***čibiltü*** *šimnu-da ese medegüljü'* [эдүгээ би амармаг ертөнцийн эзэн нүгэлт шимнуст эс мэдүүлж](Burq. 54a) || х о р ш : *'нүгэл чивэл'* || Kha. *tšiwel,* Oir. *tšiw[ə]l,* Bur. *šebel*

Чигүүрс |čigūresün|[čigū-re-sün] х у у ч : *'чөөрс'* (нарсны төрөлийн мод) || Ж= *'narasun* ***čigüresün*** *modu-tu kegür-tür yeke bii tas bayiyulju'* [нарс чөөрс модоор хийсэн шарилд их хөшөө босхож](Chang. 55) // *'Üjin eke sütan kö'üdiyēn teji'ērün* ***čigürsün*** *širo bariju södün gičigine uquju teji'ēbi'* [Үжин эх суутан хүвүүдээ тэжээхээр чөөрс шор барьж, сөд гичгэнэ ухаж тэжээв](MNT 74-7) // *čigörsün* 'cyprès' (HY M47)

Чигчий |čigečei|{< čigi-čei} *'жижиг хуруу'* || Ж= *'šigi quru'ün-u-'ān toli onuči kitugai-bār qadquju'* [чигжий хурууныхаа толиог хурц хутагаар хадхаж] (MNT 178) // ***šikčī*** *qurūn* 'мизинец' (Mu. 330) || Kha. *tšigtšī,* Ord, Bur. *šegšī,* Oir. *tšigtšigä*

Чидун |čidun|{< Chin. *ci tun* < Pers. *zeitun*} ногоон халистай, цагаан цэцэгтэй, анхилам үнэртэй бут

Чий |čii|{< Chin. *ch'ih*} *'чий'* (10 цун буюу 0,32 метртэй тэнцэх уртын хэмжээ)

Чийдэн |čideng|{< Chin. *ch'i-tēng*} *'хийн дэн'* (гэрэлтүүлэх цахилгаан дэн) || Kha. *tšīdeŋ*

Чийрэг |čigireg|{< *čigiraγ* < *tigiraq*} *'бат хатуу', 'эрүүл саруул'* || Cf. AT. *tigrāk* 'firm, though' (Clauson 471), Turk. *čīrak* 'dick, fest' (Räsänen, 112) || Ж= *'būlteyigsen* ***čigiraγ*** *kökōten'* [булцайсан чийрэг хөхтэй](Burq. 61b) // *'altan čila'ūn metū čing* ***či'īraq*** *ese bolu'āsu'* [алт чулуу мэт чин чийраг болваас] (KMQB A6) || Kha. *tšīreg,* Ord. *tširak,* Bur. *šīrag,* Oir. *tšīrəg*

Чийчаан |čičan|{< Chin. *ch'i-ch'ē*} х у у ч : *'уурын тэрэг'* (дотоод шаталтын хүчээр хөдөлөх тэрэг)

Чилийсан ||{< Chin. *qī lī xiāng*} *'хүж өвөс'* (ясны бэртэнгэд хэрэглэдэг эмийн ургамал)

Чим- |čime| *'гоёх'* || Cf. Turk. ***čīmä-*** 'arabeske' (Räsänen 111) || Ж= *'morin-u qaγan kantag-i üdter* ***čimeǰü*** *ögtügei'* [морины хаан кантагийг үтэр чимэж өгтүгэй](Burq. 1a) Энэхүү язгуураас *čimeg* [čim-(e)g] 'чимэг' гэсэн нэр үг үүсч, түүнээс хэд хэдэн шинэ үг дам үүссэн байна. || Kha, Oir. *tšim-,* Ord. *tšime,* Bur. *šeme-*

Чим* |čim|{< *čin} ганц тоот хоёрдугаар биеийн төлөөний нэрийн шууд бус тийн ялгалын үндэс. || ***čimada*** *önggeten dotortu törges soyurqaǰu* [чамд өнгөт дотортой торго барьж](Alt. 5) // ***čimadur*** *mayui belge yaγuqan ber ügei bui* [чамд муу шинж огтхон ч алга](Burq. 11b) // *bügüdeger* ***čimayi*** *qarančen sayun amui* [бүгэд чамайг хүлээн хүлцэн сууна](Burq. 6b) // *bi* ***čima-ača*** *anggi-da moridiyan ker abqui bölüge* [би чамгүйгээр морьдоо хэрхэн олж авах билээ](AT 22a) // *γayiqamsiγ lagšan-tu* ***čimaluγ-a*** *qamtudču* [гайхамшигт лагшинт чамтай хамтарч] (Burq. 61a)

Чимад- [čimad] х у у ч : *'зэмлэх', 'зөрчилдөх'* || Ж= *'Činggis qaγan-u uruγud döčin tabun od-ača inaγši-da* ***čimadulčaγsan-i*** *edüge ǰoqilduǰu'* [Чингис хааны урагийнхан дөчин таван жилээс нааш зөрчилдөн тэмцэлдэж байгаад эдүгээ ... зохилдож](Ölǰ.26) // *'kerbe γartabasu nöküd-tegen* ***čimaduyu'*** [хэрэв гартваас нөхөддөө зөрчилдүү](Sub. III:11) // *'delekei deger-e qamiγ-a yabubasu* ***čimadqu*** *yoloqu bolu'* [дэлхий дээр хаа явсан ч зөрчилдөх, голох үгүй бол] (Taq 7)

Чималихай |čimaliqai|[= čimali-qai| х у у ч : *'гомдол', 'хорсол',* || Ж= *'deger-e-eče dorudus-tur kürtele* ***čimaliqai*** *ügei-yi uqamu yu či'* [дээрээс дорогш хүртэл гомдолгүй буйг чи ойлгоно биз](Taq. 1b) // *'aqa de'ī̄-deče čimaliqai üge sonosba bi'* [ах дүүгээсээ гомдолын үг соносов би](MNT 281)

Чимар |čimar| х у у ч : *'гэм буруу'* || Ж= *'edö'ē qan ečige minü yambar* ***čimar****tur minu čimadba či'* [хан эцэг минь одоо чи миний ямар гэм бурууг чамлав] (MNT 177)

Чимархай |čimarqai|[čima-rqai] духны хоёр хажуу тал || Ж= *'deger-e-eče dorudus-tur kürtele* ***čimaliqai*** *ügei-yi uqamuyu či'* [дээрээс доош хүртэл чимархайгүй гэдэгийг чи мэдэхүү](Taq 1b4) || Kha. *tšimarxai,* Ord. *tšimarxā̄,* Oir. *tsam°rxā̄*

Чимэг |čimeg|[= čime-g] *'гоёл'* || Ж= *'linqu-a čečeg-iyer* ***čimegtü*** *nayur-un dotur-a'* [линхуа цэцэгийн чимэгт нуурын дотор](Burq. 2a) // *'jokistu ayalyu kemebesü udq-a-yin* ***čimeg****, ayalyu-yin* ***čimeg****, niγuča üge-yin* ***čimeg****'* [зохист аялгуу хэмээвээс утгын чимэг, аялгууны чимэг, нууц үгийн чимэг](Chimeg 2a) // *ene hirtüncīn* ***čimek*** [украшение этого мира](Mu. 157) || Энэ үгээс *čimegle-* [čime-g-le] 'чимэглэ-' *čimeglel* [čime-g-le-l] 'чимэглэл' зэрэг үгс үүсчээ || Kha. *tšimeg*, Ord. *tšimek*, Bur. *šemeg*, Oir. *tšimәg*

Чин |čing|{< Chin. *chéng*} *'үнэн шударга'* || Cf. AT. ***čiŋ*** 'true', 'genuine' (Clauson 424) || Ж= *'****čing*** *ünen sedkil-tü bögetele nasu ürgülji sayin üyile üyiledküi'* [чин үнэн сэдхэлт бөгөөтөл насан турш сайн үйл үйлдэх](Chang. 11) || х о р ш : *'чин сэдхэл'*, *'чин зүрэх'*, *'чин үнэн'* || Kha, Ord, Oir. *tšiŋ*, Bur. *šeŋ*

Чина* |čina| *'цаана'* гэсэн утгыг хадгалсан язгуур. Энэхүү язгуураас *činadu* [čina-du] 'чинад' (*цаад талд*), *činaγši* [čina-(γ)ši] 'чинагш *(цаашаа)*, *činaji* [čina-ji] *'цаадхи'*, *činaru* [čina-ru] 'чинару' *(цаашаа)* зэрэг үгс үүсчээ. || Ж= *čanaji ödür* 'après-demain' (Ist. 24) // *čināči ödür* 'послезавтра' (Mu. 134)

Чинагши |činaγši|[= čina-γši] *'цааш'* || Ж= ***'činaγšida*** *türgen-e odbasu'* [цаашид түргэн одвоос](Burq.27a) // *'dayīsun-u to'ōsun* ***činaġši*** *Mau-ündür-ün ebür-iyēr Hula'ān-buruġad jüg to'ōsun urtu-da ġarču,* ***činaġši*** *yorčibai'* [дайсаны тоос Мау өндөрийн өвөрөөр Улаан бургас тийш тоос татан цааш одов](MNT 173)

Чинаду |činadu|[= čina-du] *'цаад'*, *'тэртээ'*, *'эсрэг талын'* || Ж= *'čibiltü či* ***činadu*** *dayisun-a daruγdaju'* [чивэлт чи эсрэг талын дайсандаа дарагдаж] (Burq. 64a) // ***'činadu*** *dayīsun kü'ūn olon qarin bui'* [эсрэг талын дайсан олон харь хүн бий](MNT 270)

Чинажи |činaji|[=čina-ji] *'цаад талын'* || Ж = *'Tayiči'ūd Onan-u* ***činaji*** *ete'ēd hüle'ūd-turastan čeri'ūd-iyēn jasaju qadqulduya ke'ēn jasaju baiju'ūi'* [Тайчууд Ононы цаад тал дахь бусад бэхлэлтийн цэрэгүүдэс бэлдхэн тулалдая хэмээн бэлдхэж байв](MNT 144-13) // ***činači*** *ödür* 'послезавтра' (Mu.134) // *čanaji ödür* 'après-demain' (Ist.24) // ***činâji*** *ödür* 'the day after tomorrow' (Ras.201 A26)

Чинару |činaru|[= čina-ru] *'цаашаа'*, *'илүү'* || Ж= *'qan oron-iyan qayiralal ügei nilbusun-ača ber* ***činaru*** *sedkijü'* [хаан суудалаа хайрлалгүй нулмиснаасаа ч илүүгээр санаж](Burq. 30b) // *'Oŋ qan düled nadača* ***činaru*** *aju'ū'* [Он хаан надаас бүрмөсөн цааш харжээ](MNT 170)

Чингис |Činggis| *Их Монгол уласыг үндэслэн байгуулагч их хаан.* || Чингис хааны нэрийн талаар олон эрдэмтэдийн өөр өөр санал байдаг байна. Анх XVIII зууны эхээр Абул-гази гэдэг эрдэмтэн *'Татаарчуудын гаралын түүх'* гэдэг бүтээлдээ уг нэрийг *Чин* 'агуу их' + *гис* 'давуу зэргийг илэрхийлсэн дагавар' хоёроос бүтсэн *'бүхэнээс хүчирхэг'* гэсэн утгатай үг гэсэн таамаг дэвшүүлжээ. Түүний дараа франц эрдэмтэн Langlѐ түүнийг перс хэлний *jeŋ-engiz* 'дайнч' гэсэн үгтэй холбон үзсэн байна. Энэ нь угтаа дөрвөлжин бичигийн монгол дурасхалуудад их хааны нэрийг *Jiŋgis* хэмээн бичсэнтэй холбоотой байж магадгүй. Хожим D'Ohsson *Чин* 'агуу их' + *гис* 'олон тооны дагавар' гэсэн бүтэцтэй *'хүчирхэг хаан'* гэсэн утгатай үг гэж тайлбарласан бол нэрт эрдэмтэн

Д. Банзаров дээрхи саналыг үгүйсхэж, уг нэрийг их хааная *'тэнгэрийн хүвүүн'* хэмээн өргөмжилдөг байсан эртний Хүннүгийн уламжи-лалтай холбоотой байж магадгүй гэж үзжээ. Проф. G. J. Ramstedt тухайн нэрийг *teŋgis* гэдэг үгийн хувьсалын үр дүнд үүссэн гэж үзэн бий.

Т у с х а й с у д а л г а а : Aboul-Gasi, *Histoire généalogique des Tatares,* 1731, 194 // Langlè, Notices de l'Histoire de Djenguyz-khan. *Noteces et Extraits des Manuscripts de la Bibliothèque Nationale,* V, Paris, VII, 1799, 192-229 // D'Ohsson, *Histoire des Mongolia,* La Haye, 1834, I:99 // Д. Банзаров, О происхождении имени *'Чингис', 'Собрание сочинений'*, М., 1955, 175-177 Шонхор, *'Činggis'* kemekü ner-e-yin tuqai, MKUJ 4, 1985, 42-44; Ванжил, *'Činggis'* gedeg üge-yin tuqai mŏčidken oyilγalta, MKUJ 4, 1985, 45-51

Чинжаал |činǰal|{< Rus. *кинжал* < Arab. *χanǰar*} *хутага* (хоёр талдаа иртэй хурц хутага)

Чинжүү |činǰüü|{< Chin. *ch'ing chiāo*} хоолонд хэрэглэдэг халуун ногоо || Kha. *tšiŋdžū*

Чинсан |čingsang|{< Chin. *chéng xiàng*} *'түшмэл'* (хаан эзэний шадар туслагч. Чингис хаан Их Монгол уласаа байгуулаад өрлөг Мухулайд анх *'чинсан'* цол олгосон байдаг) || Ж= *'Iduγ-qud **čingsang**'* [Идуг худ чинсан] (Turf 18)

Чинцай |činčai|{< Chin. *qín cài*} *'майлс'* (бөөрөнхийдүү навчтай, цагаан цэцэгтэй, хавтагай жимэстэй, хүнсэнд хэрэглэдэг ургамал)

Чинь |čin|{< Chin. *qín*} НТӨ 221-206 онд одоогийн БНХАУ-ын Шанси мужийн дунд хэсэг, Ганьсу мужийн зүүн хэсэгт оршин тогтнож байсан хитадын анхны төрт улас

Чип |čip|{< Eng. *chip*} *'чийп', 'санамж'* (электрон технологийн хэрэглээнд цахим үйл ажиллагаа явуулах цахиурын талст суурилуулсан хагас дамжуулагч схем бүхий үйлдэлийн санах ой)

Чипс |čips|{< Eng. *chips*} *'чийпс'* (шарсан төмөсөөр хийсэн нимгэн хавтагай жигнэмэг)

Чисчүү |čisčeü|{< Chin. *zuosi chòu*} царасны хүрээр нэхсэн нимгэн даавуу

Чих |čikin|{< *čiqin*} *соносох эрхтэн* || Cf. Turk. *čikin* 'часть тела между шеей и плечевыми лопатками' (Радлов, III:2112) || Ж= *'suu-tu qaγan-u altan **čikin**-dür kürgegülüged'* [суут хааны алтан чихэнд хүргээд](Qqor.I:31) // *'ödür üǰekü-yin nidün, söni sonosqu-yin **čikin**'* [өдөр үзэх нүд, шөнө соносох чих]-(MNT 138:8) // *čiqin* 'ухо' (Mu. 134) // *čikin* 'ухо' (IM 434, IM M132) // *čikin* 'oreille' (Ist. 25) // *čikin* 'Ohr' (LH 1272) // *čikin* 'ear' (Ras.198 C1) // *čiqən* 'ear' (Zir. 96) || Kha. *tšix,* Ord. *dži^{k}xe,* Bur. *šexe,* Oir. *tšikən*

Чихэр |sikir|{< Turk. *'čikir'* < Pers. *śakar*} *нүүрс ус бүхий амтлаг идээ* || Cf. Turk. *čikir* 'сахар' (Радлов, III:2112), *šexer* 'сахар' (Щербак 2005, 46) || Ж= *'edüge bi buram **šikir** terigüten küčütü čibigin idegen-i idemüi'* [одоо би бурам, чихэр зэрэг хүчтэй шимт идээн иднэ](Burq. 41a) // ***šiker*** 'сахар' (Mu. 333) || х о р ш : *'чихэр жимэс'* || Таширамд дурдахад, орос хэлний *сахар,* англи хэлний *sugar,* герман хэлний *zucker,* франц хэлний *sucre* зэрэг нь цөм перс хэлний *śakar* гэдэгээс гаралтай ажээ. || Kha. *tšixer,* Ord, *ši^{k}xer,* Bur. *šexer,* Oir. *šik^{h}r*

Чөлгэ |čölge| х у у ч : *'муж', 'дүүрэг'* || Ж= *urida Ön čang luu neretü čölge bülege* [урид Өн чан луу нэрт газар бөлгөө](Qqor 29) || Энэ үгийн талаар Б. Я. Владимирцов (*Заметки к древнетюркским и старомонгольским текстам*, ДАН, 1929, 94), P. Pelliot (*Notes sur le 'Turkestan'*, T'P 27, 1930, 195), N. Poppe (*The Mongolian Monuments in hP'ags-pa Script*, 98) нарын дурдсан тайлбар бий

Чөлөө |čilūge| *'зав зай', 'аз завшаан'* || Cf. Turk. *čölö* 'простор, свобода' (Радлов, III:2043); Man. *čülē* 'досут' (Цинциус II:403) || Ж= *'čöle-tü bütügsen kümün-ü beye olju'* [хувь заяагаар бүтсэн хүний биеийг олж](BT161) || х о р ш *'чөлөө зав', 'чөлөө завсар' // 'зай чөлөө', 'эрх чөлөө'* || Kha. *tšölö*, Ord. *tšölö*, Bur. *sülö*, Oir. *tšölăn*

Чөмөг |čimūge|[= čimū-ge]{< *šimü-ge*} *'чөмөг'* (тулгуур ясны гол дахь тослог шим) || Cf. Tat. *čəməj* 'knuckle-bone' 'Starostin 430) || Ж= *'yasunāsa čimegen yarqaba'* [вынул из кости мозг] (Mu.388) // *čimge* 'marrow' (Ras.199 A25) || Kha. *tšömög*, Ord. *tšömögö*, Bur. *šemeg*, Oir. *tšimg'n*

Чулуу |čilayun|{< **tilayun* > *čilawūn* > *čila'ūn* > *čilu'ūn* > *čulu'ūn* > *čulūn* > *tšulū* (Kha.)} *газарын хөрөсөн дээрхи хатуулаг эрдэс* || Cf. Turk. *taš* 'stein' (Räsänen, 466), AT. *taš* 'stone' (Clauson 555), Čuv. *čul* 'камень' (Щербак 2005, 47); *ǯolo* 'камень' (Цинциус I:263) || Ж= *'čilayun-i tungyayabasu ber ken ǰ-e abqun'* [чулуут тунгаасан ч хэн авах](Sub. VI:5a) // *'čeügēn čilawūn čawūra-lu'ā'* [цэгээн чулуу цуурлаа](MNT 72) // *čila'un* 'pierre' (HY M47) || Kha. *tšulū*, Ord. *tšilū*, Bur. *šulū*, Oir. *tšolūn*

Чүдэнз |čüdenǰe|{< Chin. *ch'ü dēn dzi*} *'гэрэл гаргагч'* (гал ноцоох зориулалттай фосфорын хүчил түрхсэн гал асаах нарийн мод. XX зууны эхээр Зөвлөлтөд бараа захиалан хийлгэх үед буриад сургагч *чүдэнз* гэдэгийг *'шүдэнз'* гэж бичсэний уламаас тэр хэвээрээ дуудагдах болсон тухай акад. Б. Ринчен тэмдэглэсэн бий) || Kha. *tšüden*, Bur. *šüdenze*

Чүнчигноров |čüngčügnorbu|{< Tib. *khyung skyug nor bu*} *'гардийн бөөлжис'* (могой идсэн гарди шувууны бөөлжисөөс гарсан гэдэг домог бүхий цайвар ногоон өнгөтэй шил мэт тунгалаг эрдэнийн чулуу)

Чэрби |čerbi| х у у ч : *'түшмэл'* (Чингис хааны үеэс буй болсон хишигтэн цэргийн түшмэлийн цол) || Ж= *'Qoŋqotan-ača Süyiketü čerbi irebei'* [Хонхтоноос Сүйхэт түшмэл ирэв](MNT 120)

Чээж |čegeǰi| 1. *'биеийн дээд хэсэг'* || Cf. Man. *čežen* 'грудь' (Цинциус II:419) 2. *'оюун ухаан'* || Ж= 1. *'čegeǰi bey-e arslan, bögsen inu kümün bögetele'* [чээжин бие нь арслан, бөгсөн бие нь хүн бөгөөтөл](Chimeg 17a) // *'čēǰi dotaraqi qabudar* [опухоль внутри в груди](Mu. 132) || Ж= 2. *'sašin nom-un yosun-i čegeǰin doturayan sedkir-ün'* [шашин номын ёсыг оюун ухаандаа сэдхэрүүн](Qqor. I) // *'če'ēǰi dotora minu atugai'* [чээж дотор минь орштугай] (MNT 125) || Kha. *tsēdz*, Ord. *tšše̋dzi*, Bur. *sēze*, Oir. *tsēdzi*

Ш

Шаа |ša|{< Chin. shā} *'сиймхий тор'* (хаалга, цонхонд хаддаг сиймхий тор)

Шаа |siγ-a|{< *šiyai* > *ši'ai* > *ši'ā* > *ša'ā* > *šā*} *'шагай'* (шаант чөмөгний үзүүрт бэхлэгдсэн дөрвөн талтай жижиг яс) || Ж= *'törekü-dür bara'un ğar-tur-iyān **ši'ā-yin** tedüi nödün hadqun töreǰü'üi'* [төрөхдөө баруун гартаа шагайн төдий нөж адхан төржээ](MNT 59) // *'Jamuqa guraltuğ **ši'ā** Temüǰin-ne öğči, Temüǰin-ü činggültügtü **ši'ā** [aralǰiju] anda bolulčaju'* [Жамуха гурын шагай Тэмүжинд өгч, Тэмүжиний цудхамал шагайгаар сольж, анд бололцож](MNT 116) // *ši'a* ' cheville du pied' (HY M96)

Шаазан |šaγaǰang|{< Chin. *shā-jing*} *'ваар'* (нарийн шаварыг шатааж боловсруулан өнгөлсөн гилгар ваар) || Kha. *šādzaŋ*, Ord. *šādžiŋ*, *šādzaŋ*, Bur. *šāzaŋ*, Oir. *šāz°n*

Шаазгай |siγaǰiγai|[= siγa-ǰi-γai] *алаг өдтэй, урт сүүлтэй, шагширч дуугардаг жижиг шувуу* || Ж= *'**siyaǰiyai-yin** juǰiyan eke-yügen üsün-i isüǰü ači qariγuluγsan-a toγamui'* [шаазгайн зулзага эхийнхээ үсийг зулгааж ач хариулсанаа тооно](Sub. V:4b) // *sāǰiyai* 'сорока' (Mu. 319) // *sāǰiyai* 'pie' (Ist. 62) // *sāghsaghān* 'Pie' (Qaz. Pe 577) // *sâǰigai* 'magpie' (Ras.200 B2) || Kha. *šādzgai*, Ord. *šādžagā*, Bur. *šāzgaj*, Oir. *šāz°gä*

Шаахай |šaqai|{< Chin. *shā xiē*} *'даавуун гутал'* (түрийгүй гутал) || Kha, Bur. *šāxai*, Ord. *šāxā*

Шавдан |šabdan|{< Tib. *zhabs rten*} *'өлмий батдах'* (гүрэм засалын хүндэдхэл нэр)

Шавран |šabrung|{< Tib. *zhabs drung*} *'шадар хувилгаан'* (дахин төрөл авч хуварагч болсон хувилгаан)

Шавь |šabi|{< Uig *šabi* < Chin. *ša-mi*} *'багшаас сурагчаг'* || Cf. Skr. *śramana* || Ж= *ene tūnī **šabi*** [это его ученик](Mu. 160) || Kha. Ord, Bur. *šawī*, Oir. *šäwī*

Шагай |siγai|{> *ši'ai* > *ša'ai* > *šā* } шаант чөмөгний үзүүр дэх дөрвөн талтай жижиг яс || Cf. Turk. *šagaj* 'лодыга', 'лодыжка' (Räsänen 440) || Ж= *'**šiyaidu** kürkü usun'* [вода, доходящая до лодыжки](Mu. 333) // ***šiyai*** 'cheville de l'homme ou des animaux' (Ist 66) // *šiyai* 'Knöchel' (LH 60) // *siga* 'ankle bone' (Ras.199 A19) || Kha, Bur. *šağai*, Ord. *šā*, Oir. *šağā*

Шагжамуни |Šaγjamuni|{< Uig *šikaminu* < Skr. *śākyamuni*} *'Шагжагийн чадагч'* (буддийн шашиныг үндэслэгч Шакиямуни багшийн нэр. Хуучин ном сударуудад *'ялж төгөс нөгчсөн'*, *'сайвар одсон'*, *'чадагчийн эрхэт'* гэх мэтээр нэрлэдэг || Ж= *'**Šagimuni**-yin mör-iyer tngri-yi jalbariju bidan-a irüger ögün atuγai'* [Шагимүнийн мөрөөр тэнгэрт залбирч бидэнд ерөөл өгөх болтугай](Khub. I:14) || Энэ үг нь монгол бичигийн хэлэнд *Šagjamuni*, *Šagimuni*, *Šagiyamuni*. *Šigemuni* гэх мэт олон хувилбартай бичигдэг. || Kha. *šagdz°mün*, Ord. *šagdžamuni*

Шагимуни үз **Шагжамуни**

Шанз I |šanǰa|{< Chin. *xián zi*} урт иштэй, могойн арисаар бүрсэн дөрвөлжин цартай, гурван утастай чавхдаст хөгжимийн зэмсэг || Kha. *šaŋdzʊ*

Шанз II |siyanǰa|{< Chin. *xiàn zi*} *'хольц'* (хоол идээний амталсан хольц)

Шанзав |šangǰab|{< Tib. *phyag mdzod pa*} *'мутарын сан'* (сүм хийдийн санч)

Шанлуу |šanglu|{< Chin. *xiāng lú*} арц, хүж уугиулах дөрвөн хөлтэй жижиг таваг

Шантаж |šantaž|{< Rus. *шантаж* < Fr. *chantage*} *'шантааж', 'илчи-лэхээр заналхийлэх'*

Шанх |šangqu|{< Chin. *shang huán*} хагалбарлан унжсан үс || Kha. *šaŋxʊ*, Ord. *šaŋxu*, Oir. *šaŋχᵘ*

Шанцай |xian čai|{< Chin. *xián cài*} *даваслаж дарсан ногоо*

Шанши |šangši|{< Chin. *shàng-shí*} *'өндийн зоогло-'* (тэнгэр лусаас бороо гуйхын тул тахидаг өнчин мод)

Шаолин |šaolim| *сүм* (Хитадын Хенан мужийн Дэнфен тосхон дахь 1500 жилийн түүхтэй бүддийн шашины сүм)

Шар |sir-a| алтны өнгө || Cf. Turk. *saryk* 'желтый' (Радлов, IV:321), AT. *sariğ* 'yellow' (Clauson 848), *sāryγ* 'gelb' (Räsänen 403) || Ж= *'törülki uryuysan* ***šira*** *üsütei'* [төрөлхи ургасан шар үстэй](Maha I:7) // *'naran sara-yin kili-yēr* ***šira*** *noqai metü šiǰabalǰaǰu ğarqu büle'ē'* [үүр шөнийн заагаар шар нохой мэт шарвалзан гарах бөлгөө](MNT 21) // ***šira*** *čeček* [желтый цветок](Mu. 335) // *sira* 'желтый' (IM M137) // *sira* 'gelb' (LH 60) // ***šira*** *tosun* 'butter' (Ras. 205 B12) // *širā* 'yellow' (Zir.134) || Kha. *šar*, Ord, Bur. *šara*, Oir. *šarᵘ*

Шарвин |šarbin|{< Chin. *xiàn er bing*} *'шанзтай бин'* (тосонд хайрсан бин, хуушуур) || Kha. *šarwiŋ*

Шарз |siraǰa|[= sira-ǰa] *'нэрмэл арих'* (хорзыг дахин нэрж гаргасан шимийн арих)

Шариг |šariγ| *'шаргал'* || Cf. Turk. *sarïγ* 'желтый' (ДТС 488) || Ж= *'яриг цагаан ингэний шариг цагаан ботого'* (аман зохиол)

Шарил |šaril|{< Skr. *śarīra*} *'бие цогц'* (анх бурхан багш Шагжамуны чандар дээр гарч ирсэн гэрэлийг зааж байгаад хожимоо дээдэсийн *'ариун чандар'* гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ) || Kha, Ord, Bur. *šaril*, Oir. *šalʲr*

Шармани |šramani|{< Skr. *śramaṇerī*} *'буяны ёст эх'* (36 төрөлийн санваар хүртсэн гэлэнмаа)

Шастир |šastir)|{< Uig *šastir* < Skr. *śāstra*} *'зарлиг', 'туурвил'* (Буддийн сургаалд ариун номлолыг ийн нэрлэж байгаад хожим олон салбар ухааны ном сударыг нэрлэх болжээ.) || Ж= *'sayin ügetü erdini-yin caŋ neretü* ***šastir****-ača sayin haran-i onoqui nögö'e ǰüyil da'usbayi'* [сайн үгт эрдэнийн сан нэрт шастираас сайн ардыг онохуй нөгөө зүйл дуусав](Sub. IV) // *'nayiraγulun qolbaqui ayalγu-bar ali ba* ***sastir****-i ǰokiyabasu'* [найруулан холбох аялгуугаар аливаа шастирыг зохиовооc](Chimeg 2a) || Kha. *šaštir* Ord. *šastir*, Oir. *šastʲr*

Шат |šatu| *өөд авирах гишгүүр* || Cf. Turk. *šatu* 'лестница' (Радлов, IV:970), AT. *šatu* 'ladder', 'staircese' (Clauson 867) || Kha. *šatʊ*, Bur. *šata*, Oir. *šatᵘ*

Шатар |sitar-a|{< Pers *šatranj* < Skr. *caturanga*} *'дөрвөн хэсэг'* (анхандаа заан, тэрэг, морин цэрэг, явган цэрэг дөрөвөөр хаан эзэнээ хамгаалдаг хөлөгт тоглоом байсанаа хожимоо бага зэрэг өөрчилөгджээ.) || Cf. AT. *šatranǰ* (ДТС 521) || Ж= *'манж ноён, монгол* ***шатар*** *сураад, Гөлөгдэй заримдаа өнжин шатар нүүдэг болгоо'* (Б. Ринчен, Нууцыг задаруулсан захиа) || Kha, Ord. *šitar*, Bur. *šatar*, Oir. *šaťr*

Шах |šah|{< Pers. *šāh*} *'эзэн хаан', 'ван', 'ноён'* (эртний Перс, орчин үеийн Иранд төрийн тэргүүнээ өргөмжилөх цол. Энэ цолыг хожим исламын шашинт бусад оронуудад өргөн хэрэглэдэг болжээ)

Шах- |siqa| *'хавчих', 'дарах'* || Cf. Uig. *siq-* 'to press, squeeze' (Schwarz, 503) || Ж= *'küčü öčüken kümün-i qoyolai-ača bariju gedergü* ***šiqaqui*** *metü'* [хүч чадалгүй хүний хоолойгоос барьж гэдэрэг шахах мэт](Burq. 36a) // *'a'üla* ***šiqan*** *bawūya'* [уул шахан буруя](MNT 118)

Шахаа |siqaγ-a| *'гэсхээлтийн арга'* (Чин уласын үед гэрч баримтгүй хэрэгийг шүүхдээ сэжигтэн эттээдийг эвдэрсэн нум сум, хүний хувхай гавал, нохойн яс, эхнэр хүний өмөд зэрэгийг өлгөсөн бохир хэцний доогуур шургуулан гаргаад байцаадаг байжээ.)

Шашин |šasin|{< Skr. *šāsana*} *'ном', 'сургаал', 'цааз'* (шашин гэдэг нь эрт цагийн хүмүүс орчилон ертөнцийн аливаа юмсын мөн чанар, сүр хүч, шүтэн барилдлага хийгээд хүмүүний амьдаралын олон талыг тухайн үеийнхээ танин мэдэхүй, төсөөлөлийнхээ хэрээр тайлбарласан зүйлээс үүсэн бүрэлдэж, хийсвэрлэн хөгжсөөр ирсэн сургаал номлол юм. Дэлхий дээр загалмайтаны, исламын, буддийн, бомбын зэрэг томоохон шашин бий) || Ж= *'**šasin** nom-i ebdegčin samayui mayui sedkilten'* [шашин номыг эвдэгч самуун муу сэдхэлтэн] (Maha II:26) || Kha. *šašin*, Ord, Oir. *šadžin*, Bur. *šazan*

Шашир |šaser|{< Tib. *zhwa ser*} *'шар малгай'*. (Шарын шашины тойн хувараг хүн сүмийн хурал, ёслолын үед өмсдөг монгол гуталын оймосны хэлбэртэй, дээрээ цацагтай, ардаа залаатай өндөр малгай.)

Шейх |šeyik|{< Pers. *shīkh*} *'хүндэт ахмад'* (исламын шашинт оронуудад 50-аас дээш настай шашины зүдхэлтэний хүндэдхэлийн цол. Дээд язгууртай эрэгтэй хүнийг *шейк* (sheikh), эмэгтэй хүнийг *шейка* (sheikha) хэмээн ялган нэрлэдэг байна.)

Шив- |sibe| *'хадха', 'цоолох'* || Ж= *'qabudar bükü yaǰar-a* ***sibekü*** *kituya'* [хавдар бүхий газар шивэх хутага](Chimeg 51a) || Энэхүү язгуураас *sibegür* [sibe-gür] 'шивүүр', *sibege* [sibe-ge] 'шивээ', *sibegesü* [sibe-ge-sü] 'шивээс', *sibūge* [sibü-ge] 'шөвөг' зэрэг үгс үүсчээ || Kha. *šiw-*, Ord. *šiwe-*, Bur. *šebe-*, Oir. *šiw-*

Шивүүр |sibegür|[= šibe- / šibe + gür] *'шивээс хийх багаж'* || Kha. *šiwür*

Шивэгчин |šibegčin|[= šibe-gčin] *'зарц эмэгтэй'* || Ж= *'Utari neretei* ***šibeg-čin-iyen*** *jaruju'* [Утари нэрт шивэгчинээ зарж](Burq. 43b) || Kha, Ord. *šiweg-tšin*, Oir. *šiwəktšɪn*

Шивэлгэр |sibilger| *'гөрж сулжссэн гэзэг'* || Ж= *'qoyar* ***šibülger****-iyēn nigen-te aru de'ēre-yēn o'ōrću, nigen-te ebür-ēn de'ēre o'ōrću'* [хоёр гэзэгээ хойшоо нэг, урагшаа нэг хаяж](MNT 56) || Kha. *šiwelger,* Ord. *sirwegel*

Шивэр |siber| *царсан ойн төгөл* || Cf. Turk. *sybar* 'urwald' (Räsänen 414) Өнөөгийн *'Сибирь'* гэдэг газар зүйн нэр нь энэ үгээс гаралтай || Ord. *šiwer,* Bur. *šeber,* Oir. *šiw'r*

Тусхай судалгаа: З. Я. Баяршинова, О происхождении и значении слова *'Сибирь'*. Научн. доклады высш. школы, ист. наук, 3, 1959, 101-110

Шивээ |sibege|[= sibe-ge] 1. *'өргөс', 'хадхуур'* 2. *'хайс', 'хашаа'* || Ж= 1. *'Belgüdei modud quguru tatalaju,* ***šibe'ē*** *bariju'* [Бэлгүдэй мод хуга татаж, хадхуур барьж (MNT 79) // *čayanu šibege* 'жало скорпиона' (Mu. 131) // *sibege* 'awl' (Ras. 204 C2) || Ж= 2. *'Belgüdei modud quguru tatalaju,* ***šibe'ē*** *bariju'* [Бэлгүдэй мод хугалж, хайс барьж](MNT 79-4) // *šibe'e* 'haie' (HY M96) || Kha, Ord. *šiwē,* Bur. *šibē,* Oir. *šiwā*

Шид |šidi|{< Uig. *sidi* < Skr. *šiddhi*} *'оюуны хүч'* || Ж= *'ükügsen-ü qoyina ülü törüküi nigeken be* ***šidi****-yi öggün soyurqabasu'* [үхсэний хойно үл төрөх нэгээхэн шидийг өгөн соёрхвоос](Burq. 13) // *'Esrün-e degedü* ***siddi*** *ögtegsen-iyer'* [Эсэрүнээ дээд шид өгсөнөөр](Chimeg 14b) || х о р ш : *'ид шид'* (ер бус далдын хүч) || Kha. *šid,* Ord. *šide,* Bur. *šedi,* Oir. *šid*

Шидхэл |šidkül | х у у ч : *'хуршмын бэлэг'* || Ж= *'Čotan eke-yin* ***šidkül*** *ke'ēn qara buluğan daqu abčiraju büle'ē'* [Цотон эхийн бэлэг хэмээн хар булган дах авчирч билээ](MNT 96)

Шижим |= sejim / sijim|{< *seji-m*} *'оосор', 'үзүүр'* || Cf. Turk. *sizim* 'веревка, шнурок' (Радлов IV:721) // *'mal-un külig, čidür, noytu,* ***sijim****'* [малын хүлэг, чөдөр, ногт, шижим] (QJ B32b) || Kha. *šidžim,* Ord. *šidžim,* Bur. *šežem,* Oir. *šidžim*

Шижир |šijir| < Uig *sitir* < Sogd *st'yr* < Gr *stater*} *'мөнгөний нэгэж'* (Монгол хэлэнд *'цэвэр алт'* гэсэн утгаар хэрэглэх болжээ.) Cf. *şicir* 'refined gold', 'gold leaf' (Clauson 802) || Kha, Ord. *šidžir,* Bur. *šežer,* Oir. *šidž'r*

Ший |ši|{< Chin. *xi*} *'наадам', 'тоглоом'* (урлагийн үзүүлбэр)

Шийгуа |ši yuw-a|{< Chin. *xī guā*} *'тарвас'* (мөлхөө иштэй, шар цэцэгтэй шүүслэг том жимэс)

Шийд |seyid| *'шийдвэр'* гэсэн утгыг илэрхийлсэн язгуур. Энэхүү язгууртаас *seyidbüri* [seyid-büri] 'шийдвэр', *seyidümeg* [seyid-(ü)meg] 'шийдмэг', *seyidül* [seyid-(ü)l] 'шийдэл', *seyidke-* [seyid-ke] 'шийдэх' гэх мэт үгс салбарлан гарчээ || Kha, Bur. *šīd-*

Шийдвэр |seyidbüri|[= seyid-büri] *'шийдэл'* || х о р ш : *'тушаал шийдвэр'* || Kha. *šīdwer,* Bur. *šīdeberi*

Шийдэх- |seyidke|[= seyid-ke] *'шийдвэр гаргах'* (Хуучин албан бичигт *'шийдхэх'* гэдэг үг нь зөвхөн *'шийдвэрлэх'* гэдэг утгыг илэрхийлж байв.) Ж= *'Чи тэрэнд зар бичиг* ***шийдхэн*** *өгөх гэж явна уу*? (Л. Түдэв, Олз эрсэн хоёр) || Орчин цагийн монгол хэлэнд энэ үг нь *'ял зэм хүлээлгэх'* гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ.) || Kha, Bur. *šīdxe-*

Шинэ [illegible]
415) || х о р ш : *'тэлгүү[illegible]*

Шийянз |siyangǰa|{< Chin. *хэ уи[illegible]*

Шил |sil|{< Tib. shel} *'тунгалаг хавтан'* (*эле[illegible]* хавтан) || х о р ш : *'шил толь'*, *'шил шаазан'* || х о р ш : *'шил шаазан'* || Kha, Ord, Oir. *šil*, Bur. *šel*

Шил- |sil /sili| *'сонгох'* Энэхүү язгууртаас *sildeg* [sil-deg] 'шилдэг', *silǰi-* [sil-ǰi] 'шилж-', *silemel* [sile-mel] 'шилмэл' гэх мэт үгс үүссэн байна. || Ж= *'šilekü irge šülen bolğaju'* [шилдэг ирэгээр шөл барьж](MNT 124) || х о р ш : *'шилж сонгох'*

Шилам |šilam|{< Pers. šilām} *'услах'* (загалмайтаны шашины ёсны угаал үйлдэх ёслолтой холбоотой үг) || Ж= ***šilam**-dur oraysad tanu metüs maya ünen sedkilten ariyun aran'* [загалтайтаны шашинд орсон та мэтийн магад үнэн ариун сэдхэлтэн ардууд](Ar.1290:20-21) // ***šilan** bariba* 'соблюдал пост' (Mu. 333) // ***šilam** sara* 'месяц рамазан' (Mu. 333) // ***silam** bariba 'fastete'* (LH 59) || Проф. N. Poppe энэ үгийг *Fasten* 'мацаг' хэмээн орчуулжээ. (*Das mongolische Sprachmaterial einer Leidener Handschrift*, Bull. de l'acad. des sc. de l'URSS, S. 59)

Шилгүд- |šilgüdü| х у у ч : *'чичирэх'*, *'дагжих'* || Ж= ***'šilgüdüged** ayuyad gün čegel-ün dergede yabuqu metü'* [гүн цэлийн дэргэд айж чичирэн явах мэт] (Taq. 5b7) // *'silǰirin bükü boro'ön-a,* ***šilgüdken** bükü ǰü'ēn-e, čidqun bükü qura-da'* [шилжирэн бүхий бороонд, чичиргүүлэн бүхий жихүүнд, цудхан бүхий хурд] (MNT 230) // *šilgütbe tüni bezgek* [его трясла лихородка](Mu. 333)

Шилж- |silǰi|[= sil-ǰi] *'байрлалаа солих'* (шилж сонгосон газартаа нүүх) || Cf. Uig. *silji-* 'to move' (Schwarz, 506) Энэхүү язгууртаас *silǰilte* [sil-ǰi-lte] 'шилжилт', *silǰigüle-* [sil-ǰi-güle] 'шилжүүл-' зэрэг үгс үүсчээ. || х о р ш : *'нүүж шилжих'* || Kha. *šildž-*, Ord. *šildži-*, Bur. *šelže-*, Oir. *šildž-*

Шилтгээн |šiltegen|[= šilte-gen] Эртний монгол хэлэнд *'тосхон'*, *'суурин'* гэсэн утгаар хэрэглэгдэж байгаад эдүгээ *'хаад ихэсийн ордон'*, *'үзэсхэлэнт харш'*-ийг нэрлэх болжээ. || Ж= *'yurban **šilteged**-ün irgen bur-a tar-a odčuyu'* [гурван тосхоны ардууд ийш тийшээ одож](Turf. 22) // *šilte'en* 'hameau, village' (HY M97) || х о р ш : *'орд шилтгээн'* || Kha. *šiltəgēn*

Шилэгү |silegü| х у у ч : *'шүдлэн'* || Ж= ***'silegü** irge šülen bolğaju'* [шүдлэн ирэгийг шөл болгож](MNT 124) || Bur. *šülegen*

Шим |sim-e| *'тэжээл'*, *'шүүс'* || Cf. Turk. *simä* 'сок', 'костный мозг' (Räsänen 422) || Ж= *'öl **šim-e** ügei bolurysan belges-i üǰeǰü'* [өл шимгүй болсон бэлгэсийг үзэж](Burq. 10b) Энэхүү язгууртаас *šimeǰi-* [šime-ǰi] 'шимжи-', *simel-deg* [sime-(l)deg] 'шимэлдэг', *šimegüsü* [šime-güsü] 'шимүүс', *šimetü* [šime-tü] 'шимт' гэх мэт үгс үүсчээ. || х о р ш : *'шим тэжээл'*, *'үр шим'* || Kha. *šim*, Ord. *šime*, Bur. *šeme*, Oir. *šim*

Шим- |sime| *'зөөлөнөөр сорох'*, *'шингээж авах)* || Ж= *'böglegsen čisun-i ǰelme **šimin šimin**, ama-'ān čisudaju'* [Зэлмэ бөглөрсөн цусыг нь шимэн шимэн

хэрэлдэх, хөнөөл...

tšiwağantša, Bur. *šabğaŋsa*

Шимну |šimnu|{< Turk. *šimnu* < Sogd. *šmnw*} *'шулам'* // Pl. *šimnus* (амьтанд хор хөнөөл, буянд тодхор үйлдэгч хүсэлт тэнгэрийн нэгэн зүйл амьтан) || Cf. AT. *šimnu* 'evil spirit' (Clauson 868) || Ж= *'Bodistw qataγuǰin terigülegsen ćaγaća čibiltü* ***šimnu*** *ireǰü'* [Бодисадва хатуужин тэргүүлсэн цагаас нүгэлт шулам ирж](Burq.39) // *'dörben* ***simnus****-i nomuqadqaγsan-u tulada'* [дөрвөн шулмасыг номходхосоны тул](Chimeg 2b) || Kha. *šulmas*, Ord. *šulmus*, Bur. *šolmos*

Шимурга- |šimurγu| х у у ч : *'шийдэх'*, *'шүүд хийх'* || Ж= *'ačitu eǰen-e* ***šimurγuǰu*** *kürbesü arqaγun dora unaǰu ög'* [ачит эзэндээ шууд хүрвээс ялун дор унаж өг](Alt. 21b)

Шимүүл |šimegül|[= šime-gül] *шимдэг хорхой. (цус шимдэг жижиг ялаа.* Энэ нь угтаа *šime-* 'шим-' гэсэн үйл үгээс гаралтай. Энэ үгийн *šimaγul* 'шумуул' гэсэн хувилбар нь эдүгээ уламжилан үлджээ) || Ж= *'****šimuγul*** *sona-da idegdebesü'* [шумуул сонод идүүлвээс](Burq. 39a) // *šimül* 'муха' (Mu. 333) // *šimûl* 'gnat' (Ras. 200 B11) || Kha, Ord, Bur. *šumül*, Oir. *šomül*

Шимэдхэ- |šimedke|[= šime-dke] *'шингээх'*, *'суудхах'*, || *šimedkebe* 'to liquefy' (LH. S 21) || Kha. *šimədxe-*

Шингэ- |singge|[= šing-ge] *'уусах'*, *'нэвтэрэх'*, *'далд орох'* || Cf. AT. *siŋ* 'to sink into, to be absorbed, be digested' (Clauson 833) || Ж= *'naran* ***šinggekü****i-dür kürtele nigedügsen-dür'* [нар шингэх хүртэл нэгдсэнд](MNT 145) *//'naran* ***šiŋge'ülün*** *mün tende šitüldüǰü bawüǰu'* [нар шингэнгүүт мөн тэндээ зэрэглэн бууж](MNT 145) // *'šingebe ide'ēn* [переварил пишу](Mu. 334) // ***šingebe*** *naran* [солнце зашло](Mu. 334) // *naran* ***singekü*** *jüg* 'запад' (IM 442) // *naran šingebe* 'le soleil se coucha' (Ist. 66) // *singā* 'set the sun' (Zir. 132) || х о р ш : *'уусч шингэх'* || Kha, Ord. *šiŋge-*, Bur. *šenge-*, Oir. *šiŋgə-*

Шинель |šinel|{< Rus. *шинель* < Fr. *chenille*} *'шинээл'* (цэрэгийн хүний гадуур дүрэмт хувцас)

Шиншинүүд |senšhingüd|{< Chin. *hsien-sheng*} *'бомбын шашины лам'* || Ж= *'toyid erkegüd* ***šingšingüd*** *dašmad aliba alba γubčiri ülü üǰen'* [тойд, эрхүүд, сэншинүүд, дашмад аливаа алба татвар үл төлөн](Khub. I:8)

Шир |sir| *бод малын арис* || Cf. Uig. *širā* 'raw hide' (Schwarz, 530) || Ж= *Qasar ... Čiŋgis qahān-i erin olun yadan* ***širi****, širbüsün ideǰü yabu'ād'* [Хасар ... Чингис хааныг эрж, олж ядан шир, шөрмөс идэж яваад](MNT 183-6) || хорш : *'арис шир'* || Kha, Oir. *šir*, Ord. *šire*

Шир- |siri| *утасаар бэхлэж оех, хайлуулж гагнах* || Cf. PT *širī* 'to sew tightly', 'quilt, smock' (Starostin, 1259) Энэхүү язгууртаас *širimel* [širi-mel] 'ширмэл', *širemū* [šire-mū] 'ширэм', *širigesū* [širi-ge-sū] 'ширээс' гэх мэт үгс үүсчээ || Kha, Oir. *širə-*, Ord. *šire-*, Bur. *šere-*, Dag. *širi-*

Ширавраг |širavag|{< Uig. *širavag* < Skr. *śrāvaka*} *'соносогч', 'шавь'* (бурханаас соносон сургаалыг бусадад дамжуулан соносгох) || Ж= *'tegünčilen biratikabud kiged* ***širavag-ud*** *ber jiryalangtan boltuγai'* [түүнчилэн биратикабуд хийгээд ширвагууд жаргалантан болтугай](ВТ 162a5)

Ширгэ |širge|{< Turk. *sirkā*} х у у ч : *'цагаан цуу', 'исгэгч'* || Ж= *'kebideče* ***širge*** *kōnōrge-deče aliba alba qubčiri bü abtuqayi'* [дэлгүүрээс, исгүүрийн хөрөнгөөс алба татвар бүү автугай](Khub 1280) // *sirke* 'уксус' (Mu. 323) || Kha, Ord. *širge-*, Bur. *šerge-*, Oir. *širgə-*

Ширмэл |širimel|[= širi-mel} *'утасаар ширсэн эсгий'* || х о р ш : *'ширмэл тойруулга'*

Широлга үз Шорлог

Ширэм |siremū|[siremū] *'ширээж гаргасан төмөрийн хүдэрийн хайлш'* || Ж= *'tede dörben noqais* ***širemün*** *manǰlaitan'* [тэр дөрвөн ноход ширэмэн магнайтан](MNT 195-28) || Kha. *širem*, Ord. *širme*, Bur. *šerem*, Oir. *širm'n*

Ширээ |sirege|[= šire-ge] *дороо хөлтэй, дээрээ тавцантай тавилга* || Монгол, түрэг хэлний дундын үг. Cf. Turk. *širā* 'ein viereckiger Tisch' (Räsänin 447), Uig. *širā* 'short-legged table' (Schwarz, 530) || Kha, Ord. *širē*, Oir. *širā*, Bur. *šerē*

Шит |sitü| *'мэт'* || Ж= *'qola ber bögesü oyir-a* ***šitü*** *'* [хол ч гэсэн ойр мэт (Taq. 35a) *'medel-ün irgen inü ečige eke-yügen kekūdeglečegsen* ***šitü*** *emgenin ajuγu'* [харият иргэд нь эцэг эхээ алдсан мэт эмгэнэн байв](Jig. 9)

Шифр |šifer|{< Rus. *шифр* < Fr. *chiffre*} *'шийфер', 'нууц тулхүүр'* (номын сан, архивын баримт, шалгалтын материал зэрэгийг үсэг, тоогоор ялган илэрхийлсэн тулхүүр)

Ши Шиа |si siya|{Chin. *xī xià*} XI-XIII зууны үед одоогийн Шанси, Ордос, Ганьсугийн зарим хэсэг дээр Тангадуудын байгуулсан улас. Уул нэр нь *Да Шиа* (Их Шиа) гэж байсан боловч Сүн уласын баруун талд байсан учир *Ши Шиа* (Баруун Шиа) хэмээн нэрлэгдэх болжээ. Монголчууд түүнийг Тангуд гэж нэрлэдэг байжээ.

Шогол |šoγul|{< Tib. *sho ka li*} *хайрцагны нүд* (ном судар, бичиг цаас хийх олон шургуулгатай хайрцаг) || Ж= *'дэнгийн гэрэлд завилан сууж,* ***шоголтой*** *номоо хааяахнаа нэг харан, уруул хөдөлгөн уншина'* (Д. Намдаг, Нүгэл буян хоёр)

Шок |šok|{< Rus. *шок* < Eng. *shock* // Fr. *choc*} *'шоок', 'гэнэтийн цохилт', 'дайрлага'*

Шоколад |šokalad|{< Rus. *шокалад* Fr. *chocolat* // Eng, Sp. *chocolate*} *'шоклаад'*

Шон |šong|{< Chin. *shuān*} *'уяаны мод'* (утас, хэц татахад зориулан босхосон өндөр багана)

Шонхор |šongqur| бэсэрэг биетэй махчин шувуу || Cf. AT *siŋkur* 'a bird of prey (Clauson 898), Uig. *šuŋqar* 'hawk, falcon' (Schwarz, 524), Pers. *shunǧhār* 'a royal falcon' (Steingass, 768) || Ж= *'čagān* ***šiŋqor*** *naran sara qoyar-i adqun nisčü irejü, ğar de'ēre minü tu'ūba'* [цагаан шонхор нар сар хоёрыг адхан нисч ирээд гар дээр минь суув](MNT 63) // ***sonqur*** 'gerfalcon' (Ras. 200 A19), *shunqār* 'Gerfaut' (Qaz, Pe. 576) || Kha. *šoŋkʻor*, Ord. *šoŋxor*, Bur. *šoŋxor*, Oir. *šoŋχʻr*

Шоо |šo|{< Tib. *sho* < Chin. *xiao*} *'дөрвөлж'* (мэргэ төлгө үзэх зургаан талтай дөрвөлжин шагай) || х о р ш : *'шоо дөрвөлжин'* (тэгш дөрвөлжин)

Шоожуу |šooǰiy-a|{< Chin. *xiāo jie*} *'бага эгч'* (дээдэсийн охидыг хүндэдхэсэн нэр) || Ж= *'арван тавтай* ***шоожуу*** *нь аав ээждээ дэнлүү дээ'* (Ардын дуу)

Шоохууз |šooquuja|{< Chin. *xiāo huǒ zi*} *'залуу эр'*

Шор | širu / šoru| хадхаж сүлбэх хурц үзүүртэй нарийн мод. || Ж= *'čigürsün* ***širo*** *barīju, södün gičigine uquǰu teǰi'ēbi'* [модон шор барьж сөд гичгэнэ ухаж тэжээв](MNT 74) // ***šor*** *suqai* 'тамариск' (Mu. 337) || Энэ үгээс *šoruda-* 'шорд-', *šorula-* 'шорло-', *šorulya* 'шорлог' зэрэг үгс үүсчээ. || Ж= *širo* (MNT 74) || Kha, Oir. *šor*, Ord, Bur. *šoro*

Шорвог |šorbuγ|[= šor-buγ]{< Pers. *šor + buy*} *'гашуун', 'давастай'* || Cf. AT. ***šor*** 'salty' < Pers. *sōr* 'sour', 'bitter' (Clauson 868) || Kha. *šorwog*, Ord. *šorwok*, Oir. *šorwng*

Шоргоолж |širγulǰi|[= *širγu-* 'шурга' + lǰi] дундуураа нарийхан, хурдан хөдөлгөөнтэй шавьж (уттаа *širγu-* 'шурга-' гэсэн язгууртаас гарсан үг. Түүнийг буриад хэлэнд тусхан үлджээ.) || Ж= *'****širuγolǰin*** *nidün ügei ber bögesü busud nidüteen]-eče ülemǰi qurdun'* [шоргоолж нүдгүй боловч нүдтэй бусад амьтанаас илүү хурдан](Sub.I:6a) // ***sirğoljin*** 'ant' (Ras.200 A9) || Kha. *šorğōldž*, Ord. *šurğuldži*, Bur. *šurğalža, šorgōlzon*, Oir. *šorgɒldžʻn*

Шорлог |sirolγa|[= siro-lγa]{< sira-lγa} *шор модонд хадхаж шарсан ангийн мах.* Энэ нь уттаа *sira-* 'шарах' гэсэн язгуур дээр нэр үг бүтээх *-lγa* дагавар залгаж үүссэн ажээ. Проф. I de Rachewiltz *'roast'* (шарсан мах) хэмээн орчуулжээ. || Ж= *'Dobun-mergen ügülerün 'nökör* ***širolğa-da'*** *kējü ü* [Добун мэргэн үгүүлэрүүн: 'нөхөр шорлогодоо' хэмээжээ](MNT 13)

Тусхай судалгаа : P. Pelliot, *širolya – širalya*, T'P Ser 37, 1944, 102-112 // A. Mostaert, *A propos du mot širolya de l'Histoire secrete des Mongols*, HJAS 12, 1949, 470-476 // Ш Гаадамба, *'нөхөр сиролга-да'* гэдэг үгийн учир, *Монгол судалалын зарим асуудал* III, 1961, 36-49

Шорон |šorung|{< Chin. *qiu long*} *гэмт хэрэгтэнийг хорих газар* (шор модон хашаатай хорих газар) || х о р ш : *'шорон гиндан'* || Kha, Ord. *šoroŋ*

Шороо |širui| *газарын хөрөсний нунтаг ширхэг* || Ж= *'bulay öbesün es-e ele širgibesü* ***širuγai-bar*** *darun qamiγ-a čidaqu'* [булаг өвөө эс ширгэвээс шороогоор дарж яахин чадах](Sub. VII:8b) // *'qo'āğčin üni'ēn ... jamuqa-yin jüg mö'ören mö'ören,* ***širo'āi*** *sačun sačun bayītu'* [ухаа үнээ ... Жамухагийн зүг мөөрөн мөөрөн шороо сацан байв](MNT 121) // ***široidu*** *qutquba* [выпачкался в земле](Mu. 336) // *γajarīn doraqīn* ***širō*** [пыль находящаяся под землей](Mu. 174) // *širū* 'песок' (IM 447, IM M137) // *široa* 'dust' (Ras.201 C17) || х о р ш : *'шороо*

тоос', 'газар шороо' || Kha, Ord. *šorō*, Bur. *šorōj*, Oir. *šorā*, Dag. *širō*

Шоу |šovū|{< Eng. *show*} 'шоу', *'үзүүлэх тоглолт'* (их төлөв урлаг, спортын сонирхолтой тоглолтыг хэлнэ)

Шохой |čoqoi|{< Chin. *shih hui*} *цэрд* (цагаан чулуулагийг шатааж гаргасан нунтаг) || Kha, Bur. *šoxoi*, Oir. *šoχ"ē*

Шош |šosi{< Tib. *zho sha*} *нэг наст буурцагт ургамал* (шош нь дотороо *'бөөрөн шош', 'зүрэхэн шош', 'элэгэн шош'* гэх зэрэг олон зүйл байдаг)

Шошиго |šosiy-a|{< Chin. *zhu šog*} *'айлдхал бичиг', 'бичигтэй пайз'* (Анхандаа хаад ноёдод өргөн мэдүүлэх бичигийн нэр бүхий модон хавтанг нэрлэж байгаад хожим бичигтэй пайз модыг нэрлэх болжээ. Орчин үед эд барааnd зүүсэн танилцуулгыг нэрлэнэ)

Шөвөг |sibūge|[= šib-(ü)ge] *шивж цоолдог хурц үзүүртэй багаж* || Ж= *'kōbčin beye inū širemū-'ēr širegdegsen, šibūge-de qadququi-a čölō ügei ū'* [хөвчин бие нь ширэмээр ширэгдсэн, шөвөгөөр хадхах зайгүй](MNT 199) // *šibūge* 'шило' (Mu. 332, IM 446) // *sibege* 'awl' (Ras. 204 C2) // *sibgä* 'род шила' (IM M136) || х о р ш : *'хутага шөвөг'* || Kha. *šöwög*, Ord. *šöwögö*, Bur. *šübge*, Oir. *šöw·g^a*

Шөл |šōlū| *чанасан хоолны шингэн* || Cf. AT. *sōl* 'the juice in meat, lymph' (Clauson 824) || Ж= *'šilekū irge* ***šülen*** *bolgaju'* [шүдлэн ирэгийг шөл болгож] (MNT 124) // *sülen* 'soup', 'bouillon' (Ras. 205 B44) // *šilen* 'суп' (Mu. 333) *šile* 'суп' (IM 447) // *šila* 'бульон', 'суп' (IM M138) || *'шөл ус'* || Kha. *šöl*, Ord. *šölö*, Bur. *šülen*, Oir. *šolən*

Шөнө |sōni| *үдэшийн бүрийгээс үүрийн гэгээ хүртэлхи хугацаа* || Ж= *'surγaju ele öggügsen söyüger-i činü* ***söni*** *ödür saqiju es-e umurtabai'* [сургаж хэлсэн сургаалыг чинь өдөр шөнөгүй сахиж эс мартав](Hin. 52) // *'Bodončar ... sōni ebesün nembüle ger-tūr-iyēn ireǰü qonoqu büle'ē'* [Бодончар... шөнө өвөсөн эмбүүл гэртээ ирж хонох бөлгөө](MNT 28) // *söni* 'ночь' (IM 446) // *söni* 'nuit' (Ist. 65) // *sōni* 'Nacht' (LH 59) // *sōni* 'night' (Zir.133) // *süni* 'полночь' (IM M137) // *söni* 'Nacht' (LH 59) // *sōni* 'night' (Ras. 200 C20) || х о р ш : *'өдөр шөнө'* || Kha. *šönō*, Ord. *sönō*, Bur. *hüni*, Oir. *sön*

Шөрмөс |sirbüsū|{< **širbūr + sün*} *булчин махны доторхи булх, шандас* || Ж= *'arasun* ***širbüsün*** *miqan-iyar torlaydaysan kümün-dür adali'* [арис, шөрмөс, махаар торлогдсон хүн мэт](Burq.18a) // *Qasar ... Čiŋgis qahān-i erin olun yadan širi,* ***širbüsün*** *ideǰü yabu'ād'* [Хасар ... Чингис хааныг эрж, олж ядан шир, шөрмөс идэж яваад](MNT 183) // *širbūsün* 'tendon' (HY M97) // *širbüsün* 'жила' (Mu. 335, IM 446) // *širbüsün* 'tendon' (Ist. 64) // *širbüsün* 'Sehne' (LH 60) // *sirbūsün* 'sinew' (Ras. 199 A23) || *'шөрмөс шиндас'* // *'булчин шөрмөс'* || Kha. *šörmös*, Ord. *šörwös*, Bur. *šürmeheŋ / šürbeheŋ*, Oir. *šürws^n*

Шөрөг |šörge| *шовх үзүүртэй модон сав* || Cf. AT. *siruk* 'a pole, tent pole' (Clauson 848) || Kha. *šörög*, Oir. *šörg^a*

Шрифт |šrift|{< Rus. *шрифт* < Ger. *Schrift*} *'ширийфт', үсэгийн хэв'*

Штаб |štab|{< Rus. *штаб* < Ger. *Stab*} *'штаав'* (цэрэгийн төв удирдлага) || Ж= *'жанжин штаб'*

Шуба |šüba|{< Rus. *шуба* < Arab. *šüba*} *'шүүб', 'үстэй дээл'* (үнэт үсийг гадагш харуулан хийсэн дээл)

Шулам үз Шимну

Шулуун |silaγun| *'чигээрээ', 'цэх шударга'* || Cf. Man. *šilun* 'прямой' (Цинциус II:426) || Ж= *'šiliγun sayid ečige eke-degen tabiylaqu taqimdaγu bolqu'* [шударга сайчуул эцэг эхээ хүндэлэх тахимдуу болох](Taq. 27b) || х о р ш : *'шулуун шударга'* || Kha, Bur, Oir. *šulūŋ*

Шумуул үз Шимүүл

Шунга- |šungγu| *'шумбах', 'шурган орох'* || Cf. Uig. *šuŋgu-* 'to dive, slip' (Schwarz, 524) || Kha, Bur. *šuŋga-*, Ord. *šuŋgur-*, Oir. *šuŋgv*

Шунх |singqu|{< Chin. *zhū hóng*} *'улаан'* (шороо чулуунаас гаргаж авсан улаан будаг) || Kha, Bur. *šuŋxa*, Ord. *šuŋxu*, Oir. *šoŋxv*

Шуудай |šiγudai|{< Chin. *xiāo dài*} *'нэхмэл уут'* || х о р ш : *'уут шуудай'* || Kha, Bur. *šūdai*

Шуудан |siudan|{< Chin. *shou dian*} *'бичиг захидал* (ачаа тээш дамжуулах үйлчилгээ)

Шуудуу |šuuduu|{< Chin. *shuǐ dào*} *ус урасхах нарийн суваг* || х о р ш : *'суваг шуудуу'*

Шууз |siγuja|{< Chin. *shāo zi*} *давастай шүүсэнд нь болгосон мах*

Шуумааз |šuumaja|{< Chin. *shāo mǎ zi*} *'жижиг маахуз'* (моринд тэгнэх богц)

Шуур- |siγur| *хүчтэй салхи үлээх, хурдан хөдөлөх.* Энэ язгуураас *siγurγ-a* [siγur-γa] 'шуурга', *siγurqai* [siγur-qai] 'шуурхай' зэрэг үг үүсчээ. || Kha, Ord. *šūr-*, Bur. *šūra-* Oir. *šūr-*

Шуурга |siγurγa|[= siγur-γa] *хүчтэй салхи* || х о р ш : *'салхи шуурга'* || Kha, Bur. *šūrga*, Ord. *šūrgan*, Oir. *šūrgvn*

Шушмаа |šusim-a|{< Chin. *shuō shén me*} *'юу гэнээ?'* (Монгол хэлэнд учир мэдэхгүй жижиг хүүхэдийг хэлнэ)

Шүглэ |šüglü|{< Tib. *shugs glu*] *'исгэрэлт'* (үлээж дуугаргах дохионы хэрэгсэл)

Шүдра |šudara|{< Skr. *šudhra*} *'доод төрөл'* (хиндү шашины ёсонд хүн төрөлхитөнийг дөрвөн анги язгуурт хуваадаг бөгөөд шүдра нь хамагийн доод давхаргынханыг заасан нэр)

Шүдэнз үз Чүдэнз

Шүдэрт- |šüdertü| х у у ч : *'шударуулах', 'хадхуулах'* || Ж= *'šüdütü moγai-a südürtü'ēsü södürgen-dür bü oroya'* [шүдэт могойд шударуулвал шудараанд нь бүү ороё](MNT 164)

Шүлэг |šilüg|{< Uig *šlük* < Skr. *śloka*} Эртний энэдхэгийн уламжилал ёсоор дөрвөн мөртэй яруу найрагийг *šilüg* 'шүлэг' */a šlüg must consist of four verses/* (HJAS 17, 1954, 106) хэмээн нэрлэж байсаныг монголчууд XIV зуун хүртэл

Шүтээн |sitügen|[= sitü-gen] *'махил'* || Ж= *'sayuysan tabčang-i takil-un* ***šitü-gen*** *bolyan'* [суусан тавзанг тахилын шүтээн болгон](Burq. 45a) // *'tere yaǰar-a nigen yeke luus-un qayan-a* ***sitügen*** *selte bui aǰuyui'* [тэр газар нэгэн их луусын хаанд шүтээн сэлт буй ажгуу](Chimeg 23b) // ***šütü'ēn*** *bolbe tündü noyan dergede* [оказал ему заспутничество перед беком](Mu. 337) || Kha, Ord. *šütēn*, Bur. *šütõn*, Oir. *šütār*

Шүү |šeü|{< Chin. *xiāo*} *'шүлт'*, *'хүжир'* (арис идээлэх эрдэс давас)

Шүү- |sigü| *'шалгах'*, *'хинах'*, *тунгаах'* Энэхүү язгуураас *šigügde-* [šigü-gde] 'шүүгд-', *šigügči* [šigü-gči] 'шүүгч', *šigülge* [šigü-lge] 'шүүлэг', *šigülte* [šigü-lte] 'шүүлт', *šigümǰi* [šigü-mǰi] 'шүүмж', *šigür* [šigü-r] 'шүүр', *šigü-r-de-* [šigü-r-de] 'шүүрд-', *šigürel* [šigü-r-(e)l] 'шүүрэл', *šigüsü* [šigü-sü] 'шүүс', *šigükü* [šigü-kü] 'шүүх' гэх мэт үгс үүсчээ || х о р ш : *'шүүн тунгаах'* || Kha, Ord, Bur, Oir. *šü-*

Шүүгээ |šügüi|{< Chin. *shú gui*} *'босоо авдар'* (шургуулга, тавиур бүхий хорго) || Kha. *šügē*

Шүүдэг |šüdüg|{< Tib. *zhu dag*} *'шүүж ариудхах'* (аливаа ном бичигийг тулган шүүж, алдаа мадагийг засан заларуулах үйл)

Шүүр |sigür|[= sigü-r] 1. олон жижиг нүхээр гоожуулан шүүх хэрэгсэл. 2. хилгас, дэрэс тэргүүтэнийг багцалж хийсэн хог шүүрдэх хэрэгсэл || Ж= *'erdem-i ülü toytayayči mayui kümün* ***šigür-tür*** *adali'* [эрдэмийг үл тогтоогч муу хүн шүүртэй адил](Sub.III:7b) || Kha, Ord, Bur, Oir. *šür*

Шүүс |šigüsü| *мах, жимэс зэрэгээс ялгарсан шингэн* (Монголчууд малын махыг шүүсэнд нь шингээн алсын аян жин, дайн байлдаанд хэрэглэдэг байсан тул аяны махан хүнэсийг *'шүүс'* хэмээн нэрлэдэг байгаад уламаар *'хоол хүнс'* гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ.) || Ж= *'ulay-a* ***šigüsü*** *büü barituyai'* [улаа шүүс бүү барьтугай](Khub I :20) // *'ula'ān-u ağtas,* ***ši'ūsün****-ü qonid, sa'ālin ge'ūd'* [улааны агт, шүүсний хонь, саалийн гүү](MNT 280-22) || Kha. *šūs*, Ord. *šūsü*, Bur. *šūhen*, Oir. *šūsn*

Тусхай судалгаа: A. Mostaert, F Cleaves, Trois documents mongols des archives secretes vaticanes, HJAS 15, 1952, 440-442)

Шүхэр |*sikür*| *'дэрэвгэр дэлгэц'*, *'халхавч'* || Ж= *'erdini-yin* ***šikür*** *dabquča-yuluysan neretü Bodistv'* [эрдэнийн шүхэр давхарласан нэрт бодисадва](Burq. 51b) // ***'sikür****-ün oroi-dur adali'* [шүхэрийн орой шиг](Chimeg 39a) || Kha, Bur. *šüxer*, Ord. *šü^{k}xür*

Шээ- |sige| *шээсээ гаргах.* Энэ үгээс *šigeg* [šige-g] 'шээг', *šigereng* [šige-reng] 'шээрэн', *šigesü* [šige-sü] 'шээс' зэрэг үг үүсчээ. || Cf. Uig. *siy-* 'to urinate' (Schwarz, 504) || Ж= *'kündü eme-yin* ***ši'ēküi*** *ğaǰar-a ese ğaruğsan, kür-dün-ü tuğul-un belči'ēl-dür ese kürügsen eme'* [хөл хүнд эмийн шээх газараас эс холдсон, хүрдний тугалын билчээрт эс хүрсэн эм](MNT194) // *noqai kölēn örgün* ***šēbe*** [собака поднял свою ногу и помочилась](Mu. 337) // *sigeba* 'to urinate' (LH S19) // *sei* 'urin' (Zir.132) || Kha, Ord, Bur, Oir. *šē-*

Шээс |šigesü|[= šige-sü] *давсагаар дамжин ялгарах биеийн шингэн* || Ж= *'burtay ber* ***šigesün*** *ber bi busu'* [би буртаг ч биш, шээс ч биш](Bod. 16a) // *sesün* 'urine' (Ras. 199 B3) // *šēsün* 'моча' (Mu. 331) // *ši'ēsün* 'моча' (IM 447) // *sēsün* 'urine' (Ist. 63) || Kha, Ord, Oir. *šēs*, Bur. šēhen

Э

Э-* |e| *төлөөлөх үг* (үгүүлэгчийн оршин буй газар, үгүүлэн буй цагт харьцангуй ойр байгаа газар орон, цаг хугацааг төлөөлөн заасан анхдагч язгуур) Тус язгуураас газар орон заасан *ende* [e-(n)de] 'энд' зүг чиг заасан *eyisi* [e-yi-si] 'ийш', цаг хугацааг заасан *ejiye* [e-jiye] 'эзээ' гэсэн үгс үүсчээ. Дээрхээс гадана нэрийг төлөөлөн заах *ene* [e-ne] 'энэ', *ede* [e-de] 'эд', *egün* [e-gün] 'үүн', нэрийн шинжийг төлөөлөх *eyimü* [e-yi-mü] 'ийм', үйлийн байдалыг заасан *eyin* [e-yin] 'ийн' тоо хэмжээ заах *edüi* [e-düi] 'өдий' гэх мэт заах үгс үүссэн байна.

Эв I |eb| *'эе', 'найрамдал'* Энэхүү язгуураас *ebgüi* [eb-güi] 'эвгүй', *ebde-* [eb-de] 'эвд-', *eble-* [eb-le] 'эвлэ-', *ebse-* [eb-se] 'эвс-', *ebtü* [eb-tü] 'эвт', *ebke-* [eb-ke] 'эвх-', *ebče-* [eb-če] 'эвц-' зэрэг үндэс үүсч, тэдгээрээс олон шинэ үг салбарлан гарсан байна || х о р ш : *'зе эв', 'эв дүй', 'эв зүй', 'эв хав', 'эв найрамдал', 'эв нэгдэл', 'эв санаа', 'эв тунжсин'* || Kha, Bur. *ew*, Ord, Oir. *eb*

Эв* II |ebe| *'өвөд'* гэдэг үгийн анхдагч язгуур. Энэ язгуураас *ebečiyē-* [ebe-či-yē] 'өвчил-', *ebečile-* [ebe-či-le] 'өвчил-', *ebed-* [ebe-d] 'өвөд-' гэх мэт үгс үүсчээ

Эвгүй [= eb-ügei] *'таарамжгүй', 'нийцгүй'* Энэ үгээс *ebgüyide-* [eb-güi-de] 'эвгүйд-', *ebgüyiče* [eb-güi-če] 'эвгүйц-', *ebgüyirke-* [eb-güi-r-ke] 'эвгүйрх-' гэх мэт нийлмэл бүтэцтэй үгс үүсчээ. || Kha. *ewgüi*, Bur. *ewgüi*

Эвд- |ebde|[= eb-de] *'хэмхэлэх', 'эвгүй болгох'* || Ж= *'sedkil inü čöken genüjü nasuda čiyšabd **ebdegsen** nigül-iyen arilyaju'* [сэдхэл нь цөөн гэмшиж, насандаа шагшаавад эвдсэн нүгэлээ арилгаж](BT 160b) // *'ene eye-bēn bü **ebdedkün**'* [энэ эеэ бүү эвдэгтүн](MNT 126) // ***ebdebe** balyasuni* [разрушил стену](Mu. 148) // *ebdebe* 'разрушил' (IM 436) || Энэхүү язгуураас язгуураас *ebdele-* [eb-de-le] 'эвдлэ-', *ebdere-* [eb-de-re] 'эвдэр', *ebderkei* [eb-de-rkei] 'эвдэрхий' гэх зэрэг үндэс үүссэн байна. || х о р ш : *'эвдэж хэмхлэх'* || Kha. *ewde-*, Ord, Bur. *ebde*, Oir. *ebdə-*

Эвдэр- |ebdere|[= eb-de-re] *'эвдэрхий болох'* || Ж= *'sayitur onuju üyiledbesü ele üyile **ebderekü** qamiy-a bolqu'* [сайтар онож үйлдвэс тэр үйл хаанаас эвдэрэх](Sub.VIII:20a) // *'senšhiŋüd asara'ūlju güŋ gon **ebdere'ēsü**'* [хуварагууд асаруулж сүм эвдэрвээс](Ph. TT 1351) || Kha. *ewder-*, Ord. *ebdere-*, Bur. *ebder-*, Oir. *ebdər-*

Эвдэрхий |ebderkei|[= eb-de-r-kei] *'эвдэрсэн'* || Ж= *'dabqur čamqay-tu ger **ebderkei** oryiltu ayula-yin ölke'* [давхар цамхагт гэр, сэрвэн оройтой уулын энгэр](Sub.V:6b) // *ebderkei* 'разрушенный' (Mu. 149) // *ebderkei* 'destroyed' (Ras. 202 C18) || х о р ш : *'эвдэрхий хэмхэрхий'* || Kha. *ewderxī*, Ord. *ebder'χī*, Bur. *ebderxei*, Oir. *ebdərkā*

Эвс- |ebse|[= eb-se] *'нийлэх', 'нэгдэх'* Энэ үгээс *ebseg* [eb-se-g] 'эвсэг', *ebsel* [eb-se-l] 'эвсэл' гэсэн үгс салбарлан гарч, идэвхитэй хэрэглэгдэж байна || Kha. ewsə-, Ord. *ebse-*, Bur. *ewse-*, Oir. *ewsə-*

Эвсэл |ebsel|[= eb-se-l] *'эвлэлдэн нэгдэхүй'* || х о р ш : *'эвсэл холбоо'* || Kha. *ewsel*, Bur. *ewselge*, Oir. *ewsəl*

Эвх- |ebke|[= eb-ke] *'эвд нь оруулах'* || Ж= *ebkebe bičigi* [сложил письмо] (Mu. 151) Энэ язгууpаас *ebkemel* [eb-ke-mel] 'эвхмэл', *ebkegürge* [eb-ke-gür-ge] 'эвхүүрэг', *ebkere-* [eb-ke-re] 'эвхэр-', *ebkegesü* [eb-ke-ge-sü] 'эвхээс' зэрэг үгс үүсчээ. || Kha. *ewxə-*, Ord. *ebᵘxe-*, Bur. *ewxe-*, Oir. *epkə-*

Эвэр |eber|[= eb-r] х у у ч : *'овчин'* || Ж= *doturaki* ***eber****-i em-iyer yaryayu'* [доторхи овчинийг эмээр гаргаюу](SubVI:6) // *'Jamuqa bura'ū-yin qoyar* ***eber*** *ni'āju, nükelejü'* [Жамуха бирууны хоёр эвэр нааж нүхлэж](MNT 116)

Эгч үз **Эгэч**

Эгшиг |egesig| *'зөөлөн дуу', 'ая'* || Ж= *'egülen luu-yin* ***egešig*** *dayun neretü Bodistv'* [үүлэн луугийн эгшиг дуу нэрт бодисадва](Burq. 52a) // *'kōg dayun, irayu sayin* ***egesig*** *kemen nomlabai'* [хөг дуу яруу сайн эгшиг хэмээн номлов] (Chimeg 53b) || х о р ш : *'эгшиг дуу'* // *'ая эгшиг'* || Kha, Oir. *egšig*, Ord, Bur. *egešeg*, Oir. *ekšīg*

Эгэл |egel| *'энгийн', 'жирийн'* || Cf. AT. *égil* 'ordinary' (Clauson 106) || Ж= ***egil*** *aran toyid-i büü jaryulatuyai'* [эгэл ард тойнтой бүү заргалдтугай] || хорш: *'эгэл жирийн'* || Kha, Ord. *egel*, Bur. *egēlei*

Эгэм |egem| *мөрний дотор талын хөндөлөн яс* || Cf. AT *egin* 'плечо' (ДТС 166), Turk. *ägin* 'schulter' (Räsänen, 37); Man. *egem* 'ключица' (Цинциус II:347) || Ж= ***'egem-eče*** *tanu tataju, ere-lü'ē saca'ū bolgaju'* [эгэмээс чинь татаж эр лүгээ сацуу болгож](MNT 214) // *egem* 'Schulter' (LH 1262) // *egem* 'shoulder' (Ras,198 С6) || Kha, Ord. *egem*, Bur. *ēm*, Oir. *ām*

Эгэч |egeči|[= ege-či]{< eke-či} *враг төрөлийн доторхи насаар илүү бүсгүй хүн* || Ж= ***'egeči*** *döi qoyar ökid-i ülemji maši nigüleskü sedkil-iyer ... soyurqaju'* [эгэч дүү хоёр охиныг үлэмж их нигүүлсэхүй сэдхэлээр ... соёр-хож](Burq. 44) // ***egeči*** *inü čima-dača sayin bügsen bö'ēsü eri'ūlūye.* ***egeči****-yēn ire'ēsü jayīlaju ögkü yü či'* [эгэч чинь чамаас сайн байх бөгөөс эрүүлэ. Эгэчээ ирвээс чи зай тавьж өгөх үү](MNT 155) // *egeči* 'sœur' (HY M52) // *egeči de'ū* [старшая и младшая сестра](Mu.151) // *egeči* 'ältere Schwester' (LH 1257) || х о р ш : эгэч дүү || Kha, Ord. *egetši*, Bur. *egeše*, Oir. *egətš*

Эд |ed| *'бараа', 'тавааp'* || Cf. AT. *ed* 'имущество', 'богатство' (ДТС 162), *ed* 'movable property' (Clauson 33); Cf. Man. *et* 'товар' (Цинциус II:469) || Ж= *'oytoryui-yin sang metü bügüde dayusqali-ügei* ***ed tabar-tan*** *boltuγai* [огторгуйн сан мэт бүгэд дуусашгүй эд тавaартан болтугай](BT156a) // *'altan, mōŋgün, a'ūrasun,* ***ed tabar'*** [алт мөнгө, агуурс, эд тавaар](MNT 248) // *'bilig-ün küčün-iyer oluγsan* ***ed'*** [ухааны хүчээр олсон эд](Sub II:7b) // ***et*** *qudalduqči* [торговец товаром](Mu. 167) || х о р ш : *'эд тавaар', 'эд бараа'* || Kha. *edə*, Ord, Bur. *ede*, Oir. *ed*

Эе |eye| *'эв найрамдал', 'эвсэл', 'зөвшил'* Энэхүү язгууpаас *eyeten* [eye-ten] 'эвтэн', *eyetü-* [eye-tü] 'эвлэлд-' гэсэн үг үүсчээ. || Ж= *'tabun kō'üd metü yākin eye üge'ün büi ta'* [таван хүвүүд минь та нар ягаад эв найргүй байна вэ](MNT 76) // *'Tatar-un Yeke-čeren Belgüdei-eče 'yambar* ***eye*** *eyetüldübei' ke'ēn asaġču'ū.*

Belgūdei ügülerün: *'tan-i būgūde-yi či'ün-dür ülijü kiduya' ke'ēldüb'* [Татаарын Их-цэрэн Бэлгүүдэйгээс *'ямар зөвшилцөл зөвлөлдөв'* хэмээн асууваас Бэлгүүдэй *'та бүгэдийг тэрэгний цүүтэй чиҷулан үхүүлэе'* хэмээлдэв] (MNT 154) || хорш : *'эе эв'* || Kha. *еуэ*, Ord, Bur. *eye*, Oir. *ey*

Эстэлд- |eyetüldü|[= eye-tü-ldü] *'эвлэлд-', 'зөвшилц-'* || Ж= *'Čiŋgis qahān yeke eye uruğ-iyār-iyān ğağča ger-tür oroju* ***eyetüldübe'*** |Чингис хаан их эвсэг урагаараа нэгэн гэрт орж зөвшилцөв| (MNT 154)

Эз* |eje| *'эзэн'* гэсэн уттыг хадгалсан язгуур. || Энэхүү язгуураас *ejegüi* [ejegūi] эзгүй', *ejele-* [eje-le] 'эзлэ-', *ejed* [eje-d] 'эзэд', *ejemde-* [eje-m-de] 'эзэмд-', *ejemsi-* [eje-m-si] 'эзэмш-', *ejen* [eje-n] 'эзэн', *ejengne* [eje-n-ne] 'эзэгнэ-', *ejerke-* [eje-rke] 'эзэрх-' гэх мэт үндэс үүсч, улам тэдгээрээс олон шинэ үг дам үүссэн байна || Kha. *edzə*, Ord. *edže*, Bur. *eze*

Эзотерик |esoterik|{< Rus. *эзотерик* < Eng. *esoteric* < Gr. *ἐσωτερικός*} *'изотээрик', 'далдын хүч'* (одоогоор шинжилэх ухааны үүднээс тайлаагүй нууцлаг зүйлийн тухай ойлголт)

Эзэл- |ejele|[= eje-le] | *'эрхшээх', 'эрхэндээ оруулах'* || Ж= *'ablin-a eliy-e-de kürtegsen kümün-i tarni bütüge[g]sen aran* ***ejelemüi'*** [албин чөдхөрт хүртсэн хүнийг тарни бүтээсэн хүн эзэлмүй](Sub.II:2b) // *'mongqol qa'ān delekei-yi* ***ejeleju*** *büle'ē'* [монгол хаан дэлхийг эзэлж билээ](KMQB A6) || х о р ш : *'эзэлэн түрэмгийл-' // 'байлдан эзэл-'*

Эзэн |ejen|[= eje-n] *'эзэмшигч этгээд', 'дээд тэргүүн'* // Pl. *ejed* (Mu. 127) || Cf. AT *idi* 'хозяин', 'владелец' (ДТС 203), *iḍī* 'property master', 'lord' (Clauson 41), Turk. *ijä* 'Herr, Besitzer' (Räsänen 169); Man. *ejen* 'master', 'lord' (Norman, 72) || Ж= *'tus* ***ejen-dür-iyen*** *sögüdkegülün mön yaǰar-tayan qariyuluy-san aǰuγu'* [өөрийн эзэндээ сөгдүүлэн уул газартаа хариулсан ажээ](Chang. 25) // *'ulus-un* ***ejen*** *qahān bö'ētele yosu ügei aljiās üyīle-dür dölesgekü minü nigen buru'ū ene bolba'* [уласын эзэн хаан бөгөөтөл ёсгүй буруу үйлд автах минь нэгэн буруу болов](MNT 281) // *ejen* 'seigneur, maître' (HY M53) // *eme malun* ***ejen*** [женщина – хозяйка скота](Mu.153) // *ejen* 'owner', 'master' (Ras.203 C6) // *ezän* 'husband' (Zir. 103) || х о р ш : *'эзэн хаан'* || Kha. *edzen*, Ord. *edžin*, Bur. *ezen*, Oir. *ezᵊn*

Эзээ |ejiye|[= *e-jiye] *'эдүгээ', 'өдийд', 'энэ хооронд'* (эртний монгол хэлний **e* язгуурт заах үгийн энэ хэлбэр нь үгүүлэн буй тухайн агшинд ойр хугацааг заана) || Ж= *'quda uruy barilduysan-ača* ***ejiy-e*** *kürtele'* [худ ураг барилдсанаас өдий хүртэл](Hin.7) // *'eji'ē turug ima'āri bolju'* [эдүгээ түүгээр түшиг болгож](MNT 167) // *'erten-eče* ***ejiye*** *kürtele olon ulus irgen-ü de'ēre qan bolqarun'* [эртнээс эдүгээ хүртэл олон улас иргэний дээр хан болгарун](HY A2)

Эй Би Си {< Eng. ABC} *'эй би си', 'аа бээ'* (англи хэлний цагаан толгойн эхний гурван үсэгээр *'хамагийн наад захын ойлголт'* гэсэн утгаар хэрэглэдэг. Энэ нь монгол хэлний *'аа бээ ч үгүй'* гэсэн хэллэгтэй адил)

Эй Ти Эм {< Eng. *automated teller machine*} *'эй ти эм', 'мөнгөний автомат машин'*

Эйч Ди {< Eng. HD *'high definition'*} *'эйч ди', 'өндөр нарийвчлал'* (өнгө, дүрсний өндөр нарийвчилалтай дамжуулах тоон технологийн зурагт радио)

хэмээн энэ хэл хүргэн элчин илгээв] (MNT 133) // *elčin kelečin-iyen yosu'ar yabu ülju'* [элчин хэлэрчээ ёсоор явуулж](KMQB B4) || х о р ш : *'элчин сайд'* || Kha. *eltšin*, Bur. *elšen*, Oir. *eltšin*

Элэг |eligen| 1. бодисын солилцоог тэнцүүлэгч, таван цул эрхтэний нэг, өвөр тал || Cf. Man. *eligen* 'печень' (Цинциус II:447) 2. *'зүрэх сэдхэл'* || Ж= 1. *'eligen ayuski ber bi busu'* [элэг уушхи ч би биш](Bod. 16) // *helige* 'liver' (Ras. 198 C28) || Ж= 2. *'heligen-ü urug busut-u bida'* [сэдхэл зүрэхний садан бусуу бид](MNT 105) // ***helige*** *ba anu hemtelbei bida'* [сэдхэл зүрэхийг нь эмтэлэв бид] (MNT 105) *hümekei helige ebüridčü yabuyu'* [өмхий санаа өвөрлөж явая](MNT 152) || х о р ш : *'элэг зүрэх'* (сэдхэл санаа) || х э л ц : *'элэг барих'* (басамжилах), *'элэг дэлэх'* (өнчирөн шаналсан сэдхэлийг сэргээх), *'элэг хөших'* (зоргоолтгүй инээх), *'элэг эмтэрэх'* (шаналан зовох) || Kha. *eleg*, Bur. *el'ge*, Oir. *elk'n*

Элэгд- |elegde|[= ele-gde] *'хуучирч муудах'* || Ж= *'хэдэн уе дамжиж элэгдсэн төмөр тухүүр'* (Д. Напагдорж, Хэлхээгүй сувд) || х о р ш : *'элэгдэж хорогдох'* || Kha. *elegdə-*, Ord, Bur. *elegde-*, Oir. *eləgdə-*

Элэнцэг |elinčüg|{< elin-čüg} *'дээд өвөг'*, *'элэнц өвөг'* || Ж= *'qoyina* ***elinčüg*** *inu qara yiučing ebedčin kürtefü'* [хожим элэнц нь хар юучин өвчин хүрч] (Hin.18) // *elinčük* 'bisaïeul paternel' (HY M53) || Kha. *elentseg*, Ord. *ölöŋtši*, Bur. *elinseg*, Oir. *el'ntsəg*

Элээ |eliye| х у у ч : *'шувууны дүртэй ороолон'* || Ж= *'ablin-a* ***eliy-e-de*** *kürtegsen kümün-i tarni bütügegsen aran eǰelemüi'* [албин, ороолонд хүртсэн хүнийг тарни бүтээсэн хүн ээлнэ](Sub. II:2b) // *hele'e* 'milan' (HY M60) // *elē* 'дьявол' (Mu. 164) // *eliye* (LH S11) // *eliye* 'the Devil' (Ras.198 A6) || Kha, Ord. *elē*, Bur. *elyē*, Oir. *elā*

Эм I |em| *'өвчинийг анагаах ерөндөг'*. || Cf. *em* 'лекарство' (ДТС 171) Энэ үгээс *emne-* [em-ne] 'эмнэ', *emči* [em-či] 'эмч' зэрэг үгс үүсчээ. || Ж= *'qouru bey-e-dür qour-tu buyu j-a. joqiyan čidabasu* ***em*** *bolumui'* [хор биед хортой буюу, хэрэглэж чадваас эм болно](Sub.VIII:4a) // *em* 'medicament, médecine' (HY 54) // *em* 'лекарство' (Mu. 152) // *em* 'Arznei' (LH 1263) || х о р ш : *'эм дом'*, *'эм тан'* || Kha, Ord, Bur, Oir. *em*

Эм II |eme| *'эр'*-ийн эсэрэг хүйсийн нэр. // Pl. *emes* (Mu. 125) || Ж= *'er-e* ***em-e*** *nigen yosutu bögesü ber sayin mayui-yin ilγal bui'* [эр, эм нэгэн ёст атал сайн муугийн ялгал бий](Sub. VI:15b) // *'ke'ēlitei* ***eme****-yi barijū'* [жирэмсэн эмийг барьж](MNT 38) // *eme* 'самка' (Mu. 153) // *ėme* 'femme' (Ist. 29) // *ämä* 'женщина' (IM M123) // *eme* 'Frau' (LH 1263) // *eme* 'woman' (Ras. 198 B11) || Энэхүү язгуураас *emege* 'эмэг', *emegčin* 'эмэгчин', *emegtei* 'эмэгтэй', *emegen* 'эмгэн' гэх мэт үгс үүсчээ. || х о р ш : *'эр эм'* || Kha. *em*, Ord, Bur. *eme*, Oir. *em'*

Эмбүүл |embüle| х у у ч : *'өвөсөн овоохой'* || Ж= *'Bodončar ebesün* ***embüle*** *ger kijü'* [Бодончар өвөсөн овоохой гэр хийж](MNT 24)

Эмбүр- |embüre-| х у у ч : *'нурах'*, *'өмөрөх'* || Ж= *'tüšimel noyan* ***embüreg-sen*** *dabqur čamqaγtu ger'* [түшмэл ноён нурсан давхар цамхагт гэр](Sub. V:6b)

Эмгэг |emgeg|[= em-geg] *'биеийн гэм согог'* || Cf. AT. *emgēg* 'pain' (Clauson 155) || х о р ш : *'өвчин эмгэг'* || Kha, Bur. *emgeg*, Ord. *emgek*

Эм-Эр-Ай {< Eng. MRI *'magnetic resonance imaging'* (соронзон долгионы дүрслэл)} *'эмэрай'* (цөмийн соронзон долгионыг ашиглан хүний биеийн эд эрхтэнийг нарийвчилан харах төхөөрөмж)

Эмч |emči|[em-či] *'эм бариач'*, *'овчинийг анагаан засагч'* || Cf. AT. *emči* 'лекарь' (ДТС 172), *emči* 'physician' (Clauson155) || Ж= *emči* 'Arzt' (LH 1257) || х о р ш : *'эмч домч'*, *'эмч сувилагч'* || Kha. *emtš*, Ord. *emtši*, Bur. *emše*, Oir. *emtši*

Эмэг |emege|[= eme-ge] *эцэгийн талын ахмад эмэгтэй хүн* || Ж= *'yeke emege inū Lii obuytai'* [их эмэг нь Лии овогтой](Chang. 14) // *emege* 'mere du man' (HY M54) || Kha, Ord. *emeg*, Oir. *emgə*

Эн |eng| бөс даавууны өргөний хэмжээ || Cf. AT. *en* 'ширина' (ДТС 173) || Kha, Ord, Bur, Oir. *eŋ*

Энгэсэг |engeske|{< Skr. *kiṃsuka*} *'гинсүгийн цэцэг'* (хацарыг гоёлон буддаг улаан өнгөтэй нэгэн зүйлийн давирхайт мод) || Ж= *'Seŋgüm esergü dobtulqu bolun, eŋgesge qačar-iyān qagdaju, Seŋgüm mūn tende unaju'ū'* [Сэнгүм эсэрэг довтолох болон энгэсгэ хацараа харвуулж мөн тэнд унажээ](MNT 171) // *enggeske oo-a jegüü yambar-iyar soyurqaqu-yi jrḫ medemū j-e'* [энгэсэг оо зүү хэрхэн соёрхохыг зарлиг мэдмүү](Ail. 37a) // *engeske* 'румяна' (Mu. 161) // *ėngeske* 'fard', 'rouge' (Ist. 29) || Ж= *'Мядагмаа гээгч үсээ самнаж, нүүртээ оо энгэсэг түрхэн'* (Д. Нацагдорж, Цагаан сар ба хар нулимс) || х о р ш : *'оо энгэсэг'* || Kha. *eŋgesge*, Ord. *eŋgesᵏxe*

Т у с х а й с у д а л г а а : G. Kara, Mongol *enggeske* and Turkic *englik* in the Yemen Polyglot', AMo 9, 2009, 1-4

Энтерпренер |enterprener|{< Eng. entrepreneur} *'энтерпрээнэр'*, *'үйлдвэр худалдааны эзэн'* (бараа таваар, хөрөнгө мөнгөө зах зээл, үйлдвэр худалдааны газар нийлүүлээд ашиг орлогоо олж авдаг үйлдвэр худалдааны эзэд)

Энэ* |ene| *'энэрэх'* гэсэн утга хадгалсан язгуур. Энэхүү язгуураас *enel-* [ene-l] 'энэл', *eneri-* [ene-ri] 'энэр-' гэсэн үгс үүсчээ.

Энэл- |enele|[= ene-le] *'шаналах'* || Ж= *'tergegür-ün dergede **enelün** šinalun kebtekūi ebečin kümün-i ūjejū'* [замын хажууд энэлэн шаналан хэвтэх өвчтэй хүнийг үзэж](Burq. 8b) // *'**eneljū** šinalju yasalbasu aqu irgen-ū tōb ujayur anu edūi kū būyū'* [энэлж шаналж гасалваас аху иргэний төв язгуур нь тийм буюу] (Taq. 37b) // *enel-* 'lament', 'complain' (Zir. 102) || х о р ш : *'энэлэн шаналах'* || Kha, Ord, Bur. *enel-*, Oir. *enəl-*

Энэр- |eneri|[= ene-ri] *'хайрлах'*, *'өршөөх'*. Энэ үгээс *eneril* [eneri-l] 'энэрэл', *eneringgüi* [eneri-ŋgüi] 'энэрэнгүй' гэсэн үгс үүсчээ || Ж= *'eden-i **enerin** ōrūšiyen ülükü sedkimüyü'* [эднийг энэрэн өршөөн үл хүү сэдхэмүү] (Burq. 20b) // *eneribe* 'был сострадателен' (Mu. 160) || х о р ш : *'энэрэн нигүүлсэх'*, *'энэрэн хайрлах'* || Kha, Bur. *ener-*, Ord. *enere-*, Oir. *enᵊr-*

Энэрэнгүй |eneringgüi|[= eneri-ŋgüi *'өршөөнгүй'*, *'энэрэлтэй'* || Ж= *'тэр өвгөний **энэрэнгүй** үг соносоод, баярлан бишрч'* (Б. Ринчен, Заан залуудай) || Kha. *enereŋgüi*, Bur. *enereŋgy*

Эр |ere| *'эр'*-ийн эсрэг хүйсийн нэр. // Pl. *eres* (Mu. 153) || Cf. AT *er* 'мужчина' (ДТС 175), Turk. *ār* 'Mann', Herr, Mannschaft (Gabain 298), *ār* 'man'

(Starostin 312) || Ж= *er-e kümün bolqu-yin belge* büi' [эр хүн болохын шинж буй] (Burq. 11b) // *'Dobun-mergen-i ügei bolugsan-u qoyina Alan-go'ā ere ügei'üi bö'ed gurban kō'üd tore'ülbi'* [Добун мэргэнийг үгүй болсоны хойно Алангоо эргүй атал энэ гурван хүвүүдийг төрүүлэв](MNT 17) // *ere* 'самец' (Mu. 161, IM 437) // *ere* 'мужчина' (Mu.161) // *ère* 'homme' (Ist. 29) // *ere* 'Mann' (LH 1262) // *ere* 'man' (Ras.198 B10) || х о р ш : *'эр эм'* || Kha, Oir. *erə*, Ord, Bur. *ere*

Эр-* |erū| х у у ч : *'зовних'* || Ж= *'sedkil-iyen yayča uruyši-da maytayulqu-yi yayun* ***erütele*** *būi tan-a'* [сэдхэлээ гагцхүү өөд магтуулахыг юунд зовних буй танд](Hin. 53) // *'Hō'ēlün eke, Qasar ki'ed de'ü ner inü* ***herüjü*** *aju'* [Өэлүн эх, Хасар хийгээд дүү нар нь сэдхэл зовниж ажу](MMT 93)

Эрдэм |erdem| *'зэмшсэн мэдлэг', 'чадвар'* || Cf. AT. *erdäm* 'достойнство' (ДТС 176), *erdem* 'образование' (Щербак 2005, 35) || Ж= *'mongyol irgen bičig* ***erdem*** *es-e ber surbasu'* [монгол хүн бичиг эрдэм эс сурваас](Jig 17) // *'bilig* ***erdem*** *oyorabasu adusunača taqi dor-a kemegdeyü'* [билиг эрдэмийг орхигдуулваас адуусанаас ч дор хэмээгдюу] (Turf. 7:3) // *erdem* 'наука' (Mu. 161) // *erdem* 'Tugend' (LH 1255) || х о р ш : *'эрдэм билиг', 'эрдэм мэдлэг', 'эрдэм ном', 'эрдэм ухаан'* || Kha, Ord, Bur. *erdem*, Oir. *erdᵊm*

Эрдэнэ |erdeni|{< Uig *ärdini* < Sogd *rtny* < Skr. *ratna* > Tib. *radna* > Mo. *ardnaa*} 1. *дээдийн чухал зүйл.* Монголчуудын шашин соёлын хүрээнд *'гурван эрдэнэ', 'таван эрдэнэ', 'долоон эрдэнэ', 'есөн эрдэнэ'* гэсэн ойлголтууд байдаг. 2. *'үнэт эрдэнийн чулуу'* (үнэт эрдэнийн чулуунд бадмараг, биндэряа, доржпалам, индранил, маргад, сувад, шүр зэрэг багтана) || Cf. AT *erdäni* 'драгоценность', 'сокровище' (ДТС 176), AT *ertini* 'jewel' (Clauson 212) || Ж= *'alayan metü vaiduri* ***erdini****-bēr törülki jilmayān boltuγai'* [алга мэт биндэрьяа эрдэнэ төрөлхи зөөлөн болтугай](BT 157a || х э л ц : *'гурван эрдэнэ'* ('бурхан эрдэнэ', 'ном эрдэнэ', 'лам эрдэнэ') || Kha. *erdenə*, Ord, Bur. *erdeni*, Oir. *erdᵊni*

Т у с х а й с у д а л г а а : Х. Лувсанбалдан, *'Erdeni'* kemekü üge-yin učir, *'Mongyol kele bičig'*, 10, 1989, 60

Эрин |erin|{< Man. *erin*} *'цаг уе'* || *'эрин уе', 'эрин зуун' 'эрин цаг'* || Cf. Man. *erī* 'время' (Цинциус II:463) || Kha. *eren*

Эрих |erike| *бөөрөнхий хэлбэртэй үнэт чулуун сондор.* (Энэ үг шашины сургаал ном унших цагт хуруугаараа эргүүлдэг 108 ширхэгээр хэлхэсэн бөөрөнхий мөхлөгийг нэрлэнэ. Эрихний мөхлөгийг үнэт мод, эрдэнийн чулуугаар хийдэг.) || Ж= *'kümün-ü terigün-ü čimeg, unjiyuluysan* ***erike****, jayan-u arasun degel'* [хүний толгойн чимэг, зааны арисан дээл](Chimeg 53b) || Ж= *erike* 'ожерелье' (Mu. 163) || Kha. *eriχ*, Bur. *erχi*, Oir. *erkᵊn*

Эрлийз |erliǰe|{< Chin. *èr lèi zi*} *'хоёр төрөл'* (хоёр өөр үндэстэн болон үүлдэрийн дундаас гарсан холимог шинжтэй үр төл) || х о р ш : *'эрлийз хурлийз'*

Эрлэг I |erlig|{< Uig *erklig*} *'хүчирхэг'* (урид насны муу үйлийн үр) || Cf. Turk. ***erklig*** 'могущество' (ДТС 180), AT ***erklig*** 'possesing power' (Clauson 214), *erlig* 'повелитель', 'владыка подземного мира' (Щербак 2005, 35) || Ж= *'****erklig*** *qayan-u jüg-tür jüglegsen ebedčin kemegdekü ene büi'* [эрлэг хааны зүгт чиглэсэн

өвчин хэмээх энэ буй](Burq. 9a) // ***'erlig*** *qaγan-u egeči bükü-yin tula'* [эрлэг хааны эгэч бүхийн тул](Chimeg 55a) || Kha. *erleg,* Ord. *erlek, erlik,* Bur, Oir. *erlig*

Эрлэг II |erelig|[= ere-lig] х у у ч : *'эр хүний дусал', 'дочиг'* || Ж= ***ereligĕn*** *asqaba oqaqči 'совершающий coitus пролил свою сперме'* (Mu. 162)

Эрмэг |eremeg|[= ere-meg] *'эршүүд', 'эрийн шинжтэй'* (их төлөв унагалдаггүй гүү гэх мэт адуун дээр хэрэглэдэг) || Ж= *aman ćaγa'ān* ***eremüg*** *qulagčin-i unu'ūlju'* [ам цагаан эрмэг хулыг унуулж](MNT 87) || Kha, Bur, Oir. *ermeg*

Эротика |erotik|{< Eng. *erotica*} *'эроотиг', 'тачаангуй шинжтэй'* (урлаг, уран зохиолд хуял тачаангуйн үйлийг элдэвзэр дүрслэн үзүүлэх чиглэл)

Эрс |ersü| *'саармаг'* (шүтэн барилдсан харьцангуй шинжтэй хос шинж) || Ж= *'yaγun-u tula kemebesü urbaqu* ***ersü*** *inü sar-a-yin qayas-tur er-e kiged sar-a-yin qayas-tur em-e bolqu metü'* [юуны тул хэмээвээс урвах эрс нь сарын хагаст эр хийгээд сарын хагаст эм болох мэт](OM 11b)

Эрүү |eregü| *'гэм', 'ялтаныг гэсхээх цааз'* || Ж= *'ōber-ün kōbegün šibayun metü tayalaǰu yabubasu ta* ***eregü*** *qour-tur ülü oruγad'* [өөрийн хүүхэд шуухад мэт хайрлан явбаас та гэм хорт оруулалгүй](Hin. 29) // *'Jelme yisün aldal alda'āsu* ***ere'ū-dür*** *bü orotugai'* [Зэлмэ есөн алдаа алдсан ч гэмд бүү тооцсугай](MNT 211) // ***ere'ü*** *kibe* [совершил грех](Mu. 162) || Чин уласын үед ялтаны хэрэгийг хүлээлгэхийн тул есөн эрүү (банз, шаахай, цавчирга, туйван, сараалж, савслага, хүлэлгээ, дүүжилүүр, төөнүүр) хэмээх хүнд гэсгээл оногдуулдаг байжээ. || х о р ш : *'эрүү шүүлт'* || Kha, Ord. *erū*

Эрх |erke| *'хүч', 'эрх мэдэл'* || Cf. Turk. *erk* 'сила, могущество' (ДТС 179) *erk* 'authority', 'free will' (Clauson 220); Man. *erke* 'powerful', 'strong' (Norman, 78) || Ж= *'teyin amiduraqui* ***erke*** *kučün qamiγ-a bui'* [тийн амьдарах эрх хүчин хаа буй] (Burq. 57a) || х о р ш : *'эрх ашиг', 'эрх мэдэл', 'эрх чөлөө'* || Kha. *erxə,* Ord. *erᵏxe,* Bur. *erxe,* Oir. *erkə*

Эрхүүн |erkegün|{< Pers. *arkaūn* < Gr. *Ἀρχων} 'христийн санваартан' //* Pl. *erkegüd* (Khub.I:8) Орчин үеийн ордос аялгуунд загалмайтаны шашинтаны удамынханыг *erᵏχut* хэмээн нэрлэдэг ажээ (A Mostaert, *Ordosica, Les Erküt, descendents des chrétiens médiévaux chez les Mongols Ordos,* Bulletin of the Catholic University of Peking, VIII, 1934, 1-17 // *idem.* Dictionnaire Ordos, 247) || Б. Я. Владимирцов, *Mongolica* I. *Об отношении монгольского языка к индоевропейским языкам Средней Азии,* 'Работы по истории и этнографии монгольских народов', 131) || Ж= *'toyid* ***erkegüd*** *šingšingüd dašmad aliba alba yubčiri ülü üǰen'* [бурханы шашин, христийн шашин, бомбын шашин, исламын шашины санваартан нарыг аливаа алба татвараас чөлөөлж](Buyantu 1313) // ***erke'ūnü*** *mesǰid* [христианская церковь](Mu. 164) || Ord. *erkχūt,* Bur. *erxūt*

Эрэл |eril[= eri-l] *'хүсэл', 'мөрөөдөл'* || Ж= *'luus-un qad* ***eril-iyer*** *kei qur-a čay-tur törügülüged'* [лусын хаад хүсэлээрээ дуртай цагтаа бороо хур оруулж] (BT 167a6) // ***eril*** 'просьба' (Mu. 195) || х о р ш : *'эрэл сурал'* || Kha. *erel,* Ord, Bur. *eril,* Oir. *erʲl*

Эрэмбэ |erimbe|{< Tib. *rim ba*} *'зэрэг дэв'* (дэс дараалал) || х о р ш : *'эрэмбэ дараа'* || Kha. *eremba*

Эсгий |isegei|{< **sisegej*} || *хонины ноос зулж, хавтгайлан дагтаршуулж хийсэн бүтээгдэхүүн.* || Cf. Man. *iseki* 'войлок' (Цинциус I:332) // *sisigi* 'войлок' (Цинциус II:98) || Ж= *'qubi irgen-ü nere-'ēr* ***isgei*** *tu'ürgatan-i iriče'ülfü'* [хувь иргэний нэрээр эсгий туургатаныг хувааж](MNT 203) // *sisegei* 'войлок' (Mu. 323) // *sisege* 'feutre' (Ist. 64) // *siskei* 'felt' (Ras.202 A12) // *siskɛi* 'felt', 'coarse cloth' (Zir.132) || Kha. *esgī*, Ord. *esegī*, Bur. *ešegy*, Oir. *iškā*

Эснэ- |eseni| *'төрөх', 'мэндлэх'* (ихэс дээдэсийн таалал төгөссөнийг хүндэдхэлтэйгээр илэрхийлэхэд энэ үгийг хэрэглэнэ) || Cf. AT. *esen* 'to enquire after, to great' (Clauson 249)

Эссе |esse|{< Rus. эссе < Fr. *essai*} *'эсээ', 'найруулан зохиож бичих'*

Эстрад |estrad|{< Rus. *эстрада* < Fr. *estrade*} *'эстраад'* (хөнгөн хөгжимийн төрөл)

Эсхэл |eskel|[- eske-l] хусаран гүүний сүүг гурван жил хөхөж өссөн морь || Ж= *'Togto'ā-yin* ***esgel*** *qali'ūn-i Jamuqa anda-da unu'ūlbai'* [Тогтоогийн эсхэл халиуныг Жамуха андад унуулав](MNT 117)

Эсэг |esüg|{< *is-(ü)g*} *'айраг цэгээ'* (гүүний сүүг исхэж боловсоруулсан ундаа) || Ж= ***esüg*** *olun yadaju'* [цэгээ олж ядан](MNT 145) // *esük* 'lait de jument' (HY M55) Энэ үгээс *'esügčile'* [= *esüg-čile*] 'эсэгчил' гэсэн үйл үг үүсчээ || Ord. *esük / üsük*

Эсэгчил- |esügčile|[= esüg-čile] *'айрагдах'* (олуулаа цуглаж айраг уущгаах) || Ж= *'Bodončar tede irgen-dür odču, üdür* ***esügčilejü'*** [= Бодончар тэдгээр иргэн дээр очиж, өдөр нь айрагдаж](MNT 28)

Эсэн |esen| *'эрүүл энх', 'энх эсэн'* || Cf. AT. *esän* 'здоровый' (ДТС 183), *esenlik* 'good health, soundness' (Clauson 249), *esän* 'здровый' (Щербак 1997, 116) || Ж= *'en-e bey-e* ***esen****-dür erdem bilig sursu'* [энэ биеийн эсэн мэнд дээр эрдэм билиг сурая](Turf. VII:3) // *'Ögödei-yin amin* ***esen*** *kürgejü ireǰü büle'ē'* [Өгөдэйн амийг эсэн мэнд хүргэж ирж бөлгөө](MNT 214-61) // *esen* 'здровый телом' (IM 437) || х о р ш : *'эсэн мэнд'* || Kha. *esen*, Oir. *es²n*

Эсэргүү |esergü|[- eser-gü] *'сөрөг үзэлтэн'* (Орчин үеийн монгол хэлний улас төрийн хэллэгт энд ийм утгаар хэрэглэгдэж байна.)

Эсэруа |esru-a|{< Uig. *äzrua* < Sogd. *azruwa* < Skr. *īśwara*} *'ертөнцийг бүтээгч бурхан'.* (Энэдхэгийн *'индуизм'* шашины гурван их шүтээний нэг, дэлхий ертөнцийг бүтээгч) || Ж= *'buyan-tu üyiles-iyer amitan-i imayta* ***Esru-a****-yin qutuy-tur jokiyabai'* [буянт үйлсээр амьтаныг ямагт эсэруагийн хутагт зохиов](Burq. 4a)

Эсэрэг |esergü|[= eser-gü] *'өөдөөс', 'сөрөг'* || Ж= *'naran* ***esergü*** *büse-bēn küjü'ün-dür-iyēn erikelejü'* [нарны өөдөөс бүсээ хүзүүндээ ороож](MNT 103) // *'širui usun* ***esergü*** *tesergü nökür böged'* [шороо ус хоёр эсэрэг тэсэрэг нөхөр бөгөөд](OM 23a) // *'gurban kü tümed bolju, jamuqa-yin* ***esergü*** *inü morilaju, Dalan-baljud-[ta] bayīlduju* [гурван түмэд болж, Жамухын өөдөөс хөдөлөн Далан-балжудад байлдаж](MNT 129) || х о р ш : *'эсэрэг тэсэрэг'* || Kha. *esereg,*

Ord, Bur. *esergü*, Oir. *esərəg*

Эсэрэгэн |esergün|[= eser-gün] *'ирэх цаг'* || х о р ш : *'эсэрэгэн жил'* (ирэх жил)

Эт- |ete| *'үүсхэх'*, *'одөөх'*, *'эргүүлж нугалах'* || Cf. AT. *et-* 'совершать, создавать' (ДТС 186) || Ж= *'ulus-a qour-tu üyiles-i* ***eten*** [уласдаа хорт үйлс өдүүлэн](Hin.16) // *'kijig ebedčin-i* ***etegči*** [хижиг өвчинийг өдөөгч](Tara 21) || Kha. *etə-* Bur. *ete-* 'зайлуулах' , Oir. *et-* 'малтах', 'ухах'

Эталон |etalon|{< Rus. *эталон* < Fr. *étalon*} *'эталоон'*, *'хэмжүүр'*

Этүгэн |etügen|[=etü-gen] *'газар эх'* || Ж= *'balar* ***etügen*** *geyigsen metü'* [харанхуй дэлхий гийсэн мэт](Turf. VII:2) // *körisütei* ***etügen*** *körbejü büle'ē'* [хөвөст дэлхий хөрвөж бөлгөө](MNT 254)

Тусхай судалгаа: М. Хашимото, *'Монголын нууц товчоон'*-ы *'etügen, ötögen'* гэдэг үгийн тухай, ОУМЭИХ IX:II. 209-211

Этюд |etyud|{< Rus. *этюд* < Fr. *etude*} *'этюүд'* (судалбар зураг, жүжигчилсэн тогтолт)

Эүшээ ||[= egüšiye] х у у ч : *'тэвчишгүй'*, *'тааламжгүй'* || Ж= *'Moŋgol-un ba ere agta gajar* ***he'üšiyeji'ü*** *kölčirkemüi ke'ēgdemüi'* [монголын цэрэг эрс, агт морьд нутаг газартаа үл дасан химаралдмуй](MNT 248)

Эф-Эм || {< Eng. F *'frequency'* + M *'modulation'* (давтамжийн өөрчилөлт)} *'эф-эм'* (өндөр дамтамжтай богино долгионы радио нэвтрүүлэг)

Эфир |efir|{< Rus. *эфир*} *'эфийр'* (радио, телевизийн шууд нэвтрүүлэг)

Эфү |efu|{< Man. *efü*} *'хүргэн'* (Манжийн хааны хүргэн) || Ж= *'дайчин уласын дөрөвдүгээр тавнан 'гүрүн-и эфү' болгох чимээ ордоноо цахилгаан мэт хурдан түгээж'* (Б. Ринчен, Гүнж)

Эх I |eke| 1. *үр төлийг төрүүлэгч* 2. *эхлэл, үүсхэл* || Ж= 1.*'qaγan ečige qatun* ***eke*** *činü γašiγun-iyar nögčikü-eče bolumui'* [хаан эцэг, хатан эх чинь харамсалтай нөгчсөнөөс болмуй](Burq. 29b) // *'****eke****-deče asagsu ke'ēn irebe bi'* [эхээсээ асууя хэмээн ирлээ би](MNT 118) // *eke* 'mere' (HY M53) // *eke* 'мать' (Mu. 152*)* // *eke* 'Mutter' (LH 1256) // *eke* 'mother' (Ras.200 B21) || х о р ш : *'эх эцэг'*, *'эх орон'* || Kha. *exə*, Ord. *eᵏxe*, Bur. *exe*, Oir. *ekᵊ*

Эх II |eki(n)|{< heki(n)} *'тэргүүн'*, *'толгой'* || Ж= *'****eki*** *ebedkü-i tedüiken-i ber arilγasu kemen sedkigsen-dür'* [толгой өвөдөх тэдийхөнд эдгээх хэмээн сэдхэсэнд](Bod. 2b) // *'****eki*** *teri'ü üge'ün tula Buda'ād obogtan tede bolba'* [тэд толгой түрүүгүй тул Будаад овогтон болов](MNT 46) // *buga'ü tataju abču,* ***heki*** *inü nigen-te deledü'ēd'* [гараа суга татаж аваад толгойг нь нэг удаа цохиж аваад] (MNT 81) // *hekin* 'голова' (Mu. 183) // *eke* 'mere' (Ist. 28) // *hekin* 'Kopf' (LH 77) // *ekin* 'head' (Zir. 101) || х о р ш : *'эх адаг'* || Bur. *exi*, Oir. *ekᵊn*, Mog. *ekin*, Dag. *xeki*

Эхнэр |ekener|[= eke-ner] *'эх'* гэдэг үгийн олон тоо. (нэг эр олон гэргий авч байсан тэр цагт тэднийг тийнхүү нэрлэж байжээ. Энэ үг аяндаа олоны утгаа алдаж *'гэргий'* гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ) || Kha. *exner*, Ord. *eᵏxener*, Bur. *exener*

Эхтэн |ekiten|[= eki-ten] *'тэргүүтэн'* || Ж= *'Qudluγ-Qy-a **ekiten** daruγas noγad'* [Хутлуг хиа тэргүүтэн дарга, ноёд](Turf. 22)

Эцэг |ečige| *'аав хүн'* || Ж= ***ečige** eke kȫbegün-i asaraqu metü kȫbegün ečige eke-yi qamiγ-a sedkikü'* [эцэг эх хүүгээ асарах шиг хүү нь эцэг эхээ яахин тэгэж сэдхэх](Sub. IX:4b) // ***ečige** minü Naqu-bayan ke'ēgdeyü'* [эцэг минь Наху баян гэдэг](MNT 90) // *ečige* 'père' (HY M52) // ***ečige** ügei bolba* [лишился отца](Mu. 151) // *ečige* 'père' (Ist. 28) // *āčā* 'отец' (IM M119) // *ečge* 'Vater' (LH 1255) || х о р ш : *'эцэг эх'* || Kha. *etseg*, Ord. *etšige*, Bur. *esege*, Oir *etsᵉgə*

Эчнээ |ečin-e|[= ečі-ne] *'далд', 'нууц'* (Орчин үеийн монгол хэлэнд их төлөв хичээлд бичилэн суухгүй, бие даан суралцах хэлбэрийг хэлж байна.) || Ж= *'nidün-ü **ečin-e** naγur-un dotur-a orošiγul-bai'* [нүднээс далд нуурын дотор оршуулав](Burq. 30b) // *'nidün-ü **ečine** gēdkün' ke'ēbe'* [нүднээс далд хаягтун хэмээв](MNT 156) || Kha. *etsᵉnē*

Эш |esi|{< Uig. *išі*} 1. *'үг яриуур'* 2. *'хамаатай'* || Ж= **1**. *'ene bayiγuluγsan bii tas egüri urtu-da **eši** boluγad'* [энэ байгуулсан чулуун хөшөө өни мөнхөд яригуур үндэс болоод](Jig. 35) // *'eke boluγsan qamuγ amitan-i **eši** onol-un nom-dur jokiyaqu boltuγai'* [эх болсон хамаг амьтаныг эш онолын номд зохиох болтугай](OM 25b) || х о р ш : *'эш үндэс'* **2**. *'sayin sayin **eši** minü teyin kisügei'* [сайн сайхан хатагтай минь тийн хийсүтэй](Burq. 43b) || х о р ш : *'эш хатан'* (их хатан, тэргүүн хатагтай) || Kha. *eš*, Ord. *eši /išі*, Bur. *eše*, Oir. *iš*

Ээл |egeli|{< *e'ēli* < *ehēli* < *ibēli* < *ibe'eli* < *ibegeli*} *'ивээл', 'өгөөж'* (Энэ үг нь *ibegeli 'ивээл'* гэдэг үгийн хувьсалын үр дүнд үүсчээ.) || Kha. *ēl*

Ээр- |egere-| х у у ч : *'сахин хамгаал-', 'дайр-', 'довтол-'* || Ж= *'e'ületei sȫni ȫrȫketei ger minü **e'ēren** kebtejü'* [үүлтэй шөнө өрхтэй гэрийг минь сахин хэвтэж](MNT 230) || Kha, Oir. *ēr-*, Ord, Bur. *ēre-*

Ю

Юань |yuwan|{< Chin. *yuán*} *'мэргүүн', 'язгуур'* (XIII-XIV зууны үед Хубилай хааны үндэслэн байгуулсан их гүрэний нэр.) Эдүгээ БНХАУ-ын мөнгөний нэгэжийг мөн ийн нэрлэнэ.)

Юбка |yübka|{< Rus. *юбка* < Fr. *jupe*| *'юүпэг', 'банзал'* (эмэгтэй хүний биеийн доод хэсэгт углаж өмөсөх хувцас)

Югти |yugti|{< Uig. *yukdi* < Skr. *yukti*} *'дасал', 'зохиццол'* || Ж= *'qayan-u jrly-iyar agam yugti nom-ud-tur sayitur daduysan bi Čosgi-odsir'* [хааны зарлигаар агам югти номуудад сайтар дадсан Чойжи-Одсэр би](ВТ 166а7)

Юм |yüm|{< Tib. *yum*} *'эх бурхан'* (билиг бармидын хураангуй) || Kha. *yūm*, Ord. *im*, Bur. *yum*

Юмбүү |yuwembü|{< Chin. *yuán bāo*} *'өлгий мөнгө'* (тусхай хэвд цудхасан өөр өөр жинтэй дээд тал нь дэрэвгэр алт, мөнгөн зоос)

Юмдүүжин |yumdüüjin|{< Tib. *yu mo mde'u 'byin*] *'юмдүүжин'* (ягаан өнгийн нарийн туузан илтэстэй, эмийн ургамал)

ЮНЕСКО {< Eng. UNESCO 'United Nations Educational, Scientific and Cultural Organization'} 'ЮНЕСКО' (НҮБ-ын боловсорол, шинжилэх ухаан, соёлын байгууллага)

ЮНИСЕФ {< Eng. UNICEF *'United Nations International Children's Emergency Fund'* ЮНИСЕФ (НҮБ-ын Хүүхэд хамгаалалын сан)

Юникод |unikod|{< Eng. Unicod} *'тэмдэгтийн кодчилолын стандарт'* (цахим бичвэр дэх хөрвөх чадвартай үсэг, тэмдэгтийн тогтолцоо)

Юудэн |yeüden|{< Chin. *yǒu dan*} *'бороонь халх'* (урд хэсэгээрээ үстэй, толгойг бүтэн бүрхсэн өвөлийн малгай. Сүүлийн үед цув, пальтоны заханд залгасан толгойн бүрхэвчийг ийн нэрлэх болжээ.) || Kha. *yūdeŋ*, Bur. *yuden*

Юүл- |yegüle| *'соли-', 'шилжүүл-'* || Cf. Uig. *yul-* 'to pull out (Schwarz, 805) || Kha, Bur. *yūl-*, Ord. *yūle-*

Юүтүб {< Eng. *youtube*} *'юутүб' 'таны хоолой'* (2005 оноос олон нийтэд зориулан нээсэн видео дүрс, кино үзэж, дуу хөгжим сонсох цахим хуудас)

Я

Яам |yamun|{< Chin. *yá mēn*} *'түшмэлийн суух газар'* (Манжийн үед алба шийдхэх газарыг нэрлэж байгаад эдүгээ тодорхой салбарын төрийн бодлого хэрэгжүүлэх төв байгуулгыг нэрлэх болжээ) || Ж= *'**yamun** bayiγuluyad noγad-i tüsikūi-dūr'* [яам байгуулаад ноёдыг түшихүйд](Chang. 27) || Kha. *yām*, Ord. *yāmu*, Bur. *yāman*

Ярмаг |yaγarmaγ|{< Rus. *ярмарка* < Ger. *Jahrmarkt*} *'үзэсхэлэн худалдаа'* || Kha, Bur. *yārmag*

Яатуу |yatuu|{< Chin. *yā tou*} *'салаа гээгт'* (охин хүнийг өхөөрдсөн үг байсанаа эдүгээ бүсгүй хүнийг дороомжилсон үг болжээ)

Явуу |ibau|{< Chin. *yi bèi*} *'явуу'* (усанд амьдардаг зузаан хуягтай нилцгай биетэн) || Kha. *yawū*, Bur. *yuwū*

Ягчис |iγčas||{< Uig. *yakṣa* < Skr. *yakṣa*} *'хор өвөгч'* (газар лусын сахиус)

Яд- |yada| *'чадан ядах'*, *'арга барах'* Энэ язгууртаас *yadanggi* [yada-ŋgi] яданги', *yadar-* [yada-r] 'ядар-', *yadamaγ* [yada-maγ] 'ядмаг', *yadayu* [yada-γu] 'ядуу' гэх мэт үндэс үүсчээ. || Ж= *'asuru narin qoγolai-tu alqun **yadaqu** költen'* [асар нарийн хоолойтой, алхан ядах хөлтэй](Turf. 6:12) // *'tabu'ūla tabun ċugtai müsüd kū'ūleldün bariǰu bitü'üljü quġulun **yadaba**'* [тавуул таван багц сум нийлүүлэн барьж тойруулан хугалж ядав](MNT 19) // *yadaba* 'устал' (Mu. 450) || х э л ц : *'арай ядан'* (арайхийж), *'арга ядах'* (мухардалд орох), *'тэсч ядах'* (тэвчээр алдах), *'үзэн ядах'* (ихэд дургүйцэх) || х о р ш : *'ядаж цөхөх'* || Kha. *yadɔ-*, Ord, Bur. *yada-*, Oir. *jad*-*

Ядам |idam|{< Tib. *yi dam*} *'хувийг сахигч'* (эртний энэдхэгийн их бандида нарын бисалгалын гол шүтээн болсон амарлингуй болон догшин бурхан бүтэдийн мөн чанарыг багтаасан бурхадын чуулган. Энэ нь бурхан багшийн номлосон нууц тарнийн үндэс буюу дандарын аймагийн бисалгал бүтээлийн цогц юм) || Ж=*'üsüg terigüten uqaγan-u geyigülügči **yidam** burqan mön böged öber-iyen **yidam** bariγsan-u tula bolai'* [үсэг тэргүүтэн ухааны гийгүүлэгч ядам бурхан мөн бөгөөд өөрөө ядам барьсаны тул болой](OM 8a)

Яданги |yadanggi|[yada-ŋgi] *'ядуу'*, *'ядарсан'* || Ж= *'nigen **yadaŋgi** kü'ün kō'ün-bēn kötöljü yabuqu-yi ǰolγaǰu'* [нэгэн яданги хүн хүүгээ хөтөлж явахтай уулзаж](MNT 14) // *'hon to'ōriqui-ber **yadanggi** ulus-a ǰobolang bolqu'* [жил тойроход яданги уладаа зовлон болох](KMQB B6)

Ядар- |yadara|[= yada-ra] *'эцэж цуцах'*. Энэ үгээс *yadaraya* [yada-ra-γa] 'ядараа', *yadaray-a* [yada-ra-γa] 'ядаргаа', *yadarangγui* [yada-ra-ŋγui] 'ядарангуй', *yadarayu* [yada-ra-γu] 'ядаруу' зэрэг үгс үүсчээ. || х о р ш : *'ядарч зүдэрэх'* || Kha, Bur. *yadar-*, Ord. *jadara-* Oir. *jad*r-*

Ядуу |yadaγu|[= yada-γu] *'дорой буурай'*. || Cf. Man. *jadakū* 'бедный' (Цинциус I:337) Энэхүү үүсмэл язгууртаас *yadaγuliy* [yada-γu-liγ] 'ядуулаг', *yadayur-* [yada-γur] 'ядуур-', *yadayural* [yada-γu-ral] 'ядуурал' зэрэг шинэ үгс үүссэн байна. || Ж= *'öčüken bay-a atala **yadaγu** ary-a bilig'* [өчүүхэн бага атал

ядуу арга билиг](Qqot. IV:14) || х о р ш : *'ядуу зүдүү'* || Kha, Ord, Bur, Oir. *yadū*

Язгуур |iǰaγur|{< **hiǰaγūr* < **χiǰaγūr* < **φiǰaγūr*} > *χiǰaγūr* > *hiǰaγūr* > *iǰa'ūr* < *iju'ūr* > *uǰu'ūr* > *uju'ūr* > *uǰūr*] *'үг гарал', 'өвөг дээд'* || Cf. Man. *fuǯuri* 'начало', 'корень' (Цинциус II:302) || Ж= *hiǰa'ūrtu kürbe yama* 'вещь достигла конца' (Mu. 184) || (Эртний монгол хэлэнд **φiǰaγūr, *φuǰaγūr* гэсэн хоёр хувилбар байсан бөгөөд тэдгээрийн цаашдын хувьсалын үр дүнд орчин цагийн монгол хэл аялгуунуудын *udzūr / udzūr, yadzūr / yadzūr, odzōr / odzōr / oyōr* гэх мэт олон хувилбар үүсчээ. || Cf. Man. *oǯōr* 'происхождение' (Цинциус II:7) || Хэдий тийм боловч орчин цагийн монгол хэлэнд бичигийн хэлний *'язгуур'* (iǰaγur) гэсэн үг нь уугуул утгаа хадгалж, *'язуур'* (yadzūr), *'озоор'* (odzōr), *'оёор'* (oyōr) гэсэн үгс нь *'уг'*, *'ёроол'* гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ.) || Ж= *'olangkin köbegüd-ün aburi inu uridu **iǰaγur-iyan** kü dayan bui'* [олонхи хүвүүний зан авир нь урид язгуураа дагах буй](Sub. VI:15a) // *'Činǰgis qahan-nu **huǰa'ur** de'ere teŋgeri-eče ǰaya'atu töregsen Börte čino aǰu'u'* [Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяатай төрсөн Бөрт-чоно ажгуу](MNT 1) // *'**huǰa'ūr** mongqol qahān-nu uruq'* [язгуурын монгол хааны ураг](HY A4) // *hiǰa'ūrtu kürbe* yama 'вещь достигла конца' (Mu. 184) // *hujawur* 'Wurzel, Herkunft' (LH 76) // *hujaur* 'root' (Ras. 202 A17) || Kha. *udzūr/ idzūr / yadzūr*, Ord. *udzūr/ iǯūr*, Bur. *izaǧūr / uzūr*, Oir. *jozūr* Dag. *хоǯōr*

Ял |yala| *'гэмт этгээдэд оногдуулах гэсхээл шийдхэл'* || Ж= *'tayiǰi, tabunang qarača kümün-i iretü üǰügürtü-yi yaryabasu ba ǰančibasu eng-ün kümün-ü adali **yala'*** [тайж тавнан хүн харц ардад иртэй, үзүүртэй /мэс/ гаргах болон занчваас энгийн хүний адил ял /эдэлнэ/](QJ B15a) || х о р ш : *'ял зэм'*

Ялга- |ilγa| *'мусхаарлах', 'салгах'* || Ж= *'bökös küčüten-i **ilgaju** ögčü'* [бөхчүүд хүчтэнийг ялгаж өгч](MNT 139) // *ilγa-* 'distinct', 'separate' (Zir. 107) || Энэхүү язгуураас *ilγay-a* [ilγa-γa] 'ялгаа', *ilγaburi* [ilγa-buri] 'ялгавар', *ilγal* [ilγa-l] 'ялгал', *ilγamǰi* [ilγa-mǰi] 'ялгамж', *ilγara-* [ilγa-ra] 'ялгар-', *ilγaγūl-* [ilγa-γūl] 'ялгуул-' гэх мэт үндэсүүд үүсч, улам тэдгээрээс нийлмэл бүтэцтэй олон шинэ үг үүссэн байна || х о р ш : *'ялгаж салгах'* || Kha. *yalga-*, Ord, Bur. *ilga-*, Oir. *ilgɒ-*

Ялгал |ilγal|[= ilγa-l] *'ялгаа'* || Ж= *'er-e em-e nigen yosutu bögesü ber sayin mayui-yin **ilyal** bui'* [эр эм нэгэн ёст бөгөөс сайн муугийн ялгал бас бий](Sub. VI:15b) || Kha. *yalgal*, Bur. *ilgalga*

Ялгар- |ilγara|[= ilγa-ra] *'мусхаарлах', 'салгах'* || Ж= *'Өөд хөөрөх нарны цацараг үүлний сиймхийгээр гэрэлтэн, өнгө бүрийн туяа ялгарна'* (Д. Намдаг, Нүгэл буян хоёр) || Kha. *yalgar-*, Bur. *ilgar*, Oir. *ilgɒr-*

Ялгуусан |ilaγūγsan|[= ilaγū-γsan] *'ялан дийлсэн', 'бухэнийг мэдэгч'* || Ж= *'**ilayuy-sad-un** bilge bilig-i törügülün soyurq-a'* [ялан дийлэгсэдийн бэлгэ билигийг төрүүлэн соёрх](Burq. 2b) || х э л ц : *'ялгуусан хувисхал'*

Ялуу |ilau|{< Chin. *yá lìu*} *'бор бургас'* (тэрэгний арал, хаалга цонхны хөндөлөвч мод) || Kha. *yalū*

Ям |yam-a|{< Tib. *yams*} *'хижиг'* (адуу тэргүүтэн битүү туурайт амьтанд туссаг халдварт өвчин) || Kha. *yam*

Яма |yama|{< Skr. *yama*} *'эрлэг'* (бүддийн ёсонд нас барагсадын урд төрөлдөө хийсэн муу үйлийг шүүгч) || Ж= *Ямаранз* (хүний нэр){< Skr. *yamaraja*} 'эрлэгийн хаан'

Ямандага |yamandaγ|{< Skr. *yamantaka}* *'айлган үйлдэгч эрлэг хаан'* (Орой дээрээ үхэрийн эвэртэй, 9 толгой, 34 мутар, 16 хөлтэй догшин бурхан. Хуйларан боссон гэзэг үсээ таван өнгийн хохимой толгойгоор чимсэн, хөмсөг сахалаас нь галын дөл бадарсан, цус нь дусалсан хохимой толгойтой эрих хүзүүндээ зүүж, өвөр дээрээ нүцгэн эм тэвэрч суугаа сүрлэг догшин дүртэй бурхан)

Ямбий- |yangbiyi|{< Chin *yang pi*} *'ямбий'* (эвдэрч муудсан, хэрэгцээгүй болсон зүйл) || Ж= *'ямбий машин'*

Ямбуу |yangbuu|{< Chin. *yáng bù*} *'бөс даавуу'* (тэгш артай, бүдүүвтэр ширхэгтэй хөвөн нэхмэл даавуу)

Янаг үз **Инаг**

Янгир |yanggir|{< Tib. *gyang dkar*} *'халилын цагаан'* (уул хадаар нутагшсан зэрлэг ямааны илт үгүүлэх нэр) || х о р ш : *'янгир ямаа'* || Kha, Ord, Bur. *yaŋgir,* Oir. *jaŋǧor*

Янгирцаг |yanggirčaγ|[= yanggi-rčaγ] *'янгиа эмээл'* || Cf. Yak *ïŋïr* 'эмээл', Turk. *ïŋgïrčaq* (ачааны эмээл, хуучин муу эмээл гэх зэрэг утга) || Ж= *ači'ā inu hogtolǰu, iŋgirčag-tur inu unuǰu'* [ачааг нь оготолж, эмээлийг нь унаж](MNT 172) || Kha. *yaŋgirtsag,* Ord. *yaŋǧartšak,* Oir. *yaŋgïrcag id.*

Янгуу |yangγuu|{< Chin. *yān gāo*} *'янгуу'* (модон хөл дээр явж тоглодог жүжиг) || хорш : *'ший янгуу'* (хитад үндэстэний хөгжимт жүжиг)

Яндан |yandung|{< Chin. *yān tong*} *'утаа дамжуулах хоолой'* || Kha, Bur. *yaŋdaŋ*

Яндар |yandar|{< Tib. *gyang dar*} *'хадаг самбай'* (буян хишиг гуйж элдэв шүтээний газар өлгөсөн даллагын цагаан хадаг) || х о р ш : *'хадаг яндар'*

Янжин |yangǰing|{< Chin. *yán jīng*} *Бээжин* хотын анхны нэр. (Бээжин хотын Фан шань тойрогт байх Ян шань уулын нэрээр тийн нэрлэдэг байжээ)

